



СОЁЛЫН ЖИМЭЭР
THE CULTURAL WAY

ЭРДЭМ

ШИНЖИЛГЭЭ

ᠡᠷᠳᠡᠮ



ᠰᠢᠨᠵᠢᠯᠭᠡᠭᠡ

Эрхэлсэн: Э.Итгэл



СОЁЛЫН ЖИМЭЭР
THE CULTURAL WAY

ISSN: 2791-1446

БОТЬ VII (№ 3)

Редакцын зөвлөл:

| | | |
|---------------|----------------|----------------|
| Доктор (Sc.D) | Д.Бадамдорж | / Монгол улс / |
| Доктор (Ph.D) | Л.Чулуунбаатар | / Монгол улс / |
| Доктор (Ph.D) | Л.Хурцбаатар | / Герман улс / |
| Доктор (Ph.D) | Цолмон | / БНХАУ / |
| Доктор (Ph.D) | Ургаацэцэг | / БНХАУ / |
| Доктор (Ph.D) | Н.Мягмар | / Монгол улс / |
| Доктор (Ph.D) | Л.Хасбаатар | / БНХАУ / |
| Доктор (Ph.D) | Б.Болд | / Япон улс / |
| Доктор (Ph.D) | Залгаабаяр | / БНХАУ / |

“СОЁЛЫН ЖИМЭЭР” Соёл Судлалын Төвийн

Эрдэм шинжилгээний редакцын зөвшөөрлөөр улирал тутам хэвлэгдэх сэтгүүл

Улаанбаатар 2023

ISSN: 2791-1446

© Sodon Soyod Publishing, Mongolia



СОЁЛЫН ЖИМЭЭР
THE CULTURAL WAY

ISSN: 2791-1446

VOLUME VII

Editorial board:

| | | |
|---------------|---------------|---------|
| Doctor (Sc.D) | Badamdorj | (MGL) |
| Doctor (Ph.D) | Chuluunbaatar | (MGL) |
| Doctor (Ph.D) | Qurčabaatar | (GER) |
| Doctor (Ph.D) | Tsolmon | (PRC) |
| Doctor (Ph.D) | Urgaatsetseg | (PRC) |
| Doctor (Ph.D) | Myagmar | (MGL) |
| Doctor (Ph.D) | Qasbaatar | (PRC) |
| Doctor (Ph.D) | Bold | (JAP) |
| Doctor (Ph.D) | Zalgaabayar | (PRC) |

Edited by: Itgel. E

THE CULTURAL WAY
CENTER FOR CULTURAL STUDIES
Printed with permission of editorial board
a quarterly journal of research

Ulaanbaatar 2023

ISSN: 2791-1446

© *Sodon Soyod Publishing, Mongolia*



СОЁЛЫН ЖИМЭЭР THE CULTURAL WAY

ГАРЧИГ

1. Б. Базаргүр

Монгол хэлний “Зүрх” гэсэн үг орсон өвөрмөц хэлцийн тухай.....1

2. Б.Урангоо

Ч.Билигсайханы монгол уран зохиол судлал, шүүмжид оруулсан хувь нэмэр.....18

3. Хасхүү

Шинэ эриний жүжгийн зохиолын ур чанарын илэрхийллийн тухай өгүүлэх нь.....35

4. Цай Юнь

Олон соёлт үзлийн уялдаа-Инжиннашийн “Нэгэн давхар асар” болон “Улаанаа уйлах танхим”-ын жишээн дээр.....46

5. Бао Саруул

Сургалтын орчин дахь англи хэлний эзэмшихүйн судалгааны тойм.....64

6. Л.Чулуунбаатар

Үндэсний монгол бичгийг сэргээх хөдөлгөөний явц.....76

7. Саруул

Хасбугийн “Улаан асарын зүүд”-ийн монгол орчуулгын гар бичмэл дэвтрүүд.....94

8. Соёлбаатар

Ил хаант улсын Аргун хааны гурван элчийн үйл хэргийг өрнө, хятад, перс сурвалжаас хайх нь.....104

9. Өнөр

Хамгаалалт ба өв залгамжлал: Зүүн монголын ардын үлгэрээр дамжуулан хамтач эх оронч үзэл төлөвшүүлэх туршилага.....112

10. Э.Итгэл

Дарьганга уулын хошууны нийгмийн зарим асуудлыг тодруулах нь.....126

МЭДЭЭЛЭЛ



СОЁЛЫН ЖИМЭЭР THE CULTURAL WAY

CONTENT

1. **Bazargur. B**

Mongolian language's heart related idiom study.....1

2. **Urango. B**

Biligsaikhan's contribution to Mongolian literary studies and criticism.....18

3. **Khaskhuu**

Essay on the expression of literary quality in new age drama.....35

4. **Cai Yun**

The integration of multiculturalism-on the examples of Injinnash's "Negen dabqar asar" and "Ulaanaa uilaq tanqim"46

5. **Bao Saruul**

A review of research on English language acquisition in teaching environments.....64

6. **Chuluunbaatar. L**

The progress of the movement to restore the national Mongolian script.....76

7. **Saruul**

Manuscript notebooks of the Mongolian translation of Hasbu's "Ulaan asar'in zuud".....94

8. **Soyolbaatar**

Researching the affairs of the three envoys of Argun khan of the Ile Kingdom and searching them in Chinese and Persian sources.....104

9. **Unur**

Conservation and Legacy: Experiences of collaborative patriotism through eastern Mongolian folktales.....112

9. **Itgel. E**

Clarifying some social issues of Darganga Mountain Cape.....126

NEWS



СОЁЛЫН ЖИМЭЭР THE CULTURAL WAY

ЭРХЛЭН ХЭВЛҮҮЛЭГЧИЙН ҮГ

Энэ удаагийн дугаарт Өвөр Монголын Их Сургуулийн Монгол Судлалын Дээд Сургууль тус сургуулийн Монгол улсыг судлах хүрээлэн, Ордос хотын Техникийн Дээд Сургууль, Монголын Үндэсний Их Сургуулийн эрдэмтэн багш, залуу судлаачдын өгүүллүүд багтлаа. Манай сэтгүүлийн алсын зорилго бол монгол улс дахь хөрш орнуудын залуу судлаач, эрдэмтдийн судалгааны төв цаашилаад монголын соёл судлалд зохих хувь нэмрийг оруулах явдал билээ. Уйгуржин монгол бичгээс кирилл бичигт хөрвүүлэх, хятад хэлнээс монгол хэлэнд орчуулах орчуулгын баг, зүтгэл нийт хамт олондоо талархал илэрхийлье. Халуун сэтгэлээр цаг бүр туслан дэмжих эрхэм номын садан ӨМИС-ийн доктор Бао Ургаацэцэг, Шаогуань Их Сургуулийн багш, доктор Жан Юань, ШУА-ийн ХЗХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан доктор Т.Батбямба, ӨМИС-ийн Монгол улсыг судлах хүрээлэнгийн лектор Хасхүү болон бусад бүх номын ах эгч дүү, найз нөхөд, багш нартаа чин сэтгэлээсээ талархаж буйгаа энд тэмдэглэе. Эрдэм шинжилгээний сэтгүүлтэй холбоотой санал хүсэлт, шүүмж байваас харамгүй илгээхийг хичээнгүйлэн хүсье. Таны аливаа санал шүүмжийг бид мэхийн хүндэтгэн хүлээн авах болно.

Эрдэм шинжилгээний редакцын зөвлөлийн гишүүн

Э.Итгэл / Түүхийн ухааны докторант /

2023 оны 09 сар



МОНГОЛ ХЭЛНИЙ “ЗҮРХ” ГЭСЭН ҮГ ОРСОН ӨВӨРМӨЦ ХЭЛЦИЙН ТУХАЙ

Б.Базаргүр*

ХУРААНГУЙ

Өвөрмөц хэлц түүн дотроо монгол хэлний өвөрмөц хэлц бол монгол хэл бол өвөрмөц хэлцээр баян бөгөөд хэлцийн тухай олон эрдэмтэд судалж толь бичиг, эрдэм шинжилгээний өгүүлэл, ном зохиол бүтээл гаргасаар ирсэн байдаг. Монгол хэлний өвөрмөц хэлцийг үзэх үзэл онол, ойлголт ангилалыг ч мөн адилгүй олон янзаар гаргаж тодорхойлж ирсэн байдаг. Эдгээр онол ойлголтуудыг нэгтгэн дүгнэсэн нийтээр хүлээн зөвшөөрсөн зүйл одоогоор гараагүй байна. Ер нь ямар ч хэлний хувьд адил байдаг болов уу хэмээн бодно. Яагаад гэвэл өвөрмөц хэлцийг яг ийм тийм ингэж ангилж болно гэсэн нэгдсэн ойлголтыг бий болгоход ч хүндрэлтэй яагаад гэвэл өвөрмөц хэлц нь бүтэхдээ өвөрмөцөөр бүтдэг бөгөөд үүнд ямар нэгэн дүрэмд захирагдана гэдэг нь хүндрэлтэй юм. Жишээ нь: ихэнх өвөрмөц хэлц хоёр үгнээс бүтэх боловч нэг үгээр бүтэх, хоёроос дээш үгээр бүтэх зэрэг ч зөндөө байна. Ингэж бүтэхдээ тухайн ард түмний зан заншил орчин, түүх соёл, ямар нэгэн үйл явдал зэргээс болж бүтэх ба үүнд тухайн хэлний онцлогт байдал үг бүтэх ёс, өгүүлбэр зүйн байдал ч нөлөөлдөг. Иймээс ч өвөрмөц хэлцийн аливаа тодорхойлолтонд нэгдсэн нэг ойлголт байдаг нь өвөрмөц хэлц бол тухайн хэлнийхээ онцлогыг хадгалагч, соёл түүхийн илрэл юм гэж бичсэнтэй санал нэг байна.

Түлхүүр үгс: *Өвөрмөц хэлц, хэлц үг, хэлц, хэллэг, идиом, толь бичиг*

Өвөрмөц хэлцийн ангиллуудыг аваад үзвэл ч олон янзаар ангилсан нь харагддаг. Жишээ нь бүтцийн хувьд, хэлбэрийн хувьд, илэрхийлж буй утгын хувьд гэж ерөнхийлж үндсэн 3 янзаар олон судлаачид ангилсан байна. Монгол улсын эрдэмтэн судлаачдын ангилал нь дээрх мэт 3 янзаар үзсэн бол, өвөрмонголын судлаачдын

* Өвөр Монголын Их Сургуулийн Монгол Судлалын Дээд Сургуулийн докторант



THE CULTURAL WAY

хувьд ямар үгээр бүтсэн бүтцийн хувьд ангилсан ангилал дээр санал нэгтэй байдаг байна.

Нэгэн зүйлийн талаар бичсэн адилгүй ойлголтуудаас нийтлэг чанар, нэгдсэн тодорхойлолт ойлголтыг гаргахыг зориогүй бөгөөд тэгэх ч боломжгүй зөвхөн монгол хэлний зарим өвөрмөц хэлцийн онцлог байдал, үүсэл гарал, үгийн бүтцийг энэхүү өгүүллээр гаргахыг хичээсэн болно.

Өвөрмөц хэлцийн тухай:

Монгол улсын их сургуулиас 2022 онд хэвлүүлсэн монгол хэлний 15 боть номыг гаргасан бөгөөд өвөрмөц хэлцийг дараах мэт үзсэн байна. үүнийг аваад үзвэл: бүрдүүлж буй үгсийн утга нь бүгд юм уу, аль нэг үгийн утга нь шилжиж, шууд бус нэрлэлтийг үүсгэсэн тогтвортой холбоо үгсийг өвөрмөц хэлц гэнэ гээд монгол хэлний өвөрмөц хэлцийг 8 үндсэн шинжтэй: бүрдүүлж буй үгсийн утга бүрэн юм уу аль нэг үгийн утга нь шилжсэн байна, утга дүрслэл болон өгүүлэгчийн сэтгэл хөдлөлийн нэмэлт утгатай байна, бүрдүүлэгч үгсийг сэлгэж болохгүй, хэлний бэлэн нэгж байна, тухайн ард түмний аж ахуй, шашин шүтлэг, соёл боловсрол, газар нутгийн онцлог, оюуны мэдлэгийн тусгал байна, үгчлэн орчуулж болохгүй гэсэн шинжтэй байна гэж үзсэн байна. өвөрмөц хэлцийг ангилахдаа бүрэн өвөрмөц хэлц сул өвөрмөц хэлц гэж хоёр л ангилсан бөгөөд энэ ангилал нь өөрөө өвөрмөц хэлцийн шинжийг тодорхойлохдоо бүрдүүлэгч үгсийн утга бүрэн юм уу аль нэг үгийн утга шилжсэн байна гэсэн шинж дээр тулгуурлан бүрэн өвөрмөц хэлц , сул өвөрмөц хэлц хэмээн хоёр хуваасан байна.

Бүрэн өвөрмөц хэлц: Бүрдүүлж буй үгсийн утга нь бүгд шилжээд аль нэг үгээс утга нь үл мэдэгдэх, хэлц үгсийг бүрэн өвөрмөц хэлц гэнэ гэж үзсэн байна. жишээ нь: гараа угаах-үрэн таран хийх/эд хөрөнгө/

Сул өвөрмөц хэлц: Бүрдүүлж буй үгсийн зарим үгийн утга нь мэдэгдэх хэлц үгийг сул өвөрмөц хэлц гэнэ. Жишээ нь: алга дарам газар-өчүүхэн газар гэж хэлэхэд өчүүхэн бага газрыг алганы хэмжээтэй жишин хэлсэн байна. дээрхээс үзэхэд өвөрмөц хэлцийн шинжийг тодорхойлохдоо 8 үндсэн шинжийг гаргасан ч ангилахдаа тодорхойлсон тодорхойлолтоо барин зөвхөн нэг шинжийг харгалзан



THE CULTURAL WAY

үзэж ангилсан байна. үүнээс өвөрмөц хэлц бол тогтвортой холбоо үгээр бүрдсэн байх ёстой, эдгээр тогтвортой холбоо үг нь бүтнээрээ утга шилжсэн байх ёстой аль эсвэл аль нэг үг нь утга шилжсэн байх ёстой мөн жишин хэлсэн буюу метафор/зүйрлэл/ байх ёстой гэсэн утга гарж байна. харин Б.Ринчен 1950 онд нийтлүүлсэн үгийн утга учир өгүүллийнхээ Идиом гэдэг холбоо үгийн учир хэмээх наймдугаар хэсэгтээ “хэд хэдэн үг нийлэн, нэг утга ухагдахуун бүхий бүрэн иж болдог ёс хэл бүхэнд байдаг учир тусгай нэртэй байдаг юм хэлний шинжлэлд үүнийг идиом гэж нэрлэдэг.”

Мөн М.Базаррагчаа “хоёр буюу түүнээс дээш үгс нийлж өвөрмөц утга илтгэнэ. Тогтвортой чөлөөт бус үг, холбоо үг, өгүүлбэрийг өвөрмөц хэлц, хэвшмэл хэллэг гэж нэрлэсээр ирсэн ба хэлц үг хэлц хэллэг ч гэх нь бий.” Ш.Лувсанвандан “үгсийн санд нэжгээд үгээс гадна мөн хошоод буюу түүнээс дээш хэд хэдэн үг хоорондоо нягт холбогдон үргэлж хэвшмэл байдалтай тогтмол хэрэглэгддэг нь түүний утга санааг үг тус бүрийн утга санаанд оногдуулан ойлгож болохгүй, харин бүхэл бүтэн түүний цогцоос ухан ойлгох ёсон буй хэмээн үзсэн байна. тэгэхээр өвөрмөц хэлцийн аль ч тодорхойлолтонд өвөрмөц хэлцийг бүрэн гүйцэт тодорхойлоогүй мөн дээр нь эрдэмтэн судлаачдын үзэх үзэл ч адил бус байна.

Өвөрмонголын өөртөө засах орны судлаачдын үзэл онол:

1. Судлаач Давхарбаяр хэлцийг

Тогтвортой холбоо үг бол үндсэндээ хэлц болдог байна. Холбоонд орсон үгийн өөр хоорондын нэгдэл нь салшгүй бэхжин, тухайн хэлэнд үргэлж бэлхэн нийц болж, утга ба хэрэглэхүйн хувьд нэгэн бүхэл болсон байдаг нь хэлцийн гол чухал шинж мөн. Хэлц нь тэр хэлний хэрэглэгч ард түмний ахуй амьдралтай гүн холбоотой байдаг учир түүнтэй танил биш хүнд тэр бүр тодорхой ухагдахгүй байж болно. Жишээ нь: тэмээ хариулсан хүн буурынхаа зангаа андахгүй.¹

Гээд хэлцийг дотор нь 3 ангилж авч үзсэний нэг нь өвөрмөц хэлц юм. Өвөрмөц хэлц бол: Зарим хэлцийн дотор багтсан үгийг утга зүйн хувьд нэг нэгээр салган авч үзэж огт болохгүй. Цөмөөр нийлж нэгэн санаа илтгэх бөгөөд үг тус бүрийн тодорхой утга нь алдсан байдаг. Ийм

¹ Монгол хэлний хэлцийн бүтцийн мэдэлгийн хөмрөгийн тухай судлал Давхарбаяр 2014 хөх хот 212-р тал



THE CULTURAL WAY

үгийн санжсан холбоо үгийг өвөрмөц хэлц буюу idiom гэнэ. Ийм хэлийн утга санааг түүний үг тус бүрд оногдуулан ойлгож болохгүй, харин түүний бүхэл бүтэн цогцоос нь ухаж мэддэг ажээ. Өвөрмөц хэлцийн утга нь бүхэл шинжтэй бөгөөд бүрэлдэхүүнд багтсан үгсийн хэл зүйн харьцаа нь тодорхой бус болсон байна. Жишээлбэл: нүд үзүүрлэх, долоон булчирхайгаа тоочих гэх мэт.² Мөн тэрээр хэлцийн бүтцийн талаар ангилсан бөгөөд ингэж ангилахдаа

1. Жинхэнэ нэр ба тэмдэг нэр хоёроос бүтсэн байж болно
2. Жинхэнэ нэрийн зүйлээс бүтсэн байж болно
3. Жинхэнэ нэр ба үйл үг хоёроос бүтсэн байж болно.
4. Жинхэнэ нэр тооны нэр хоёроос бүтсэн байж болно
5. Жинхэнэ нэр дайвар үгийн зүйлээс бүтсэн байж болно
6. Жинхэнэ нэр сул үгтэй холбогдон
7. Тэмдэг нэр ба үйл үг хоёроос бүтсэн
8. Тэмдэг нэр ба дайвар үг
9. Үйл үгийн зүйлээс
10. Үйл үг ба дайвар үг³

Гэж хуваасан нь 1983 он хэвлэгдэн гарсан “Орчин цагийн монгол хэлзүй” ном мөн Ж.Төмөрцэрэнгийн “Монгол хэлний үгийн сангийн судлал” 2004 хөххотноо хэвлэгдсэн номонд мөн ингэж ангилжээ.

Өвөрмонголын их сургуулийн эрдэмтэн Түмэнжаргал 2018 онд хэвлүүлсэн “Одоо үеийн Монгол хэл” бүтээлдээ Хэлц гэдэг нь хоёр буюу хоёроос дээш үгээс бүрэлдсэн утга ба хэлбэрийн талаар тогтворжин хэвшсэн үгтэй адилхан утга үйлдэлтэй хэлэнд бэлэн байдаг онцгой үг хэллэгийг хэлдэг.

Хэлцийг бас хэвшмэл үг, хэвшмэл хэллэг, хэвшмэл хэлц гэх мэтээр нэрлэдэг. хэлц нь:

1. Бүтэц нь хэвшсэн шинжтэй

Хэлц бол хэлэнд бэлэн байдаг хэвшсэн бүтэц бүхий зүйл юм. Хүмүүс үүнийг өөрийн хэрэгцээгээ үндэслэж зохион байгуулах биш. Энэ талаараа хэлц бол энгийн үгсийн холбооноос ялгаатай байдаг. Хэлцийн бүрэлдэхүүнийг дураараа нэмж хасах буюу сольж болдоггүй. Хэлц өгүүлбэрийн бүтцэд бүхэл цогцоороо нэг үгийн утга үйлдэлтэйгээр

² Монгол хэлний хэлцийн бүтцийн мэдэлгийн хөмрөгийн тухай судлал Давхарбаяр 2014 хөх хот 215-р тал

³ Орчин цагийн монгол хэлзүй Дээд сургуульд зориулсан 1983 хөххот



THE CULTURAL WAY

оролцоно. Жишээлбэл: хүйс тэмтрэх, өөх ч биш булчирхай ч биш, илжиг ч үгүй гурван лан ч үгүй гэх мэт.

2. Утга нь тогтворжсон шинжтэй

Хэлцийн утга нь тогтворжсон байдаг учраас утгыг нь дураар өөрчилж болдоггүй юм. Хэлцийн утга нь үүнийг бүрэлдүүлсэн үг нэг бүрийн утгын нийлбэрээр илрэх биш, харин бүхэл цогц дээр илэрнэ. Хэлцийн бүтцэд орсон үгийн заримынх нь утга шилжсэн буюу адилтгасан эсвэл утга дүрслэг шинжтэй болсон байдаг. Жишээлбэл: гэдэс гарах гэвэл гарахын утга шилжжээ.

3. Үндэсний өвөрмөц шинжтэй

Хэлц бол нийгмийн амьдралын тусгал болох тул тухайн үндэстний түүх, соёл, зан үйл, сэтгэхүй ба амьдралын арга маяг зэргийг илтгэдэг. Монгол хэлний хэлцээс монголчуудын өвөрмөц соёл сэтгэхүйн онцлогийг олж хардаг. Жишээлбэл: олбогоо цоортол суусан мэргэнээс олныг тойрсон мунхаг дээр гэх мэтийн хэлц бол монгол үндэстний аж амьдрал соёл, зан үйлийн өвөрмөц сэтгэхүй зэрэгтэй холбогдон зохиогдсон байдаг.

4. Илтгэмжээр уран хавлаг шинжтэй

Хэлц бол зүйрлэл, давуулал, хослуулал, сорчлол, дүрслэл зэрэг найруулгын орны арга барилаар дамжуулж өөрийн илтгэнэ гэсэн санаа ба уран хавлаг бөгөөд амьд дүрслэлээр илтгэж чаддаг. Жишээлбэл: адууны алаг нь сайхан аялгууны алаг нь муухай гэх мэтийн хэлцийг уран зохиолд тохитой газарт нь эвтэй хэрэглэвэл илтгэнэ гэсэн утга санааг нүдэнд үзэгдэж гарт баригдам уран хавлаг амьд дүрслэн илтгэж чадах юм.

Хэлцийн төрөл зүйлээр хуваахдаа:

1. Өвөрмөц хэлц
2. Хавт үг
3. Сэцэн үг
4. Сургаал үг
5. Хошин үг гэж төрлөөр ангилсан байна.

Тэрээр өвөрмөц хэлцийг тодорхойлохдоо:



THE CULTURAL WAY

Үг нэг бүр уул утгаа алдаж хамтдаа өөр нэг утга илтгэдэг хэлцийг өвөрмөц үг гэнэ. Монгол хэлэнд ялангуяа ардын аман ярианд өвөрмөц үг маш олон байдаг. Өвөрмөц үгийг сурч эзэмшин эвтэй сайхан хэрэглэж чадвал хэлний илтгэх чадварыг ихээхэн дээшлүүлдэг.⁴ Өвөрмөц үгийг зарим хүмүүс хавт үгэнд багтаан оруулсан байдаг. Өвөрмөц үг ба хавт үгийг дүрслэг, ёгтлог байдгаараа адилавар талтай боловч эд хоёр ялгаатай юм. Өвөрмөц үг бүтцийн талаар хоёр гурван үгийн холбоогоор нэг ухагдахууныг илтгэж байдаг болохоор хавт үгээс ялгаатай юм. Утга илтгэхийн хувьд хавт үгийн бүтцэд орсон үг уул утгаа алдаад нэгмөсөн өөр нэг утгыг илтгэж байдгаараа утга ялгах байдал нь нэн далдраг болсон байдаг. Өвөрмөц үг бол ярианы өнгө будгаар нэлээд гүн байдаг. Жишээлбэл: нүд хужирлах

Харин 2005 онд Өвөрмонголын их сургуулиас гаргасан “Одоо үеийн монгол хэл” номонд өвөрмөц хэлцийг хэвшмэл үгийн зүй гэж нэрлээд 1. Энгийн холбоо үг 2. Хэлний зүйн онцлог 3. Үгийн утгын хэвшсэн хэмжээ гэсэн 3 талаар үзэж болно. Төрөл зүйлийн талаар 1. Хоршоо үг 2. Хавт үг 3. Тогтмол үг гэж ангилсан байна.

өвөрмөц хэлцийг нэгтгээд аваад үзвэл үгсийн аймаг тэр дундаа хэлцийн үгийн дотор харьяалагдаж тогтвортой холбоо үг/тухайн хэлний бие даасан утга илтгэдэг дохио болж чадах хоёр буюу хэд хэдэн үгийг уул хэлний холбохын хууль зүйн дагуу бие биед нь захируулан холбож бодит ертөнцийн үзэгдлийг заан нэрлэсэн хэлний нийлмэл дохио/-ээс бүтэх бүрдүүлэгч үгс эсвэл аль нэг үг нь өөрийн үндсэн утгаасаа шилжсэн, бүхэл бүтэн цогц утга санааг илтгэж тухайн ард түмний аж ахуй, шашин шүтлэг, соёл боловсрол, газар нутгийн онцлог, оюуны мэдлэгийн тусгал юм гэж үзэж болхоор байна.

Монгол хэлний “Зүрх” гэсэн үг оролцсон өвөрмөц хэлцийн тухай:

Зүрх гэсэн үгийн тодорхойлолтыг анагаах ухааны толь бичигт тодорхойлсон байдлыг аваад үгвэл бол хүний биеийн таван цул эрхтний нэг цус шахах үүрэгтэй эрхтэн гэж тодорхойлсон бол монгол хэлний тайлбар толь бичигт зүрх гэсэн үг нь 1. Хүн амьтны цусны эргэлтийн гол эрхтэн 2. Зориг цөс 3. Гол чухал гэсэн үндсэн 3 утгатай⁵ байна гэж үзсэн байна. үгийн хувьд аваад үзвэл цусны эргэлтийн гол эрхтэн боловч өвөрмөц хэлцийн хувьд ямар байгааг харвал:

⁴ Түмэнжаргал “Одоо үеийн Монгол хэл” 2018 он Хөххот 434-р тал

⁵ Я. Цэвэл монгол хэлний товч тайлбар толь Улаанбаатар хот 2013 он х-408



THE CULTURAL WAY

Монгол хэлэнд байгаа өвөрмөц хэлцүүдээс “Зүрх” гэсэн үг оролцсон өвөрмөц хэлцийг түүн авч үзэхэд нийт 198 илэрсэн байна. эдгээр 198 өвөрмөц хэлцээс хоёр үгнээс бүтсэн өвөрмөц хэлцийг аваад үзвэл нийт 103 тоотой илэрсэн. Хоёр үгнээс бүрдсэн өвөрмөц хэлцийг дээр дурдсан хэлцийг өвөрмонголын эрдэмтдийн хэлцийн бүтцийн ангиллаар ангилж үзвэл:

| № | нэр | тоо | Жинхэнэ нэр э нэр жинхэнэ э нэр | тэмдэг нэр Жинхэнэ нэр | Жинхэнэ нэр тэмдэг нэр | Жинхэнэ нэр үйл үг | Жинхэнэ нэр дайвар үг |
|---|------|-----|--|---------------------------------|---------------------------|-----------------------|--------------------------|
| 1 | Зүрх | 103 | 25 | 10 | 8 | 58 | 2 |

Хүснэгт-1 “Зүрх” орсон хэлцийн бүтцийн ангилал

Хэлцүүдийг тийн ялгалаар хэрхэн хувирсныг харвал:

Хүснэгт-2 “Зүрх”

орсон хэлцийн тийн ялгалаар хувирсан байдал


| № | Биеийн эд эрхтний нэр | тоо | харьяалах /ийн4/ | өгөх орших /д,т/ | заах /ийг4/ | гаргах /аас4/ | үйлдэх /аар4/ | хамтрах /тай4/ | Нэрлэх |
|---|-----------------------|-----|---------------------|---------------------|----------------|------------------|------------------|-------------------|--------|
| 1 | Зүрх | 103 | 5 | 3 | 0 | 2 | 2 | 10 | 81 |

Илэрхийлж буй утгын хувьд аваад үзвэл:

Монгол хэлний “Зүрх” гэдэг үгээр илэрсэн өвөрмөц хэлц 198 ширхэг байна. Үүнийг хамгийн их утга авсан байдлаар харвал



THE CULTURAL WAY



Монгол хэлний зүрх гэсэн үг орсон хэлцүүд дотроос аймхай, айх, зориггүй гэсэн утгууд нь маш их илэрсэн байна. Харин эсрэгээрээ тухайн хэлцийн эсрэг утгууд болох зоригтой гэсэн утгууд нь мөн их боловч тоо нь харьцангуй бага байна. Монголчууд зүрхээр зориггүй гэсэн утгуудыг авдаг бол цэс гэсэн үгээр зориг зүрхтэй гэсэн утгуудыг олон авсан байна.

Хүснэгт-3 Монгол хэлний “Зүрх” орсон өвөрмөц хэлцээс айх гэсэн утга авсан өвөрмөц хэлцүүд

| № | Өвөрмөц хэл | Утга | жишээ |
|---|---|--------------------------|--|
| 1 | Бор зүрх бол бол хийж богино хавирга шир шир хийх | Ихэд айх | |
| 2 | Бор зүрх борт гэж богино хавирга ширт гэх | Айх балмагдах, сандрах | |
| 3 | Бүр зүрх нь бол бол хийж | Айх, санаа зовох | Санааны үзүүр зүүгүй байтал зүрх хатгах хэвш |
| 4 | Бялзуухай зүрхтэй | Зориггүй, аймхай хулчгар | Барсын дүртэй бялзуухай зүрхтэй |
| 5 | Гол зүрх | Айж цочсон | |



THE CULTURAL WAY

| | | | |
|----|--------------------------------|---|---|
| | амаар гарах | буюу тамир муутай хүн яаран бачимдаснаас болж зүрх ихэд түгших | |
| 6 | Зүрх авах | Сүрдэх, айх имээх | |
| 7 | Зүрх агших | ихэд айх | харанхуй хавцлын ирмэгээр явахад зүрх агшиж толгой эргэх юм |
| 8 | Зүрх алдах | Айх | Маргааш чи намайг буудахдаа зүрх алдан халирч болохгүй шүү (Б.Догмид, Үхэх хүнд хань хэрэггүй) |
| 9 | Зүрх амаараа гарах шахах | их айх | Хүүгийн зүрх амаараа гарчих шахаж дэнсэлж хэдэн саахалтын тэртээд айлын ноос савж байгаа ээжийгээ дуудаж ирэхээр гүйлээ. Б.Р Үүрийн туяа |
| 10 | Зүрх баатар | Аймхай, халирамхай, хулчгар | |
| 11 | Зүрх байхгүй | Айх эмээх, хулчгар сул дорой | |
| 12 | Зүрх дутах | Арай чадахгүй байх, шийдэж чадахгүй | Чи ч миний энэ хэлэх гэж зүрх дутаад олон хоног өөрийгөө зовоосон үгийг бараг гадарлаж байгаа биз. |



THE CULTURAL WAY

| | | | Н.Банзрагч цагаан нутаг | Хошуу |
|----|---------------------------------|--|---|-------|
| 13 | Зүрх дэлбэрэх | Уурлаж хилэгнэх Айх | | |
| 14 | Зүрх дэлдэх | Айх | | |
| 15 | Зүрх зүсэгдэх | Айх өрөвдөх зэрэгцэх | | |
| 16 | Зүрх мохох | Айх | | |
| 17 | Зүрх муутай | Зориггүй | | |
| 18 | Зүрх мятрах | Зүрхшээх айх | | |
| 19 | Зүрх нь амаар гарах | Сөөлгөлөх, амьсгаадах, зүрх савлах | | |
| 20 | Зүрх нь булдан булдан гэх | Зүрх нь чичрэх тай адил | | |
| 21 | Зүрх нь мятрах | Айх, халирах | | |
| 22 | Зүрх нь савлах | Маш их уурлах, айх баярлах | | |
| 23 | Зүрх нь хагарах | Туйлын айж цочих | | |
| 24 | Зүрх нь чичрэх | ихэд айх, туйлаар эмээн сүрдэх | Тэнгэрийн сум хаяанд нь буух шиг гэнэт гадаа нь үрээ мориных нь янцгаах танил дуу хангинахад Гульнар зүрх чичрэв Ш.Ванчаарай Хар нүдэн Гульнар | |
| 25 | Зүрх нь шантрах | Айх, зориггүйдэх, зориг нь харих | | |
| 26 | Зүрх сул | Аймхай | | |



THE CULTURAL WAY

| | | хулчгар | |
|----|---------------------------------|--------------------------------------|---|
| 27 | Зүрх үхүүлэх | айлгах, сүрдүүлэх | цэргийн дэглэм, амьдрал хэцүү гэж зүрх үхүүлэх үг их л сонссон. Би шантраагүй |
| 28 | Зүрх үхэх | шантрах, сэтгэлд багтахгүй | чи бол учир мэдэх хүн шүү дээ гэсээр ухуулагч бадриун гараа Цэвэлд сарвайлаа. Энэ хүнтэй нүүр тулахтай зэрэг Цэвэлийн зүрх нь үхэх шиг болж юу хэлэх гэж байснаа мартаад орхив. Л.Түдэв Нүүдлийн замд |
| 29 | Зүрх хагарах | Үхтэлээ айх, маш их айх | |
| 30 | Зүрх хагарах шахах | Ихэд айх | |
| 31 | Зүрх цохих | Айх сандрах | |
| 32 | Зүрх цөс үгүй | Аймхай хулчгах | |
| 33 | Зүрх цөсгүй | Аймтгай хулчгар | |
| 34 | Зүрх чичрэх | Ихэд айх, туйлаар эмээн сүрдэх | |
| 35 | Зүрхгүй хүн | Зориггүй | Зүрхгүй хүн зүгээ олохгүй Зүрхгүй арав үхнэ |
| 36 | Зүрхий нь амаараа үхүүлэх | мохоох, айлгах | Тэгье тэгье гэж Лодой баян баярлаад үдэш нь Батбаяр Жамба Сүрэн |



THE CULTURAL WAY

| | | | |
|----|-------------------------|--|--|
| | | | эмгэн хоёрт Лодой баяны зүрхийг амаараа үхүүлснийг ярьж тэр бяцхан хотынхон сэжиг ихтэй аймхай баяныг элгээн хөштөл инээж шоолов. Б.Р Үүрийн туяа |
| 37 | Зүрхий нь сугалах | Айлгах | |
| 38 | Зүрхийг нь авах | Зүрхийг нь үхүүлэх | |
| 39 | Зүрхийг нь үхүүлэх | Айлгаж зоригийг нь хугалах мохоох сул дорой байдалд хүргэх | Мөн улиастайн монгол цэрэгт хятад цэргийн сүр хүчийг үзүүлж зүрхийг нь үхүүлэх гэж жанжин амбан хоёр тийнхүү цэргийн сургуулийг олны өмнө шалгаж үзэх гэж тогтсон нарийн арга байжээ. Б.Ринчин Үүрийн туяа |
| 40 | Зүрхийг нь чангаах | Зүрхийг нь сугалах тай адил | |
| 41 | Зүрхших | Айх эмээх | |
| 42 | Зүрхэн үс босох | Үнэхээр аймаар | Байлдааны газрын эмгэнэлт байдлыг хэлбээс үнэхээр зүрхний үс босмой |
| 43 | Зүрхэнд шар суух | Айх хашрах | |
| 44 | Зүрхэнд шар ус хуруулах | айдас төрүүлэх, санаанаас | |



THE CULTURAL WAY

| | | | |
|----|------------------------|---|---|
| | | гарахгүй болтол айлган сүрдүүлэх, | |
| 45 | Зүрхээ гартаа атгах | Хэзээ магад аюул болох болуузай хэмээн машид айн болгоомжлон явах | |
| 46 | Зүрхээ гартаа барих | Аюул болуузай хэмээ машид айн болгоомжилж явахыг дүрсэлсэн хэллэг | |
| 47 | Зүрхээ зүсүүлэх | Юмнаас айж эмээх | |
| 48 | Зүрхээ хагартал айх | Ихэд айх, балмагдах, | |
| 49 | Туулай зүрх | Аймхай | Эр хүний зориг зүрх биш туулайн зориг зүрх л надад заяажээ. Ж.Дашзэгвэ |
| 50 | Туулай зүрх гаргах | Айх, дальдрах, их л айх | |
| 51 | Туулай зүрхтэй | Аймхай хулчгар | |
| 52 | Усан зүрхтэй | Зориггүй | |

Монгол хэлний тайлбар толь, хэлцийн толь, өвөрмөц хэлцийн тольнуудаас шүүж үзсэн байдлаар бол монголчууд “Зүрх” гэсэн энэ үгээр хамгийн их айх мэгдэх чичрэх гэсэн утгуудыг авдаг байна. Монголчууд “Зүрх” гэсэн үгээр дотно хайртай янаг гэсэн



THE CULTURAL WAY

утгыг авдаг ч тийм олон биш бөгөөд “Зүрх” болон “Сэтгэл” гэсэн хоёр үгээр холбон хайртай янаг амраг гэж зүрх тархитай нийлж байж сэтгэлээс гардаггүй хайрт гэсэн санааг илэрхийлж байгаа нь харагдаж байна. мөн дээр нь “элэг” гэсэн үгийг оруулсан байна. жишээлбэл: элэг зүрхний угаас, элэг зүрх шиг, элэг зүрхнээс, зүрх сэтгэлээ өгөх, зүрхний амраг, сэтгэл зүрхний хүн, зүрхний угаас, зүрхний оосор, зүрхнээс уяатай, зүрхэнд асах, зүрхээ хуваах гэх мэт. Монгол хэлний туулайн зүрх, туулайн зүрхт гэх өвөрмөц хэлцээр туулайг аймхай, зориггүй зүрх муутай хэмээн зүйрлэдэг бол англи хэлэнд chicken heart буюу тахиан зүрхт гэж хэлдэг. Тэгэхээр монгол болон англи хэлний хувьд тухайн хэлээр яригчдын соёл, ахуй орчны ялгааг эндээс харж болно. англи хэлний өвөрмөц хэлцийн толь бичгээс зүрх гэсэн үг орсон өвөрмөц хэлцүүдийг түүж үзсэн бөгөөд нийт 208 тоотой өвөрмөц хэлц илэрсэн байна. англи хэлний хувьд “Зүрх” гэсэн үгээр ихэвчлэн хайртай дотны янаг амраг гэх буюу эсвэл шархал зүрх, хаягдсан гунигласан хайраас болж шаналсан гэх утгууд их байдаг. эдгээр утгууд нь монгол хэлний хэлцүүд дотор ч байдаг ба айх гэсэн утгаас бол тооны хувьд ихгүй байдаг.

Зүрх гэсэн үгтэй холбоотой онцлохуйц хэлцүүдээс дурдвал: Зүрхээ чангалах-зоригжих. Энэ хэлц нь айх үед хүний зүрх маш хүчтэй хурдан цохилдог бөгөөд энэ байдлаа даран өөрийгөө зоригжуулан аливаа үйлдэл хийх гэсэн утгаар хэрэглэдэг байсан бол өнөөдөр энэ хэлцийг аливаа зүйлийг хийхийн өмнө архи уухдаа нэг удаа уугаад хийх гэсэн утгаар хэрэглэх болсон.

Элэг зүрхний уяатай-чин сэтгэлээсээ. Энэ хэлц нь 1960 онд анх “Халуун элгэн нутаг” дууны хамгийн эхний бадаг бөгөөд монголчууд энэ дуунд маш их дуртай, олонд алдаршсан юм. Энэ дууны энэ бадгаас улбаалсан ч байж болох ч элэг зүрх нэгтэй, элэг зүрхэнд гэсэн хэлцээс үүссэн ч байж магад бөгөөд чин хайртай, хамгаас хайртай гэсэн утгыг авдаг байна. Монголчууд зүрхээр айх хулчийх гэсэн санааг ихэвчлэн илэрхийлдэг гэж ойлгож болно. гэхдээ зүрх бол хайр дурлалыг зориг зүрхийг, тоомжиргүй бүдүүлэг, хайхрамжгүй гэсэн утгуудыг ч мөн авдаг байна.

Монгол хүн атгахан зүрх, хүрэн зүрх, алаг зүрхний хүн гэж хайртай дуртай миний амраг гэж ойлгодог бол харин англи хүн зүрхийг улаан өнгөөр дүрсэлж ойлгодог байна.



THE CULTURAL WAY

Өвөрмөц хэлц бол аливаа хэлний онцлогыг хадгалагч, бүрдүүлж буй үгс нь өөрөө утга шилжиж тухайн хэлний онцлог, тухайн ард түмний соёл түүхийн баримт болдог. Жишээлбэл: англи хэлний зүрх гэсэн үг орсон өвөрмөц хэлцүүдээс *my heart bleeds for you*-миний зүрх чиний төлөө урсана, мөн яг эсрэг утгаар нь мөн бас хэрэглэсэн байна. Самуэл жонсон 1763 онд алуурчин эх орноосоо урвагч хүн цаазаар авхуулахын өмнө миний зүрх эх орныхоо төлөө урсана гэж хэлэхэд олноороо инээд алдан худал ярьж байгааг шоолон инээлдэв хэмээн бичиж тэмдэглэн өгүүлснээр эсрэг утгыг нь олон нийтээр хэрэглэх болсон.

Өвөрмөц хэлц нь тухайн бүрдүүлэгч үгс нийлэн нэгэн бүхэл тогтмол утгыг илэрхийлнэ.

Өвөрмөц хэлцийг бүрдүүлэгч үгсийг дураараа сольж болохгүй бөгөөд ингэж сэлгэсэн тохиолдолд утга алдагдах боломжтой. Жишээ нь: туулайн зүрх гэвэл аймхай хүнийг хэлнэ хэрвээ туулай гэдэг үгийг арслангийн зүрх гэж сольвол зоригтой хүнийг хэлнэ. “Энэ арслангийн зүрх” гэсэн өвөрмөц хэлц нь “*lion hearted Richard King*⁶” гэсэн английн нэгдүгээр Ричард хааныг нэрлэсэн нэр бөгөөд хатан зоригт, аймшиггүй зоригт гэсэн санаагаар энэ хааны байлдан дагуулалтыг илэрхийлж үүнээс хойш англи хэлэнд арслангийн зориг зүрхтэй гэж хэлж иржээ. Энэ хааны байлдан дагуулалтын үеийн тухай бид “Робин Гүүд” хэмээх киноноос харж болно. харин эсэргээрээ монголчуудын хувьд амьдрал ахуйн хувьд арслан хэмээх амьтан амьдардгүй бөгөөд энэ нь ч өвөрмөц хэлцэд тусгалаа олоогүй байна. тэгэхээр эндээс харвал өвөрмөц хэлц үүсэн бий болоход тухайн хэлээр яригчдын газарзүйн онцлог мөн нөлөөлдөг байна. *lionhearted* энэ өвөрмөц хэлц нь англичуудын байлдан дагуулалт соёлын нөлөөгөөр бусад улсад тарсан гэж хэлж болно. үүнтэй адил тархсан хэлцүүд ч олон тохиолдоно. Жишээлбэл: бидний монголчууд дэлхийн соёлын нөлөөгөөр зүрхийг улаан өнгөөр зурж дүрсэлж хайр дурлалын хамгийн гол бэлэг тэмдэг болгон хэрэглэх болсон.

⁶ <https://www.thecollector.com/king-richard-i-the-lionheart/>



THE CULTURAL WAY

ДУГНЭЛТ

- Өвөрмөц хэлц бол тогтвортой холбоо үгнээс бүрдэг, бүрдүүлэгч үгс нь өөрийн утгаасаа өөр утгыг илэрхийлдэг, тухайн хэлнийхээ бүтцийг хадгалдаг, түүх, соёл, зан заншил, газар нутгийн онцлог, хүний сэтгэцийн онцлогийг илэрхийлдэг үгсийг хэлнэ.
- Монгол хэлний хувьд өвөрмөц хэлцээр арвин баялаг бөгөөд зөвхөн Зүрх гэсэн үг орсон өвөрмөц хэлцийн хувьд 198 тоотой илэрсэн байна.
- Зүрх нь өөрөө цусны эргэлтийг хариуцдаг эрхтэн юм гэвч монголчууд бид Зүрхийг ойлгохдоо мөн өвөрмөц хэлцээр ашиглахдаа аймхай, хулчгар, зориг зүрхгүй гэсэн утгыг ихэвчлэн авч байна.
- Зүрх гэсэн үгээр илэрсэн өвөрмөц хэлцүүдийг аваад үзвэл ихэнх нь хоёр үгнээс бүтсэн байгаа нь харагдаж байна.
- Зүрх гэсэн үг сэтгэл гэсэн үгтэй нийлбэл хайртай дуртай, хамгийн дотны гэсэн утгыг авч байна.
- Зүрхийг орчин үеийн залуусын хувьд аваад үзвэл хайр сэтгэл эсвэл хүний бие эрхтэн гэж ойлгодог нь англи хэлний англи соёлын орчин нөлөөлсөнтэй холбоотой болов уу. Уг нь бол бидний монголчууд “Элэг” гэсэн үгээр дотны янаг хайртай хүн гэсэн утгууд ихээр авч хэрэглэж байсан.

ABSTRACT

Any language has an idiom. Idioms represented human life, tradition, culture, chronicle time events, etc. a lot of researcher study this field and are trying to find their origin in, history, lexical meaning, and semantic structure and try to classify idioms. This study tries to find idioms related to ‘heart’ in Mongolian language. Also try to study this heart related idioms semantic, idiom structure some of the idiom explanation.

Key words: *Idioms, phrases, dictionary*



THE CULTURAL WAY

НОМ ЗҮЙ

1. МУИС "Монгол хэл судлалын түүх, Монгол хэлний үгийн сан, найруулга судлал 3-р боть" УБ., 2020 он
2. МУИС "Соёлын үг хэллэгийн товч тайлбар толь" УБ., 2000 он
3. Базаррагчаа.М "Хэлний үндсэн ба завсрын төвшгний нэгжийг тал бүрээс нь үзэх нь" УБ., 1991 он
4. Бат-Ирээдүй.Ж "Монгол хэлний үг, утгын сан" УБ., 2006 он
5. Баянсан.Ж "Соёл, Хэл, Үндэстний сэтгэлгээ" УБ., 2016 он
6. Баянсан.Ж "Монгол хэлний зүйрлэсэн хэллэгийн утга соёлын тайлбар толь" УБ., 2019 он
7. Ж.Раднаабазар.Ж "Анагаах ухааны толь бичиг" УБ., 2011 он
8. Лувсанжав.Чой "Монгол хэлний өвөрмөц хэллэг" УБ., 1966 он
9. Мон судар хэвлэлийн газар "Монгол хэлний өвөрмөц хэлцийн толь" УБ., 2011 он
10. МУБИС "Монгол хэлний өвөрмөц хэлцийн утга, хэрэглээ" УБ., 2021 он
11. Самбуудорж.О "Орчин цагийн монгол хэлний улс төрийн этгээд үг хэллэг" МУ.ШУА ХЗХ хэл зохиол судлал 22 дэвтэр УБ., 2009 он
12. Энхжаргал.С "Монгол хэлцийн тайлбар толь" УБ., 2019 он
13. Давхарбаяр "Дундад улсын монгол судлалын хөмрөг Хөххот., 2014 он
14. Өвөрмонголын Их сургууль "Одоо үеийн монгол хэл" Хөххот., 2005 он
15. Түмэнжаргал "Одоо үеийн монгол хэл" Хөххот., 2019

Ч.БИЛИГСАЙХАНЫ МОНГОЛ УРАН ЗОХИОЛ СУДЛАЛ, ШҮҮЖИД ОРУУЛСАН
ХУВЬ НЭМЭР

Б.Урангоо*

ХУРААНГУЙ

Монгол Улсын гавьяат багш, Шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор, уран зохиолын онолч, шүүмжлэгч Ч.Билигсайхан агсан бол монголын орчин үеийн уран зохиол судлалын түүхэнд тодрон гарсан цөөхөн судлаачдын нэг, үндэсний уран зохиолын нэгэн үеийг хөтлөн замчилсан нэрт шүүмжлэгч, олон мянган шавь нараа сурган хүмүүжүүлсэн эрдэмтэн багш билээ. Тэрбээр монголын эрт ба эдүгээ үеийн уран зохиолын харилцаа холбоог тодруулж, түүхэн үечлэлийг бичиж, онол, шүүмжийн шинэлэг хандлагыг бий болгосон судлаач шүүмжлэгч юм. Ч.Билигсайхны судалгаа шинжилгээний бүтээлийг хамгийн ерөнхийд нь Монголын хүүрнэл зохиолын шүүмж судлал, Монголын эртний уран зохиол судлал, Орчин үеийн уран зохиолын онол, шүүмжийн судалгаа гэж 3 ангилан үзэж уран бүтээлийн туршлагыг цаашид дэлгэрүүлэн судлах шаардлагатай юм.

Түлхүүр үгс: *Ч.Билигсайхан, утга зохиолын онол, шүүмж*

Удиртгал

Уран зохиолын судлал шүүмжлэл бол уран зохиолтойгоо хамт үүсэж хөгжиж ирсэн, “нийгэм цаг үе-утга зохиол-шүүмжлэл” буюу “уншигч-зохиолч-шүүмжлэгч” гэсэн харилцаанд оршдог сэтгэлгээний өвөрмөц зүйл билээ. Орос зөвлөлтийн утга зохиолын онолд судлал шүүмжлэл (литературная критика) хэмээх нэр томъёог уран зохиол нийгмийн холбоог нээн илрүүлдэг танин мэдэхүйн өвөрмөц салбар гэдэг утгаар нийтлэг хэрэглэж нэгэнт хэвшсэн байна. Ерөөс уран зохиолын төрүүлж буй болгосон нийгэм, түүх сэтгэл зүйн олон арван нөхцөл шалтгааны дотроос хамгийн их анхаарал татдаг сэдэв нь нийгэм цаг үеийн хамаарал, түүний учир шалтгаан юм.

* Өвөр Монголын Их Сургуулийн Монгол Судлалын Дээд Сургуулийн докторант



THE CULTURAL WAY

1842 онд оросын нэрт судлаач В.Г.Белинский “Урлаг утга зохиол шүүмжлэлтэй гар гараасаа барилцан бие биедээ нөлөөлж ирсэн юм. Урлаг шүүмжлэлийг бий болгоогүй. Шүүмжлэл ч урлагийг бий болгосонгүй. Харин хоёулаа тэр цагийн ерөнхий санаа эрмэлзлэлээс үүсэн гарчээ” гэж бичсэнийг манай нэгэн үеийнхэн урлаг уран зохиолын талаарх ерөнхий хандлага болгосоор ирсэн байна. Түүнчлэн зохиолыг үнэн зөв шинжилж, түүнд нэмүүр нөхүүр хийж чадсан шинжээч нар суут сэтгэгч нарыг төрүүлж, эрдэмтэн мэргэдийг алдаршуулж иржээ.

Уран зохиол судлал шүүмжлэл, нийгэм цаг үеийн хамаарлыг шүүнэ гэдэг бэрх хэцүү бөгөөд нэн хүнд ажил юм. *“Хүн болгон зохиолч болж чаддаггүйн адил шинжээч болж үл чадна. Утга зохиол шүүмжлэл бол мэдлэг, хатуужил, тэсвэр сорьсон халтиргаа гулгаа, шарваа ихтэй маш эмзэг авьяас юм”* гэж ХХ зууны нэрт утга зохиол судлаач, шүүмжлэгч Г.Жамсранжав нэгэнтээ бичжээ. Энэ хальтиргаа гулгаа, шарваатай замаар замнаж авьяасаа сорьсон судлаач шүүмжлэгч бол Ч.Билигсайхан юм.

Монгол Улсын гавьяат багш, Шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор Ч.Билигсайхан 1970-аад оноос 2010-аад он хүртэл 40 гаруй жил монголын уран зохиол судлалаар ажилласан монгол уран зохиол судлаач, шүүмжлэгч билээ. Тэр бээр уран зохиолын онолын судалгааг оюутан байх үеэсээ эхлүүлсэн бөгөөд энэ чиглэлээр “Эрин цагийн амьсгал” (1976), “Орчин цагийн монгол роман” (1981), “Уран чадварын нууц” (1983), “Арван хөрөг” (1986), “Уран бүтээлчийн ертөнц” (1988) зэрэг 30-аад ном хэвлүүлжээ. Түүний бүтээлийн дотор уран зохиолын онолын чиглэлээр туурвисан “Монгол эрх товчис” (2000), “Ухаарахуй” (2003) номууд онцгой байр эзэлнэ.

Профессор Ч.Билигсайхан “Ухаарахуй” нэртэй шинэ үеийн уран зохиолын онолын номыг *“сэргээгч” чанарыг аугаалсан олон зохиолч, суралцагч оюутан, сонирхогч нарт гэрэл гэгээ, өмнөхийг замчлагч болсон*” (До.Цэнджав), *“Монгол эрх товчис”-ыг самтинлан зангидаж, монгол сонгомол элит уран зохиолын уламжлал, шинэчлэлийг судлан, утга зохиолын судлал шүүмжлэлийг шинжилж, утга зохиолын судлал шүүмжлэлийг сонгодог утгаар нь хөгжүүлэхийн төлөө цуцалтгүй, няцаагүй хүчин зүтгэсэн*” (Ү.Хүрэлбаатар) хэмээн судлаачид үнэлжээ.

Ч.Билигсайхан эрдэм судлалын ажлын зэрэгцээгээр бүх нийтийн гоо зүйн боловсрол, утга зохиол, урлагийн боловсролыг дээшлүүлэх, соён



THE CULTURAL WAY

гэгээрүүлэх чиглэлд тууштай ажиллан “Монгол романы талаар эргэцүүлэхүй”, “Монгол хүүрнэл зохиолын өнөө маргааш”, “Шинэ зууны утга зохиолын өнгө төрх” зэрэг 130-аад эрдэм шинжилгээний өгүүлэл, уран сайхны шүүмжлэл бичжээ. Тэр бээр эрдэм судлалын ажил туурвихын зэрэгцээгээр багшлах үйлсэд нэгэн мөр зүтгэж 2 доктор, 40-өөд магистрын ажлыг удирдан хамгаалуулсан байна.

МУИС-ийн профессор, уран зохиолын онолч, шүүмжлэгч Ч.Билигсайхан агсан бол монголын орчин үеийн уран зохиол судлалын түүхэнд тодрон гарсан цөөхөн судлаачдын нэг, үндэсний уран зохиолын нэгэн үеийг хөтлөн замчилсан нэрт шүүмжлэгч, олон мянган шавь нараа сурган хүмүүжүүлсэн эрдэмтэн багш билээ. Бид энэхүү өгүүлэлд түүний монгол уран зохиол судлал, шүүмжид оруулсан хувь нэмрийн тухай өгүүлэхийг хичээлээ. Сэдвийн судлагдсан байдлын хувьд бидний олж үзсэнээр 2009 онд ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгээс эрхлэн гаргадаг “XX зууны монгол зохиолчид” цувралын 46-р ботид түүний намтар уран бүтээлийн талаар Д.Өлзийбаяр бичсэн байна. Түүнчлэн “Уран зохиол судлал” сэтгүүлийн XXV ботид судлаач Ц.Банзрагч “Уран зохиол судлаач шүүмжлэгч Чойжилжавын Билигсайхан” (2001) хэмээх өгүүлэл бичжээ. Мөн “МУИС”-ийн профессорын эрдмийн өв” цувралаар түүний бүтээл туурвилын эмхэтгэлийг 2 ботиор гаргасан байна.

1. Судлаач, шүүмжлэгч Ч.Билигсайханы намтарын товч

Чойжилжавын Билигсайхан нь Хөвсгөл аймгийн Галт суманд 1946 онд төржээ. Энэ талаар тэр бээр өөрийн бичсэн намтартаа: *“Би 1946 оны намар оройхон өвөлжөөнд буухын өмнөхөн төрсөн юм гэнэ лээ. Сар өдрийг аав ээж тодорхой мэддэггүй байлаа. Тэр үед манай нутаг Сайн ноён хан аймгийн Далай Чойнхор вангийн хошуу байв. 1931 оноос Архангай аймгийн Идэр сум болов. Би Идэрийн голын хөвөө доод бургаст гэх жалгад төрсөн юм. Миний өвөг эцэг тайж гаралтай Жамсран гэж хүн байсан. Тэр хүн хоёр хүүтэй байсан нь Чойжилжав, Намсрайжав нар юм. Би Чойжилжавын хүү, айлын ганц хүү байжээ. Аав минь Жамсран тайжийн хүү болон 1914/1915/ онд төрсөн юм. Аав багаас лам болж Хөөнгийн хүрээнд, Бадмаанямбуу уулын энгэрт хорь шахам жил суусан юм. Хүрээ тарахад аав маань хөдөөлж ээжтэйгээ хамт мал маллан амьдрах болжээ. Өвөг эцэг маань өндөр наslaагүй хүн юм. Ер нь манай аав ээж одоогийн Галт сумын Зүрх багийн нутаг Хонхор Хайлааст, Жаргалантын улс юм гэсэн. Онон голын бэлчирээс*



THE CULTURAL WAY

нааш манай хошуунд наян тайж амьдардаг байжээ. Жамсран тэр наян тайжийн нэг байжээ. Ээж минь яг энэ нутгийн Зүрх сумын Очир хиагийн Магсар банди гэгч хүний охин байсан. Би энэ нагац өвөг эцгээ яг дуурайсан хүн юм гэнэ лээ. Ээж аав минь тэгж ярьдаг сан. Манай сум намайг төрсний дараахан Хөвсгөл аймагт харьяалагдах болсон нь учиртай. 1932 оны Тариатын хүрээний алдартай бослого яг манай нутагт болсон юм. Манай Идэр сум 1961 оноос Галт гэдэг нэртэй болсон юм. 1932 оны эсэргүү бослогыг дараад Далай Чойнхор вангийн хошууг гурван аймгийн нутагт хувааж цацсан юм гэнэ лээ. Одоогийн Завхан аймгийн Идэр, Их-Уул, Хөвсгөл аймгийн Галт, Шинэ- Идэр , Жаргалант, Архангай аймгийн Тариат, Цахир, Өндөр улааны хагас зэрэг сумд манай хошууных байжээ” (2022: 6) гэж бичсэн байдаг. Тэр бээр 1955-1965 онд бага дунд сургууль, 1965-1970 онд МУИС-ийн Монгол хэл, уран зохиолын ангийг төгсөөд Хөвсгөл аймгийн Мөрөн хотын дунд сургуульд багшаар ажиллажээ.

Түүнийг уран зохиолын их өргөөнд МУИС-ийн багш, доктор С.Лувсанвандан хөтлөн оруулж, уран зохиолд дур сонирхолтой болгосон агаад 1960-аад онд Ш.Гаадамба, Ц.Мөнх нарын байгуулсан “Залуу шүүмжлэгчдийн нэгдэл”-д орж шүүмж судлалын гараагаа эхэлжээ.

Тэрбээр уран зохиолд хэрхэн хорхойссон тухайгаа: *“Бүр багаасаа ном унших их хорхойтой байж. Манай ангид надтай хамт ном унших дуртай, шүлэг цээжилж концертод унидаг Л.Жанчивдорж гэх хүүхэд байх /хожим гавьяат жүжигчин болсон/. Намайг 9, 10-р ангид байхад Монголын уран зохиолын хичээлийг их сайхан заадаг Цэвээнсүрэн гэж монгол хэлний багш байж билээ. Миний нагац өвөг Магсар маш их, сайхан хууч ярьдаг хүн байж билээ. Энэ мэтээс болж би 10-р анги төгсөөд МУИС-ийн монгол хэл, уран зохиолын ангид дурлаж байж орсон юм. Намайг 10-р анги төгсөх үеэр “Соёл, утга зохиол” сонинд М.Гаадамба, Ч.Лодойдамба хоёрын Д.Нацагдоржийн “Ламбугайн нулимс” өгүүлэгийн талаарх маргаан ид хэвлэгдэж байж билээ. Энэ үеэс судлал шүүмжлэлийг нэлээн сонирхдог байсан. Энэ үед МУИС-ийн Монгол хэл, уран зохиолын тэнхимийн эрхлэгч М.Гаадамба байв. Энэ хүн таван жил уран зохиолын талын бараг бүх хичээлийг өөрөө заасан юм. 1967 оны намар Зохиолчдын хорооны Шүүмжлэл судлалын зөвлөлийн эрхлэгч Ц.Мөнх гэдэг хүн Гаадамба багштай хамт манай ангид ирж залуу шүүмжлэгч бэлтгэнэ гэж сонирхсон хүмүүсийг нэлээд*



THE CULTURAL WAY

ятгаж цуглуулсан юм. Энд манай ангиас Л.Нямаа, Т.Галсан, Чулуунбаатар бид хэд элсэж билээ” (2022: 6) хэмээн дурссан байна.

Ийн тэр бээр 1967 оноос анхны шүүмжээ бичиж, уран зохиол судлал, шүүмжийн салбарт хөл тавьжээ. Тэр бээр “Хөгжмийн эгшиг” шүүмждээ Ж.Пүрэвийн “Хөгжмийн эгшиг” романыг “*Өвөрмөц сэдэвтэй боловч тавьсан асуудлаа хэтэрхий хөнгөн шийдсэн, харьд цагаачилж тэнэсэн хүний эх орноо гэх санааг өнгөц гаргаж, -Эх орон гэж юу юм бэ? Сайнбилиг яагаад “төрсөн газрын шороо алт” гэх болов гэдэг нь ер дүрслэгдээгүй байна*” (1976: 22) гэхчлэн маш зоримог шүүмжлэн, алдаа оноог нь үнэн зөв дүгнэсэн байна.

Анхны шүүмжээ хэрхэн хэвлэгдсэн тухайд тэр бээр “Ц.Мөнх багш: *“Та нар онол номыг нь үзэж байгаа хүмүүс зүгээр шууд шүүмж бич, би түүнийг чинь үзэж зөвлөнө” гэв. Ингээд би нэлээд нухаж байж зохиолч Ж.Пүрэвийн “Хөгжмийн эгшиг” романы тухай нэг юм бичив. Багш маань улаан эрэн болтол хэд хэд засаад “Утга зохиол, урлаг” сонинд хэвлүүлсэн билээ. Энэ миний анхны сонинд гарсан шүүмж байв. Явц дундаа залуу шүүмжлэгчдийн нэгдэл нэртэй болж Д.Өлзийбаяр, Х.Сампилдэндэв, Б.Цэдэв, Ч.Дагвадорж, Ч.Энхдалай зэрэг хүмүүс нэгдэж бичсэн шүүмжүүдээ хэлэлцдэг болсон. 1968 оноос “Утга зохиол, урлаг” сонин, “Цог” сэтгүүлд залуу шүүмжлэгчдийн булан гэдгийг тогтмол шахам гаргаж хэвлэдэг боллоо. 1968 онд би 5-6 шүүмж хэвлүүлж “Утга зохиол урлаг” сонины оны шагналыг хүртэв. Ц.Мөнх багш л биднийг урамшуулах зорилгоор хийсэн хэрэг. 1967-1969 оны хооронд бидний шүүмж төвийн хэвлэлүүдэд олонтоо гарч их л дуулиан шуугиантай болов. Сүүлдээ ч зохиолчид шүүмжийг тэр бүр үзээгүй байснаас баахан ад үзэж биднийг “Мөнхийн улаан хамгаалагчид” гэгцээх болов. Тэр нь нөгөө Хятадад соёлын хувьсгал болж баахан залуусыг улаан хамгаалагчид хэмээн дэвэргээж байснаас үүдэлтэй” (2022: 7) хэмээн дурсжээ. Тэр бээр 1972-1973 онд Москва хотод М.Горькийн нэрэмжит утга зохиолын дээд сургуулийн дэргэдэх Утга зохиолын дээд курст суралцаж төгсжээ. 1974-1995 он хүртэл МЗЭХ-ны “Утга зохиол урлаг” сонины утга зохиолын ажилтан, нарийн бичгийн дарга, МРТУХ-д ерөнхий редактор, МУИС-д багш, Унгар улсын Будапешт хотын их сургуульд монгол хэлний багш зэрэг ажлыг хийж ирсэн ба 1995 оноос Унгар Улсын Их Сургуульд багшилж байв. Энэ үеийнхээ талаар тэр бээр: “1970 онд Их сургуулиа төгсөөд шууд*



THE CULTURAL WAY

Монголын Зохиолчдын Эвлэлийн хороонд хуваарилагдаж очив. Анх сургууль төгссөн залуухан хүнийг Зохиолчдын хороо авч байгаа нь анхных. Энэ маань Ц.Мөнх багшийн ач. Ингээд би насан турш судлал шүүмжлэлтэй зууралдах ажлаа эхэлсэн юм. 1971 онд Москвад Утга зохиолын дээд курст намайг явуулсан. Хорин хэдтэй залууг гадаадад дээд курст явуулж байгаа анхны тохиолдол байсан юм. Дээд курс төгсөөд Зохиолчдын хороонд 10 жил, “Утга зохиол урлаг” сонины сурвалжлагч, хариуцлагатай нарийн бичгийн даргаар ажиллав. Энэ үед сонины эрхлэгч С.Эрдэнэ гуай байсан нь надад их аз болсон юм. Ер нь бол энэ хэдэн жилд С.Эрдэнэ, Б.Явуухулан, Ц.Гайтав, Л.Чойжилсүрэн, Д.Мягмар, Д.Тарваа, Л.Түдэв, С.Удвал, Д.Содномдорж, Д.Намдаг, Ч.Лхамсүрэн, Д.Наваансүрэн зэрэг ахмадууд, П.Пүрэвсүрэн, П.Бадарч, Жан.Шагдар, Ш.Цогт, Б.Лхагвасүрэн, Д.Цоодол зэрэг үеийнхэнтэйгээ ойртон танилцаж уран бүтээлийг нь ойроос харж үерхэж нөхөрлөсөн маань хойшдын уран бүтээлд минь онцгой таатай нөлөөлсөн”¹ хэмээсэн байдаг.

1987 онд “Монголын уран зохиол дахь малчны дүрийн хувьсал” сэдвээр хэл бичгийн ухааны доктор (Ph.D)-ын, 1997 онд “Монгол түүхэн уран зохиол” сэдвээр шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэрэг хамгаалж, 1995 онд доцент, 1996 онд профессор цол хүртсэн байна.

Тэр бээр МЗЭ-ийн 1993 оны шагнал хүртжээ. “Эрин цагийн амьсгал” (1976), “Орчин цагийн монгол роман” (1981), “Уран чадварын нууц” (1982), “Монгол уран зохиол дахь малчны дүрийн хувьсал” (1990), “Арван хөрөг”, “Монгол эрхи товчис”, “Ухаарахуй”, “Бичгийн мэргэдийн билгүүн товчоо”, “Цагийн салхи асгарсан авьяас” болон ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгээс эрхлэн хэвлүүлсэн “Монголын орчин үеийн уран зохиолын түүх-I, II, III боть”-ийн үндсэн зохиогчоор оролцсоноос гадна ШУАийн Хэл зохиолын хүрээлэнгээс эрхлэн нийтлүүлдэг “XX зууны монгол зохиолчид” цуврал бүтээлийн 32 (Л.Чойжилсүрэн), 40 (С.Лувсанвандан), 71 (Д.Төрбат), 74 (Д.Батбаяр), 98 (С.Эрдэнэ)-р боть буюу нийт 5 ботийг бичсэн байна.

¹ Ч.Билигсайхан. 2022. *Бүтээл туурвилын эмхэтгэл I боть*. МУИС-ын Профессорын эрдмийн өв цуврал. Эрхлэн хэвлүүлсэн Д.Заяабаатар, эмхэтгэж, хэвлэлд бэлтгэсэн Г.Нарантунгалаг. Уб., 7 дугаар тал.



THE CULTURAL WAY

II. Ч.Билигсайханы уран бүтээлийн голлох амжилт, монгол уран зохиол судлал, шүүмжид оруулсан хувь нэмэр

Монголын уран зохиолыг “малчны дүр”-ийн хувьслаас модерн утга зохиолын онол хүртэл нь судалж, утга зохиолын судлал, шинжлэлийн салбарт дагнасан өвийг цогцлоосон Ч.Билигсайхан профессорын “Монгол түүхийн уран зохиол”, “Монгол түүхэн зохиол” бүрэлдсэн монгол арга, төрлийг сурвалжилсан “Монгол эрхи товчис” (2000) хэмээх суурь бүтээлийг нэн тэргүүнд онцлууштай. Учир нь уран зохиолыг, тэр дундаа дорнын уран зохиолыг үечлэх дэлхийн жишгийг он цагийн хувьд шинээр бичих, өөрчлөх шаардлагатайг эх зохиол болон хэл, бичгийн баримт, дурсгалуудаар нотолж өгсний хувьд энэ номыг давын өмнө нэрлүүштэй. Улмаар уг туршлагаа баяжуулан шинэ үеийн уран зохиолын онол, чиг хандлагыг танилцуулсан “Ухаарахуй” (2004) номоо хэвлүүлсэн нь суурь судалгаанд үндэслэсэн нэн шинэлэг бүтээл байсан юм. Шүүмжийн олон уран бүтээлээс нь “Монголын уран зохиол дахь сэргэн мандалтын үеийг тодруулах асуудалд”, “Монголын сонгомол /элит/ зохиолын уламжлал”, “Монголын уран зохиолын соён гэгээрүүллийн үе” хэмээх цараатай цуврал өгүүллүүдийг дурдаж болно. Тэр бээр дэд эрдэмтний зэрэг хамгаалсан бүтээлээрээ 1990 онд “Монголын орчин үеийн уран зохиол дахь малчны дүрийн хувьсал” гэсэн ном, шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан бүтээлээрээ “Монгол эрхис товчис” (2000) ном тус тус хэвлүүлжээ.

III. Ч.Билигсайханы монголын хүүрнэл зохиолын шүүмж судлал

Ч.Билигсайханы судалгааны нэг гол чиглэл нь хүүрнэл зохиол, тэр дундаа монгол романы судалгаа байв. Тэр бээр энэ тухайгаа “*Би анхны шүүмжээсээ эхлэн гол төлөв романыг судалж, шинжилж бичиж байлаа. Их сургууль төгсөхдөө ч монгол роман судалсаар диплом хамгаалсан юм. Шинэ үеийн уран зохиолын түүхэнд гарсан романуудыг нэлээд судалж, 1981 онд “Орчин цагийн монгол роман” судалгааны жижиг ном хэвлүүлэв. Тэр үед гарсан зуу шахам романыг нэлээдгүй эргүүлж тойруулж судалсан бүтээл энэ юм. Түүнээс хойш ч романы судлалаар нэлээд өгүүлэл судалгаа бичсэн. Эдгээрийн үр дүнд “Монголын орчин үеийн уран зохиолын түүх” гэдэг гурван боть номд романы хэсгүүдийг би бичсэн юм. Зөвлөлтийн эрдэмтэн Л.К.Герасимович “БНМАУ-ын утга зохиол” номынхоо 2-р дэвтэрт миний романы судалгаануудыг гол болгож ашигласан тухайгаа дурдаж*



THE CULTURAL WAY

үнэлж дүгнэсэн билээ. Энэ завсар “Уран чадварын нууц”/1983/, “Уран бүтээлчийн ертөнц” /1988/ зэрэг яруу найраг өгүүллэгийн түүврийн тухай бичсэн номоо хэвлүүлсэн билээ”² хэмээн дурссан байдаг.

Түүний анхны шүүмжийн түүвэр 1976 онд “Эрин цагийн амьсгал” нэртэйгээр хэвлэгджээ. Энэ түүврийн “Роман ур чадвар” гэсэн тэргүүн бүлэгт үргэлжилсэн үгийн 10 гаруй зохиолд шүүмж бичиж, “Сүүлийн үеийн роман” нэртэй тууж олишрч мэдэхээр болж байна. Эдэнд романы хэмжээ шаардлага тавиад задалж үзэхэд чамлагдаж байна” гэж дүгнэсэн байна. Мөн зохиолуудын дүрийн боловсруулалтад ажиглалт хийсэн байна. Тухайлбал, “Ж.Пүрэвийн “Гурван зангилаа” романы Хасбаатар гэдэг түүхэн дүрийг “ижил нэртэй гараа зангиддаг адил хэвшилтэй гурван өөр зан байдал үзэл бодолтой хүний дүр гарчээ” гээд “энэ дүрийн хөгжилтөнд бага анхаарснаас болжээ (1976: 17) гэж дүгнэсэн байна. “Бас олон зохиол боловсруулалт муутай, болхи найруулгатай мохоо үг хэллэг, ойлгомжгүй үг өгүүлбэр элбэг байна” (1976: 34) гээд тэр ч байтугай “резерв, проводник, купей, зажигалок гэх мэт үгсийг бэлэн зэлэн монгол үг байсаар байтал тэр чигээр нь хэрэглэсэн” (1976: 35) гэх зэргээр шүүмжилсэн байна.

Тус номын “Эрэн цагийн амьсгал” гэсэн хоёрдугаар бүлэгт: ХХ зууны хоёрдугаар хагасын үеийг монголын аж үйлдвэр, хөдөө аж ахуйн өөрчлөлт шинэчлэлт, шинэ хүний дүр төрх, ёс заншил сэтгэл санааны өөрчлөлтийг яруу тод уран сайхны үнэмшилтэй дүрслэх талаар олж байгаа ололт дутагдлыг арваад зохиол дээр шүүн бичсэн байна. Эл номын эхний бүлэг шүүмжийн хурцхан өнгө аястай байсан бол сүүлийн бүлэгтээ уран зохиолыг цаг үе нийгэмтэй нь холбосон судалгааны аястай болсон нь “судлаачийн бичих арга барилд гарсан өөрчлөлт” гэж судлаач Ц.Банзрагч үзжээ.

Ч.Билигсайханы удаах ном нь 1981 онд бичсэн “Орчин цагийн монгол роман” гэдэг бүтээл юм. “Монголын уран зохиолын түүхнээ 1930-1940-өөд оны үед томоохон туужууд бичигдэж, 1949 онд Ч.Лодойдамба “Алтайд” гэдэг бэсрэг роман, 1950 онд Б.Ринчений “Үүрийн туяа” хэмээх (бүрэн хэмжээний) гурван дэвтэр роман хэвлэгдэж гарснаар роман бичлэгийн шинэ үе эхэлсэн” гэж тэр бээр үзжээ.

² 7



THE CULTURAL WAY

Анхны шүүмж, анхны номоосоо эхлэн үргэлжилсэн үгийн томоохон төрлийг голлон судалж, шүүмжилж асан судлаач бээр уг бүтээлдээ, шинэ уран зохиолын түүхнээ гарсан анхны романаас эхлээд, 1970-аад оны сүүлч үе хүртэлх бүхий л романыг судлан үзэж, түүхэн үед бүрэлдэн тогтсон роман хөгжлийн явц, түүхэн онцлогийг тоймлон дүгнэж, амьдрал түүхийн үнэнийг уран сайхнаар боловсруулан дүрийг бүтээх томоохон туршлага болсноор барахгүй, уран зохиолын цаашдын хөгжилд нөлөөлсөн, дүрийнхээ сэтгэхүйд нэвтэрч тэдний дотоод сэтгэл, бодол санаа, учир шалтгаант хөгжил хувьслыг үзүүлэх талаар амжилт олсон зэргийг гярхай ажиглан, онолын үндэстэй зөв зүйтэй дүгнэлт хийжээ. Тэр бээр *“Өмнөхийнхөө ололт доголдлыг зайлигүй тунгааж үзэж түүнээс илүү байх ёстой гэдэг шаардлагыг хожмынх нь зохиолчдод хүлээлгэх ёстой юм”*. *“Манай гэсэн хэмжүүрийг өнөө үеийн юм уу энэ зууны гэсэн арай илүү далайцтай хэмжүүрээр солих цаг болжээ”* гэсэн шаардлага тавьж энэхүү номоо туурвижээ. Энэ ном судалгааны бүтээл боловч дээрх шаардлагын үүднээс шүүмжийн өндөр түвшинд бичигджээ.

Ч.Билигсайхан “Ур чадварын нууц” (1983) зохиолчийн уран чадвар, урлах эрдэм, авьяасын тухай Д.Нацагдорж, Д.Намдаг, Ч.Лодойдамба, С.Эрдэнэ зэрэг ахмад дунд үеийн болон бусад олон залуу зохиолчдын уран бүтээлээс жишээ татаж, шүүмжлэл судлалын өгүүлэл 20 шүүмж оруулсан байна. Эдгээртээ хэв шинжит дүр бүтээх, уран дүрийн зан байдлын хөгжлийн логик уялдааг дотоод зүй тогтлын дагуу хөгжүүлэх, дүрийн сэтгэлийн ертөнцийг гаргах талаар шинэ санал дүгнэлтийг дэвшүүлж, *“урлах эрдэм бол уран бүтээлийн сүнс”* гэж үзжээ.

Мөн *“зохиолч, шүүмжлэгч хоёрын уран бүтээл олон талаараа ялгаатайн дотроос гоо сайхны үзэл бодлоо илэрхийлах арга хэлбэр нь өвөрмөц байдаг байна. Зохиолч оюун ухаандаа хуримтлагдаад хэлэхгүй байж чадахгүй болсноо бичдэг бол шүүмжлэгч зохиолчийн бүтээлээр дамжуулан гоо сайхныг гүйцэд ойлгоод түүгээр дамжуулан гоо сайхны үзэл бодлоо илэрхийлдэг билээ. Хүний нээсэн гоо сайхныг гүйцэд ойлгоод түүгээр дамжуулан өөрийн бодлоо хэлнэ гэдэг “үнэхээр ахадсан ажил. Гэвч энд нэгэнт хөнгөлөлт байдаг нь авьяас төгөлдөр зохиолч жирийн хүнд нээгдээгүй тэрхүү гоо сайхан руу хүний оюун бодлыг “хөтлөн залдаг” гэж сонирхолтой ажиглалт хийсэн байна.*

Тэр бээр авьяаслаг зохиолчидтой насан туршид холбоотой байж, зохиолчдын байгууллагад нэгэн арван (1972-1982) жил ажиллаж



THE CULTURAL WAY

зохиолчдын нээсэн гоо сайхныг гүйцэд ойлгоод түүгээр дамжуулан өөрийн бодлоо хэлдэг “ахадсан” ажлаа хийж байхдаа БНМАУ-ын төрийн шагнал хүртсэн Д.Намдаг, Ч.Лхамсүрэн, Ч.Чимид, Б.Явуухулан, Ц.Гайтав, С.Эрдэнэ, Л.Түдэв, Д.Пүрэвдорж, С.Дашдооров, Д.Мягмар нарын уран бүтээлийг судлан шүүж, ойртон дотносож байсан тухайгаа өгүүлсэн “Арван хөрөг” нэртэй номыг туурвижээ. Монгол оронд төдийгүй тив дэлхийд бүтээл нь хэвлэгдсэн дээрх зохиолчдын уран бүтээлээр хийсэн хөргүүд нь тэдний зан байдал, урлан бүтээх арга барил, бүтээсэн дүр нь янз янз боловч, ард түмнийхээ амьдрал тэмцлийн дүр төрхийг үгийн уран, авьяас билгийнхээ ид шидээр мөнхжүүлэн үлдээж чадсан авьяастнууд болохыг баталж чадсан байна.

1988 онд хэвлүүлсэн “Уран бүтээлийн ертөнц” номдоо “Дондогийн Цэвэгмид” гэсэн хөрөг, “Их тээлийн даваа”-нд уулзсан шинэ танилууд”, “Далайд давалгаан, айрагт хөдөлгөөн чухал”, “Найргийн хүлгийн ган дөрөө”, “Гэгээн өглөөний шүлгүүд”, “Ийм хур буух ёсгүй” зэрэг шүүмжийн хамт, роман судлалаа үргэлжлүүлж, тухайн үед ихэд хөгжиж байсан түүхэн романы тухай хэд хэдэн өгүүлэл оруулжээ. “Уран сайхны түүхэн зүйн зарчим нь шинжлэх ухааны түүхэн зүйгээс чанарын ялгаатай” гэж үзээд “түүхийн аль нэг үеийн хөгжлийн зүй тогтлыг томъёолон гаргах бус, түүхийн явц, хүмүүсийн зан байдал, ухамсарт хэрхэн яаж тусаж үлдэв гэдгийг нарийвчлан дүрслэхэд уран бүтээлчдийн зорилго оршдог билээ” гэж тэмдэглээд “Түүхэн зүйн зарчим гэдэг бүхэлдээ уран сайхны бүтээлд бодит байдлыг тусгах тухай тодорхой бүрэлдсэн зарчим юм. Түүхэн үйл явдал хүмүүст яаж нөлөөлснийг гадна талаас нь үзүүлснээр түүхэн зүйн зарчим хэрэгжихгүй. Харин бүхэл бүтэн дүрийг түүхт тодорхой агуулгаар биежүүлэн дүрсэлж үзүүлснээр сая жинхэнэ сайн уран бүтээл төрдөг жамтай ажээ” гэж дүгнэсэн байна. Мөн тэр бээр “Мандухай цэцэн” романы тухай бичсэн өгүүлэлдээ түүхэн баримтыг уран зохиолд яаж ашиглах талаар болоод түүхт роман, түүхэн сэдэвтэй роман гэсэн санааг дэвшүүлсэн нь баримтат зохиол тэргүүлэх байрт гарсан бөгөөд өнөө үед ч улам ч сонирхолтой болж буйг илэрхийлжээ.

II. II. Ч.Билигсайханы монголын эртний уран зохиол судлал

Ч.Билигсайхан амьдралынхаа сүүлийн арав гаруй жил эрхи товчис болон түүхэн уран зохиол судалжээ. Мөн монголын уран зохиолыг үечлэх асуудалд өөрийн саналаа дэвшүүлсэн “Монголын уран зохиолын түүхийг үечлэн судлах нь” (1995), “Монголын уран зохиол



THE CULTURAL WAY

дахь сэргэн мандлын үеийг тодруулах асуудалд” (1988) зэрэг өгүүлэл хэвлүүлжээ. Аливаа үндэстний уран зохиолын үүсэл хөгжлийг ардын аман зохиолтой холбож тайлбарладаг билээ.

Ч.Билигсайхан аман зохиол бичгийн зохиолын холбоо хамаарлын талаарх судалгааны ажилдаа “...монгол сонгомол уран зохиол нь өөрийн үзэл санаа, илэрхийллийн тодорхой чиглэл хандлага, урлахуйн нарийн арга барил, бичлэгийн үнэн магадтайг баримт түүх, заримдаа илэрхий үнэн хэрэг явдлаас юм уу түүний “цуурайнаас” төрсөн шүлэг дуу, битүү далд утгатай домог хуучаар орлуулан гаргаж, эрхилэн хэлхэх замаар гагцхүү болсон явдал, үнэн түүхийг үзүүлэх зарчимд хатуу захирагдаж иржээ (2010: 7) гэх буюу “Эрхи товчист монгол бичээчид ид шидийн маягийн этгээд дүр дүрслэл нэлээд оруулдаг. Тэр нь бичээчийн санаанаасаа зохиосон зүйлс мэдээж биш, эртний домог, хууч, үлгэр, түүхээс авсан зүйлс. Тэдгээрийг нарийвчлаад үзэхээр ихээхэн нууц далд учир утга агуулсан, өнөөдөр этгээд гажууд ид шидийн мэт санагдах боловч алс хойчдоо нууц нь нээгдээд, учир нь тодроод ирж магадгүй зүйлс олон. Эдгээрийг хүн санаанаасаа зохиогоогүй түүхийн учир шалтгааны үүднээс байж мэдэх хувь тавилантай зүйлс байдаг. Түүхийн ой дуртгал, ухаан, логик гэдэг хичнээн их авьяас билигтэй ч гэсэн хувь хүнийхээс ямагт илүү гүн гүнзгий байдаг” (2010: 176-177) гэх мэтээр аман зохиол түүний дотор домог хийгээд бичгийн уран зохиолын холбоо хамаарлыг дурдсан байдаг.

Монгол үндэстний уран зохиолын үүсэл гарлын тухай эрдэмтдийн санал дээр Ч.Билигсайхан доктор шинэлэг олон санал дэвшүүлэн гаргажээ. Энэ нь “манай эриний өмнөх 3-р зууны орчмоос монголын эртний аймгууд “Кемү” хэмээх өвөрмөц бичиг хэрэглэн мод чулуунд өөрсдийн үг эшээ бяцан (бичиж) байснаа эдүгээгийн бичээч гэдэг үг хүртэлх урт удаан хөгжлийг туулжээ. Тэр үеийн “бяцаач” (бичээч) гэдэг үг эдүгээ зохиолч түүхч болсон гэдэг дүгнэлтэд хүрчээ. Мөн энэ үеэс удмын эш, судруудыг нэгтгэх (товчоолох) түүнээ утгын утсанд хэлхэн эрхилэх ажлын эхлэл тавигдсан” гэж үзжээ. Энэ эш удмын бичгээс түүхэн уран зохиол үүсэж, өөрөөр хэлбэл угийн бичиг, хад чулуу, пайз тамгын бичээс, овог аймгийн бичмэл, удмын судар, монгол намтар гэх мэтчилэн боловсрол хөгжин, XVII-XVIII зууны үед эрхи товчис болсон гэж үзсэн байна. “Монгол уран зохиолын эхлэл болсон товчис эрхсээс XX зуунд түүх, уран зохиол гэж салсан байна. Монголчууд түүхэн цаг үед болсон, түүхтэй сургамжтай хэрэг явдлыг товч оновчтой үнэн зөв илэрхийлсэн хэдэн мөр шүлэг дуунд багтаан үе



THE CULTURAL WAY

улируулан цээжлэх буюу тэмдэглэдэг байжээ. Түүний бичээч нар товчоолон бичдэг, товчоолсон түүх шүлэг тайлбарыг шүүн тунгааж дараалалд оруулан эрхилдэг байна. Шүлэг үргэлжилсэн үг хослон бичсэн түүхт үйл явдлын гэрч товчис нь эрхис нь монголчуудаас хүн төрөлхтний соёлд оруулсан нэгэн өвөрмөц хувь нэмэр” гэж баталжээ.

Тэрбээр монголын эртний уран зохиолын судалгааныхаа талаар “1990-ээд оны эхнээс Монголын эртний уран зохиолын түүхэн дэх түүхэн баримтат уран зохиолуудыг судалж эхэлсэн. Энэ судалгаандаа Өвөр монголын профессор Б.Гэрэлт, Оросын эрдэмтэн Г.Михайлов, Л.Скородумава зэрэг эрдэмтэдтэй нягт холбоотой ажиллаж Монголын түүхэн зохиолуудыг гарал үүслийн хувьд болон тэдгээрийн төрөл зүйлийг тодорхойлж түүх уран зохиолын нэн өвөрмөц сонин дурсгал болохыг нь тодруулан нэлээд цаг зав хөдөлмөр гаргаж судлав. Энэ судалгаанд Унгарын эрдэмтэн Д.Кара, Монголын академич Д.Цэрэнсодном, Өвөрмонголын профессор Б.Гэрэлт нар олон удаа уншин танилцаж зөвлөж байснаар 1998 онд “Түүхэн уран зохиол бүтээх монгол арга бүрэлдсэн нь” гэсэн сэдвээр хэл бичгийн шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалав. Энэ бүтээлийг маань Монголын уран зохиол судлаач гадаад дотоодын судлаачид нэлээд өндөр үнэлсэн юм. Энэ үнэлэлт нь: 1. Монголын түүх, уран зохиол хоёр XIX зуун хүртэл тодорхой зааг ялгаагүй хөгжиж ирсэн ба эдгээр түүхэн зохиолуудыг “бичээчин” гэдэг тусгай мэргэжлийн хүмүүс бичиж туурвиж байжээ. 2. Эртний Хүннү улсын үеэс Кемү гэдэг үсэг хэрэглэгдэж үүгээр хад чулуу модон тамга найз, хөшөө дурсгалын үг үсгийг сийлбэрлэн бичиж ирсэн нь нэн олон бөгөөд энэ нь монгол нутгаас олон арваар олдсоор байгааг түүхэн уран зохиолын дурсгал гэж үзжээ. 3. Монгол түүхэн уран зохиол нь нэн эртнээс үүсэлтэй бөгөөд анхны бичиг, хадны бичээсээс эхлээд эрх товчоон хүртэл тодорхой ялгаа бүхий төрөл жанруудтай маш өвөрмөц бичгийн зохиолын бүхэл бүтэн сан хөмрөг юм гэдгийг нотолсон бөгөөд Нийтийн тооллын II зууны үеэс эх үүсэл нь тавигдсан юм гэдгийг баримтаар нотолжээ гэсэн гол хэдэн дүгнэлтийг гадаад, дотоодын эрдэмтэд хүлээн зөвшөөрсөн юм. Энэ судалгаагаа “Монгол эрх товчис” нэрээр 2000 онд хэвлүүлэв. Монголын соёлын түүхэнд угийн бичиг удмын судраас эхлээд эрх товчис хүртэл буюу Чингисийн чулууны бичгээс аваад овог ураг бүхний угийн бичгүүд хүртэл олон зуун түүхтэй уран зохиолын дурсгал Монголд бий бөгөөд томоохон төрөл болох эрх товчис нь “Монголын нууц товчоо”, “Алтай товч”, “Шар тууж”,



THE CULTURAL WAY

“Асрагч нэртнийн түүх” гэх мэтчилэн нэн өвөрмөц түүх, уран зохиолыг салгаж үзээгүй хольцолдуулан бичсэн, дэлхийд хосгүй түүхэн уран зохиолын дурсгалыг монголчууд бүтээсэн бөгөөд дэлхий дахинаараа өнөөдрийг хүртэл сонирхон судалсаар байна. Энэ судалгаа нэг хүний дуусгах хялбар судалгаа биш. Цаашидаа олон эрдэмтэн монголын түүхэн уран зохиолыг судлах нь лавтай” (2022: 8) хэмээсэн байдаг.

II. III. Ч.Билигсайханы орчин үеийн уран зохиолын онол, шүүмжийн судалгаа

Дэлхийн уран зохиолын хөгжлийн түүхэнд XIX зууны хоёрдугаар хагасаас урлахуйн шинэ чиглэлүүд бий болж, XX зууны эхээр модернизмын үзэл санаа туурвил зүйд нэвтрэн дэлхийн урлаг, соёл, уран зохиол, шинжлэх ухааны салбаруудыг хамарсан том хөдөлгөөн болж төлөвшсөн билээ. Амьдралыг учир зүйн дагуу бодчилон өгүүлдэг зарчим бүхий реалист сэтгэлгээнээс чөлөөт сэтгэлгээний зарчим буюу хийсвэрлэх, хэлбэрдэх, бүтэцлэх, ондоошуулах, бэлгэдэх зэрэг бодгүйчлэх янз бүрийн арга зарчмын цөм нэгдэл болсон модерн урлаг, уран зохиол дэлгэрч, улмаар 1960-аад оны орчим дээрх чиглэл “пост” үе рүүгээ шилжиж, энэ үе шат ч эдүгээ хуучирч “мета модернизмын үе” иржээ. Хүн төрөлхтний утга соёлын ертөнцөд бий болсон энэ өв сангийн тухай буюу модернизмаас постмодерн үеийн урсгал чиглэлийн тухай танилцуулсан судалгааны ажил бол Ч.Билигсайханы “Ухаарахуй” (2004) бүтээл юм. Тус номын онолын ололтын талаар нэрт шүүмжлэгч, Монгол Улсын Төрийн шагналт, профессор Д.Цэнд “МУЗ-ын түүхнээ онолын сэтгэлгээний шинэ хандлагыг нээж байгаа энэ бүтээл уран зохиолын мөн чанарын асуудал, түүний өвөрмөц онцлог, уран зохиолын дүр, буюу хүний өвөрмөц зан төрхийг дүрслэх чадвар, уран зохиолын аймаг, төрөл зүйл, зохиолчийн шидэт мэдрэмж, онгод зэрэг олон ойлголтод өмнө баримталж ирснээс өөрөөр өргөн хүрээнээ эргэлзээ ээдрээт, зөрчилт байдалд дэвшүүлэн тавьж маргах, шүүмжлэх, талархах, эсэргүүцэх сэтгэгдлийг зүй ёсоор төрүүлж буй нь нэн шинэлэг аястай болжээ. Нөгөө талаар өмнөх үед бидний заншил болсон өрөөсгөл хандлага үгүйсгэл маягаар харьцаж, хөрөнгөтний үзлийг шүүмжлэх нь гэдэг нэрийн дор авах юмгүй муулж ирсэн натурализмын чиглэл, модернизмын чиглэл, постмодернизмын үүсэл, төлөвшил, чиг хандлага, гол төлөөлөгчид, дэлхийн уран зохиолд эзлэх байр суурь, өнөө үед эдгээрийн нөлөөг өгүүлсэн нь бодтой цоо шинэ ойлголтыг бидэнд өгч байна” (Билигсайхан, 2022: 183) хэмээн үнэлсэн байдаг.



THE CULTURAL WAY

Тус бүтээлд утга зохиолын онол шинжлэлийн нарратолог буюу өгүүлэмжийн онол, америкийн “Шинэ шүүмжлэл”-ийнхний баримтлал, рецептив этетика буюу ойлгоцын гоо зүй, гереневтика (тайлал зүйн онол), фенеменологи дэг сургууль (сэтгэхүйн үзэгдлийг тайлах), домог зүйн шүүмжлэл, структурализм, модернизм, постмодернизм, деконструктивизм (бүтцийг үгүйсгэхүй), постструктурализм гэх мэтийн онолын чиглэлүүдийг танилцуулж, ерөнхий ойлголтуудыг тайлбарласан нь ихээхэн шинэлэг судалгаа болсон байна.

Харин “Бичгийн мэргэдийн билгүүн товчоо” номдоо утга зохиолын онол шинжлэлийн дэг сургуулиудын талаар дэлгэрэнгүй өгүүлсэн нь бий. Тухайлбал, херменевтик шинжлэлийн тухайд *“Тайлал зүйн ухагдахуун нь тайлбар /интерпретаци/, ойлгоц хоёр юм. Аливаа эх бичгийг зөв тайлбарлахын тулд юуны өмнө тайлагч (интерпретатор) эх бичгийн гадна талын хүчин зүйлд бус харин түүнийг уншаад төрж байгаа ойлгоцдоо бүр тодруулбал, өөрийн зөн мэдрэмжээ илүү чухалчлах явдал гэж үздэг. Эх бичгийн гадаад орчин болох зохиогдсон газар орон, он цаг, зохиогчийн намтар түүх зэрэг нь тэргүүн зэрэг үүрэггүй гэж тайлал зүйн чиглэлийнхэн үздэг юм”* (2010: 254) гэж уран зохиолын херменевтик шинжлэлд тайлбарлагчийн зөн билиг чухал болохыг тодотгосон байна.

Түүнчлэн психоанализмын шинжлэлийн талаар *“ХХ зууны урлагийн сэтгэлгээнд З.Фрейд, К.Юнг нарын үзэл нээлт үнэтэй нөлөө үзүүлжээ. З.Фрейд хүний далд ухамсрын нөлөө тусгалыг ихэд үнэлсэн бол К.Юнг хүний ухамсаргүй үйл ажиллагааг нь уран бүтээл туурвихад яаж тусалдгийг үнэмшилтэй нотолсон санагддаг. Хүний ухамсаргүй үйл ажиллагаа тодорхой дүрийг бус хүний төсөөллийг таагдамгүй байдлаар хэлбэржүүлсэн схемүүдийг төрүүлж байдаг гэж К.Юнг үзжээ. Энэ схемүүдийг архетип /анхны дүр дүрс гэсэн герег үг/ гэж Юнг нэрлэжээ. Энэ схем ухамсарт орж ирээд сая сэтгэлгээний туршилагаар тодорхой агуулгатай болж ирдэг гэнэ”* (2010: 280-281) гэхчлэн тайлбарласан байдаг нь мөнхүү арга чиглэлийн мөн чанарыг тодруулан, үүрэг нөлөөг нь үнэлсэн хэрэг юм.

Мөн структурализмын шинжлэлийн талаар *“Бүтэц зүйн аргын гол ухагдахуун нь урлагийн бүтээлийн гол үндсэнд байгаа тэмдгүүдийн тогтолцоо, бинар (хос) эсрэгцлийн хэлбэржил зэргийн зүй тогтолыг ухаарснаар сая урлагийн бүтээлийн утга зүйн гүнд нэвтэрч түүнийг зөв танин мэдэж чадах ажээ. Ерөөс урлаг уран зохиолын бүтээлийн*



THE CULTURAL WAY

үнэт чанар нь түүний бүтэц зүйд байна гэж үздэг” (2010: 254) хэмээн бичсэн байна.

Харин деконструктивизмын шинжлэлийн талаар “Ер нь байгууламжийг үгүйсгэх чиглэлийнхний үзэлд суурилоод ерээд оноос пост постмодернизм гэдэг онол гарч ирж байна гэж бичдэг болжээ. /Поль де Мань “Слепота и прозрение” СП. 2002 гэсэн номыг орос хэлээр хэвлэн гаргажээ./ Энэ номд эх бичвэр /текст/-ийг үнэн зөв задлан шинжлэх замаар түүний дотоод зөрчилт шинжид нь зөв нэвтэрч гэмээнэ сая жинхэнэ утга учирт нь хүрч чадна. Бас энд зохиолчийн санаа бодол, уг текстийн илэрхийлж буй утга дээр уншигчийн ухаарч олж авч буй утгыг нэмж байж эх бичвэрийн үнэн утга илэрнэ гэх “текстийн онол”-ын баримтлалыг дэвшүүлжээ” (2016: 81) гэсэн байдаг билээ. Алив тексүүдийн хуучин схемчлэлийг үл хэрэгсэх замаар постмодерн уран бүтээлийг ойлгох боломжтой талаар ийнхүү бичсэн байдаг.

Ч.Билигсайхан нь монголын эрт эдүгээгийн уран зохиолыг судлахаас гадна ирээдүйд санаа тавьж уран бүтээлээ туурвисаар байжээ. Тэр бээр “Шинэ зууны утга зохиолын өнгө төрх” (2000), “Урлаг ойлгох дэлхийн жишиг ба бид” (2001) зэрэг бүтээлүүдээрээ шилжилтийн үеийн уран зохиол болон ирээдүйн уран зохиолд санаа тавьж “зохиолч, яруу найрагч, гүн ухаантнууд энэ цаг үеэ дагаад адилхан хүнийрхээд илтгэл алдраад ирээдүйгээ үзэн ядсан сэтгэлгээгээр зохиолоо бүтээж монгол уншигчиддаа оюун санааны хувьд дахин дарамтлах хэрэггүй юм” гэжээ. Тэр бээр “Чухам өнөөдөр уран сайхны сэтгэлгээний хувьд бид хүн төрөлхтний өнөөгийн хүрсэн өндөрлөг буюу постмодернизм, деконструктивизм, постструктурализмын тэр арга зарчимд угтан тосож нийлэх ёстой” гэж үзсэн нь цаг үеэ мэдрэн таньсан судлаач эрдэмтэн мөнийг харуулж байна. Ер нь сүүлийн үеийн дэлхий нийтийн уран зохиолын хөгжил нь хөнгөн хээнцэр, нийтийн соёл тал руугаа хүчтэй түлхэгдэж буй нь талаар өгүүлээд “Монголын хүүрнэл зохиол сүүлийн арваад жилд элит болоод масс чиглэл рүүгээ илэрхий салах замаар хоёр туйл руугаа тэмүүлж эхлэлээ. Үүнийг гайхах хэрэггүй, жам ёсны үзэгдэл болов уу гэж санаж байна. Үүний зэрэгцээ энэ хоёрын дундуур хээнцэр юм уу беллетристик маягийн романууд ч гарсаар байна. Зохиолч юуны юм уу, ямар сэдэвтэй байх нь уран зохиол судлалд төдий хамаатай бус, харин зохиол болсон эсэх нь хамгийн гол зүйл билээ” (2010б: 169) гэж дүгнэсэн байдаг. Мөн шинэ зууны уран зохиол хэрхэн хөгжих талаар “XXI зуун гармагц зохиомол уран зохиолын



THE CULTURAL WAY

үе дууссан. Одоо жинхэнэ амьдралын тухай, жинхэнэ өөрийн бодол санаагаа бичдэг болжээ. Шүлэг гэхэд л “дотор” би ингэж бодож байгаа, энийгээ л бичдэг. Энэ бичсэн юм миний амь амьдрал, би зохиомол юм бичээгүй. Минийхээр амьдрал ийм байдаггүй, ийм байдаг гэсэн хатуу юм руу уран зохиол очиж байна. Тиймээс Монголд яваандаа “уран” утга зохиол болох шат руугаа явж байна. Эцсийн эцэст дэлхийн утга зохиол баримттай юм руу хөгжиж байна. Өгүүллэг, тууж, роман бүгд эсээ маягийн. Эсээ гэдэг бол арга биш, сэтгэлгээ. Ухаандаа “Би” гэдэг эсээ бичье гэвэл би өөрийнхөө тухай л бичнэ. Миний дотор ийм бодол байна, түүнийгээ л гаргана. Тэгэхээр уран зохиол гэдэг ерөөсөө л бодит амьдрал, Уран зохиол нарийндаа философитой их холбоотой. Гүн ухаан, амьдралын тухай үзлийн цогц болчихгүй юу” гэж бичсэн байдаг.

ДҮГНЭЛТ

Ч.Билигсайхан нь монголын эрт ба эдүгээ үеийн уран зохиолын харилцаа холбоог тодруулж, түүхэн үечлэлийг бичиж, онол, шүүмжийн шинэлэг хандлагыг бий болгосон судлаач шүүмжлэгч юм. Дээрхээс дүгнэн үзэхэд доктор, профессор Ч.Билигсайхны судалгаа шинжилгээний бүтээлийг хамгийн ерөнхийд нь:

1. Монголын хүүрнэл зохиолын шүүмж судлал
2. Монголын эртний уран зохиол судлал
3. Орчин үеийн уран зохиолын онол, шүүмжийн судалгаа гэж 3 ангилан үзэж уран бүтээлийн туршлагыг цаашид дэлгэрүүлэн судлах шаардлагатай юм.

Түүнчлэн түүний бичсэн “Арван хөрөг”, “Сэнгийн Эрдэнэ”, “Сономын Лувсанвандан”, “Дарамын Батбаяр”, “Лхамсүрэнгийн Чойжилсүрэн”, “Бичгийн мэргэдийн билгүүн товчоон”, “Цагийн салхи асгарсан авьяас” зэрэг намтар түүхийн баялаг баримт, задлал, торгон мэдрэмж, өргөн агуулга бүхий олон туурвилууд, “Ухаархуй” зэрэг онолын суурь бүтээлүүд нь хойчийн мэргэдийн ширээний ном болсоор байх нь дамжиггүй биз ээ.



THE CULTURAL WAY

ABSTRACT

Honored teacher of Mongolia, Doctor of Science (Sc.D), professor, literary theorist and critic Ch.Biligsaikhan is a scientist and teacher who has educated thousands of students. He is a researcher and critic who clarified the relationship between early and modern Mongolian literature, wrote a historical periodical, and created an innovative approach to theory and criticism. Ch. Biligsaihn's research and analysis work can be divided into 3 categories: criticism of Mongolian narrative, ancient Mongolian literature, theory and criticism of modern literature.

Key words: *Ch. Biligsaikhan, literary theory, criticism*

НОМ ЗҮЙ

- Аниргүйн нууцыг нээгч Чойжилжавын БИЛИГСАЙХАН. 2016. Эмхэтгэсэн Бямбажав Г. Ред. М.Уянсүх. Дархан, 262 х.*
- Банзрагч Ц. 2001. *Уран зохиол судлаач шүүмжлэгч Чойжилжавын Билигсайхан. Уран зохиол судлал. Боть XXV. fasc. 17. 179-185 х.*
- Билигсайхан Ч. 1976. *Эрин цагийн амьсгал. УХГ. Уб., 148 х.*
- Билигсайхан Ч. 1981. *Орчин цагийн монгол роман. УХГ. Уб., 128 х.*
- Билигсайхан Ч. 1983. *Уран чадварын нууц. УХГ. Уб., 124 х.*
- Билигсайхан Ч. 1986. *Арван хөрөг. УХГ. Уб., 120 х.*
- Билигсайхан Ч. 1990. *МОҮУЗ дахь малчны дүрийн хувьсал. Уб., 183 х.*
- Билигсайхан Ч. 2000. *Монгол эрхис товчис. Уб., 232 х.*
- Билигсайхан Ч. 2000. *Шинэ зууны утга зохиолын өнгө төрх. “Уран зохиол судлал” сэтгүүл боть 7. Уб.,*
- Билигсайхан Ч. 2010. *Бичгийн мэргэдийн билгүүн товчоон. “Адмон” ХХК. Уб., 314 х.*
- Билигсайхан Ч. 2022. *Монгол эрхий товчис & Ухаарахуй. Бүтээл туурвилын эмхэтгэл-I боть. МУИС-ийн Профессорын эрдмийн өв цуврал. Эрхлэн хэвлүүлсэн Д.Заяабаатар. Эмхэтгэж, хэвлэлд бэлтгэсэн Г.Нарантунгалаг. Уб., 264 х.*
- Билигсайхан Ч. 2022. *Утга зохиолын шүүмжлэл. Бүтээл туурвилын эмхэтгэл-II боть. МУИС-ийн Профессорын эрдмийн өв цуврал. Эрхлэн хэвлүүлсэн Д.Заяабаатар. Эмхэтгэж, хэвлэлд бэлтгэсэн С.Дашдэжид. Уб., 279 х.*
- Өлзийбаяр Д. 2009. *Чойжилжавын Билигсайхан. ХХ зууны монгол зохиолчид-4б. “Бемби сан”. Уб., 78 х.*

ШИНЭ ЭРИНИЙ ЖҮЖГИЙН ЗОХИОЛЫН УР ЧАНАРЫН ИЛЭРХИЙЛЛИЙН
ТУХАЙ ӨГҮҮЛЭХ НЬ

- *Шинэ эриний монгол жүжгийн зохиолын жишээн дээр*

Хасхүү*

ХУРААНГУЙ

Ерөнхийлсөн урлаг болсон жүжгийн зохиол нь утга урлагийн дүрэмжүүллийн дагуу өөрийн гэх онцлогоороо хөгждөг. XX зууны 80, 90-ээд оны Дундад улсын жүжгийн зохиолд соёлын ухамсар, амь насны ухамсар болон эдүгээч ухамсар болон эдүгээч ухамсрын нэг бүлэг шинэ элемент илэрч, урлаг гэх утгаас хүнийг дүрслэн үзүүлэх болсон байдаг. Тус өгүүлэлд XX зууны 80, 90-ээд оны монгол жүжгийн зохиолоор жишээлэн, дундад улсын шинэ эриний жүжгийн зохиол гунигт жүжүг болон баярт жүжгийн зохион бичлэгийг ашиглан хүнийг жинхэнэ урлагийн талаас нь дүрсэлж эхэлснийг бодит жишээгээр задлан шинжлэх болно.

Түлхүүр үгс: *Шинэ эриний жүжгийн зохиол, гунигт жүжүг, баярт жүжүг*

XX зууны 80-аад онд, Дундад улсын уран зохиол нь нийгмийн улс төр, соёлын амьдрал дунд чухал байр суурь эзлэх болж, улс төрийн илтгэл болон сэтгэлгээний илэрхийллийн зууч болсон юм. 1985 оны урьд хожидоор дундад улсын уран зохиолд гол урсгал устаж, угийн ерөнхийдөө нэг л туйлширсан хөгжлийн байдал арилан, олон туйлт хөгжлийн хандлага илэрчээ. Энэхүү эргэлтийн хугацаанд уран зохиолд соёлын ухамсар, амь насны ухамсар болон эдүгээч ухамсар бүхий нэг бүлэг шинэ элемент илэрч, уран зохиолын хүрээнд шинэ урсгал бий болон урьд харагдаагүй шинэ төрх байдлаар хөгжиж эхлэв. Удмаа мэдэх хөдөлгөөн болон түүнийг дагалдан бий болсон соёлын ухамсар хамгийн түрүүнд хүмүүсийн анхааралд оржээ. “Удмаа мэдэх хөдөлгөөн гэнэт бий болсон биш, 80-аад оны бодлогошролын уран зохиолын гол

* Өвөр Монголын Их Сургуулийн Монгол улсыг судлах хүрээлэнгийн лектор
Монгол улсын нөхцөл байдлыг судлах төвийн судлаач. hasihu112233@163.com



THE CULTURAL WAY

сэдэв нь өнөө үеийн улс төрд тунгаалт хийсэн боловч уран зохиол шарх сорвиос бодлогошролд шилжин орсны дараа зарим зохиол бүтээлийн түүхэн шинж, соёлын элемент болон зан үйлийн үнэ цэн нь улам чангарсан байна”¹. Үүний хамт амь насны ухамсар ч уран зохиолд өөрийн гэх орон зайгаа эзлэх болсон юм. Уран зохиол зөвхөн улс төр, аж ахуй, ёс суртахууны талаас л хүнийг дүрслэх биш, харин амь насны ур чанарыг нээн, хүн гэх мах цустай дүрийг бүтээхэд хүч тавьж эхэлсэн нь энэ цаг эриний уран зохиолын гол онцлог болжээ.

Энэ үеэс уран зохиол болхи бүдүүлэг, мунхаг балайгаас ангижирч боловсныг л уриалахад биш, харин хүний байгалийн шинж, оюунч бус шинжийг чухалчлан, хүний ур чадавх, байгаллаг шинжийг нээхэд гол хүчээ тавих болжээ. Уран сайхны гоо сайхны ухамсар амь насны амьжирлын хүчийг магтан дуулж, үүнийг дагалдан зэрлэг бүдүүлэг, хүчирхэг бардамнал нь мөн уран зохиолын дүрслэн бичих чухал элемент болж аймтгай, сул дорой мэтийн буурай шинж нь уран зохиолын гансрал зовнил, санаа алгаслын дүрслэгдэхүүн болсон юм. Энэхүү үзэгдэл нь ондоошсон боловсны эсэргүүцлийн хувиар хүний мөн чанарыг шинжлэн, хүнийг бүрэн бүтнээр нь илэрхийлэхэд идэвх нөлөөтэй. Уран зохиолын нэг чухал төрөл болсон жүжгийн зохиол нь мөн хүнийг ур чанараас нь, байгалийн шинжээс нь илүү дүрслэх болсныг тус өгүүлэлд гунигт жүжгийн зориг санаа болон баярт жүжгийн шинж гэх хоёр дэд хэсэгт хуваан задлан шинжлэх болно.

Нэг. Гунигт жүжгийн зориг санаа

Гунигт жүжиг хийгээд баярт жүжиг нь хоёр зүйлийн адил бус зөрчил мөргөлдөөний арга хэлбэрийг илэрхийлэн үзүүлэх гоо сайхны хэвшил болно. Баярт жүжиг нь мөн гунигт жүжигтэй адилаар нийгмийн амьдрал ба урлагийн хүрээнд тусгалаа олсон байна. Өрнө дахины жүжгийн уламжлал эртний грекийн үеэс эхэлж, эртний грек ромын жүжиг, европын дундад зууны жүжиг, утга урлагийн сэргэн мандалтын үеийн жүжиг, эртний сонгодог үзлийн жүжиг, романтик үзэл ба ахуйч үзлийн жүжиг, эдүгээч үзлийн жүжиг гэх хөгжлийн замаар хөгжин иржээ. Өрнө дахины жүжгийн гоо таашаалын үндсэн хоёр хэлбэр болох гунигт жүжиг, баярт жүжиг нь туйлшрал эсэргүүцлийн дунд уялдаа нэвчилдлийг бий болгон хоёр зүйлийн нөлөө ихтэй жүжгийн хэлбэр болсон байна. Гунигт жүжиг нь хүний байгаль нийгэмд эсрэгцүүлсэн

¹ 乔以钢总主编, 李新宇主编, 《现代中国文学》(1949-2008), 南开大学出版社, 2009年7月, 199页。



THE CULTURAL WAY

аргагүйдэл, зан чанарын мөргөлдөл, итгэл бишрэлийн зөрөө, хүн чанарын эмзэг дутагдал, оюун санааны далд гиюүрэл/*гуниглал* зэрэг оршихуйн зовуурийг хамгийн үнэнчээр, хамгийн гүнзгий илэрхийлж, гай гамшиг, үрэгдэл сүйдлээр дамжуулж “өнө мөнхийн төв ёсны ялалт”-ыг дэлгэн харуулан, амь насны үнэ цэнийн тухай чанадын халамжлалыг бий болгодог онцлогтой. Энэ онцлогийг үндэслэвэл гунигт жүжгийг нэгэн төв чанга мөртөө хүмүүсийн өр өвдөл, аюул айдасыг төрүүлдэг үйл ажиллагааны дуурайлт хэмээж болно. Гунигт жүжгийн зориг санаа нь нэгэн зүйлийн эрх чөлөөт зориг санаа, эсэргүүцлийн зориг санаа, бие үрэгдүүлэх зориг санаа, тэсвэр хатуужилтай зориг санаа, ялалтын зориг санаа болох юм.

Шинэ эринээс өмнөх хугацааны зохиолчдын урлагийн сэтгэхүй улс төрийн сэтгэхүйгээр урлагдан, зохиол бүтээл ухуулал сурталчлал, сурган хүмүүжүүлэх чадавхийг онцгойлон чухалчилж байв. Энэ үеийн монгол жүжиг нь хэрэг бодисын гэнэтийн шинж ба зайлшгүй шинж, үзэгдэл ба мөн чанарын дотроос зайлшгүй шинж ба мөн чанарыг илэрхийлэхийг л өрөөсгөлөөр хөөцөлдөж, цаг үеийн гунигт жүжиглэг хэрэг учирт гар дүрэхээс татгалзаж, утга урлагийн улс төрд үйлчилж, ажилчин тариачин цэрэгт үйлчлэх зорилтын дагуу ангийн дайсныг шүүмжлэхээр гол болгож, баясангүй үзлээр жүжгээ чимж байсан нь үнэн билээ.

Иймэрхүү гүйхэн дулимаг, хөнгөн хуудам баясангүй үзлийн нөлөөлөлд эртнээс аваад шийдвэргүйгээр зөрчил мөргөлдөөн бүр хялбарчлагдаж, гутрангуй үзэл нь хөөрөгдөн ангийн зөрчлөөр тодлогдож, зохиолчдын сэрэмжтэйхээр тойрон гарах “гунигт орон” болжээ. 80, 90-ээд оны монгол утга зохиолд илэрсэн гунигт орон гэдэг үзэгдлийг үндсээс нь тайлбарлавал, тэр нь монгол жүжигт илэрсэн гунигт жүжгийн далд шинж буюу монгол гунигт жүжгийн хөгжлийн явцад илэрсэн гунигт шинж болох юм. Шинэ эринд үзэл санаа чөлөөлөгдөн 80, 90-ээд оноос зохиолчдын шинийг үүтгэх зориг санаа улам сэргэж, нэг бүлэг гунигт ухамсрыг агуулсан жүжгийн зохиол зулай зулайгаа гишгэн мэндлэв. Гунигт орныг эвдсэн анхны бүтээл дуулианы дунд мэндэлж, энэ нь жүжгийн зохиолд урлаг гэх талаас илүү авч ярих нөхцөл боломжийг бий болгосон юм. 1978 оны 8 сарын 11-ний өдрийн “Вэнь хуй бао сонин” дээр Фудань их сургуулийн дундад улсын хэл утга зохиолын салбарын нэгдүгээр оны сурагч Лү Синьхуа-ийн бичсэн “Шарх сорви” гэх өгүүллийг нийтлэв.



THE CULTURAL WAY

Тус зохиол нэг хуудас зохиол боловч түүний тусгасан агуулгаас үзвэл нийгэм журамт нийгмийн амьдрал доторх эмгэнэлт жүжиг болно. Гол баатар Ван Шяохуа-ийн эмгэнэлт хувь заяа ба онцгойлон тус зохиолын эмгэнэлт төгсгөл нь уншигчдын сэтгэлийн хөвчийг хүчтэй доргиулан хүмүүсийн чээж дүүрэн хилэн хорслыг төрүүлж, өөрийн эрхгүй эмгэнэлийн нулимс унагадаг байна. Тус зохиол нь хэдийгээр урлагийн талаар бага сага хүрэлцэхгүй газар байвч эмгэнэлт жүжгийн гунигт орныг эвдэх нэг удаагийн урлагийн баатарлаг үйлдэл болсон байна². Гунигт орныг зоригтой эвдэн нийгмийн бодит үнэнийг тусгасан гунигт жүжгийн зохиолын ихэнх нь хошин шог жүжиг байж, хошин шогийн дунд гуниг гашууныг агуулсан шинжтэй. Үүнээс гадна нэг бүлэг төв жүжиг ч гунигт ухамсрыг илрүүлж, үндэстний назгай хойрго зан чанар, уламжлалт ойлгогдохуун ба нийгмийн хөгжлийн зөрчил, таваарын аж ахуйн түрэлт доорх хүний оюун сүнсний идэгдэл, мөс чанарын муудал, амь ахуйн түгшүүр зэрэг өргөн хэмжээний агуулгыг багтаах болсон юм. Монгол гунигт жүжиг нь төв чанга, эрхэм дээд, эрэлхэг баатарлаг зориг санааг илтгэдэг.

1. Гунигт жүжгийн төв чанга зориг санаа

Төв чанга бол нэгэн зүйлийн амьдрахуйн байдал, хайр сэтгэлийн хэлбэр болох мөртөө гунигт жүжгийн зориг санааны чухал илрэл болно. Хэрэв гунигт ухамсрыг илэрхийлсэн хошин шог жүжиг нь хөнгөн дэгжин хөг аясын дунд уй гашууг мэдрүүлдэг бол гунигт жүжиг нь тэндээ төв чанга хөг аясын дунд сайн сайхан зүйлсийн нуруулт сүйрэлтийг үзүүлдэг.

2. Гунигт жүжгийн эрхэм дээд зориг санаа

Гунигт жүжигт эрхэм дээд хэрэг бодис хувь биед даралт өгч хувийн өчүүхэн бага, ялимгүй байхыг мэдрүүлэх боловч мөн хувь биеэ зоригжуулж, хувьдаа эрч хүч олгох чадамжтай байдаг юм. Ингэхлээр хүн төв чанга мөртөө аугаа их зүйлтэй эсрэгцэх үед хувь биеийн хайр сэтгэл, зориг санаа ч эрхгүй дагалдан дээшилж, эрхэм дээд төрөгдөл ордог байна.

3. Гунигт жүжгийн эрэлхэг баатарлаг зориг санаа

² Хархүү. Одоо үеийн монгол уран зохиолын урлагийн судлал. ӨМАХХ 2001, 10 сар, т 131



THE CULTURAL WAY

Эрэлхэг баатарлаг бол гунигт жүжгийн цог сүлд болно. Гунигт жүжгийн гол баатрын ихэнх нь бүр эсэргүүцэл тэмцлийн зориг санаа, биеэ үрэгдүүлэх зориг санаатай. Тэдний үхэлд зоригтой эсрэгцэх баатарлаг сонголт нь гунигт жүжгийн зориг санааны тулах цэг болдог. Хэрэг энэхүү тулах цэг байхгүй бол гунигт жүжгийн төв чанга хөг аяс, эрхэм дээд үзэл санааны ахуй бүр оршихуйн сууриа алдахад хүрнэ.

С.Билэгтийн “Гаада мэйрэн” жүжиг нь гунигт жүжгийн онцлог шинж агуулж, гунигт орныг эвдэж, нутаг усаа хамгаалахаар сэдэвлэсэн жүжгийн төлөөлөх бүтээл болно. Жүжиг эхлэхэд “Батын муу үр хүүхэд чинь чухам хэзээ нутагтаа эргэж ирэхийг мэдэхгүй ...(холоос үймээн самуун дэгдэнэ, Бат барьж тавьсанаа алдаж, холын барааг зүрх муутай ширтэнэ), (Гомбо аав бүдүүн модыг түшиж, хүүр онгон өөд удтал гөлрөн зогсож туйлын харамсалтайгаар мөрний хөвөөнд очиж явган сууж мөрний усаар нүүр гараа угааж, хэд хэд балгана) хэмээн жүжиг эхэлнэ. Энд Бат болон Гомбо аав хоёрт тохиолдсон гунигт учралыг сүвэгч үлдээж тавиад, Гомбо (туйлын зовнилтойгоор) ай харь хөндлөн газар хөөгдөн очсоноос нутагтаа үхсэн нь дээр ... (үймээн шуугиан улам ойртоно, нэгэн бүлэг малчид араг үүргээ үүрч, сагс саваагаа тохойлж, агширга настнаа сугадан түшиж, ангаа хүүхдээ тэврэн хөтөлж, харгис хэрцгий атар хагалбарлах цэрэг ба хуйн цэргийн хар албадлагын доор зүдүүхэн гэлдэрчихнэ), Ян (цааш хэдэн малчдыг айлган сүрдүүлж явуулан, цэрэгт) хөө бушуу дуудаж, түргэн явуул, явах дургүй бол гуяд, эсэргүүцвэл бууд (буугаар сүрдүүлнэ) гэж нутгийн малчид атар хагалбарлах цэрэгт хөөгдөж байгааг зураглан гаргадаг. Жүжигт гурван овооноос Сибирьт хүртэлх атар газрыг Мүгдэн журганы засгийн газарт худалдан өгч, эндэх малчдыг хөөж нутгийг нь дэнслэхээр ирсэн цэрэг ноёдыг эсэргүүцэн өргөдөл гаргасан дүр зураг дэлгэгджээ.

Газар нутгаа Мүгдэн журганы засгийн газарт худалдан өгсөн Дархан ван, мүгдэн журганы Жан Дужюнь хоёрын тунхаг бичгийг бүдүүн модон дээр нааж тавин Ян (сэлэм сугалж) та та мэ ди аль шээстэй аавын хүү нь аймшиггүй урж хаяхыг нь би нэг үзье (Гомбо хилэн хорслоо дарж ядан тунхаг бичгийг урж аван газар хаяна, малчид дээрээс нь гишгэлнэ, Ян аа та та та нар улаан үс ургаж, уу уу урвах санаатай юу? (Гомбо аавыг чавчина), (Гомбо аав оногдож, тэнгэр өөд хандан газар ойчин унана, хүмүүс ихэд цочин хэлмэгдэнэ, Гомбо оо (арай гэж газраас нэг атга шороо авч нүдний өмнөө барьж үзэн үзэн байгаад нас нөгчინө), газар нутгаа харийн хүмүүст худалдахгүйн төлөө эсэргүүцэж харгис цэрэгт цавчигдаж үхсэн Гомбо өвгөн газар



THE CULTURAL WAY

нутгийнхаа төлөө бие үрэгдсэн баатар болов. (Гаада талд нь очиж үрсэн өвдгөөрөө сөгдөж, атга шороог нь малгайдаа тосож аваад гэнэт, гүйн босож сэлмээ авч нэг л сэлмээр газар хадсан гадасыг хага цавчин хаяна) Гаада мэйрэн нутгийнхаа төлөө, газар шорооныхоо төлөө тэмцэхээр зориг шулуудаж, Гаада мүүгдэнд хүрч зарга хийх хэмээгээд тэнд хоригдоно. Эхнэр Мүдэн нь хоёр цэргийн хамт Гаада мэйрэнг аврахаар явахаар охин Тянь Жиньлянь-аа Батын эхнэрт найдаж тэд нарыг хамт зугтаалгах гэж байгаад дэмий удалгүй Батын эхнэр хар цэрэгт алагдана. Мүдэн ээ охин минь үнэхээр дайсны гарт орвол яадаг билээ? (Мүдэн аргагүй эцэстээ шүдээ зуун нүдээ аньж өөрийн охиныхоо өөд харвана), (Мүдэн гэр өрхдөө гал тавьна), (хилэн хорслын гал түймэр хөдөө нутгийг улайгана), Мүдэн хэдэн цэргийн хамт Гаада мэйрэнг гянданаас аварч, Гаада мэйрэн нутаг усаа хамгаалахаар хар цэрэгтэй үзэлцэж аюулт дайсныг бүрмөсөн сөнөөхөөр ах дүү олноороо мордоцгооё хэмээн жүжиг төгсдөг. Тус жүжигт гол баатар Гаада мэйрэн жүжиг төгстөл амьд мэт байна гэлээ ч нутгийнхаа төлөө амиа үрэгдүүлсэн хэдэн малчид харамсалтай. Бүх жүжиг эхнээсээ дуустал хурц ширүү тэмцэл, хорсол зүхлийн уур амьсгалаар бүрхэж, гунигт жүжгийн төв чанга, эрхэм дээд, эрэлхэг баатарлаг шинжийг бүрэлдүүлж чаджээ. “Буй бүхий гунигт жүжигт гоо сайхны шинж давамгайлдаг.

Гунигт жүжигт гаслан зовлон, өшил хорсол, гомдол, эрэлхэг баатарлаг, ял нүгэл холилдсон элдэв олон сэтгэлгээ байдаг ч гунигт жүжгийн үзэл санааны хэв маягийн мөн чанар нь нэг зүйлийн гоо сайхан, эрхэм дээд, нэг зүйлийн өртөг болон ёс журмын хариуцлага байдгийн³ учир Гаада мэйрэн жүжигт газар нутгийнхаа төлөө чармайн тэмцэж байгаа дархан хошууны малчдын хорсол, нутгийнхаа төлөө амиа алдаж байгаа Гомбо өвгөн, Бадам, Тянь Жиньлянь нарын зовлонт учрал, малчдыг мөлжин дарлаж байгаа хар цэргийн ял хилэнц, нөхөр нутгийнхаа төлөө охиноо өөрийн гараар буудсан Мүдэний өөрийгөө буруутгаж зовсон сэтгэл зэргийн элдэв олон сэтгэлгээ нийлэлдэн тус жүжгийн гунигт шинжийг бий болгож, үнэн ёс нутгийн малчдынхаа төлөө хэмээн зүтгэсэн эсэргүүцлийн зориг санаа, ёс журмын төлөөний хариуцлага жүжигт эхнээс төгстөл тусгагдаж гунигт жүжгийн жинхэнэ утга учир, чадавхийг илэрхийлж чадав. Мөн жүжгийн баатар нэг бүрчлэн төв чанга, эрхэм дээд, эрэлхэг баатарлаг шинжийг агуулж, нутгийнхаа төлөө үхэхээс буцахгүй тэмцэж байгаа эзэн хүний

³ 施旭升, 《戏剧艺术原理》, 中国传媒大学出版社, 2006年5月, 322页。



THE CULTURAL WAY

хариуцлагат сэтгэлгээ нь гунигт жүжгийн гоо сайхан, эрхэм дээд, үнэ цэн болон ёс журмын хариуцлагын бодит орших хэлбэр болж чаджээ.

Дуулалт жүжиг “Риймаа” нь мөн гунигт жүжиг, Риймаа хүүхний Тана гэг элдэв олон гажлаас янаг хүнээ алдаж, Гуань ноёнд худалдагдан солиорсон харуусалт учралыг бичдэг. Жүжиг эхлэхэд (Хүлэг дөнгөн данган суух газар олоод, Риймаагаа суулгаж цуураа авч цуурдан Риймаагаа сугадуулахын зэргээр өөрөө ч сэтгэлийнхээ гунигаа дуулан хөл амарч сууна) Хүлэг: дуулна. Эрээн алаг цэгцүүхэй чинь, өргөс юм шүү ээ Риймаа минь, Эрэг гангаа эргэж тойроод, Дэвтрээд байна шүү ээ Риймаа минь, Энхрий бага чинийхээ, Өвчин гэмийг арилгая гээд, Эзгүй талын харгуй замаар, Энэлж явна шүү аав чинь би хэмээн Хүлэгийн хүүхнийхээ төлөө зовсон сэтгэлгээг дүрсэлдэг. Жүжигт үргэлжлүүлэн Риймаагийн янаг Шагдар дайсныг дарахаар цэрэгт мордохоор болоод нутгийн буурлууд, ахас ихэс андууд нь түүнийг мордуулах найр хийж, дайснаа дарж буцаж ирээд Риймаатайгаа сайхан амьдрал байгуулахыг зөгнөж байгаа үзэгдэл илэрнэ.

Ингээд 3 жилийн дараа Шагдар дайснаа дарж дархан цолоо мандуулаад буцаж ирсэн хойно хаан гэг Танад дагалдаж, Тана гэг элдэв олон арга хэрэглэн Шагдартай суухаар хичээгээд эцэстээ ноёноор Риймааг худалдуулж, Шагдарыг хүчээр дэргэдээ байлгаж янаг хоёрыг салгадаг. Риймаа хүнд худалдагдсанаа мэдэж хэтэрхий зовсоноос солиорон асга хад тойрч явна. Риймаатай адил Гуань ноёнд худалдагдсан ван хөгшний хүүхэн Цүй Синь байдаг. “Риймаа (дуулна) Зүсэр дайсны арга мэхэнд Риймаа би хууртагджээ, зовлонд учирсан Цүй Синь-ий дуу элэг зүрхийг шимшрүүлнэ, ... ээ ... ээ, аюулт эмсийн хорио гэгч нь, аржиг мангасын ам шиг, албатын охин Риймаа намайг, аван залгихаар ангайж байна, (Гуань ноён болон Тана гүнж хоёр Риймааг худалдах бичиг дээр хуруу даруулах гэж шахамдуулна)”, Тана гүнж Шагдартай хамт амьдрахын төлөө түүний хуучин янаг Риймааг эмсийн газар худалдаж байгааг хараад уншигчдын дургүйцэл, уур хилэн бадрах нь лавтай.

“Гунигт жүжиг өрөвдөх болон айх эмээхээр дамжуулж энэхүү өрөвдөл ба айх эмээхээ гадагшлуулдаг. Сайн гунигт жүжиг нь хүн зөвхөн махбодын сэрэгдлийг л олгох биш, харин хүний сэтгэл сэрэгдэлтэй уялдан уншигчдад үзэл санааны сэнхрүүлэл олгодог. Иймээс багцлан өгүүлбэл, гунигт жүжгийн гоо сайхны үйлчилгээ нь доорх хоёр зүйлд багтана. Нэг нь, уншигчид гунигт жүжгийн баатрын



THE CULTURAL WAY

ялагдлыг харж өрөвдөх сэтгэлгээ үүснэ. Нөгө нь гунигт жүжгийн баатрын ялагдлаас болсон эмэгнэл зовнилыг хараад сүрдэх болон өрөвдөн гайхах сэтгэлгээ үүснэ. Энэ хоёр зүйлийн сэтгэлгээний илрэл гунигт жүжгийн сонирхолын дунд сүлжилдэн оршиж, хүмүүсийн дотоод сэтгэлийн битүүрлийг гадагшлуулдаг. Гунигт жүжгийн гоо сайхны таашаал нь энэ хоёр зүйлийн будлиант сэтгэлгээний бачим давчуу уур амьсгал болон энэ бачим уур амьсгалын гадагшлууллын дунд оршдог”⁴ ёсоор Риймаа жүжгийг тайлбарлавал уншигчид, Риймаагийн янаг хүн Шагдараа алдсан, хүнд худалдагдан солиорсон, асга хаданд тойрч явсан учралыг хараад, Риймааг өрөвдөж, Тана гэгчийн хийж байгаа үйл ажиллагаанд гайхаж эгдүүцэх сэтгэлгээ төрнө.

Энэхүү гайж эгдүүцсэн сэтгэлгээг гунигт жүжгийн гоо сайхны үзэгчийн сэтгэлгээн дэх дарлал гадагшилсан нь хэмээж болно. Мөн Цусан гавьяа дахь тэмээт хорголжин үсэг барлах мэргэжил сурахын төлөө барс чоно үүргэлдэж, хулгай дээрэм цувсан балар хөдөөнөөс сүрдсэнгүй, улсын эрх мэдлийг хамгаалахын төлөө японы ов мэхийг шууд илчилдэг сайн эрийн дүрээр дүрслэгдэн гардаг. Гунигт жүжиг нь яг иймэрхүү баатар хүмүүсийн үйл ажиллагааг үзүүлдэгээс бүх зохиолд эрэлхэг баатарлаг цог сүлд нэвчиж байдаг.

Хоёр. Баярт жүжгийн шинж

Баярт жүжгийн зориг санаа нь үндсэндээ нэг зүйлийн эрх чөлөөт зориг санаа болон шүүмжлэлийн зориг санаа болох юм. Баярт жүжгийн зориг санаа бол тухайн жүжгийн сүнс нь мөн. Үүнд голдуу хошигнон шүүмжлэх зориг санаа, баясангуй итгэлтэй зориг санаа, оюунч хэтрүүлэл зориг санаа, эрх чөлөө хөөрөлдөн наргилдах зориг санаа хэмээх 4 зүйлийн зориг санаа багтаж байдаг. Баярт жүжгийн гоо сайхны хамгийн ил тод үр нөлөө нь даруй инээд болно. Инээд нь баярт жүжгийн хамгийн үндсэн онцлог мөртөө баярт жүжгийн зориг санааны илрэмж мөн.

Өнөөгийн монгол яриат жүжгийн зохиолд баярт жүжгийн эзлэх хувийн жин гунигт жүжгийн эзлэх хувийн жингээс хол илүү байна. Өнгөрсөн зууны 80-аад онд “Хүн малын эрэл”, “Хий горьдол”, “Оюун билгээ нээ”, “Хоёр Хутагай” гэх мэтийн нэлээд чанартай баярт жүжиг

⁴ 施旭升, 《戏剧艺术原理》, 中国传媒大学出版社, 2006年5月, 334页。



THE CULTURAL WAY

бичигдэж байсан бол 90-ээд оны гялбаан жүжгийн халуурлаас болж нэн арвин шог хошин жүжиг гарчээ. Баярт жүжигт инээдэмт үйл хөдөлгөөнийг ашиглах, дүрийн зан чанарын бүтээлт, шог энгийн хэл хэллэг, учрал ахуйн бүтээлт зэргээр дамжуулж эрх чөлөөний төлөөлөл болсон инээдийг бий болгон, баярт жүжгийн зориг санааг нэг хэмжээнд бадруулж байдаг юм. Инээдэмт үйл хөдөлгөөнийг ашиглаж баярт жүжгийн зориг санааг илрүүлсэн “Хоёр Хутагай” жүжгийг үзвэл, тус жүжигт Гармаа нийтийн хургыг хоёр дарагдуулж үхүүлчихээд чононд нэр халдааж, арьсыг нь өөрөө авч, Хутагай Бадамаас эзэгий хурууд солихоор ирээд Бадамд шүүмжлэгдэж байтал бригадын байцаах гишүүн Өлзий жүжигт гарна.

“Гармаа ихэд сандран гар дахь хурууддаа ч үгүй, газар дахь арьсандаа ч үгүй болохдоо хуруудаа барьсан хэвээрээ хоёр арьсан дээрээ лаг хийгэл завилж сууна. Өлзий: (арьсыг нь үзсэн боловч үгүй юм шиг ээр) Гүй хө манай хоёр найз чинь яаж байх нь энэ вэ? нэг нь ханзан доороо шавар баримал шиг шалайж суугаад гартаа бас хурууд барьчихжээ. Нэг нь ханзан дээрээ хадан дээр суусан бүргэд шиг хөнгийн харж байгаа нь юу болж байх нь энэ вэ?(Бадам буруу харан сууна). Өлзий: (инээж) тэг тэг түр байсхийгээд ээ, та хоёрын асуусан асуулт над гэнэтхэн сонин санагдчихлаа. Үгүй ер нь та хоёрын суусан байдалд ч гэсэн даанч сонин харагдаад байна ... (бодолхийлж), найз нар аа яавал дээр вэ? болвол надад тайлбарлаад өгвөл ямар вэ? Бадам: (Гармаа руу зааж) түүнээс асуу. Өлзий: чухам яасан юм вэ? Гармаа найз аа, Гармаа: (сандран) аа ... аа ... (инээж) би энд зүгээр суусан юм. Өлзий: зүгээр суусан юм гэнэ ээ? Гармаа: (инээмсэглэж) тийм тийм, үүнийг бас сонирхохоор юу л байна даа, Өлзий: үнэхээр сонин л хэрэг байна, юунд тэр нойтон чийгтэй газар сууж байх юм бэ? чиний тэр суусан шинж ч гэсэн надад тун эвгүй үзэгдэж байна, яг л өндөг дарсан эмэгчин тахиа шиг байна, Гармаа: (инээмсэглэж) ингэж суувал сайн юм гэнэ, (хормойгоо ийш тийш нь дэлгэж) энэ ... энэ аргыг манай Хутагай эгч надад зааж өгсөн юм” хэмээн санаа амар хариулна. Тус хэсэгт Гармаагийн эмэгчин тахиа шиг овойж суусан эв хавгүй үйл хөдлөл нь булхай хэргээ халхлах гэсэн зорилго ба даравч далдайж булавч бултайдаг үр дүн хоёрын зөрчлийг үзүүлж, инээд ханиадын дунд шүүмжлэн хошигнох үр дүнд хүрсэн байна.

Баярт жүжгийн зориг санааны гол илрэл болох инээдийг энэ жүжиг маш эвлэг тохируулж, жүжгийн санааг инээдэнд шингээн оруулж чаджээ. “Батсангийнхан” жүжигт, Түгэм настан хүү



THE CULTURAL WAY

Батсангийнхаа хуримыг хийхээр бэлтгэн, Санжаад хадгаламжийн дэвтрээ өгч мөнгө гарган авахуулж хоршооноос хуримын юм авахуулах хэмээн явуулахад, Түгэм ээжийн охин нь хадгаламжийн дэвтрээ гээсэн гэж банкинд ярин Санжаагийн мөнгө гарган авахыг хориглоно. Түгэм ааж ажилч аривчаар амьдралаа цогцлоон, хүү Батсангаа цэрэгт явуулж, охин Саранцэцэгээ их сургуульд явуулсан байна. Жүжгийн төгсгөлд Дамрин: (ажилч аривчаар алсан сайн сайхныг байгуулья гэсэн туг барин орж ирнэ) Түгэм ээж бол цаг үргэлж ажилч аривчаар амьдардаг учраас нэг хоёр, тав арваар хадгалсаар байгаад хэдэн жилийн дотор хэдэн зуу болгожээ. Энэ бол манай дугуйланд хэв дүрэм болсон болохоор манай зээллэгийн хоршооноос энэ тугийг хүргэлээ ... Түгэм: эсвэл охинд өг, энэ охин байсангүй бол би бас ... энэ өнгө гэрэл бол Батсангийнхны л мөн болохоор гурвуул л авья хэмээн Түгэм ээж эс л хадгалж байсан мөнгөө гарган авчихсангүйдээ сэм баярлаж тугийг авдаг.

Жүжгийн энэ үлгэр үйл явдлын дунд Түгэм ээж болон Санжаа хоёрын яриа хошин шог, баярт жүжгийн онцлогийг хадгалж чаджээ. Санжаа: иш Түгэм минь, Санжаагийн чинь явдал санаагаар ердөө болохгүй, өглөө эрт ирье гэсэн нь манай эхнэр намайг хуримын бэлэг авахаар хоршоонд явна гэнэ. Тэгээд би хоршоонд очоод түрүү мулталмагцаа ирж байх нь энэ, Түгэм: пэй тэгвэл чи өнөөхөө хүзүүдээд суулаа биз дээ, Санжаа: үгүй жаахан түрүү чангарвал түргэн яваад ирэхдээ дээр үү дээ, Санжаа: (бас нэг хөнтөрч, цээжээ дэлдэн, шүлсээ залгилан, зангирсан юм шиг овлоно) үл тэгэлгүй, би чиний үүнийг авсан хойноо л зовчихлоо, ил уувал Санжаа бас архи ууж байна л гэнэ, далд уувал эхнэр өндөрдвөл бас гэрэлтэнэ, аягүй бол манайхан чинь Батсанд гүйж ирээд хэлчихнэ, энд Санжаагийн яриаг гол болгон, төлөөлөх чанар бүхий үйл хөдөлгөөнөөр жишээ татаж Санжаа гэх хүний дүрийг хошин шогоор дүрсэлжээ. Санжаа архинд дуртай, элдэв аргаар архи олж уух гэж зоог дэлгэн Түгэм настны тулгам асуултыг элдэв аргаар шилжүүлж байна. Санжаа бол үг зоог олонтой, архинд шунасан хүний дүр болно. Жүжигт боломж л олдвол архи олж уухыг бодон амьдралаа ардаа хаясан Санжааг архитай холбон хошин байдлаар дүрслэн гаргасан байна.



THE CULTURAL WAY

ДҮГНЭЛТ

Шинэ эриний монгол жүжгийн зохиол хүний ур чанарыг гунигт жүжиг болон баярт жүжгээр дамжуулан илрүүлэн гаргаж байв. Гунигт жүжгийн төв чанга, эрхэм дээд, эрэлхэг баатарлаг зориг санаа нь шинэ эриний хүмүүсийн агуулж байсан зан чанар, зориг санаа нь байж, хүний ур чанарыг илэрхийлэх боломж олсон эринд уран зохиол, урлагт тэр хэвээрээ дүрслэгдэж эхэлсэн юм. Баярт жүжгийн эрх чөлөөт зориг санаа болон шүүмжлэлийн зориг санаа нь шинэ эриний монгол жүжгийн зохиолын илэрхийллийн гол арга хэлбэр болж, хүнийг жинхэнэ урлагийн талаас дүрслэн бичих чухал арга хэлбэр болж байсан юм.

ABSTRACT

Drama, as a comprehensive art, develops according to literary and artistic norms. In the Chinese drama of the ninety's of the 20th century, a series of factors, such as cultural consciousness, life consciousness and modern consciousness, began to describe people from an artistic point of view. Taking the Mongolian drama of the ninety's of the 20th century as an example, this thesis analyzes the use of tragedy and dramatic writing features in Chinese new era drama to describe human characteristics from an artistic perspective.

Keywords: *New Age drama Tragic Drama*

НОМ ЗҮЙ

- Хархүү. Одоо үеийн монгол уран зохиолын урлагийн судлал. ӨМАХХ 2001
- 施旭升, 《戏剧艺术原理》, 中国传媒大学出版社, 2006 年
- 乔以钢总主编, 李新宇主编, 《现代中国文学》(1949-2008), 南开大学出版社, 2009 年



ОЛОН СОЁЛТ ҮЗЛИЙН УЯЛДАА – ИНЖИННАШИЙН “НЭГЭН ДАВХАР АСАР”
БОЛОН УЛААНАА УЙЛАХ ТАНХИМЫН ЖИШЭЭН ДЭЭР

Цай Юнь*

ХУРААНГУЙ

Монгол үндэстний ойрх үеийн алдарт зохиолч Инжиннашийн “Нэгэн давхар асар” болон “Улаанаа уйлах танхим” нь олон эшит соёлын уялдлын чухал төлөөлөгч мөн. “Нэгэн давхар асар” болон “Улаанаа уйлах танхим”-д монгол үндэстний уламжлалт гоо таашаахуйн үзэлт байхаас гадна, агуулга, бүтэц, хэлбэрийн талаар хятадын сонгодог роман “Улаан асрын зүүд”-ний нөлөөг хүртжээ. Хоёр зохиолд байгаа шигтгэл шүлэг нь энэтхэг төвөдийн “Зохист аялгууны толь” -ийн дуун чимгийн цөөн хэдэн зарчмыг барьж бичсэн байдаг. Зохиолд илэрсэн үзэл санаа нь ч дэлхийн уран зохиолын хүрээнд өргөн яригдаж байсан эмэгтэйчүүдийн өвөрмөц чанарын чөлөөлөлтийн үзэл санаатай нэлээд төсөөтэй байна. Хураангуйлвал, “Нэгэн давхар асар” болон “Улаанаа уйлах танхим” нь өврийн үндэстний уран зохиолын уламжлал болон зохион туурвилын зарчмаа баримтлахын хамт хятад, монгол, төвөдийн соёлын идэвх элементийг төстэй уялдуулсан бөгөөд үзэл санааны хувьд ойрх үеийн өрнө дахины үзэл санаатай ч адил байх нь онц үнэлүүштэй юм.

Түлхүүр үгс: *Инжиннаш, Нэгэн давхар асар, Улаанаа уйлах танхим, олон эшит соёл*

Инжиннаш (1837-1892) нь 19 дүгээр зууны монгол үндэстний алдарт уран зохиолч, бодлоготон мөн. Инжиннашийн “Нэгэн давхар асар”, “Улаанаа уйлах танхим” нь монгол үндэстний соёлын ул мөр байх мөртөө хятад төвөд зэрэг олон соёлын үзэл хослуулсан онцлог тодорхой байдаг.

Инжиннашийн романы тухай судлал нь 20 дугаар зуунаас эхлэн эрдэмтэд олон талаас эрэлхийлэл хийж, маш өндөр амжилтад хүрчээ.

* Өвөр Монголын Багшийн Их Сургуулийн Монгол судлалын дээд сургуулийн багш, доктор



THE CULTURAL WAY

Гэвч олонх бүтээл нь монгол хятад уран зохиолын харьцааны талаар “Улаан асрын зүүд” болон “Нэгэн давхар асар”, “Улаанаа уйлах танхим”-ын харьцааны талаас судалжээ. Тус өгүүлэл нь хятад, монгол, төвөд, энэтхэг тэрчлэн өрнө дахин зэрэг олон эшт соёлын талаас “Нэгэн давхар асар”, “Улаанаа уйлах танхим”-ыг судлан зохиогчийн зохион бүтээх орчинд Инжиннашийн зохиол бүтээлийн тухай сүвэгчлэл хийхийг зорив. Энэ талаас Инжиннашийн зохиол бүтээлийг судалсан судлаач харьцангуй цөөн байдаг. Онцгойлон энэтхэг төвөдийн шүлэг зүй болон өрнөдийнхний ойрх үеийн үзэл санаа болон Инжиннашийн зохиол бүтээлийн хоорондох харьцааны талаар анхаарсан судлаач үгүй гэж хэлэхэд болно. Зохиогчийн ажигласнаар “Нэгэн давхар асар” болон “Улаанаа уйлах танхим”-д “Улаан асрын зүүд”-ний нөлөө маш тодорхойгоос гадна, шигитгэл шүлэгтээ энэтхэг төвөдийн “Зохист аялгуун толь”-ийн дуун чимгийн аргыг ч хэрэглэжээ. Онцгойлон үзэл санааны хувьд 19 дүгээр зууны өрнөдийнхний эмэгтэйчүүдийн өвөрмөц чанарын чөлөөлөлтийн үзэл санаатай ч ойролцоо тал бий.

Инжиннашийн роман нь монгол үндэстний ойрх үеийн зохиол бүтээлд хятад үндэстний уран зохиол, энэтхэг төвөдийн шүлэг зүй, нэн ялангуяа өрнөдийнхний үзэл санааг агуулсанаараа онцлогтой. Хятад улсад олон үндэстний утга зохиолын үзлийг 21 дүгээр зуун өнгөрөөд сая дурьджээ. Гэтэл монгол үндэстний уран зохиолч Инжиннаш зохиол бүтээлдээ олон үндэстний уран зохиол болон соёлын уялдааг илрүүлсэн бөгөөд дорно өрнөдийн уран зохиолын уялдаа нэвтрэлцэл солилцлыг тусгажээ. Инжиннашийн “Нэгэн давхар асар”, “Улаанаа уйлах танхим” нь хятад үндэстний уран зохиол, монгол үндэстний уран зохиол, энэтхэг төвөдийн шүлэг зүйн онол, өрнөдийнхний уран зохиол болон соёлын уялдааг харуулжээ. Олон үндэстний уран зохиолын тухай үзэлтэн Liu Kuili судлаач өгүүлэлдээ эрт дурьдав. Лиү Күйли хэлэхдээ: “Бид өөрийн зохион бүтээл, судлалаараа адил бус үндэстний соёлын солилцоо, соёлын нөлөөний бодит байдлыг илрүүлэхэд гол нь нэгэн хэвээр түгээмэл утга агуулга дээрх солилцоо болон нөлөөг яриад байх биш, харин бодитоор тэдгээрийн харилцан солилцол болон нөлөөллийн бодит явц болон шинж чанар, утга агуулгыг тайлбарлахад байна”¹ гэжээ.

¹ 刘魁立:《继往开来-全国少数民族文学史学术会议上的发言片断》,《民族文学研究》,1987年第2期。Liu Kuili судлаачаас тус өгүүлэлдээ: эл үндэстний хоорондох хоёр тал болон олон талын солилцооны талаар анхаарвал зохино гэжээ, бусад үзэлтийг Liu Kuili-судлаачийн өгүүллээ харна уу.



THE CULTURAL WAY

Иймээс Инжиннашийн “Нэгэн давхар асар”, “Улаанаа уйлах танхим”-д илэрсэн олон үндэстний уран зохиол болон олон эшт соёлын харьцааг тодруулах нь тийм хялбар биш, эрхбиш үнэн баримтад суурилах хэрэгтэй.

Нэг. “Нэгэн давхар асар” ба “Улаанаа уйлах танхим”-ын уялдаа болон зөрөөт шинж

“Нэгэн давхар асар”, “Улаанаа уйлах танхим” нь монгол үндэстний уран зохиол нь ардын аман зохиол болон түүхэн үлгэрээс салж, тухайн үеийн бодит амьдралаар сэдэвлэн тусгай зохиол болсон хамгийн анхны ахуйч үзлийн зохиол бүтээл бөгөөд монгол үндэстний уран зохиолын түүхэнд чухал байр суурьтай байдаг².

“Нэгэн давхар асар”, “Улаанаа уйлах танхим” болон “Улаан асрын зүүд”-ний харьцаа холбооны талаар эрдэмтэд судлаад нэлээд хугацаа өнгөрчээ. Гол үзэлт нь “Нэгэн давхар асар”, “Улаанаа уйлах танхим” болон “Улаан асрын зүүд” нь зохиолын баатар, үлгэрийн бүтэц, бүлэгт романы зохион бүтээлтийн талаар цөм “Улаан асрын зүүд”-ний нөлөөг хүртсэнд төвлөрч байна. Гэтэл нарийн зүйлсийн хувьд “Улаан асрын зүүд”-тэй адилгүй зүйл байна. Иймээс бид нөлөө судлалын талаас “Улаан асрын зүүд” нь Инжиннашийн роман дахь “Улаан асрын зүүд”-ний нөлөөг үзэхэд Инжиннаш “Улаан асрын зүүд”-ийг хүлээн авах явц дунд хөөцөлдөж буй үндэстний шинж, даруй түүний зохион бүтээлтийн зөрөөт шинж, зөрөөт шинж буй болсныг задласан суурин дээр Инжиннашийн өвөрмөц шинж бүхий зохион бүтээлтийн онцлогийг илрүүлэх нь зангилаа болно.

Инжиннашийн “Нэгэн давхар асар”, “Улаанаа уйлах танхим” нь “Улаан асрын зүүд”-ийг дууриасан тал байх бөгөөд Улаан асрын зориг санааг залгамжлан, феодалын нийгэм аяндаа хоцрогдож, феодалын ёс гормийн доор залуучуудын зол бус нь цаг эриний гунигт жүжиг мөн. Инжиннашийн хэдэн хайр дурлалыг харуулсан зохиол, “Саран Хөхөөгийн тууж”, “Улаан үүлний нулимс”, “Нэгэн давхар асар”, “Улаанаа уйлах танхим” эдгээрт нэгэн нийтлэг онцлог байна. Энэ нь даруй хэлбэрийн талаар дотор газрын эрдэмт хөвүүн гоо охидын романыг дууриан, онцгойлон “Улаан асрын зүүдэн”-ийг дууриаж, агуулга сэдвийн хувьд, Зүн шин фү-ийн өнгөрсөн хэрэгт тулгуурлан

² Инжиннаш. Улаанаа уйлах танхим. ӨМАХХ., 1981 т 4



THE CULTURAL WAY

зохиогчийн үзэж харсан говийн өмнөх монголын нийгэмд гүн үндэслэжээ³.

Инжиннаш “Нэгэн давхар асар”-ын илэрхий оршилдоо “...Энэ бичиг дур харгис бэр, зүсэр татварын гэм үгүй ба гэрийн эрхийг дотоод дур тушаасан алдаш үгүй ину “Улаан асрын зүүд”-ээс бахаан өвөрөө боловч Чин, Лү хоёр хүний санаан Цай Дай хоёулаас өврөө үгүй бөгөөд Пү ию-ийн ганцаарын үзэл бас Бо Ию-ын нэгэн таалал лугаа адил шигийн дээр ло тайтай, Жин фү рэн-ы сэдлэгээр хоёр тийш нухласнаар Дү ию-гийн сайн учрал тэргүүлэгч цэцгийг бараадсан мэт болсон ану Жя мү, Фэн Жие-ийн сэтгэл нэгэн адил нийлсэнээр Бо Цай-н гайхалтай барилдлага зурсан боорсог адил хоосдоноос ямар өврөө ялгал бий!”⁴ гэж “Нэгэн давхар асар” болон “Улаан асрын зүүд”-ний харьцаа холбоог маш тодорхой гаргажээ.

Зохиолын баатрын дүр бүтээсэн талаар Цао Сюэ Цин-ий “Улаан асрын зүүд”-дээ Жя Боию, Лин Дайию, Шүе Боцай зэрэг сонгодог зохиолын баатрын дүр байдаг. Инжиннаш “Нэгэн давхар асар”, “Улаанаа уйлах танхим”-даа Бэй Пүюю, Лү мэй, Чин Мө, Шэн Рү зэрэг сонгодог дүрийг бүтээжээ. Цао Сюэ Цинь болон Инжиннашийн зохиолын баатар нэг нэгээрээ бүр дүйж байна. Жишээлбэл, Пү ию болон Бо ию, Лү Мэй болон Лин Дайию, Чин Мө болон Шүе Боцай гэх мэт. Нэн “Нэгэн давхар асар”-ын 14 дүгээр бүлгийн гарчиг нь хүртэл “Зуны туйлын тухай Чин боцай салах санааг тогтоовай, сэрүүний цаг болхуна Лин Дай ию баярын мэдээг соносвай” гэж байдаг. Гэтэл бид Чин Мө, Лү Мэй болон Пү ию-ийг хялбараар Шүе Боцай, Лин Дайию болон Жя Боию тай бүрэмсэн адилаар үзэж болох үгүй. Пү ию нь Жя Боию-ийн хуулмал дүр буюу дууриасан дүр огт биш, харин Пү ию нь гэр бүлийн хариуцлагатай сэтгэлтэй залуу тул Жя Боию мэт охидын дунд хэнхдэг сул хүнтэй үндсэнээсээ адил үгүй. “Улаан асрын зүүд”-ний зохиолын гол баатар Жя Боию нь баян тансаг орчинд өдөржин охидтой хамт жаргаж байдаг. Шүе Боцайаас Жя Боию-д “Баян эрхэм сул хүн” гэх хоч нэр өгсөн юм. Гэтэл “Нэгэн давхар асар”, “Улаанаа уйлах танхим” дахь Бэй Пү ию нь охидтой өдөржин холилдон наадах биш, харин ном сурахын дагуу аавдаа туслан ордны ажлыг хариуцдаг. Эндээс Жя Боию болон Бэй Пү ию нь мөн чанарын ялгаатай. Инжиннаш “Нэгэн давхар асар”, “Улаанаа уйлах танхим”-ын зохиолын

³ 扎拉嘎：《比较文学：文学平行本质的比较研究-清代蒙汉文学关系论稿》，呼和浩特：内蒙古人民出版社，2002年，第194页。

⁴ Инжаннаш. Нэгэн давхар асар, ӨМАХХ., 1978 т 8



THE CULTURAL WAY

баатрын дүрийг бүтээхдээ “Улаан асрын зүүд”-ийг дууриасан тал байх мөртөө өвөрмөц онцлог бүхий зохиолын баатрын дүрийг бүтээсэн байна.

Зохион бүтээсэн сэдэвлэхүүний хувьд, “Нэгэн давхар асар”, “Улаанаа уйлах танхим” нь “Улаан асрын зүүд”-ийг дууриан Пү ию болон Лү Мэй, Чин Мө-ийн янаг хайрыг бичжээ. Иймээс Инжиннаш “Нэгэн давхар асар”, “Улаанаа уйлах танхим”-даа “Улаан асрын зүүд”, “Улаан асрын зүүдний үргэлжлэл”, “Улаан асрын зүүдний дахин сэргэлт” зэрэг романы зарим үйл явдлыг өөрийн зохиол бүтээлдээ шилжүүлэхийн хамт зоригтой өөрчлөн бичив. “Нэгэн давхар асар”-ын 20 дугаар бүлэг болон 21 дүгээр бүлэгт Чи Боюю-ийн ээж нь Бэй Хэо-ийн ордонд Чин Мө-тэй уулзаж, Ло Тайтай-аас хүнд гуйсан эсэхийг асуухад Ло Тайтай энэ дашрамаар Пү ию-ийн ээж Жин Фүрэн-ийг албадан Чин мө-д танын сүйх зүүлгэж, Пү ию-д Чин мөг гуйх санааг илэрхийлэв. Энэхүү сүйх зүүлгэх үйл явдал нь “Улаан асрын зүүдний дахин сэргэлт” гэх зохиолын 27 дугаар бүлэг дэхь Жү Ло Тайтай Чиү Рүй-д сүйх зүүлгэсэн үйл явдлыг дууриасан байна. Инжиннаш “Нэгэн давхар асар”, “Улаанаа уйлах танхим”-даа “Улаан асрын зүүд” дэхь Лиү Лоло Жя Фү-д гурван удаа очсоныг дууриан Бай Ло гуа- Бэй Хэү Фү-д гурвантаа очсон үйл явдлыг зохиов. Мөн “Нэгэн давхар асар”-т Мио Луан ураг эсэргүүцсэн үйл явдал нь “Улаан асрын зүүд”-ний Юан Ян-ий ураг эсэргүүцсэн үйл явдалтай маш адил. Энэхүү үзэгдэл нь Инжиннашийн чухал бус үйл явдлын зохицуулалт болон сэдвийн хувьд “Улаан асрын зүүд”-ний нөлөө их байгаа нь нэн тодорхой байна.

Үлгэрийн бүтцийн талаар Мин Чингийн үеийн маш олон роман нь шашны төрөл арилжан мэндлэх зэрэг үйл явдлаар зохиолын эхлэлт болгодог. “Нэгэн давхар асар” нь шашны домгоор эхлэн зохиолын баатрын хувь заяаг урьдаар мэдүүлэн, онцгой зарим үйл явдал нь “Улаан асрын зүүд”-ний зарим үйл явдлыг шууд шилжүүлсэн тал ч байдгийг дээр нэгэнт дурьдав.

Гэвч үлгэрийн төгсгөлийн талаар “Нэгэн давхар асар”, “Улаанаа уйлах танхим” нь “Улаан асрын зүүд”-тэй адилгүй. “Улаан асрын зүүд” романы эцэст Жя Боюю гэрээс гарч, Лин Дайию үхэж, Шүе Боцай хоосон гэрийг ганцаар сахисан байхад “Нэгэн давхар асар”, “Улаанаа уйлах танхим”-ын төгсгөл нь эрдэмт хөвгүүн гоо охины мэт их уулзалт болж, гунигт жүжиг нь баярт жүжиг болж, маш тодорхой цаг үеийн онцлог болон үндэстний шинжийг хадгалжээ.



THE CULTURAL WAY

“Нэгэн давхар асар”, “Улаанаа уйлах танхим”-ын “Улаан асрын зүүд”-ээр толь болгосон бүлэгт романы бүтэц, агуулга, хэлбэрийн талын нөлөөнд тодорхой илэрч байна. Хэдийгээр “Нэгэн давхар асар”, “Улаанаа уйлах танхим” нь “Улаан асрын зүүд”-ийг толь болгосон буюу нөлөөлөгдсөн ул мөр маш илэрхий боловч үндэстний онцлог бүхий үүдэн бүтээлч тал ч тодорхой байдаг. Жишээлбэл, “Улаан асрын зүүд” дэхь эмэгтэй зохиолын баатрын дүр нь уламжлалыг эсэргүүцэхэд “Нэгэн давхар асар”, “Улаанаа уйлах танхим” дахь эмэгтэй зохиолын баатрын дүр нь өвөрмөц шинж нэн тодорхой мөртөө феодалын ургийн ёсыг ч эсэргүүцдэг.

Инжиннашийн “Нэгэн давхар асар”-ын зохион бүтээх зарчим нь хэлбэрийн талаар дотор газрын романыг дууриасан боловч агуулгын хувьд говийн өмнөх монголчуудын нийгмийн амьдралд суурилжээ⁵. Инжиннаш “Нэгэн давхар асар”, “Улаанаа уйлах танхим”-аараа дамжуулан монгол үндэстний ард түмнийг хятад үндэстний соёлыг ойлгох ба ойртолцох жич түүний уран зохиол нь монгол хятад үндэстний соёлын солилцооны түүхэнд маш чухал үйлдэл үзүүлжээ⁶.

Ерөнхийлвөл, дээрх зүйл зүйлийн үзэгдэл нь Инжиннашийн адил хоёр бүтээл “Нэгэн давхар асар”, “Улаанаа уйлах танхим” нь монгол хятад хоёр үндэстний уран зохиолын харилцан солилцон харилцан уусалдсаны төлөөлөл болно. Инжиннаш “Улаан асрын зүүд” болон түүний үргэлжлэл болон Мин Чингийн үеийн романы суурин дээр монгол үндэстний онцлог бүхий хайр дурлалын роман зохиосон юм. Гэтэл энэ зүйлийн нөлөөний тухай Инжиннаш зөвхөн “Улаан асрын зүүд”-ийг дууриан зохиов гэх үзэлтийг зөвшөөрөхгүй, учир нь “Нэгэн давхар асар”, “Улаанаа уйлах танхим”-ын үлгэрийн түүхэн ахуй, нарийн ширийн үйл явдлын зохицуулалт эрэгтэй эмэгтэй зохиолын баатрын төгсгөлийн хувьд “Улаан асрын зүүд”-тэй цөм адилгүй болсон тул монгол хятад уран зохиолын харилцааны талаас Инжиннашийн романыг үзэхэд нөлөөг олж харах мөртөө зөрөөт талыг ч олтгойлж болохгүй, мөн Инжиннашийн романд хийсэн шинэчлэлийг олж харах нь маш чухал байдаг.

⁵ Хөгжилт: 《尹湛纳希与儒家文化》，沈阳：辽宁民族出版社，2021年，第187页。

⁶ Эрдэнэтогтохын зохиолын сонгомол. ЛяоҮнХХ., 1988 т 235



THE CULTURAL WAY

Хоёр. “Нэгэн давхар асар”, “Улаанаа уйлах танхим”-ын шигтгэл шүлэг дэхь энэтхэг төвөдийн “Зохист аялгуун толь”-ийн дуун чимгийн ул мөр

Инжиннаш монгол, хятад, манж, төвөд, санскрит хэлэнд нэвтэрхий⁷ мөртөө төвд хэлэнд нэвтэрч “Зохист аялгуун толь”-ийн онол нь “Нэгэн давхар асар”, “Улаанаа уйлах танхим”-ын зохион бүтээлийн үйлдэл гээд тодорхой илрэлээ олж буй. “Нэгэн давхар асар”, “Улаанаа уйлах танхим” дахь шүлгийн төрөл хэлбэр баялаг, түүнд бүлгийн гарчгийн шүлэг, шигтгэл шүлэг, бүлгийн төгсгөлийн шүлэг зэрэг олон төрөл байдаг. Агуулгын талаар мөн монгол үндэстний уламжлалт амьдрал, хятад үндэстний тариалангийн соёлтой холбогдох баялаг агуулга бий. Энэхүү өгүүлэлд зөвхөн “Нэгэн давхар асар”, “Улаанаа уйлах танхим”-д илэрч буй шигтгэл шүлэгт⁸ судалгаан хийх болно. “Нэгэн давхар асар”, “Улаанаа уйлах танхим”-ын шигтгэл шүлгийн бичилтийн онцлогыг харахад, хятад үндэстний эртний бүлэгт романы шүлэг зохиох аргыг хэрэглэснээс гадна, монгол үндэстний уламжлалт шүлэг, хятад үндэстний хэмжээт шүлэг, энэтхэг төвөдийн “Зохист аялгуун толь”-ийн ул мөр ч илэрхий байна. Онцгойлон шигтгэл шүлгийн хэлбэрийн талаар шууд “Зохист аялгуун толь”-ийн дуун чимгийн нөлөөг хүртсэн байдалтай юм. Монгол эрдэмтдийн зохиол бүтээл дотор ямар нэгэн зохиолоо эхлүүлэх буюу төгсгөхдөө эсвэл зохиолын дундаа заавал хэдэн бадаг шүлэг бичиж, бурхан бодисадвад залбиран даатгасан, бишрэн мөргөсөн сэтгэлгээ, зохиолын агуулга санааны чиглэл, зохиолын агуулгын тухай бодол төөрөгдөл, зохиогчийн тухай, зохиогчийн зохион бүтээсэн тухай чимээ зангийг бичин оруулдаг байна. Эдгээрийг даруй дахилт төгсгөлийн шүлэг ба завсрын шүлэг гэнэ⁹. Энэхүү өгүүлэлд “Нэгэн давхар асар”, “Улаанаа уйлах танхим”-ын жишээг цөм романы ямар нэгэн бүлгийн эхлэлт буюу бүлгийн дунд байгаа хэдэн бадаг шүлгээс сонгов.

⁷ Инжиннашийн мэддэг хэлний талаар адил бусын хэллэг бий. олонхи сурвалж бичигт Инжиннашийг монгол, хятад, манж, төвд хэлэнд нэвтэрхий гэдэг. Гэтэл 《蒙古族非母语创作研究-以辽宁为例》 гэх номд тэмдэглэснээр “Инжиннаш өвөр монгол, хятад, төвд, санакрит хэлэнд чадамгай, иймээс хятад хэлээр бичсэн шүлэг болон орчуулсан сонгодог бүтээл нь бүхнээ тархав” гэжээ. Хэдийгээр дээрх хоёр зүйлийн адил бус тэмдэглэл байгаа боловч Инжиннашийн мэддэг хэлний талаар монгол, хятад, төвд хэл мэдэх нь эргэлзээ үгүй.

⁸ Энэхүү өгүүлэлд судлагдаж бий шигтгэл шүлэг нь “Нэгэн давхар асар”, “Улаанаа уйлах танхим” дахь бүлгийн дунд байгаа шүлэг болох юм.

⁹ Шү Лин. Монголчуудын төвд хэлэн дээрх утга зохиолын онолын тогтолцоо. ЛяоҮнХХ., 2014 т 619



THE CULTURAL WAY

Инжиннашийн “Нэгэн давхар асар”, “Улаанаа уйлах танхим” дахь шүлгийн мөр, шүлгийн бадаг нь “Улаан асрын зүүд”-ний бүлгийн дундах шүлэгтэй адилгүй, доор нэгэн жишээгээр үзүүлвэл, “Улаан асрын зүүд” дэхь шүлэг нь “花魂默默无情绪，鸟梦迟迟何处惊” гэх маягаар нэг нэг үгээ давтдаг. Гэтэл “Нэгэн давхар асар”, “Улаанаа уйлах танхим”-ын үүнтэй адил давталт нь зөвхөн нэгэн хэсэг л болно. “Нэгэн давхар асар”, “Улаанаа уйлах танхим”-ын шигтгэл шүлгийн хэлбэр нь тэр хэвээрээ “Зохист аялгуун толь”-ийн дуун чимгийн үйлдэл болох бөгөөд шигтгэл шүлэгт зөвхөн үйлдэхүйеэ бэрх чимгийн зүйлийг ашиглав. Доор “Нэгэн давхар асар”, “Улаанаа уйлах танхим”-д илэрч бий “Зохист аялгуун толь”-ийн дуун чимгийн үйлдэхүйеэ бэрх чимээр жишээлвэл, “Нэгэн давхар асар”-ын 9 дүгээр бүлгийн гарчиг “Цэнгэлийн дээр цэнгэлийг эрж цэцэгт нуур дур шүлэглэмой, ташаагийн дотор ташаагаар нийлүүлэн бэлэгт хатгуурыг хайрламой”-д мөн мөрийн дотор завсардсан үгс байна. Шүлэгт байх “цэнгэл, ташаа” нь бүр давтагдаж байгаа үгс мөн. Энэхүү бүлгийн гарчиг нь монгол шүлгийн толгой холбох аргыг хэрэглэсэн биш, харин “цэнгэл, ташаа” гэх хоёр үгийг сонгон завсардсан хос төгөлдөр чимгийн бүтцийг үүсгэн, “Зохист аялгуун толь”-ийн дуун чимгийн үйлдэхүйеэ бэрх хос төгөлдөр чимгийн арван хоёр зүйлийн чимгийн долдугаар зүйлийн чимгийн хэлбэр болох мөрийн эхэн болон мөрийн дунд завсардсан хос төгөлдөр чимгийн аргыг ашиглажээ. Дээрх бүлгийн гарчиг нь хэдийгээр “Зохист аялгуун толь”-ийн дуун чимгийн үйлдэхүйеэ бэрх хос төгөлдөр чимгийн мөрийн эхэн болон мөрийн дунд завсардсан хос төгөлдөр чимгийн аргыг ашигласан боловч шүлгийн мөрийн бүтцийн талаар “Зохист аялгуун толь”-ийн шүлгийн бадагтай адилгүй. “Зохист аялгуун толь”-ийн шүлгийн бадаг нь цөм дөрвөн мөр шүлгээр бүрдсэн байхад энэхүү бүлгийн гарчиг нь хоёрхон мөр шүлгээр бичигджээ. Тэр мөртөө энэхүү бүлгийн гарчигийн шүлэг нь хэлбэрийн талаар хятад үндэстний бүлэгт романы бүлгийн өмнөх шүлгийн нөлөө байхаас гадна “Зохист аялгуун толь”-ийн хос төгөлдөр чимгийн аргатай ч уялдуулжээ.

Бас “Нэгэн давхар асар”-ын 21 дүгээр бүлэгт Пү Ию-ийн уйлсныг дүрсэлсэн шүлэг “Нулимс нь цуварсан нүдээрээ нулимс нь цуварсан шүлгийг үзмой, гэдэс тасрах сэтгэлээр гэдэс тасрах хүнийг мөрөөдмөй” гэх шүлэгт байгаа хос төгөлдөр чимгийн давтаж бий үг нь “нулимс нь цуврах, гэдэс тасрах” болно. Энэ шүлэгт мөн “Зохист аялгуун толь”-ийн дуун чимгийн үйлдэхүйеэ бэрх хос төгөлдөр чимгийн 12 дугаар зүйлийн чимгийн 7 дугаар чимгийн зарчимаар зохиожээ. Гэвч



THE CULTURAL WAY

Инжиннашийн сонгосон нэгдүгээр давтаж бий үг “нулимс нь цуврах, нулимс нь цуварсан” гэдэг үг нь утгийн талаар нарийн ялгаатай. Энэхүү хоёр үгийн ялгаа зөрөө нь голдуу үйл үг болох “цуврах” болон “цуварсан”-д байна. “Цуврах” гэх үг нь “цувар+ах”-ын хувилбар мөн бөгөөд тэмдэг үйл үгийн ирээдүй цагийн илэрхийлж, өмнө хойнох үйл үгийн холболтын дунд ирээдүйд үүсэх үйл буюу хэргийг илтгэдэг, энэхүү өгүүлбэрт ирээдүйд урсах нулимсыг илтгэжээ. Монгол хэлний тэмдэг үйл үгийн дагавар “ху, хү, хуйца, хүйцэ” зэрэг дөрвөн дагавар байдаг, тэдгээр нь цөм ирээдүйд болох үйл явдлыг илэрхийлнэ. Мөн энд байгаа “цуварсан” нь “цувар+сан” гэх үйл үгийн хэлбэр болох бөгөөд “гсан, гсэн” дагавар нь тодорхой өнгөрсөн цагийн утгатай, цагаар тодотхон холбох “гсан, гсэн” нөхцөл нь өмнөх үйл үгийн хээ өнгөрсөн цагийг заахын зэрэгцээгээр уг үйл үгээ хойт үгтэй нь холбож хойд үгээ өнгөрсөн цагт харицах үйл үгээр тодотгоно¹⁰. Монгол хэлний тэмдэг үйл үгийн өнгөрсөн цагийг илтгэх дагавар нь “гсан, гсэн, сан” гэж гурав байдаг. Тэдгээр нь цөм өнгөрсөнд болсон үйл буюу явдлыг илтгэдэг. Иймээс Инжиннаш өврийн шигтгэл шүлэгтээ адилхан үгийг сонгон хос төгөлдөр чимгийн зарчмаар шүлэг зохиохдоо зөвхөн үгийг давтахын тул адилхан үгийг л сонгосон бус, харин монгол хэлний үйл үгийн цагийн хувирлаар утгийн адил бусыг илэрхийлдэг. Энэ нь Инжиннаш зохиолдоо хэдийгээр “Зохист аялгуун толь”-ийн дуун чимгийг ашигласан боловч монгол үндэстнийхээ хэл уран зохиолын илтгэх аргын суурин дээр авч хэрэглэсэн байна гэдгийг харуулж байна.

Инжиннашийн “Нэгэн давхар асар”, “Улаанаа уйлах танхим”-д нийт 286 шүлэг байж, шүлгийн олонх нь шигтгэл шүлэг буюу гарчиг шүлэг байж, шүлгийн мөр нь 1164 мөр байдаг. Гэтэл “Зохист аялгуун толь”-ийн дуун чимгийн зарчмаар бичсэн шүлэг нь харьцангуй бага юм.

Бас жишээлбэл, “Нэгэн давхар асар”-ын шигтгэл шүлэг “Хүлис бүхий удвалын чанар тунгалаг, хүсэл бүхий хүний зан амурлингуй. Хүйтэн шүүдрийн алтны цогцос чихимэй, хөдөлгөх салхины хасын гишүүн чанга, хүчирхэгийг уграад өморхогийг бас угаргаж, хөөр дур ухамжтай дур найр дур нэн ухамжтай”-д байгаа “уграад, ухамжтай” гэх хоёр мөр шүлэгт илэрч бус давтагдсан үг болно. Инжиннаш монгол үйл үг “уграх”-ын адил бус байдлын хувирал болон “ухамжтай” гэх тэмдэг үг болон үйл үгийн үгсийн сангийн ялгалаар утгын адил бусыг илрүүлжээ. Инжиннашийн дээрх нэгэн бадаг найман мөр шүлгийн хоёр

¹⁰ Б.Бямбаасан. Орчин цагийн монгол хэлний үг зүйн байгуулалт. ӨМСХХХ., 1992 т 198-199



THE CULTURAL WAY

мөрт нь үг давтагдаж байдаг, даруй “уграад, угаргаж, ухамжтай” зэрэг үгс болно. Тэр мөртөө үгийн утгийн талаар тодорхой ялгаатай нь “огураад, огургаж” гэх хоёр үг болно. монгол хэлний “огураад” нь “огуру+аад” гэх үгийн хувилвар болох бөгөөд “аад/оод, ээд/өөд” гэх дагавар нь нөхцөлөөр илрэх хэлний зүйн утга нь нэг тохиолдолд байдал, нөгөө тохиолдолд цагийг заах утгатай байж болно. “огураад” нь өнгөрсөн цагийг илтгэж байна. “огургаж” нь харин зэрэгцсэн утгыг гаргадаг байна. Монгол хэлний зэрэгцсэн нөхцөл үйл үгийн дагавар нь “ж, ч” гэх хоёр дагавар юм. Энэ хоёр дагавар нь үйлийн зэрэгцэн үүсч байгааг илтгэнэ. Монгол хэлний нөхцөл үйл үг нь олонх байдалд өгүүлбэрийн дотор ганцаар илрэхгүй, харин хоёр буюу хоёроос дээш зэрэгцсэн нөхцөл хамтаар зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр болох буюу бусад үйл үгтэй хамт нэгэн өгүүлбэрт илрэх үед нөгөө үйл үгийн хээ уридал болдог. Монгол хэлэнд “огураад, огургаж” гэх үгийг угсаруулан хэрэглэх тохиолдолд, ямар нэгэн үйл нь зохих хугацаанд үргэлжлэн үүсч байгаа байдлыг илтгэнэ. Инжиннаш энэхүү шигтгэл шүлэгтээ нөхцөл үйл үгийг угсаруулан хэрэглэж, адил бус дагаварын адил бус хувиралаар үйлийн үргэлжлэн үүсч байгааг илэрхийлэв.

“Улаанаа уйлах танхим”-ын 7 дугаар бүлэгт илэрсэн шигтгэл шүлэг “Өнгөрөх дорно салхинаа өврийн дураар хийстүгэй, өнгөрөх дорно салхин өврийн дураар хийстүгэй” гэх хоёр адилхан мөрөөр давтаж байгаа нь “Зохист аялгуун толь”-ийн дуун чимгийн үйлдэхүйеэ хялбар чимгийн хоёрдугаар зүйлийн нэгдүгээр мөрийг хоёрдугаар мөрт давтах хос төгөлдөр чимэг болно. Энэхүү хос төгөлдөр чимгийг “Зохист аялгуун толь”-д нэгдүгээр мөрийг хоёрдугаар мөрт давтаж, гуравдугаар мөрийг дөрөвдүгээр мөрт давтах хос төгөлдөр чимэг гэдэг. Гэвч Инжиннаш зөвхөн өмнөх хагас, даруй нэгдүгээр мөрийг хоёрдугаар мөрт давтах хос төгөлдөр чимгийн аргыг л хэрэглэжээ. Гэвч Инжиннашийн шүлэгт “салхинаа, салхин” гэх хоёр үг нь үгийн утгийн талаар адил боловч ялгаа их, “салхинаа” нь “салхинд хийсэх” гэх санааг гаргахад, “салхин” нь үнэнхүү өврөө салхинд дураар хийсэх гэх санааг илтгэсэнээр утгын ялгаа их болсон байдаг. Энэхүү чимэг нь Алшаа лхарамба Агваандандарын “Зохист аялгууны толын гурван бүлгийн жишээ үлгэрлэл саруул оюутаны хүзүүн чимэг үзэсгэлэнт сувд эрих хэмээгдэх оршвой” -д “нэгдүгээр мөр нь хоёрдугаар мөрийг хоёрдугаар мөрт давтах, гуравдугаар мөрийг дөрөвдүгээр мөрт давтах”¹¹ гэж бичдэг. Гэтэл төвд үндэстний <藏族诗学修辞指南> гэх номд энэхүү

¹¹ Б.Гэрэлт. Нүдэнийг баясгахуй сувдын унжилга. ӨМСоХХ., 1991 т 456



THE CULTURAL WAY

чимгийг “нийтээр үг давтах” хятадаар “普遍叠字” хэмээн нэрлэх бөгөөд зургаан зүйлийн үг давтах аргийн дөрөвдүгээр нь болно¹².

Мөн “Улаанаа уйлах танхим”-ын 14 дүгээр бүлгийн шигтгэл шүлэг “Сэтгэл тавин цэцэг таривас цэцэг эс дэлгэрээд, санаан үгүй уда хадхавас уда сүүдэртэй болзухуй”-д “цэцэг, уда” нь давтагдаж буй үг болох бөгөөд энэ мөр шүлэг нь монгол шүлгийн “са” авиагаар толгой холбосон байдаг. Энэхүү шүлэгт “Зохист аялгуун толь”-ийн дуун чимгийн үйлдэхүйеэ бэрх чимгийн арванхоёрдугаар зүйлийн чимгийн хин дөрвөн мөрийн мөрийн дунд завсардсан хос төгөлдөр чимэг болно. Гэтэл Инжиннашийн шүлэгт хоёрхон мөрт “Зохист аялгуун толь”-ийн чимгийн зарчмыг ашигласанаараа шүлгийн мөрийн тоо нь Энэтхэг Төвдийн “Зохист аялгуун толь”-ийн дөрвөн мөр нэгэн бадаг шүлэг болдогтой ч адилгүй мөртөө монгол үндэстний уламжлалт шүлэг нэгэн бадаг шүлэг нь толгой буюу сүүл холбон бичдэг уламжлалтай ч ондоо болсон байна. Ийм үзэгдэл нь энэтхэг төвөдийн шүлэг зүйн зарчмыг хятад монгол шүлгийн уламжлалтай органикаар уялдуулсан нийтлэг жишээ болжээ.

Гэвч, “Нэгэн давхар асар”, “Улаанаа уйлах танхим”-д байгаа шигтгэл шүлэг нь бүхэлдээ энэтхэг төвөдийн “Зохист аялгуун толь”-ийн чимгийн нөлөөг хүртсэн биш, зарим нь монгол үндэстний уламжлалт шүлэг буюу ардын аман зохиолын магтаал, шүлгийн үг буюу сургаал шүлгийн аргаар бичигдсэн байдаг ч зарим нь хятад үндэстний хэмжээт шүлгийн онцлогийг тодорхой тусгасан байдаг.

Энэтхэг төвөдийн “Зохист аялгуун толь”-ийн дуун чимгийн зарчимаар бичигдсэн шигтгэл шүлгийг ярихад, “Нэгэн давхар асар”-ын шүлгийн мөр нь “Улаанаа уйлах танхим”-ын шүлгийн мөрөөс мөрийн тоо илүү байдаг. Энэ нь Инжиннашийн үзэл санаа нь хойно өмнө хувиралт гарсантай холбоотой байж мэднэ. Өмнөх үед зохиогдсон “Нэгэн давхар асар”-ын шүлгийн мөр эсвэл агуулгийн дунд бурхны шашны үзэл санаа бүхий үлгэр байх бөгөөд энэтхэг төвөдийн “Зохист аялгуун толь”-ийн зарчмыг ч ашиглажээ. Гэтэл түүнээс сүүлд зохиогдсон “Улаанаа уйлах танхим” нь үзэл санааны хувьд өрнөдийнхний ойрх үеийн эмэгтэйчүүдийн өвөрмөц чанарын чөлөөлөлттэй ойртохын зэрэгцээ хэлбэрийг чухалчилдаг “Зохист аялгуун толь”-ын дуун чимгийн зарчмыг ч төдий л хэрэглэхээ байжээ.

¹² “Нийдэм үг давтах” тухай <藏族诗学修辞指南> гэх номд “Магтаал шүлэгт шүлгийн мөрийг хоёр удаа давтах аргыг нийдэм үг давтах арга гэдэг” гэжээ.



THE CULTURAL WAY

Инжиннашийн “Нэгэн давхар асар”, “Улаанаа уйлах танхим”-ын гарчиг шүлэг, болон шигитгэл шүлэг нь агуулга хэлбрийн талаар ийм баялиг байдаг нь Инжиннашийн монгол, хятад, манж, төвөд зэрэг олон хэлний боловсрол сайнтай ч зохих холбоотой. Инжинашийн “Нэгэн давхар асар”, “Улаанаа уйлах танхим”-д байгаа шигтгэл шүлэг нь монгол үндэстний аман зохиол бичгийн зохиолын шилдэг уламжлалыг өвлөн залгамжласнаас гадна, ах дүү үндэстний уран зохиолын давуу талыг ч шингэжээ. Тийм мөртөө Инжиннашийн шигтгэл шүлэгт хэрэглэсэн “Зохист аялгууны толь”-ийн дуун чимгийн үг давтах аргийг хэрэглэсэн нь зөвхөн үгийг л давтаж байгаа биш, харин шүлгийн найруулгын шаардлагаас үйл үгийн байдал буюу үгсийн сангийн адил бусаар санаагаа илтгэдэг. Энэ нь нэгэн зүйлийн шинэчлэл болох бөгөөд Инжиннаш хятад үндэстний бүлэгт романы бүлгийн дундах шүлэгтэй адилгүй арга маягийг хөөцөлдөж байсны чухал баримт мөн. Инжиннашийн “Нэгэн давхар асар”, “Улаанаа уйлах танхим”-даа хэрэглэсэн үгийн давталт нь “Зохист аялгуун толь”-ийн дуун чимгийн нөлөөг хүртсэн боловч төвөд хэл дэхь “Зохист аялгуун толь”-ийн тайлбараас тодорхой ялгаатай. Олонхдоо хоёр мөрөөр нэгэн шүлэг болдог хятад үндэстний бүлэгт романы хэмжээт шүлгийн ашигладаг арга, гэтэл Инжиннашийн шигтгэл шүлэгт илэрч буй үгийн давталт нь энэтхэг төвөдийн “Зохист аялгуун толь”-ийн нийтээр хэрэглэдэг зарчим болно. Инжиннашийн шигтгэл шүлэг нь хятад үндэстний хэмжээт шүлэг болон энэтхэг төвдийн шүлэг зүйн зарчмыг харилцан уялдуулсан нийтлэг жишээ болсон байна.

Дээрхийг хураангуйлахад, Инжиннашийн “Нэгэн давхар асар”, “Улаанаа уйлах танхим”-ын шигтгэл шүлгийн хэлбэр маш баялаг. Инжиннашийн энэхүү шинэчлэл нь хоёр талын чухал утга агуулгатай. *Нэгт*, “Зохист аялгуун толь”-ийн дуун чимгийн зарчим нь монгол бичигтний романд байгаа шигтгэл шүлэгт анх удаа ашиглагдсанаараа монгол үндэстний уран зохиолын уламжлалд “Зохист аялгуун толь”-ийн чимэг нь монгол лам нарын төвөдөөр бичдэг уламжлалыг баялагжуулав. *Хоёрт*, Инжиннашийн “Нэгэн давхар асар”, “Улаанаа уйлах танхим”-ын шигтгэл шүлгийн хэлбэр нь монгол үндэстний монгол хэлээр зохиодог шигтгэл шүлгийн хэлбэрийг ихээр шинэчилжээ.



THE CULTURAL WAY

Гурав. “Нэгэн давхар асар”, “Улаанаа уйлах танхим”-ын үзэл санаа нь өрнөдийнхний эмэгтэйчүүдийн өвөрмөц чанарын чөлөөлттэй уялдах нь

“Нэгэн давхар асар”, “Улаанаа уйлах танхим” нь цөм хар тамхины дайнаас сүүлд буй болсон байна. “Нэгэн давхар асар” нь бараг Инжиннашийн хорин наймаас хорь есөн насны хороонд (1864он-1865он) бичигдсэн бөгөөд энэ нь Инжиннашийн ээж аавынх нь залуугийн үеийн янаг хайр болон ураг хуримын зол бусаар үндсэн материал болгосон уран бүтээл болно¹³. “Улаанаа уйлах танхим” нь Инжиннашийн ээж нас барсаны дараа даруй 1876 оноос эхлэн бичиж, дараа жилд нь бичиж дуусав. Тухайн үеийн Чин улс нь хагас колони хагас феодалын нийгэмд орохын зэрэгцээ эзэрхэг түрэмгий ёс, феодал ёсыг эсэргүүцэх, эрх тэгш ардчилалыг эрмэлзэх, өвөрмөц чанарын чөлөөлөлт бүхий ардчилалын үзэл санааны урсгал нь мөн хятад улсад маш их хурдаар уламжлан тархаж, Инжиннаш нь яг ийм нийгмийн үзэл урсгалын нөлөөг хүртэв¹⁴.

Олны мэдэхээр, “Нэгэн давхар асар”, “Улаанаа уйлах танхим”-д эрэгтэй эмэгтэйн ураг хуримаас гадна, феодалын ёс дүрмийн доорх эмэгтэйчүүдийн өвөрмөц чанарын чөлөөлөлтийн асуудлыг бичжээ. “Улаанаа уйлах танхим”-д Бэй Пүюү зүүдэндээ Лү Мэй, Чин Мө болон Шэн Рү-г эржээ. Энэ үед Лү Мэй, Чин Мө болон Шэн Рү цөм ургийн болзоотой байж, Шэн Рү нь хуримлаагүйгээр урьдаар бэлэвсэн болж, Лү Мэй болон Чин Мө нь цөм Пү июг бодож албаар эзэн мэдүүлсэнгүй урагт дургүйцэн хурим хийхээс өмнө Лү Мэй нь эрэгтэй хүний хувцасыг өмсч харангуй шөнөөр зугтаажээ. Чин Мө нь мөрөнд харайж аврагдан харь нутагт тэнүүчлэв. Тэд нар аль олон хүчир саадыг туулж, хамгийн сүүлдээ Ханжоу-д Пү ию-тэй уулзсан байна. Шэн Рү нь ч Жин Фүрэн эзэн мэдэж, Пү Ию-тэй ураг тогтсон байдаг. Инжиннашийн зохиол нь хайртай хүн нь цөм төгөс төгөлдөр төгсгөлтэй болох гэх гол аясаар Пү Ию нь гурван охиныг хатанаар буулган авсан гоё үр дүнтэй болсон юм. “Улаанаа уйлах танхим” гэх зохиолын төгсгөлийн нэгэн бадаг шүлэгт “Элэр балар гурван жилийн хэрэг, өдөр дөл нэгэн үдийн зүүдэн, үүний дотрох үнэн магадыг эрвээс эвэрт туулай үст мэлэхийн зүрх” гэж бичсэн нь эрэгтэй эмэгтэй зохиолын баатрын баярт төгсгөл нь зөвхөн зүүд төдий гэдгийг дамаар харуулжээ.

¹³ 扎拉嘎：《比较文学：文学平行本质的比较研究—清代蒙汉文学关系论稿》，呼和浩特：内蒙古人民出版社，2002年，第187页。



THE CULTURAL WAY

Инжиннашийн зохиол дахь Лү Мэй, Чин Мө ураг хуримыг эсэргүүцэхдээ “явах” маягаар эсэргүүцэж Лү Мэй харанхуй шөнө эрэгтэй хүний хувцасыг өмсөж зугтаажээ. “Лү Мэй-ийн учрал хүсэл хөөцөлдөл болон шаардлага нь тухайн нийгэмд нийтэд нь оршиж байгаа үзэгдэл. Иймээс түүний эсэргүүцэл нь нэн гүнзгий бөгөөд төлөөлөх чанартай болж чаджээ ... Түүний эсэргүүцэл нь тухайн үед маш олон тооны эмэгтэйчүүдэд хүсэл зориг авчирчээ. Тэднийг хавсран тухайн нийгмийн муу муухай байдлыг зөв таниулах мөн өөрийн биеэр зөвөөр таних эрч зориг авчрав. Иймээс түүний ажил нь монгол эмэгтэйчүүдийн өөрийнхөө хүсэл зоригийг хөөцөлдөж болно гэсэн шинэ цаг иржээ гэдгийг мэдүүлсэн. Тэр нь монгол үндэсний уран зохиолын түүхэн дэхь мөнхийн жишээ болж тухайн үеийн хятад үндэсний уран зохиол ч жишээ утга үүрэгтэй болжээ.¹⁵ Чин Мө өөрийн хайрласан хүндээ төв үнэнч, ямарваа харш саадыг хайхралгүй үхлээр феодалын ургийн ёсыг эсэргүүцэж хоёулаа хэдийгээр идэвхитэй болон идэвхигүй эсэргүүцлийн ялгаа байвч Инжиннаш цөм “явах” маягийг сонгожээ. Эдгээр нь уламжлалт ёс суртлыг давж эмэгтэйчүүдийн уламжлалт байр суурийг үгүйсгэжээ. Тэд нар өөрийн аз жаргалаа хөөцөлдөж, өөрийн хувь заяагаа сонгож эзэмдэж бүр болно. Иймэрхүү эмэгтэйчүүд нь үзэл санаа чөлөөтэй онцгойлон өөрийн хайр дурлалаа чөлөөтэй сонгож болно.

Инжиннашийн романд уламжлалт феодалын ёс суртахууныг эсэргүүцсэн Лү Мэй, Чин Мө мэтийн өвөрмөц чанарын чөлөөлөлтийн зориг санаа бүхий эмэгтэйчүүдийн дүрийг бүтээжээ. Лү Мэй болон Чин Мө нь Инжиннашийн зохиолд дорой буурайгийн төлөөлөл биш, харин тэд өөрийн үзэл санаатай мөртлөө өөрийн үйлдлээрээ үүнийг гэрчлэв.

Зохиогчийн ажигласнаар эмэгтэй зохиолын баатар феодалын ургийн ёсыг эсэргүүцэх болон зохиолын төгсгөлд монгол үндэсний ураг хурим чөлөөтэй гэх үзэл санаа байхаас гадна өрнө дахины эмэгтэйчүүдийн өвөрмөц чанарын чөлөөлөлт хийх үзэл санаатай төсөөтэй байдаг. Доор дэлхийн уран зохиолын түүхэн дээр адилхан цаг үеийн хэдэн зохиолоос жишээ татъя.

Өрнө дахины сонгодог уран зохиолын дотор Ifson-ний жүжиг “Хүүхэлдэйн гэр” нь 19 дүгээр зууны сүүл үед бичигдэв. Зохиолч Ifson урлагч, шүлэгч болохын хувьд маш чадамгайгаар тухайн нийгмийн

¹⁴ 尹湛纳希著 甲乙木翻译：《一层楼》（汉文），呼和浩特：内蒙古人民出版社，1978年，第1页。

¹⁵ 乌兰：“试析《一层楼》炉梅形象”，新疆师范大学学报（哲学社会科学版），1989年第4期。



THE CULTURAL WAY

эмэгтэйчүүдийн эрх тэгш байх асуудлыг олж харсан мөртлөө эмэгтэйчүүдийн чөлөөлөлтийн хөдөлгөөний тухай давшсан санал дэвшүүлэв¹⁶. Одоо болтол “Хүүхэлдэйн гэр” нь эмэгтэйчүүдийн чөлөөлөлтийн асуудлын талаар маш сонгодог зохиол болсоор байгаа билээ. Энэхүү зохиолд эмэгтэйчүүд сэрэх хэрэгтэй гэх асуудлыг дурьдаж эрэгтэйчүүд эрх мэдэлтэй нийгэм болон эмэгтэйчүүдийн чөлөөлөлтийн хоорондох зөрчил мөргөлдөөнийг илрүүлэв. “Хүүхэлдэйн гэр”-т Нара “явах” маягаар эмэгтэйчүүдийн өвөрмөц чанарын чөлөөлөлтийн асуудлыг тусгажээ. Бараг адилхан цаг үед бичигдсэн Лев Толстой “Анна Каренина”-г 1877 онд бичиж дуусав. Зохиолд Анна анх шударга бус бэр байснаасаа дотоод сэтгэл маш баялаг өвөрмөц чанарын чөлөөтэй үзэл санаатай эмэгтэй болжээ. Эдгээр зохиол бүтээлд адил бус талаас эмэгтэйчүүд өөрийн хайр дурлалаа чөлөөтэй хөөцөлдөх ураг хуримын эрх чөлөөтэй болон эмэгтэйчүүдийн чөлөөлөлт болон сэргэлтийн асуудлыг тусгажээ.

Гэтэл Инжиннашийн романд эмэгтэй зохиолын баатрын эцсийн төгсгөл нь “Улаан асрын зүүд”-ээс ялгаатай. Энэ үзэгдэл нь зөвхөн феодалын ураг хуримын ёсыг эсэргүүцсэн асуудал төдий биш харин түүний үзэл санааны дэвшилтэт шинжид байна. Онцгойлон Инжиннашийн “Улаанаа уйлах танхим”-д тусгайлан эмэгтэйчүүдийн өвөрмөц чанарын чөлөөлөлт хийх үзэл санаа нь өрнө дахины ойрх үеийн дэвшилтэт үзэл санаатай адил. Энэхүү үзэгдэл нь харин дэлхийн уран зохиол болон улсын дотоодын уран зохиол гэх ялгаа байвч үзэл санааны хувьд адилхан. Дэлхийн олон улсын адилхан цаг үед амьдарч байсан зохиолчид цөм эмэгтэйчүүдийн өвөрмөц чанарын асуудлыг анхаарч байжээ. Инжиннашийн “Нэгэн давхар асар” болон “Улаанаа уйлах танхим”-ын үзэл санааны хүрээнд улсын дотно гадна гэж ялгалгүй нэн хоцронгуй хязгаарын орны монгол үндэстний ойрх үеийн зохиолчийн уран зохиолд ч ойрх үеийн дэвшилтэт үзэл санаатай гэдгийг гэрчилж байна.

Тухайн үед Инжиннаш зөвхөн феодалын ураг хурим гэх гол сэдвийг анхаарч байсан төдий биш. Харин эмэгтэйчүүдийн хувь заяаг анхааралдаа авч эмэгтэйчүүдийн учралыг өрөвдөж байжээ. “Улаанаа уйлах танхим”-ын төгсгөл нь эмэгтэйчүүдийн сайн сайхан, зол жаргал амьдрал болон хувь заяаг нь хүлээгээд ирдэг биш харин эмэгтэйчүүд өөрсдөө хөөцөлдвөл тэдний үр дүн сайн болно гэдгийг харуулж байна.

¹⁶ 《外国文学史》编写组：《外国文学史》（第二版下册），北京：高等教育出版社，2018年，第37页。



THE CULTURAL WAY

Инжиннашийн романд илэрсэн үзэл санаа нь эмэгтэйчүүд өөрсдөө дотроосоо сэргэн өвөрмөц чанараа чөлөөлнө гэдгийг илрүүлжээ. Манж чингийн монголчуудын нийгэм нь нийтдээ эрэгтэйчүүд эрх мэдэлтэй нийгэмд эмэгтэйчүүдийн мэдрэх болон эмэгтэйчүүдийн өвөрмөц чанарын чөлөөлөлтийн үзэл санааг илрүүлсэн нь маш ховорхон. Энэхүү үзэгдлийн тухай Инжиннаш тухайн үед өрнө дахины уран зохиол буюу өрнө дахины үзэл санаатай танилцаж байсан гэдэг. Энэ тухай сурвалж бичигт тодорхой тэмдэглэл байхгүй боловч романд адилхан үзэл санааг илрүүлсэн нь уран зохиолд адилхан цуурай болсон үзэл санаа нэгдэж байна.

Үзэл санааны хувьд илэрсэн эдгээр төсөөтэй үзэгдлийг бид зөвхөн нөлөөлөх болон нөлөөлөгдөх нэг талаас харж болохгүй. Энэ нь ойрх үеийн улсын гадаад дотоодын буюу монгол үндэстний дотоодод эсвэл өрнө дахины онцгойлон дэлхийн үзэл санааны хүрээнд адилхан асуудал буюу төвөгтэй байдал байж эдгээр зохиолчид өөрийн болон зохиолдоо адилхан бодол санаатай байсан боломж бий. Эдгээр нь уран зохиолын зэрэгцээ судлалын үед маш баялаг судалгааны орон зайг хангав.

“Нэгэн давхар асар” болон “Улаанаа уйлах танхим”-ын үзэл санаа нь өрнө дахины ойрх үеийн үзэл санаатай төсөөтэй үзэгдэл нь Инжиннаш болон өрнө дахины зохиолчид үзэл санааны талаар адилхан байсныг илрүүлжээ. Судлаачид зэрэгцээ судлалаар үндэстэний уран зохиолын өөрийнх нь зөрөөт байдлыг үгүйсгэж орон зайны хязгаарыг давж үзэл санааны адилхан байдлыг эрдэг гоо сайханы журам горимыг илэрхийлж болно. Дэлхийн уран зохиолын хүрээнд илэрсэн дэвшилтэт үзэл санаа нь Манж чин үеийн монгол оронд адилханаар илэрдэг нь монгол үндэстний уран зохиол нь ойрх үеийн уран зохиолын урсгал түүний гэрэл гялбаатай гэдгийг харж болно.

Инжиннашийн роман нь өөрийн үндэстэнийхээ уран зохиолыг уламжилж шинэчилснээс гадна Энэтхэг, Төвдийн “Зохиост аялгууны толь”-ийн уламжлал. Хятад үндэстний романы зохион бичих ур мэргэшил зэргийг ашигласан мөртлөө өрнө дахины уран зохиолын үзэл санаатай төсөөтэй болсон нь монгол үндэстэний уран зохиолын зохион бичих арга болон ур мэргэжлийг ихээр баялаг болгожээ.



THE CULTURAL WAY

ДҮГНЭЛТ

Дээрхийг хураангуйлбал Инжиннашийн “Нэгэн давхар асар” болон “Улаанаа уйлах танхим” нь хятад, монгол, төвөд зэрэг олон үндэстний уран зохиолын харилцан уялдсан бүтээл төдийгүй түүний агуулга, хэлбэр, үзэл санааны олон талт шинж болон гүн гүнзгий чанараараа монгол үндэстний ойрх үеийн сонгодог уран зохиол болжээ. “Нэгэн давхар асар” болон “Улаанаа уйлах танхим” нь агуулга бүтцийн талаар хятад үндэстний сонгодог уран зохиол “Улаан асрын зүүд”-ний нөлөөг хүртсэн байна. Шигтгэл шүлэг нь энэтхэг төвөдийн “Зохист аялгууны толь”-ийн дуун чимгийн зарчмыг бага хэмжээгээр ашиглаж үзэл санааны талаар өрнө дахины уран зохиолд илэрсэн үзэл санаатай төсөөтэй болжээ. Иймээс Инжиннашийн романд агуулга, хэлбэр, бүтэц, үзэл санаа зэрэг олон талаар маш олон зүйлийн уялдаа болон бүтээлч талууд олон байдаг.

ABSTRACT

“Negen dabqar asar” and “Ulaanaa uilaq tanqim” were influenced by the Chinese classical literature “Ulaan asar-in zuud” in terms of content and structure. Shiggat poem uses to a lesser extent the melodic principles of the Central Indian “Zoqist ayalguni toli” and is similar to the ideas found in Western literature about ideas. Therefore, Injinnash's novel has a lot of coherence and creativity in many aspects, such as content, form, structure, and ideas.

Key words: Injinnash, Negen dabqar asar, Ulaanaa uilaq tanqim, multi-heard culture



THE CULTURAL WAY

НОМ ЗҮЙ

1. Инжиннаш. Улаанаа уйлах танхим. ӨМАХХ., 1981
2. Инжаннаш. Нэгэн давхар асар, ӨМАХХ., 1978
3. Эрдэнэтогтохын зохиолын сонгомол. ЛяоҮнХХ., 1988
4. Б.Гэрэлт. Нүдэнийг баясгахуй сувдын унжилга. ӨМСоХХ., 1991
5. Б.Бямбаасан. Орчин цагийн монгол хэлний үг зүйн байгуулалт. ӨМСХХХ., 1992
6. Шү Лин. Монголчуудын төвд хэлэн дээрх утга зохиолын онолын тогтолцоо. ЛяоҮнХХ., 2014
7. Хөгжилт: 《尹湛纳希与儒家文化》，沈阳：辽宁民族出版社，2021年，第187页。
8. 刘魁立：《继往开来-全国少数民族文学史学术会议上的发言片断》，《民族文学研究》，1987年第2期。
9. 扎拉嘎：《比较文学：文学平行本质的比较研究-清代蒙汉文学关系论稿》，呼和浩特：内蒙古人民出版社，2002年
10. 尹湛纳希著 甲乙木翻译：《一层楼》（汉文），呼和浩特：内蒙古人民出版社，1978年
11. 乌兰：“试析《一层楼》炉梅形象”，新疆师范大学学报（哲学社会科学版），1989年
12. 《外国文学史》编写组：《外国文学史》（第二版下册），北京：高等教育出版社，2018年

СУРГАЛТЫН ОРЧИН ДАХЬ АНГЛИ ХЭЛНИЙ ЭЗЭМШИХҮЙН СУДАЛГААНЫ
ТОЙМ

Бао Саруул*

ХУРААНГУЙ

Сургалтын орчин дахь англи хэлний эзэмшихүй бол голчлон сургалтаар дамжин англи хэлийг суралцах явцын судалгааны хүрээ болно. Тэр бол тусгайлан хичээлийн танхимын хэлний сургалтаас суралцагчдад үзүүлэх нөлөөг судалдаг. Ойрын жилд заах сургалтын орчин дахь англи хэлний эзэмшихүй нь түүний хэлний сурлагын үр бүтээл дэх чухал их нөлөөнөөс болж дэлгэрэнгүй судалгааны гол сэдэв болсон байна. Тус өгүүлэл заах сургалтын орчин дахь англи хэлний эзэмшихүйн онолын суурь жич гол судалгааны агуулгыг тайлбарлаж, дараа нь үргэлж хэрэглэдэг судалгааны аргыг танилцуулж, улсын дотоодын нэн олон судлаачид хийгээд багш нараас англи хэлний эзэмшихүйн судалгаанд урам хайрлахыг хүссэн байна*.

Түлхүүр үгс: *Заах сургалтын орчин, англи хэлний эзэмшихүй, судлах агуулга, судлах арга*

Гадаад хэлний эзэмшихүй бол 1960 оны сүүлчээр бий болсон аясаар буюу жолоодох орчинд хэрхэн эх хэл бус хэлийг сурах асуудлыг шийдвэрлэхээр зорилгоо болгосон судалгааны хүрээ болно. Заах сургалтын орчин дахь (instructed) англи хэлний эзэмшихүй нь түүний шинээр хөгжсөн хуваарь хүрээ болсны хувьд хойнох байдалд төвлөрүүлэн, сургалтын нөлөөг илэрхийлэхийг зорьдог, даруй заах аргын англи хэл суралцах явцад үзүүлэх нөлөө болно¹. Хичээлийн танхимтай шууд холбогдох их хэмжээний онол ба гэрчлэлтийн судалгаа

* Өвөр Монголын Багшийн Их Сургуулийн Гадаад Хэлний Дээд сургуулийн лектор

* Тус өгүүлэл бол 2022 оны Өвөр Монголын Багшийн Их Сургуулийн суурь шинжилгээ судалгааны төрөл зүйл (зөвшөөрсөн номер: 2022JBQN067)-ийн онц чанартай бүтээл болно.

¹ Ortega, L. 2013. SLA for the 21st century: Disciplinary progress, transdisciplinary relevance, and the bi/multilingual turn [J]. Language Learning 63: 1-24.



THE CULTURAL WAY

нь сургалтын орчин дахь англи хэлний эзэмшихүйг бүрэлдүүлж, түүнийг бусад хамаа бүхий хуваарь хүрээнээс ялган гаргасан байна. Түүний чанга хэрэглээний чанарын онцлогоос болж, судалгаа болон сургалтын хоорондох харьцааг чухалчилж, түүний судалгааны үр дүн нь манай улсын англи хэлний заах сургалтад чухал бодит чиглүүлэх ач холбогдолтой юм.

Заах сургалт нь англи хэлний эзэмшихүйд үйлдэл үзүүлж чадах эсэх асуудлын тухай судалгааны гүнзгийрэхийг дагалдан, заан сургах орчин дахь англи хэлний эзэмшихүйн тухай судалгаа нь аажмаар эрдэм шинжилгээнийхэнд чухалчлагдсан байна. Хичээлийн танхимыг ажиглах этгээд болгож англи хэлний эзэмшихүйг судлах нь манай улсын гадаад хэлний хичээлийн танхимын орчинтой нэн авцалдаж байдаг.

Манай улсад instructed гэдгийг “заах сургалтын орчин дахь”, “хичээлийн танхимын орчин дахь”, “хичээлийн танхимын заах сургалт дахь”, “жолоодлого доорх”, “хичээллэх маяг дахь” хэмээн орчуулж байна. Гэвч анхаарууштай нь заах сургалтын орчин тойрон нь зөвхөн уламжлалт утга агуулга дээрх хичээлийн танхимыг л заах бус, бас хичээлийн гаднах, улсын гаднах сурлагын төрөл зүйл, компьютерийн тусламж хэлний сурлага, цахимын сурлагын орчин тойрон зэргийг багтаана. Жишээлбэл, хийсвэр хичээлийн танхим бол улмаас улам дэлгэрч байгаа англи хэлийг суралцах орчин болж, сурагчид цахим дээр ба цахимаас гадна, бүрмөсөн цахим дээр буюу холилдох хэлбэрийн хичээлэлтийн хооронд сонголт хийж болно.

Нэг. Заах сургалтын орчин дахь англи хэлний эзэмшихүйн судалгааны онолын суурь

Заах сургалтын орчин дахь англи хэлний эзэмшихүйн судалгаа нь нийгмийн удирдамжаас мэдрэхүйн удирдамж хүртэлх бүх талын онолоор толилон, англи хэлийг хэрхэн хамгийн сайн заахыг судалдаг. Мэдрэхүйн үзэл нь англи хэлний эзэмшихүйд холбогдох сэтгэцийн явцыг голлодог. Үүнд хэлний оруулалт (input) ба суудал, хэрхэн мэдлэгийг төрөлх хэлнээс англи хэлэнд шилжүүлэх жич хэрхэн хэл зүй ба үгсийн сангийн дотоод далд ба гадаадын ил мэдлэгийг хөгжүүлэхийг багтааж байна. Заах сургалтын орчин дахь англи хэлний эзэмшихүйг танин мэдэх арга нь ердөө оруулан боловсруулах, чээжлэх ба анхаарлын онолд түшиглэдэг. Жишээлбэл, оруулан боловсруулах онол, мэргэшил эзэмших онол, харилцан үйлчлэлийн арга зэрэг болно.



THE CULTURAL WAY

Оруулан боловсруулах онол нь суралцагчийн оруулалтаас байгуулагдсан хэлбэр ба утгын холболтын тогтоцод холбогдох мөртөө яагаад зарим оруулалтыг харалт хэлний мэдлэгийг бий болгон, бусад оруулалт нь тийм бус гэдгийг тайлбарласан байна. Билл Ванпаттен-аас аливаа заан сургалтын арга маягаар дамжин суралцагчийн анхаарлыг хүлээж авахад бэлэн байгаа харалт хэлний оруулалтын хэлбэр дээр шилжүүлэх нь маш чухал гэж санаачилсан байна².

Мэргэшил эзэмших онол нь мэргэшил эзэмшихэд тоочилтын чанартай мэдлэгээс эхэлдэг, даруй дүрэм ба мэдлэгээс эхэлдэг гэж Роберт Декейсер дурдан гаргажээ. Дахин давтан боловсрох ба ашигтай хариу тусгалаар дамжин, хүн төрөлхтөн ур мэргэжил хүртэж, нэн өндөр оновчтой чанар ба урсам шулуунаар тогтсон үүргийг биелүүлж чадах болно³. Тус онолыг хичээлийн танхим дахь ямар нэгэн боловсрол ба хариу тусгалын төрөл зүйл нь нэн бүтэмжтэй гэдгийг нотлоход хэрэглэнэ.

Харилцан үйлдэх үзлийн арга нь харилцан үйлдлийг чухалчилж, суралцагч нь харалтад хэлийг оруулж, зөвлөлдөн, хариу тусгалыг хүлээн авахын хамт гаргалтыг бий болгодог гэж тайлбарласан байна⁴. Эдгээр бүрэлдэхүүний доторх аль нэг нь ч гэсэн бүр суралцагчийн хэлний хэлбэрийн тухай анхаарлыг татахаар дамжин сурлагын үр бүтээмжийг шилдэгжүүлж болох учраас маш олон судлаачид заах сургах орчин дахь англи хэлийг эзэмших тухай судалгаандаа энэхүү онолыг лавлан ашигласан байна.

Үүнтэй харьцуулвал, нийгэм соёлын үзэл нь англи хэлний эзэмшихүйн үүсгэсэн нийгэм ба соёлын ахуй байдлыг чухалчилдаг. Үүнд хэлний хэрэглээний нийгмийн харилцан үйлдэл дэх үйлдэл, соёлын журамжил ба өртгийн үзлийн хэлний сурлага дундах чухал чанар жич эрхийн харьцааны хэлний хэрэглээ ба эзэмшихүйд үзүүлэх нөлөөг багтаана. Заах сургатын орчин дахь англи хэлний эзэмшихүйн

² VanPatten, B. 2017. Situating instructed language acquisition: Facts about second language acquisition [J]. *Instructed Second Language Acquisition* 1: 45-59.

³ DeKeyser, R. 2017. Knowledge and skill in ISLA. In S. Loewen & M. Sato (Eds.), *The Routledge handbook of instructed second language acquisition* (pp. 15-32). New York, NY: Routledge.

⁴ Long, M. 1981. Input, interaction, and second language acquisition [A]. In H. Winitz (eds). *Native Language and Foreign Language Acquisition* [C]. New York: New York Academy of Sciences. 259-278.



THE CULTURAL WAY

нийгэм соёлын арга нь ердөө нийгмийн хэлний шинжлэл, үг хэлний задлалт ба шүүмжлэлийн онолоор лавлалт болгоно. Жишээлбэл, нийгэм соёлын онол нь бас харилцан үйлдлээс үүсгэсэн англи хэлний эзэмшихүйг тайлбарлав. Гэтэл мэдлэг бол оролцогч ба нийгмийн орчны хоорондох нийгмийн хамтаар цогцлосон гэдгийг ойлгох хэрэгтэй, хожим нь бодгаль биеийн суралцагчид өмчлөгдсөн төдий гэж үздэг⁵. Заах сургалтын талаар тэр нь суралцагчийн хоорондох нийгмийн харьцааг ахиулж, харалт хэлний сурлагад нэн ашигтай мөртөө ухагдахуунд суурилсан заах сургалтаар дамжин хэлний ухагдахууны дотоодчиллыг ахиулдаг.

Хэдийгээр мэдрэхүй ба нийгэм соёлын үзэл нь заах сургалтын орчин дахь англи хэлний эзэмшихүйг судлахад маш чухал боловч тэдгээр голдлого ба жишилт нь адилгүй байдаг. Мэдрэхүйн үзэл нь англи хэлний эзэмшихүйг нийгмийн зуучийн явцаар жишиж, суралцагч нь үг хэлийг оруулах ба хэрэглэхээр дамжин үг хэлийг эзэмшдэг гэж үздэг билээ. Нөгөө талаар нийгэм соёлын үзэл нь англи хэлний эзэмшихүйг нийгмийн зуучийн явцаар жишиж, суралцагч нь утга агуулгатай орчин тойронд бусадтай харилцахаар дамжин үг хэлийг эзэмшдэг гэж үзэж байна. Мэдрэхүй ба нийгэм соёлын үзлийн хоорондох нэгэн зангилаан ялгаа бол тэдний заах сургалтын үйлдлийн тухай үзэл болно. Мэдрэхүйн үзэл нь ердөө тодорхой заах сургалтыг хэлний сурлагыг ахиулах бүтэмжтэй арга гэж үздэг, учир нь суралцагчийг хавсран үг хэлний бүтэц ба дүрмийн тухай ухамсарт ухамсрыг хөгжүүлдэг. Үүнтэй харьцуулбал нийгэм соёлын үзэл нь харалт хэлний нийгэм тойрог дахь үнэн бодитой харилцан үйлдэл ба нэвчилтийн чухал чанарыг чухалчилдаг тул заах сургалтын үр бүтээмж нь харьцангуй ахуй байж, цаашилбал хэл сурлагад ашиггүй гэж үзнэ.

Заах сургалтын орчин дахь англи хэлний эзэмшихүйд хэрэглэх онолын хэв маяг нь хэлний заах сургалт ба суралцах арга барилд чухал ач холбогдолтой юм. Мэдрэхүйн үзлээр тодорхой удирдлага ба үйлдэл нь хэлний сурлагыг бүтэмжтэй ахиулж, ялангуяа дүрэм буюу ухамсарт хэрэгцээний талаар нэн илэрхий үйлдэлтэй гэдэг. Нөгөө талаар нийгэм соёлын үзлийн үзэхээр хэлний сурлага нь үнэн бодитой нийгмийн орчинд үүсэх үед хэлний сурлага нэн бүтэмжтэй болж, суралцагчийн үг хэлийг хэрэглэн утга агуулгатай солилцоо хийхийг ахиулдаг гэв.

⁵ Lantolf, J. 2000. Sociocultural theory and second language learning. Oxford: Oxford University Press.



THE CULTURAL WAY

Хоёр. Гол судлах агуулга

Заах сургалтын орчин дахь англи хэлний эзэмшихүйн судалгаа нь голдуу доорх асуултанд хариулна.

1. Заах сургалт нь хэрхэн (a) англи хэлний эзэмшихүйн үндсэн хэмжил (түүний арга зам, хурдац ба эцсийн амжилт), (b) англи хэлний эзэмшихүйн үндсэн бүрэлдэхүүн хэсэг (хүрэлцэх-exposure, суралцах хэлбэршил, дотоод явц ба тогтоц), (c) англи хэлний эзэмшихүйн гол явц (англи хэлний онцлог ба мэдлэгийн дотоодчиллол, засварлах ба бэхжүүлэх) ба (d) англи хэлний эзэмшихүйн адил бус төрөл хэлбэрийн мэдлэг (далд ба ил хэлбэр, тоочилтын чанар ба зарчимт чанар) зэрэгт нөлөөлөх тухай:

Нэгдүгээрт, Зарчмын талаар заах сургалт нь ямарваа нэгэн хэлний сурлагын явцын хэмжилд нөлөөлдөг. Тэр нь эзэмшихүйн арга замд нөлөөлж мэднэ (даруй заах чиглүүлэг хүртэж байгаа суралцагч нь адил бус дэс дарааллаар харалт хэлний бүх зүйлийн онцлогийг эзэмшиж магад), тэр нь хэлний сурлагын хурдац (даруй хурдатгах буюу удаашруулах)-д нөлөөлж мэднэ, тэр нь хамгийн эцсийн амжилтын хэр хэмжээ ба сурлагын эцсийн байдал (даруй чиглүүлэг хүртэж байгаа хэл суралцагч нь эцэстээ ямархуу хөгжлийн шатанд хүрэх)-д нөлөөлж болно.

Хоёрдугаарт, Үндсэн бүрэлдэхүүн хэсгээс авч үзвэл заах сургалт нь доорх нэг зүйл буюу олон зүйлийн ажиллагааг гүйцэтгэж байна гэж үздэг: заах сургалт нь суралцагчид харалт хэлтэй ойртох (даруй оруулах ба гаргах тохиол)-ыг хангадаг, заах сургалт нь суралцагчийн харалт хэл хэрэглэх ба суралцах хэлбэршилд нөлөөлдөг (жишээ нь урамшуулахаар дамжуулах), заах сургалт нь суралцах явц ба тогтоцыг хөндөж болно, эс тэгвээс эдгээр явц ба тогтоцыг гүйцэд хөгжөөж чадахгүй байдаг (жишээ нь автоматчилах явц, хэлний илрэлийн дахин цогцлолт).

Гуравдугаарт, Заах сургалтын үйлдлийг дүрслэн тоочихын төлөө хэлний сурахуйн явцыг мэдлэгийн дотоодчиллол, мэдлэгийн засварлал ба мэдлэгийн бэхжил гэх гурван том төрлийн явцыг багтаана гэж жишиж болно. Тэгэхээр заах сургалтын харалт ба үр бүтээмжийг доорх мэт дүрсэлж болно. Заах сургалт нь суралцагчийг шинэ харалт хэлний мэдлэгтэй болгож болно (жишээ нь үгсийн сангийн хэмжээ нэн баялаг, хэл зүй нэн будилаантай), заах сургалт нь суралцагчийн харалт хэлний мэдлэг, онцгойлон хэлбийх юм уу зохисгүй тал (нэн оновчтой болгохын



THE CULTURAL WAY

төлөө)-ыг залруулдаг (дахин цогцолдог), заах сургалт нь суралцагчийн харалт хэлний мэдлэгийг бэхжүүлдэг (тэд нарын харалт хэлийг нэн хялбархан хэрэглэж, нэн өргөн дэлгэр үүрэг ба чадамжийг биелүүлэхэд хялбар харуулдаг) товчлон өгүүлбэл тэд нарыг нэн урсам хэлэ эзэмшигч болгодог.

2. Заах сургалтын үр бүтээмжид нөлөөлөх элемент юу юу байдаг вэ? үргэлж тохиолддог элементэд (a) суралцагчийн элемент, (b) заах сургалтын төрөл хэлбэр, (c) харалт хэлний онцлогийн нөлөө зэрэг багтана.

Суралцагчийн элемент нь заах сургалтад их бага ч гэсэн адил бусын үр дүн гаргана, энэ нь бодгаль бие болсон суралцагчийн нас, танин мэдэхүйн боловсронгуйн хэмжээ, танин мэдэхүйн хэв маяг, урам зориг, өвөрмөц чанар, үг хэл сурах чадамж (language aptitude) ба сурах үеийн хоёр дахь хэлний боловсронгуйн хэмжээгээр шийдвэрлэнэ.

Ойрын жилүүдэд заах сургалтын төрөл хэлбэрийн зууч үйлдэл нь заах сургалтын орчин дахь англи хэлний эзэмшихүйн судалгааны гол зүйл болно. Заах сургалтын хэлбэрийг төлөв нэвтрэлцлээр төв болгосон заах сургалт ба хэлбэрээр төв болгосон заах сургалт гэж хуваана⁶. Нэвтрэлцлээр төв болгосон заах сургалт (communication focused instruction) бол суралцагчийг идэвхээр утга агуулга бүхий хэлэлцээ ба үнэн бодитой мэдээ зангийн солилцоонд оролцуулахаар зорилго болгосон юм. CFI үг хэлийг хамгийн сайн нь хэлбэр – чадавхийн холбоог анхаарахаар дамжин суралцахыг санаачилдаг. Энэ нь суралцагчаас харилцан үйлдэх дунд идэвхтэй зөвлөлдөхөөр хичээсний үр дүн мөн гэж үзнэ. Хэлбэрээр төв болгосон заах сургалт (form focused instruction) гэдэг бол үг хэлний хэлбэрийн тухай суралцагчдын анхаарлыг татахад хэрэглэх аливаа заах сургалтын хичээл зүтгэлийг заадаг⁷. Оруулалт дахь хэлбэр тухайлбал хэл зүйн бүтцийн онцлог жич дан үгс, авиа, цаашилбал нийгмийн хэл шинжлэл ба хэл хэрэглээний ухааны онцлог нь суралцагчийг хуумгай болгож мэднэ, тиймээс хэрэв

⁶ Ellis, R. 1994. The study of second language acquisition. Oxford: Oxford University Press.

⁷ Spada, N. 1997. Form-focused instruction and second language acquisition: A review of classroom and laboratory research [J]. Language Teaching 29: 1-15.



THE CULTURAL WAY

суралцагчийн анхаарлыг ямар нэгэн аргаар хэлбэрт татвал, суралцагч эдгээр онцлогийг сая шингээж чаддаг⁸.

Үүнээс гадна харалт хэлний онц тогтсон зарим онцлог нь заах сургалтын үр бүтээмжтэй холбоотой байж магад, харалт хэлний зарим онцлог нь бусад онцлогоос нэн илүү заах сургалт (зарим төрлийн заах сургалт)-д тохирч магад, гэвч холбоо бүхий хязгаарлал нь юу болох нь харахан тодорхойгүй байна. Зарим судлаачид хэлний задлалтын уламжлалт хүрээ хэмжээг үндэслэн энэхүү адилтгалыг дүрсэлдэг, даруй харалтын онцлог нь авиан ухаан, үгсийн сангийн ухаан, хэлбэр дүрсний ухаан, өгүүлбэр зүй, үг хэлний хэрэглээний ухаан буюу нийгмийн үг хэлний ухаанд харьяалагдах эсэхийг үздэг. Гэвч нэг хэлний хүрээнд ч гэсэн зарим онцлог нь бусад онцлогоос нэн илүү заах сургалтад тохирдог. Зууч элементэд оруулалтын дундах харалтын онцлогийн сэрж мэдрэгдэх илэрхий чанар, түүний чадамж буюу үгийн утгын ил тод хэмжээ, түүний солилцооны даац зэрэг болно.

Гурав. Судлах арга

Гадаад хэлний хичээл дэх заах ба сурах явц нь туйлын бэрхшээлтэй байдаг. Энэхүү бэрхшээлт чанарыг илрүүлэхийн төлөө, бид ердөө сурлага нь хэрхэн үүссэн, эсвэл ямар нэгэн элемент нь сурлагад нөлөөлөхийг анхааран шинжлэхээр барахгүй бас бодгаль бие болсон суралцагч жич тэдний суралцах үйл ажиллагаа, туршлагыг нэн гүнзгий шинжлэн ойлгох хэрэгтэй. Заах сургалтын орчин дахь англи хэлний эзэмшихүйн судалгаа нь бүх талын аргыг ашиглаж, тоошил судалгаанаас чанаршил судалгаа жич холимог хэлбэрийн судалгааны аргыг ашиглана. Гэтэл арга болгон нь өөр өөрийн гэсэн давуу ба сул талтай.

(Нэг) Тоошил судалгаа

Тоо хэмжигдлийн тоо баримтыг цуглуулж, бүртгэлийн аргаар задлах арга болно. Туршилтын судалгаа бол гадаад хэлний эзэмшихүйн судалгааны дунд үргэлж хэрэглэдэг нэг зүйлийн тоошил судалгааны арга болно, түүний зорилго нь ердөө чанга хязгаарлах орчин тойронд ямар нэгэн жишилт нь гэрчлэлтийн тоо баримтын дэмжлэгийг олсон эсэхийг шалгахын төлөө юм, иймээс туршилтын судалгаа нь

⁸ Schmidt, R. (1995). Consciousness and Foreign Language Learning: A Tutorial on the Role of Attention and Awareness in Learning. *Attention and Awareness in Foreign Language Learning*, 9, 1-64.



THE CULTURAL WAY

судалгааны үр дүнд нөлөөлж мэдэх тэдгээр хувьсагч хэмжигдэхүүнийг эзэмшиж, судалгааны үр дүнд нөлөөлөхөөс зайлсхийнэ. Туршилтын судалгаа бол хувьсагч хэмжигдэхүүний хоорондох шалтгаан үрийн харьцааг сүвэгчлэх нэг зүйлийн шинжлэх ухааны судалгааны арга болно. Судлаачаас хутгуурлын хувьсагчийн туршилтын дугуйлан ба эзэмшлийн дугуйланд үзүүлэх нөлөөг чанга хязгаарлаж, бүх дугуйлан суралцагчийн дундах шийдвэрлэх хувьсагч хэмжигдэхүүний хувиралыг эзэмшин, хувьсагч хэмжигдэхүүний хоорондох шалтгаан үрийн харьцааг хянана. Туршилтын судалгаа нь биднийг хавсарч ямар нэгэн элемент (жишээ нь заах сургалтын зарлиг, оруулалт буюу үйлдэх төрөл зүйл) нь хэлний сурлагыг ахиулж чадах эсэх жич хэлний сурлагыг хэдий их хэмжээн дээр ахиулж чадах эсэхийг судална.

Жинхэнэ туршилтын чанартай судалгаа нь доорх шаардлагыг хангах хэрэгтэй. 1, хувьсагч хэмжигдэхүүн ба хувьсагдахууныг дурдахын хамт тодорхой тодорхойлно. 2, ямар нэгэн хэлбэрийн оролцоо-даруй боловсрол гар дүрэхээр дамжин хувьсагч хэмжигдэхүүний хувьсагдахуунд үзүүлэх нөлөөллийг хянана. 3, туршилтын дугуйлан ба эзэмшлийн дугуйланг бүрэлдүүлнэ. 4, туршигдагч нь адил бус дугуйланд хуваагддаг. 5, өмнөх сорилт ба хойнох сорилт-хойно ба хойшилсон сорилтоор дамжин хоёр дугуйлангийн олсон хувийн илэрхий зөрөө байх эсэхийг олно. Гэвч үнэндээ олонх тооны хичээлийн танхимд суурилсан судалгаа нь жинхэнэ туршилт биш харин туршилт маягийн судалгаа болно, учир нь ихэнх туршилтын чанартай судалгаа нь энгийн хичээлийн орчин тойронд явагддагаас хэмжигдэхүүний хязгаарлалыг яг туршилтын судалгаа шиг чанга шаардаж чадахгүйгээс болжээ.

Тоошил судалгааны нэг давуу тал бол тэр нь нарийн оновчтой, бусдач ба найдвартай тоо баримтыг хангадаг. Тоошил судалгааг бас жишилтийг шалган нягтлахад хэрэглэж болох бөгөөд судалгааны үр дүнг нэн олон хүмүүст дэлгэрүүлж болно. Гэтэл тоошил судалгааны нэг дутагдал гэвэл хэлний сурлагын будилаант чанар ба хөдлөнгүй чанарын тухай гүнзгий ойлголт олоход хэцүү юм. Үүнээс гадна тоошил судалгаа нь хэлний сурлагын нийгэм ба соёлын ахуй байдлыг хуумгайлсан байж мэднэ. Жишээ нь нэгэн илэрхий хэлбэрийн заах сургалтын үгсийн сангийн сурахуйд үзүүлэх нөлөөг хянах тоошил судалгаа нь суралцагчийн туршлагаас урьдсан мэдлэг, урам зоригийг тооцолсонгүй байж мэднэ.



THE CULTURAL WAY

(Хоёр) Чанаршил судалгаа

Ажиглалт, сурвалжилга ба бусад хэлбэрийн тоо баримт цуглуулахаар дамжин тооны бус тоо баримт цуглуулах аргыг хэлнэ. Үргэлж хэрэглэдэг чанаршил судалгаанд асуултын хуудасны хяналт, хичээлийн танхимын тухай газрын ажиглалт жич багш ба суралцагчийн эргэцүүллийн чанар ба сэтгэн бодох мэдүүлэлт зэрэг багтана. Чанаршил судалгааны нэг давуу тал нь гэвэл суралцагч, багш болон бусад хамаа бүхий хүмүүсийн зогсоцоос хэлний сурахуйн явц дахь элбэг баялаг бөгөөд нарийн нягт ойлголтыг хангадаг. Чанаршил судалгаа нь бас хэлний сурлагад нөлөөлөх нийгэм ба соёлын элементийг тогтооход ашигтай. Жишээ нь урам зоригийн англи хэлний эзэмшихүй дэх үйлдлийн чанаршил судалгаа нь сурвалжлан ярилцах ба ажиглахаар дамжин суралцагчийн итгэл зориг, байдал ба өнгөрөлтийг нягталж, тэр нь буй бүхий үг хэл суралцагчийг төлөөлж чадахгүй байж магад.

Анхаарууштай нь хичээлийн танхимын орчин дахь хоёр дахь хэлний сурлагын явцыг нэн гүнзгий, нэн бүх талаар ойлгохын төлөө, ойрын жилд үндэстний ойллогын судалгаа улмаас улам судлаачдын хүрээллийг олж байна. Үндэстний ойллогын судалгаа бол аяндаа үүссэн, тасалдалгүй орчин тойрон дахь хүн төрөлхтний үйл ажиллагааны судалгаа байж, үйл ажиллагааны тухай соёлын тайлбарлалтад анхаарлаа төвлөрүүлдэг. Тэр нь олон талт өнцгөөс олон янзат чанартай тоо баримт (жишээ нь хичээлийн танхимын ажиглалт, асуултын хуудсын шинжлэл, сурвалжилга)-ын чухал чанар жич эдгээр тоо баримтаар үйл ажиллагааны энгийн загварыг дүрслэн тоочих ба ойлгохыг чухалчилдаг. Үндэстний ойллогын судлал гурван гол онцлогтой, өнгөрсний шинжлэл, ерөнхийлсөн чанар, соёлын талаас хүн төрөлхтний үйл ажиллагааг ажиглах, үүнээс гадна хичээлд оролцогсдын өдрийн тэмдэглэл буюу хичээл бэлтгэх тэмдэглэл зэрэг нь ч үндэстний ойллогын судлаачдын үргэлж хэрэглэдэг арга болно. Үндэстний ойллогын судалгаанд бас үйлдэлцэх задлалтын систем буюу дуу хураалтаар хичээлийн танхимын ажиглалт хийдэг, бас хээрийн шинжлэлээр эдгээр аргыг нөхвөрлөж болно. Жишээ нь Мацумото үндэстний ойллогын арга хийгээд ярилцлагын задлалт (зохиогч түүнийг үг хэлний үндэстний ойллого гэдэг)-тай уялдуулан хоёр дахь хэлний хичээлийн танхим дахь суралцагч ба ухаалаг гар утасыг хэрэглэн үг хэлний сурлагад оролцох жич гар утасны хэрэглэлт нь хэрхэн хичээлийн танхимын үг ярианы байдалд нөлөөлөх тухай судалжээ.



THE CULTURAL WAY

Тус судалгаа нь ярилцлагаар хичээлийн танхимын үйлдэл хөгжилтийн байдлыг задлан шинжилж, үндэстний ойллогыг хэрэглэн суралцагч юунд онц тогтсон цаг мөчид гар утас хэрэглэх, тэд гар утас дээрх ямар зүйлийн эх баялаг хэрэглэх зэргийг сурвалжлан ярилцжээ. Судалгаанд илрүүлснээр суралцагч хичээл дээр гар утас хэрэглэх нь тэднийг бүх зүйлийн эх баялгийг гүйцэд ашиглан нэлээд урт яриаг боломжтой болгон мэдлэгийн санаачилгат эрхийг олж, харилцааны асуудлыг шийдвэрлэж чадах болгоно гэжээ.

(Гурав) Холимог судалгааны арга

Энэхүү арга тоошил ба чанаршил судалгааны аргыг уялдуулан, хэлний сурлагын тухай нэн бүх талын ойлголтыг хангадаг. Холимог аргын судлалын нэг давуу тал нь адил бус ирэлт ба хараасаас ирсэн тоо баримтанд гурвалжилсан хэмжилт хийж болно. Энэ нь судалгааны үр дүнгийн бүтэмжит чанар ба найдварт чанарыг дээшлүүлж чадна. Холимог аргын судлал нь бас тоошил ба чанаршил судалгааны хязгаарт чанарыг шийдвэрлэхэд ашигтай. Жишээ нь үгсийн сангийн заах сургалтын хэл суралцагчид үзүүлэх нөлөөн тухай холимог аргын судалгаанд үгсийн сангийн мэдлэгийн тогтсон хэмжээний хэмжилтийг хэрэглэж болох мөртөө бас суралцагчийн заах сургалтын бүтэмжит чанарын тухай үзлийн чанарын тоо баримтыг хэрэглэж болно. Гэтэл холимог аргын судалгааны нэг дутагдал нь төлөвлөгөө ба хэрэгжүүлэлт нь будилаантай мөртөө цаг зарцуулж мэднэ. Бусад судлах аргатай харьцуулбал холимог аргын судалгаа нь бас нэн их хэмжээний тоо баримт ба нэн олон их баялаг хэрэгсэнэ. Жишээ нь хэлний хичээлийн суралцагчид үзүүлэх үр бүтээлийн нөлөөллийн холимог аргын судлалд хэлний чадварыг хэмжээлэн хэмжих чухалтай бөгөөд суралцагчийн биеч ойлголт ба мэдрэмжит чанарын тоо баримт хийх чухал юм.

Заах сургалтын орчин дахь англи хэлний судалгаан дахь судлах аргын сонголт нь судлах асуудал буюу жишилт жич судлаачдын хэрэглэж болох эх баялаг ба цаг хугацаанд суурьлах хэрэгтэй. Бүх талын аргад цөм өөрийнх нь давуу тал ба дутагдалтай тал бий, судлаачид судлах аргыг сонгохоосоо өмнө эдгээр давуу ба дутагдлыг бодолхийлэх хэрэгтэй. Судлаачид олон зүйлийн судалгааны аргыг бүтээлчээр ерөнхийлөн хэрэглэж болно, ялангуяа тоо баримт цуглуулах арга маяг нь аль чадахаар олон янзын байж, үнэн бодит үг хэл суралцах орчин тойрон дахь хэлний заах сургалт ба сурлагын тухай шинэ асуудлыг хайн сүвэгчилж болно.



THE CULTURAL WAY

ДҮГНЭЛТ

Заах сургалтын орчин тойрон дахь англи хэлний эзэмшихүй бол голдуу заах сургалтын орчин байдалд сурахуйн тогтоц жич нөхцлийг хэрхэн эзэмдэх тухай сүвэгчилж англи хэлний эзэмшихүйг ахиулдаг, иймээс заах сургалтын үйлдэл лүгээ хамгийн шууд холбоотой байж, бүтэмжтэй үг хэлний заах сургалтын үйлдлийг илрүүлэх ба үг хэлний сурлагын үр бүтээлийг чанаржуулахад туйлын чухал байдаг. Тус өгүүлэлд заах сургалтын орчин тойрон дахь англи хэлний эзэмшихүйн судалгааны онолын суурийг тодорхойлон өгүүлж гол ухагдахуунд тайлбарлалт хийсэн бөгөөд үргэлж хэрэглэдэг гурван зүйлийн судлах аргыг танилцуулав. Үүгээр дамжин улсын дотоодын нэн олон судлаачид хийгээд багш нар тус судалгаанд урам хайрлахыг хүссэн байна.

ABSTRACT

Instructed second language acquisition (ISLA) is a research field that focuses on the process of learning English through formal teaching. It is an important sub field of second language acquisition (SLA) research, specifically studying the impact of classroom based English teaching on learning outcomes. In recent years, ISLA has become a widely studied topic due to its significant impact on language learning outcomes. This article first explains the theoretical basis and main research topics in ISLA. Then, it introduces commonly used research methods in order to attract more attention from domestic scholars in the SLA field and foreign language teachers.

Keywords: instructional environment; second language acquisition; research topics; research method



THE CULTURAL WAY

НОМ ЗҮЙ

1. Ortega, L. 2013. SLA for the 21st century: Disciplinary progress, transdisciplinary relevance, and the bi/multilingual turn [J]. *Language Learning*
2. VanPatten, B. 2017. Situating instructed language acquisition: Facts about second language acquisition [J]. *Instructed Second Language Acquisition*
3. DeKeyser, R. 2017. Knowledge and skill in ISLA. In S. Loewen & M. Sato (Eds.), *The Routledge handbook of instructed second language acquisition*. New York, NY: Routledge.
4. Long, M. 1981. Input, interaction, and second language acquisition [A]. In H. Winitz (eds). *Native Language and Foreign Language Acquisition* [C]. New York: New York Academy of Sciences.
5. Lantolf, J. 2000. *Sociocultural theory and second language learning*. Oxford: Oxford University Press.
6. Ellis, R. 1994. *The study of second language acquisition*. Oxford: Oxford University Press.
7. Spada, N. 1997. Form-focused instruction and second language acquisition: A review of classroom and laboratory research [J]. *Language Teaching*
8. Schmidt, R. (1995). *Consciousness and Foreign Language Learning: A Tutorial on the Role of Attention and Awareness in Learning*. *Attention and Awareness in Foreign Language Learning*

ҮНДЭСНИЙ МОНГОЛ БИЧГИЙГ СЭРГЭЭХ ХӨДӨЛГӨӨНИЙ ЯВЦ

Л.Чулуунбаатар*

Коммунист үзэл суртлын хэрмэл хүлээснээс гарч Монгол түмний үндэсний ухамсар сэргэн мандаж, түүх, ёс заншил, аугаа соёл маань эргэн ирсээр даруй 33 жил болж байна. Тэр дундаа Үндэсний монгол бичгээ сэргээх хөдөлгөөн 1985 онд эхэлсэн гэж үзвэл 38 жилийг ардаа орхин одсон байна. Энэ хугацаанд Улсын Их Хурал, Засгийн газар, Ерөнхийлөгч, БСШУ-ны Яамны олон арван тогтоол, зарлиг, тушаал, шийдвэр гарч лут том хүчтэй ажлын комиссуудыг байгуулаад ч бүх нийтээрээ монгол бичгээ сэргээн хэрэглэх явдал удааширсаар байна. 1941 онд кирил бичигт шилжих тогтоол гарч, 1951 он гэхэд гэхэд бүх нийтээрээ хэрэглэж эхлээд 1990 он хүртэл ердөө 39 жилийг туулсан билээ. Гэтэл бид хоосон уухилсаар байтал цаг хугацаа улиран одож, тэр 39 жилийг ч бас ардаа орхиж магадгүй болоод байна. Монгол бичгийг төрийн бичиг болгосны 800 жилийн ойг улс орон даяар баяр хөөртэй, сүр дуулиантай тэмдэглэн өнгөрүүлсэнээс хойш бас л 19 жил хэдий нь улиран одсон байна.

1941 онд түүхийн ээдрээт нөхцөл шалтгаан, төр засгийн хатуу шийдвэрээр кирил үсгийг албан ёсны бичиг болгон хэрэглэсэн боловч монголын уламжлалт худам монгол бичиг утга соёлын хэрэглээнээс бүрэн гарсангүй. 1990 оноос монгол бичигтээ эргэж орох тухай хурц маргаан үүсэж, түүнийг төрийн бичиг болгох олон нийтийн санал хүчтэй болсоор ирэв. Монгол бичгийг кирилээр сольсны дараа хамгийн их бэрхшээлтэй тулгарсан хүмүүс бол зохиолчид байсан. Монгол бичгээр зохиолынхоо эх дээр ажиллах нь хэл найруулга, дуудлага болоод бичлэгийн тансаг байдлыг эрхэмлэхэд илүү төхөмтэй учраас тэр юм. 1962 онд МЗЭ-ийн III их хурлын өмнө Улс төрийн товчоонд зохиолчдыг хүлээн авч уулзсан байна. Энэ үед “Тунгалаг тамир” романаа бичиж байсан нэрт зохиолч Ч.Лодойдамба гар бичмэлээсээ жишээ татаж ярихдаа: Монголоор бичиж, дараа нь шинэ үсгээр буулгачихаад эргээд уншихад сайхан нь алга болчихдог болохыг тайлбарлаж, яруу найрагч Б.Явуухулан “Шинэ бичиг шүлэг их эвдэж байна. Хуучин үсгээр байгаа Инжинашийн шүлгийг шинэ бичигт буулгахад дордож байна” хэмээн нотолж, бага цаг алдсан дээрээ эргэж монгол бичгээ хэрэглэе гэсэн санал тавихад нь Ю.Цэдэнбал няцаажээ. Төрийн хошой шагналт хөгжмийн зохиолч

* Монголын Үндэсний Их Сургуулийн багш, доктор, профессор



THE CULTURAL WAY

Жанцанноров нарын хөгжмийн томоохон зүтгэлтнүүд “Хөх торгон цамц” хэмээх ардын дууны хөх гэдэг үгийг хоёр үе болгохоос өөр аргагүй болдог хэмээсэн нь монгол бичгийн хэлээр дуулахад илүү сонсголонтой байдагтай холбоотой юм. Монгол бичгийн хэлний сонгодог уламжлалыг өвлөн залгамжилсан Б.Ренчингийн хэл найруулгыг таашаахгүй байснаар үл барам түүний нөлөө залуучуудад халдварлахаас айж байсан. Хуучирсан үг хэрэглэж, хуучин бичгийн хэв маягаар хөөцөлдлөө гэж залуу шүлэгч нарыг хүртэл зэмлэж байжээ.¹ 1980-аад оны дунд үеэс өөрчлөн байгуулалтын үзэл санаагаар цэнэглэгдсэн монголчуудын үндэсний ухамсар илтэд сэргэж, үндэсний монгол бичгээ сурах хөдөлгөөн газар сайгүй өрнөсөн билээ. Олон нийтийн хүсэл зориг, эх оронч санаачлагыг дэмжиж, тухайн үеийн Ардын Боловсролын Яамны сайд Б.Даваасүрэн 1985 оны 1- сарын 4-ны өдөр “Зарим багшаар сонгон суралцах хичээл заалгах тухай” 302 тоот тушаал гаргасан нь монгол бичгийн сэргэн мандлын эхийг тавьж, ерөнхий боловсролын сургуульд 50-иад оны сүүлээс огт үзэхээ байсан монгол бичгийн хичээлийг дунд сургуулийн 7, 8-р ангид үзэх болж, дунд сургуулийн болон олон нийтэд үзэхэд зориулсан монгол бичгийн сурах бичгүүд зохиогдон гарч эхлэв. 1970-аад онд зохиогдсон Д.Чойжилсүрэн, Х.Далхжав нарын монгол бичгийн сурах бичгийн дараа 1986 онд Чой.Лувсанжав, Ж.Лувсандорж нарын дунд сургуульд үзэх монгол бичгийн сурах бичиг гарч, хот хөдөөд албан байгууллага, соёл үйлчилгээний газруудад монгол бичгийн дугуйлан, дамжаа хичээлүүлж эхлүүлэн, телевизээр МУИС-ийн багш Ш.Чоймаа монгол бичгийн хичээл зааж, сургалтын зарим материал хэвлэгдэн гарлаа. Ер нь профессор Ш.Чоймаа 1989, 1990, 1991 онуудад бүх нийтийг монгол бичигт сургахад зориулан 60 удаагийн цуврал хичээл зааж, ард түмний монгол бичгийн багш алдрыг олон түмнээсээ хүртсэн билээ. Үүний хажуугаар монгол ёс заншил, шашин соёлын зан үйл сэргэж эхлэв. 1990 он гэхэд үндэсний сэхээтнүүдийн дуу хоолой сонин болгоноор цууриатаж байлаа. 1990 оны 6-р сарын 1-нд Сайд нарын зөвлөлийн 285 тоот тогтоол гарч 1990-1995 онд багтааж бүх нийтийг хос бичигтэн болгох, улмаар монгол бичгийг төрийн албан бичиг болгохоор заав. Энэ тогтоолын дагуу Ардын боловсролын яамны сайдын тушаалууд гарч нэгдүгээр ангиас монгол бичгээр сургалт явуулах шийдвэр гаргав. Ардчилсан холбоо болон ардчиллын удирдагч нар илтгэл, өгүүлэл, мөрийн хөтөлбөртөө эн тэргүүнд тусгаж, ардчилсан хувьсгалын нэг гол уриа нь мянган жилийн уламжлалт үндэсний бичгээ сэргээх явдал байв. Сонин сэтгүүлүүдэд “Монголчууд бид 1941 онд монгол бичгээ кирилл үсгээр сольж гучаад жилийн дотор ард түмнээ бичиг үсэгтэн болгож, тив дэлхийд гайхагдаж байсан боловч дэлхийн бичиг үсгийн соёлын санд оруулсан оюуны үнэт соёлоо орхиж том алдаа хийсэн

¹ Г.Мэнд-Ооёо. Сонгодог уламжлалаа үгүйлсээр. /Утга зохиол/,1990-2-9, № 7



THE CULTURAL WAY

юм. ...Хойч үедээ бид монгол бичгээ бүрэн өвлүүлэхийн тулд бүх нийтийн сургалтын бодлого явуулах нь зүйтэй.”² Мөн оноос Улсын хэвлэлийн газар монгол бичгээр ном хэвлэх боломжийг бүрдүүлж зарим сурах бичиг, “Монголын нууц товчоо” зэргийг монгол бичгээр хэвлээд байв. Монгол бичигтэй холбоотой газруудын санаачлагаар 21 хүний бүрэлдхүүнтэй Монгол бичгийн ардын хүрээлэн байгуулагдаж монгол бичгээ улс даяар дэлгэрүүлэн сургах ажлыг зохион байгуулахад саланги хэсгүүдийн ажлыг нэгтгэн чиглүүхэд үйлчлэнэ гэж тунхагласан байна. 1991 онд олон нийтийн эрчимтэй хөдөлгөөн, монголын эх оронч дэвшилт сэхээтнүүдийн чармайлт зүтгэлээр албан хэргийг 1994 оноос монгол бичгээр хөтлөн явуулах 36-р тогтоолыг Улсын бага хурлын ухаалаг эрхэм гишүүд гаргав. Үүний дагуу БНМАУ-ын засгийн газар 1991 оны 6-р сарын 21-ны өдөр “БНМАУ-д албан хэргийг монгол бичгээр хөтлөн явуулах бэлтгэлийг хангах тухай” 186-р тогтоол гаргав. Тогтоолд хавсралтаар бэлтгэлийг удирдан явуулах комиссын бүрэлдхүүнийг Засгийн газрын шадар сайд Д.Дорлигжав даргатай, Боловсролын сайд Н.Уртнасан, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга Д.Моломжамц нарын орлогч даргатай байгуулж гишүүдэд Боловсролын тэргүүн дэд сайд Б.Энхтүвшин, Хууль зүйн сайд Ж.Амарсанаа, Үндэсний хөгжлийн сайд Ж.Батсуурь, Худалдаа үйлдвэрийн сайд С.Баярбаатар, Сангийн сайд А.Базархүү, Соёл урлагын хорооны дарга Б.Бадар-Ууган, Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгч Д.Баатар, Засгийн газрын дэргэдэх радио, телевизийн ерөнхий захирал Х.Цэвлээ, Улсын архивын хэрэг эрхлэх газрын дарга Л.Мэндсайхан нарын лут их хүчтэй комиссыг байгуулжээ. Энэ тогтоол нь: нийт хүн амыг 1991-1993 онд монгол бичигт сургах, хөтөлбөр, сурах бичиг, гарын авлага, монгол бичгийн зөв бичих зүйн толь боловсруулан гаргах, туршлагатай, монгол бичгийг төгс эзэмшсэн хүмүүсээр заалгах, их дээд сургуулийн монгол хэлний ангийн болон багшийн сургуулийн оюутнуудаар 1992 оноос хөдөлмөрчдийн дунд монгол бичиг заалгах, төрийн захиргаа, олон нийтийн байгууллагад ажиллах монгол бичгийн бичээч нарыг уг байгууллагуудын зардлаар нь сургаж бэлтгэх, орон нутагт сургах ажлыг орон нутгын засаг захиргаанд даалгах, төв, орон нутгийн хэвлэлийн тоног төхөөрөмжийг шинэчлэн тоноглож, хэрэгцээт бичгийн машинаар 1992-1993 онд хангах, шаардагдах хөрөнгийг гаргах, хэвлэл мэдээллээр сурталчлах, сонин сэтгүүлд нүүр булан гаргах, заримыг монгол бичгээр дагнан хэвлэх гэх зэргийн тус тусын яаманд хариуцуулсан бүх талыг хамарсан, монгол түмний сэтгэл зүрхийг баясаасан тогтоол болж гарсан юм.³

² Л.Чулуунбаатар. Монгол бичгээ яах вэ. /Утга зохиол/, 1990-2-9, № 7

³ БНМАУ-ын Засгийн газрын тогтоол, шийдвэрийн эмхтгэл. БНМАУ-д албан хэргийг монгол бичгээр хөтлөн явуулах бэлтгэлийг хангах тухай. 1991 он, х.320-323



THE CULTURAL WAY

Мөн энэ онд монгол бичгийг олон улсын оюуны өмчөөр бүртгэн авсан нь монгол түмний дэлхий оюуны санд оруулсан үнэт соёл болохыг батлан харуулсан хэрэг болсон юм.

1991 оны хичээлийн жилээс эхлэн бага сургуульд орсон 1-р ангийн 300 бүлэгийн бүх сурагчдад бүх хичээлийг монгол бичгээр зааж эхлэн сурах бичгүүдийг хэвлэн гаргаж эхэллээ. Чой.Лувсанжав багшийн хичээл зүтгэлээр Япон улсад тусгай захиалан хийлгэсэн 1000 ширхэг цахим бичгийн машин хүрэлцэн ирж бичээч нарын курс зохион байгуулав. Шагжийн “Зөв бичих дүрмийн толь”-ийг Өвөрмонголд дахин хэвлүүлж Чой.Лувсанжав, Ж.Бат-Ирээдүй нарын зөв бичих дүрмийн толиуд гарав. 1991-1993 он бол монгол бичиг сурах их өрнөлтийн үе байлаа. Засгийн газрын тогтоолын дагуу болон нэрт сэтгүүлч Т.Галдангийн санаачлагаар монгол улсад цор ганц “Хүмүүн бичиг” хэмээх сониныг МОНЦАМЭ агентлагийн Ерөнхий захирал Ч.Эрдэнийн 66 тоот тушаалаар уг агентлагийн харьяанд байгуулж, сонины эрхлэгчээр Т.Галданг томилсноос хойш одоо хүртэл тасралтгүй хэвлэгдсээр байна. Гэвч 1993 оноос сургалтын эрч нь саарч эхэлсэн байна. Хамгийн түрүүнд монгол бичгээр сургалт явуулж байгаа сурагчдын эцэг, эх, тэд нарт зааж байгаа багш нараас эсэргүүцэл гарч эхэллээ. Монгол бичгээ байтугай эх түүхээ мэдэхгүй европжсон соёлт залуу эцэг эхчүүд хүүхдэдээ тусалж чадахгүйн бухимдал, үсэг нүдлүүлэх хялбар аргад дасаж сурсан, үеийн аргаар сургадаг уламжлалт аргыг мэдэхгүй багш нарын залхуурал нэгдэн нийлж монгол бичгийг муучлахын эхийг тавив. Үүнийг уухайн тас шүүрэн авч Монголын ардчилсан хүчний сонинууд монгол бичгийг сэргээхийн эсрэг компани дэгдээж дөчөөд оныг давтаж эхлэв. Энэ тухай “Ил товчоо” сонинд Чех улсын монголч эрдэмтэн Давид Лукаш “Одоогийн монголын сэхээтнүүд түүний дотор оппозиц хүчний сэхээтнүүдийн олонх нь орос дунд сургуулиар дамжиж, ЗХУ агсанд дээд боловсрол олсон, коммунист номенклатурын хүүхдүүд мөн нь нууц биш. Тэд нэгэнт эх хэл, эх соёлоосоо бүрэн таслагдсан учраас дуудлага бичлэгийн зарим зөрөөтэй /англи, франц шиг их дөрөөтэй биш/ болсон монгол бичгийг сурахаас үнэнхүү бэрхшээж монгол бичгээ сэргээх байтугай харахыг ч хүсэхгүй байна. Монгол бичгийн эсрэг тэдний дэгдээж байгаа компанийг Сталин, Чойбалсангийн ачаар эрдмийн өндөр зэрэгтэй болж авсан хуучинсаг үзэлтэй зарим хүн өдөөн дэвэргэж, засгийн эрхийг баригч коммунист МАХН чимээгүйхэн сахал дотроо битүү инээмсэглэн харж байна” хэмээн бичиж байв.⁴

1941 онд кирилл бичгийг аваад сэхээтнүүд хамгийн хойрго хандаж, далдуур эсэргүүцэн байсан боловч нам төрийн хүчтэй нударгын шаардлагаар сурсан бол өнөөгийн монголын сэхээтнүүд бас л монгол бичгээ сэргээх

⁴ Давид Лукаш. Монгол бичгийн эмгэнэлт хувь заяа. /Ил товчоо/, 1993-6-1-10, № 14



THE CULTURAL WAY

шийдвэрийг эрчимтэй эсэргүүцэж ардчилсан нийгэм гэдэг үзлийн дор, нөгөө талаас угаасаа монгол сэтгэхүйгээсээ хэт холдсон учир огт ойлгохгүйгээсээ болж өөрсөд шигээ мунхарсан олныг хөөрөгдөн дагуулж монгол бичиг сэргээх компаниг ажлыг төр олон нийтийн бүхий л хэрэгсэлээр эсэргүүцэн тэмцсэн юм. Энэ нь хүн амын тогтворгүй хэсэг болох залуучуудыг уруу татаж тэдний сурах эрчийг сааруулав. Мөн нөгөөтэйгүүр Улсын их хурлын зарим гишүүд латин үсгийг албан хэрэгт хэрэглэх төсөл өргөн барих зэргээр олон нийтийн анхаарлыг ихээхэн саармагжуулсан болой. “Кирилл бичиг авах үеийн сэхээтнүүдийн эсэргүүцэл бол яруу тансаг баялаг сайхан найруулгат дэлхийд хаана ч байхгүй үндэсний бичиг үсгээ гээж орхихын эсрэг бухимдал байсан. Харин энэ цагийн сэхээтнүүдийн энэ эсэргүүцэл бол залхуурал, ухаан мулгуугийн шинж хийгээд уламжлалт соёл, зан заншил, хэл сэтгэхүйгээсээ хэрхэн холдож, бие нь монгол, ухаан нь харийнх болсныг харуулсан тод жишээ болсон юм. Нөгөө талаар хуучин биднийг бүх зүйлээр хянаж байсан улс, монголчуудын үндэсний ухамсар нэн ихээр өрнөн дэлгэрэхээс эмээсэн бодлын болгоомжилсон санаа бодол ч тэднээр дамжин хэрэгжсэн нь энэ болой. Сонгуульд ялахын тулд сонгогчдоос хамгийн их оноо авах гэж үндэсний үзлийг хуурамч хөөрөгдөж байсны илрэл бас болов” хэмээн монгол бичгийн хөдөлгөөнийхөн дүгнэж байв. 1993 онд хийсэн Албан хэргийг монгол бичгээр хөглөн явуулах бэлтгэл ажлыг эрхлэх улсын комимссын хурлыг Монгол улсын шадар сайд асан Л.Энэбиш даргалан хийлгэж “Монгол бичиг сургах ажил үнэн чанартаа их үлбэгэр явж, төв орон нутгийн төрийн байгууллагууд жигд ажиллаж чадсангүй” гэсэн дүгнэлт хийсэн байна. Тэгээд 1994 онд сургалтыг эрчимжүүлж, монгол бичиг сайн мэддэг багш, оюутан, сурагчид, хүмүүсийг дайчлан оролцуулах нь зүйтэй бөгөөд засгийн газарт цаашдын бодлого чиглэлийг оруулж шийдвэр гаргуулах нь зүйтэй гэж тогтжээ. Мөн энэ үед монгол бичгийг дэмжигч эрдэмтэн, зохиолч, сэхээтнүүд нийгэмлэг байгуулж төрийн ордонд их хурлаа хийж төр засгийн удирдлагад өргөх бичиг илгээв. Үүний дагуу 1994 оны 3-р сарын 16-нд Монгол улсын засгийн газрын Албан хэргийг монгол бичгээр хөглөх бэлтгэл хангах ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 64 тоот тогтоол гарав. Үүнд: Төрийн яам, газар, байгууллагуудын албан хаагчдыг 1994 онд багтаан монгол бичигт сургаж, 1995 онд төрийн албан хэргийг монгол бичгээр эрхлэх түвшинд хүртэл чадваржуулах, 16-49 насны бүх хүнийг 1995-1996 онд багтаан монгол бичигт тайлах ажлыг зохион байгуулах, зохион байгуулалт захирамжлалын баримт бичгийг стандартын холбогдох байгууллагуудтай хамтран 1994 онд багтаан боловсруулах, Ерөнхий боловсролын сургуулиудын I-IV ангийн бүх хичээлийг монгол бичгээр, V-X ангиудад нийгмийн ухааны хичээлүүдийг монгол бичгээр, бусад хичээлийг кирилл үсгээр тус тус явуулж байгааг зүйтэй гэж үзэж цаашид монгол бичиг хэрэглэх явдлыг боловсролын бүх шатны



THE CULTURAL WAY

сургалтад гүнзгийрүүлэх арга хэмжээ авах, бүх сонин хэвлэлийн зарим материалыг монгол бичгээр гаргах, батлагдан гарч байгаа хуулиудыг монгол кирилл бичгээр хамт хэвлэж байх, яам тусгай газрууд батлан гаргаж байгаа нийтлэг шинж чанартай эрх зүйн актуудыг монгол бичгээр бичиж харьяа байгууллагууддаа хүргэж байх, радио, телевизын хөтөлбөр, үзвэр үйлчилгээний зарлал, улс хоорондын харилцааны нот бичиг, гэрээ хэлцэл зэргийг монгол бичгээр үйлдэж байх, 1994 оноос монгол бичгээр хөтөлж эхлэх албан бичгийн төрөл, түүний жагсаалтыг энэ оны эхний хагаст багтаан баталж холбогдох газруудад хүргүүлж мөрдүүлэх, бэлтгэлийг хангах улсын комиссын нарийн бичгийн даргыг томилж ажиллуулах зэрэг заалтуудыг тус тусын хариуцсан газарт нь даалгажээ. Энэ тогтоолыг гарсны дараа Ж.Мягмарсүрэн нарын сэтгүүлчид “Сэрэхгүй бол сайхан зүүд” хэмээн тавлан Монголыг дундад зуунтай нь хадах гэлээ хэмээн бухимдан бичиж улсын их хурлын гишүүдийг сэнхрэхийг уриалж байв. Тэр цагаас хойш 26 жил улирсан болохоор нээрээ л сайхан зүүд болоод өнгөрчээ. Зарим сэтгүүлч өөрсдийн санасан бодсоноороо цэцэрхэж зарим нэг эрдэмтэд ч инээдтэй хөгийн юм бичиж нийтлэх болов. Эдгээр хөгийн юмны хариуд С.Дулам нарын эрдэмтэд их хурлын эрхэм гишүүдэд илгээлт явуулж “Ирээдүйгээ харж шийдэх ёстой асуудал гэж бас байдаг бөгөөд тэдний нэг нь монгол бичиг мөн. Монгол бичиг бол ирээдүй олон улиралд тодрон гэрэлтэх хүний оюуны эрхэм үнэт зүйлсийн нэгэн бөгөөд өнөөдөр үүсэл гарлыг нь монгол биш гэж шүүмжилж байгаа улс ирээдүйд харин ч дэлхийн олон үеийн олон үндэстний оюун билгээр шүүн тунгаагдаж, тэр дундаа монгол хүний сэтгэлгээний мөн чанарыг гайхалтай хадгалснаараа улам ч гайхагдах болно гэдгийг сэхээрэх нь соёлт хүний өмнө хүлээх бидний нэг бичигдээгүй үүрэг нь юм” хэмээн харамсан анхааруулж 64-р тогтоолыг хэвээр үлдээхийг уриалж байв. Гэвч 1994 оны УИХ-ын хаврын чуулганы сүүлчийн өдөр баталсан 66-р тогтоол нь мянга гаруй жилийн түүхтэй хүн төрөлхтний соёлын өвийг уламжлан суралцах үр үндсийг эрх зүйн хувьд бүрэн тасалж түүхэнд үзэгдээгүй ихээр туйлшрав. МУ-ын Ерөнхийлөгч П.Очирбат “Монгол бичиг нь манай ард түмний мянган жилийн оюуны соёлын их өвийг, түүгээр ч зогсохгүй Энэтхэг, Төвд зэрэг дорно дахины эртний түүхт улс түмний оюуны соёлоос ч агуулан хадгалж, хойч үедээ уламжлан өвлүүлсэн монгол түмний уламжлалт соёл иргэншлийн нэгэн гол тэнхлэг мөн билээ. Монгол бичиг бол бас латин, грек, кирил, араб бичгүүдийн хамтаар, хүн төрөлхтөний зохион хэрэглэж ирсэн авианы бичгийн нэг, энэ утгаараа хүн төрөлхтөний соёлын сан хөмрөгт бидний өвөг дээдсийн оруулсан гайхамшигт хувь нэмэр, монголчууд бидний түүх, соёлын уламжлалт зүйл оюуны өв мөн”⁵ хэмээн онцлон дурьдаж хоёр удаа хориг

⁵ Хүмүүн бичиг сонин, 1994-7-22, дугаар 27(107)



THE CULTURAL WAY

тавиад ч дийлсэнгүй. “Төрийн толгойд уламжлал, зан заншил, түүх соёл, үндэсний хэлбичиг, ард түмнийхээ ахуй амьдралыг мэдэхгүй хүмүүс гарвал ямар аюултай гэдгийг яруу тод харуулав. Эргүү тэнэгүүдийг эзэн ноён суулгавал эрхгүй түмэн ардыг зовооюу хэмээсэн эрдэнийн сан субашидийн доторх сургаал юутай үнэн бэ. Монгол бичиг үсгийн түүх нь эхнээсээ аваад эцсээ хүртэл монголын ард түмний биеэ даасан байдал, тусгаар тогтнолын түүхтэй хамгийн нягт холбоотой байдаг гэдгийг тэд огт ойлгосонгүй.”⁶ Тэр үеийн монгол бичгийг дэмжигч сэтгүүлчид, үндэсний бичиг үсгийг сэргээхийн төлөө хөдөлгөөнийхөн Улсын их хурал архичинд гаргаагүй аагаа монгол бичигт гаргалаа хэмээн халаглан бичиж байв.

Гэхдээ ард түмэн, монгол бичигт элэгтэй эрдэмтэн судлаачид, залуусын сэтгэлийг тайвшруулах мөн бэлтгэл ажлыг эрчимжүүлэхийн тулд Улсын Их хурлаас уг 66-р тогтоолдоо “Уйгаржин монгол бичгийн үндэсний хөтөлбөр” боловсруулахыг Засгийн газарт даалгасан билээ. Үүний дагуу Засгийн газрын боловсруулсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр”-ийг 1995 оны 6 сарын 23-ны өдрийн 43-р тогтоолоор батлан гаргаж “Бүх нийтийг сургах, бүх шатны сургуульд багш бэлдэх, ном сурах бичгээр хангах, хэвлэх үйлдвэрийг компьютержүүлэх, хэвлэхэд төрөөс дэмжих, өргөн хэрэглээ, орчин бий болгох, тасралтгүй байх зарчмаар зохион байгуулах” зэрэг лут зорилтуудыг 2001 онд багтаан хэрэгжүүлэхээр дэвшүүлэн тавьж олон улсын хамтын ажиллагааг үүнд хандуулж төсөл хэрэгжүүлэн, сургалт зохион байгуулна хэмээн заасан билээ. Гэвч түүнээс хойш олон он улиран одож хоёрдахь монгол бичгийн үндэсний хөтөлбөрөө 2008 онд дахин дэвшүүлэн гаргасан билээ. Харин олон улсын хамтын ажиллагааны удаа дараагийн төсөл латин бичгийн хөтөлбөр болон зүсээ хувиргаж үргэсэн зээр шиг хулжин одсон. 1995 онд Үндэсний монгол бичгийг сэргээх олон улсын сангийн дэмжлэг туслалцаатайгаар “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр”-ийг монгол бичиг, кирил, англи хэлээр хавсран ном болгон хэвлэн гаргасан нь монгол бичигт ээлтэй хүн бүхний ширээний ном болоод байна. 2005 оноос эхлэн монгол бичгийг ард нийтийн бичиг болгох шийдвэр гарна гэсэн саруул ухаант хүмүүсийн найдвар улиран одоод дахин 18 жил өнгөрч байна. 1990 оноос хойш холбогдох яамны 14 тогтоол, Их хурлын 5 тогтоол, Засгийн газрын 8 тогтоол, МУ-ын Ерөнхийлөгчийн 9 орчим хориг, зарлиг гарсан боловч энэ ажил огт тасрахгүй хирнээ, үлгэн салган алдаг онон хэрэгжин, үндэсний бичиг соёлоо гэх сэтгэлгүй түшмэдүүдийн харгаагаар мартагнахын мананд уусан монголын хууль гурав хоноод мартагдахын үлгэрийг яруу тодорхой үзүүлсээр байна. Гэвч энэ хугацаанд саруул ухаант, эх оронч сэтгэлт, үндэсний бичиг соёлоо дээдлэгч эрдэмтэн судлаачдын хүч хөдөлмөрөөр 40 гаруй сурах бичиг,

⁶ Ц.Шагдарсүрэн. Монгол үсэг зүй. УБ., 1981, х.5



THE CULTURAL WAY

20 гаруй толь бичиг, компьютерийн бичих, хөрвөх программууд болон олон улсын кодын систем нэгэнд бий болж, 2000 оны 2-р сард Женев дэх олон улсын стандартын байгууллага монгол бичгийн кодыг баталсанаар цахим бичвэрт бичих, хэвлэхийн зовлон арилж монгол бичгийн орчин аажим аажимаар бүрэлдэн бий болоод байна. Монгол бичгийн тогтолцоо, онол, арга зүй, илэрхийлэх гайхамшигийн талаар арваад хүн эрдэмийн зэрэг хамгаалж олны хүртээл болгоод байна. 2001-2003 оны хооронд монгол бичгийг зааж сургах, түгээн дэлгэрүүлэх орчин бүрэлдүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж МУ-ын Ерөнхийлөгчийн зарлигаар Т.Дашцэдэн, Т.Галдан, Ш.Чоймаа, Т.Галсан, Н.Жадамба нарт “Монгол Улсын Гавьяат” цол хүртээсэн билээ. Мөн энэ хугацаанд олон нийтийг өргөнөөр хамарч, ихээхэн хүч тавин хийж хэрэгжүүлсэн ажил бол Монгол төрийн бичиг хэрэглэсний 800 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлсэн явдал юм. МУИС-ийн профессор Ш.Чоймаа "Зууны мэдээ" сонины 2003 оны 2 сарын 20-ны № 42(1240) дугаарт “Эзэн Чингис хаан - Монгол бичиг - 800 жилийн ой” хэмээх өгүүлэлийг хэвлүүлж, мөн Монгол улсын ерөнхийлөгчийн тамгын газар санал болгон хүргүүлжээ. Үүний дагуу 2003 оны 6 сарын 25-ны өдөр тухайн үеийн МУ-ын Ерөнхийлөгч Н.Багабандийн “Чингис хааны иггээсэн Монгол төрийн бичиг хэрэглэсний 800 жилийн ой”-г тэмдэглэн өнгөрүүлэх тухай 105 тоот зарлиг гарч, Ерөнхийлөгчийн зарлигийг 2003 оны 9-р сард МУИС-ийн багш, оюутнууд баяр талархалтайгаар, ёслолын байдалтай хүлээн авч 23 зүйлт хийх ажлын төлөвлөгөө гарган ажиллаж эхэлсэн байна. 2004 оны 3 сарын 19-ны өдөр БСШУ-ны сайд А.Цанжид “Монгол төрийн бичиг хэрэглэсний 800 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх” тухай 71-р тушаал гаргаж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд ШУА-ийн дэд ерөнхийлөгч, академич Б.Энхтүвшин дарга, МУИС-ийн МХСС-ийн захирал доктор Л.Чулуунбаатар орлогч даргатай БСШУЯ, Монгол бичгийн нийгэмлэг, Монгол бичгийг дэлгэрүүлэх сан, “Хүмүүн бичиг” сонин, Улаанбаатар хотын боловсролын газар, Боловсролын хүрээлэн, ШУА-ийн Хэлзохиолын хүрээлэн, СУИС, Урчуудын эвлэлийн хороо, Улсын Нийтийн Номын Сан, Монголын Үндэсний Төв Архив, МУБИС, Багшийн коллеж, Хэл Иргэншлэлийн Дээд Сургууль, Гурван Эрдэм Багшийн Дээд Сургууль, МУИС-ийн МХСС, МОХ-ны төлөөлөл орсон комиссыг байгуулж, 26 ажлыг төлөвлөснөөс доорх ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. “Миний монгол бичиг”, “Монгол цэвэр бичиг”, “Чингис хааны төрийн бичгийн уламжлал”, “Монгол бичиг мэргэдийн оюуны толинд”, . “Монгол бичиг бол монгол туургатан ард түмний ган аргамж”, “Чингис хааны билиг сургаалиас” зэрэг ном товхимолыг МУИС-ийн МХСС, МУБИС, Гурван Эрдэнэ Багшийн Дээд Сургуулийн багш нарын хүчээр эмхэтгэн хэвлүүлж олны хүртээл болгосон байна. “Хүмүүн бичиг” сонины



THE CULTURAL WAY

105-р дугаарыг ойд зориулан 20000 ширхэг монгол бичгээр хэвлэн гаргаж нийтэд түгээжээ. МУИС-ийн мэдээ сэтгүүлийн 4-р сарын сүүлийн дугаарын 8 нүүрийг монгол бичгээр мөн хэвлэн гаргасан байна. 2004 оны 4-р сарын 22-нд “Монгол бичгийн тулгамдсан асуудал” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг МУИС-ийн МХСС зохион явуулж Монгол улсын Их, Дээд сургуулиудын эрдэмтэн багш нар, БНХАУ, Турк, Солонгос, Япон улсын 5 мэргэжил дээшлүүлэгч эрдэмтэн оролцож нийт 36 илтгэл хэлэлцсэн байна. Мөн Их, Дээд сургуулиудын оюутнуудын дунд “Монгол бичиг миний бичиг” сэдэвт оюутны ЭШ-ний бага хурлыг 4-р сарын 30-нд МОХ, МХСС-ийн Оюутны зөвлөл хамтран хийжээ. БСШУЯ-аас олгодог Монгол бичиг соёлоо хөгжүүлэх үйлсэд хүчин зүтгэсэн болон монгол бичгийг олон хүнд сургасан хүнд олгодог “Үндэсний бичиг соёлоо дэлгэрүүлэгч” тэмдэг, үнэмлэх бий болгож энэ медалийн анхны дээжийг Монгол улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр, МУИС-ийн багш хөдөлмөрийн баатар Т.Дашцэдэн, МУ-ын гавьяат багш Ш.Чоймаа, уг медалийн эх загварыг гаргасан МУ-ын гавьяат зураач П.Балдандорж, Ардын уран зохиолч Т.Галсан, МУ-ын гавьяат багш Ц.Өнөрбаян, Монгол улсад цорын ганц монгол бичгээр хэвлэгддэг “Хүмүн бичиг” сонины эрхлэгч МУ-ын соёлын гавьяат зүтгэлтэн Т.Галдан нар 2004 оны 5 сарын 2-нд хүртсэн билээ.⁷

Монгол бичгийн улсын уралдааныг Ертөнц төвөөс эрхлэн Их, Дээд сургуулиудын дунд явуулж 100 гаруй оюутан оролцсоноос МХСС, МУБИС, Хүмүүнлэгийн Их Сургууль, Гурван Эрдэнэ Багшийн Дээд Сургуулийн оюутнууд идэвхтэй оролцож медаль хүртсэн байна. Мөн Ардын багш Д.Чойжилсүрэнгийн нэрэмжит монгол бичгийн олимпиадыг МУИС-ийн оюутнуудын дунд мэргэжлийн болон мэргэжлийн бус ангиллалаар явуулж 96 оюутан оролцон, МУИС-ийн захирал Ц.Ганцогийн тушаалаар 12 оюутныг өргөмжлөл, медаль, мөнгөн шагналаар шагнасан байна. Монгол уран бичлэгийн улсын уралдааныг Хэл Иргэншлийн Дээд Сургууль дээр 5-р сарын 1-нд бүх нийтийн дунд явуулав. 4-р сарын 30-нд УННС болон УТА-г байгаа монгол ном, бичиг дурсгалын үзэсгэлэнг УННС-ын Үнэт ховор номын танхимд нээж, Д.Батбаяр, Ц.Ойдов, Г.Отгонбаатар, Т.Жамьяансүрэн, Баатарчулуун нарын зураач урчуудын болон хөдөө аймгуудын багш нарын монгол бичгээр бичсэн уран бичлэг болон бичиг хэрэгслийн үзэсгэлэнг 4-р сарын 30-аас эхлэн гаргаж олон нийтэд үзүүлсэн байна. Ойн арга хэмжээний хүрээнд МУ-ын Гавьяат багш Ш.Чоймаагийн монгол бичгийн хичээлийг 2004 оны 4-р сарын 27-оос эхлэн Монгол Телевизээр дахин заасан байна. Монгол бичиг соёлын талаар мэргэжлийн эрдэмтэд радио, телевизээр удаа дараа нэвтрүүлэг хийв. Чингис хаан иггээсэн монгол төрийн бичгийн 800 жилийн

⁷ Б.Элбэгзаяа, Монгол бичиг хорин жилийн товчоон, Улаанбаатар, 2004, 105 дахь талд



THE CULTURAL WAY

ойд зориулсан өдөрлөгийг бага, дунд, их, дээд сургуулиудад 4-р сард зохион явуулаа. Монгол бичиг үсгийн тухай баримтат кино хийх ажлыг МУИС-ийн Авай төв эрхлэн хийсэн болно. 2004 оны 5 сарын 2-ны өдөр Монгол төрийн бичиг хэрэглэсний 800 жилийн ойг улс орон даяар тэмдэглэн өнгөрүүлж, баярын хурлын Монгол улсын төрийн ордны хурлын их танхимд хийсэн билээ. Хуралд МУ-ын Ерөнхийлөгч илгээлт ирүүлж “Монгол бичиг бол монгол хэлний онцлогт гайхамшигтай зохицон нийцэж, өргөн дэлгэр нутагт аж төрж ирсэн монгол туургат олон овог аймагт нийтлэг үйлчилж, нутаг нутгийн аялгуу эрх тэгш найрсан хөгжих боломжийг хангасан төдийгүй, нийт монголчуудыг бичиг үсэг, хэл соёлын талаар нэгтгэх түүхэн чухал үүрэг гүйцэтгэсэн юм” хэмээн гол онцлогийг нь цохон тэмдэглэсэн билээ. Мөн МУ-ын Ерөнхий сайд Н.Энхбаяр биечлэн оролцож үг хэлэн, БСШУ-ны сайд А.Цанжид болон эрдэмтэд илтгэл тавьсан билээ. Энэ баяр нь үндэсний бичиг үсгийн баярыг анхлан тэмдэглэсэн өдөр болсон юм. Түүнээс хойш 16 дахь удлаагаа тэмдэглэн өнгөрүүлээд байна. Энэ арга хэмжээний хүрээнд хурлын дараа Сүхбаатарын талбай дээр Монгол бичгийн нэрэмжит яруу найргийн болон дуу хуурын наадам зохион явуулж, хүүхэд багачуудын дунд уран бичлэгийн болон зөв бичлэгийн уралдааныг зохиож, монгол бичгээр хэвлэгдсэн болон монгол бичиг соёлын тухай номын худалдаа ажиллуулах, чимэглэл, бэлэг дурсгалын “Монгол бичиг” сэдэвт үзэсгэлэн, худалдааг Урчуудын эвлэлийн хорооны үзэсгэлэнгийн танхимд гаргахаар төлөвлөсөн боловч цасан шамарга шуурсан цаг агаарын таагүй нөхцөлөөс болоод хийж чадаагүй билээ. Гэвч нэгэнт төлөвлөсөн ажлыг 6 сарын 1-ны хүүхдийн баярын үеэр Их, дээд сургууль болон хотын боловсролын газар хийж гүйцээсэн юм. Ойн хуралдаанд аймаг болгоноос монгол бичгийн тэргүүний нэг нэг багш хүрэлцэн ирж оролцсон нь монгол бичгээ сургах, судлах ажил хөдөө, хотгүй нийт ард түмний хэрэг болсныг харуулсан билээ. Төлөвлөсөн ажлуудаас газар болон, хөрөнгө мөнгө олдоогүйн улмаас Монгол бичгийн гэрэлт хөшөөний шав тавих ажил, Япон улсын Сумо бөхийн 5-р сарын башед түрүүлсэн бөхөд олгодог цомын өргөмжлөлийг монгол бичгээр үйлдэж олгох, болон 800 жилийн ойд зориулж сери марк гаргах ажлыг Монгол шуудан компани хариуцан хийх байсан нь огт хэрэгжээгүй билээ. Ялангуяа Монгол бичгийн гэрэлт хөшөөний ажлаар МУ-ын гавьяат 5 ахмад багш хотын захиргаа, энэ тэр газраар хөөцөлдөж, хандивын данс нээгээд ч үр дүнд хүрэлгүй хад мөргөж хоцорсон билээ. Гэсэн хэдий боловч төлөвлөсөн ажлынхаа ихэнхийг хийж амжуулан, монгол түмнийхээ үндэсний бичиг үсгээ гэсэн сэтгэлийг сэргээж, улс орон даяараа үндэсний бичгийн өдрийн тэмдэглэдэг болсон нь 1000 гаруй жилийн түүхтэй монгол бичгээ сэргээн хэрэглэхэд улс орон даяараа, төр засаггүй анхаарал тавьсан их ач холбогдолтой зүйл болсон билээ.



THE CULTURAL WAY

2008 оны 5 дугаар сарын 28-ны өдөр Монгол Улсын Засгийн газрын 196 дугаар тогтоолоороо “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-2”-ийг баталсан бөгөөд дараах гол агуулгыг багтаасан юм.

- “Хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн улсын төсөвт тусган хандивлагчдын зээл, тусламж, болон хувийн хэвшлийн байгууллагын санхүүгийн оролцоог нэмэгдүүлэх замаар санхүүжүүлэхээр

- Монгол бичгийн багшийг бэлтгэх, давтан бэлтгэх

- Монгол бичгийн сургалтын орчныг сайжруулж, хэрэглээг өргөтгөх

- Иргэдэд монгол бичгийг албан ба албан бус сургалтаар зааж сургах

- Монгол бичгийн судалгаа, сурталчилгааны ажлыг өргөжүүлэх

Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээний дүнгээс үзэхэд хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтын хэрэгжилт 87.5 хувийн биелэлттэй байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн удирдлагын дэмжлэг, оролцоо нэмэгдсэн, мэргэжил дээшлүүлэх сургалтыг бүсийн болон сургууль төвтэй хэлбэрээр зохион байгуулах ажил орон нутагт амжилттай хэрэгжиж байгаа, монгол бичгийн танхим байгуулах, сургалтын орчин бүрдүүлэх арга хэмжээнд ахиц гарсан, төрийн болон аж ахуйн нэгж байгууллагын хаяг, бүтээгдэхүүний шошгыг монгол бичгээр бичих хандлага тогтворжиж эхэлсэн зэрэг ололттой тал цөөнгүй байна. Иргэд, олон улсын байгууллага, төслөөс 33.4 сая төгрөгийн хандив, тусламж үзүүлсэн нь хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ихээхэн дэмжлэг болсон байна

2008 онд ерөнхийлөгч болсон Ц.Элбэгдорж 2010 оны 7- сарын 06-ны өдөр

“Монгол бичгийн албан хэрэглээг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” 155 тоот зарлиг гаргасан нь XIII зууны үеийн Мөнх хааны гавьяаг давтсан гавьяат үйл болсон юм.

Агуулга нь: Үндэсний эрх чөлөөний хувьсгалын 100 жилийн ойг угтаж, үндэсний монгол бичгээ сэргээн хэрэглэх төрийн бодлогын хэрэгжилтийг идэвхжүүлэх зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн гучингуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12 дахь хэсгийг тус тус баримтлан зарлиг болгох нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүдээс гадаад улсын адилтгах төвшний албан тушаалтанд илгээх албан бичиг, захидлыг монгол бичгээр үйлдэж, орчуулгыг тухайн улсын эсвэл НҮБ-ын албан ёсны аль нэг хэлээр хавсарган илгээж байхаар тогтоосугай.



THE CULTURAL WAY

2. Иргэний төрсний болон гэрлэлтийн гэрчилгээ, бүх шатны боловсролын сургалтын байгууллагаас олгож буй үнэмлэх, диплом, гэрчилгээнд крилл болон монгол бичгээр зэрэгцүүлсэн бичилт хийж байсугай.

3. 2008 онд баталсан "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-II"-ын хэрэгжилтийн явц, үр дүнг 2011оны 2 дугаар улиралд дүгнэж, хэрэгжилтийг цаашид эрчимжүүлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгосугай.

4. Энэхүү зарлигийг хэрэгжүүлэхэд шаардагдах бэлтгэл ажлыг хангаж, 2011 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.⁸ Энэ зарлигийн кагуу Ерөнхийлөгчийн тамгын газар болон Гадаад яаманд монгол бичгийн мэргэжилтэн бий болсон бөгөөд албан бичгийг гадаад орнуудад монгол бичгээр явуулж эхлээд байна. 2012 оны хаврын 11-р анги төгсөгчид болон Их, дээд сургуулийн бүх төгсөгчидын гэрчилгээ, дипломын хавсралтын монгол бичгээр бичиж гаргасан нь ерөнхийлөгчийн зарлигийг хамгийн сайн хэрэгжүүлсэн ажил болсон юм.

Мөн телевизийн зарим нэг нэвтрүүлгийн нэр хаяг болон зарим суртчилгааны самбар, ганц хоёр албан газрын хаяг монгол бичгээр бичдэг болсон болон Монгол бичгийн үндэсний хөтөлбөр, Ерөнхийлөгчийн зарлиг гээд дээрээс анхаарал хандуулж байгаа боловч бүх нийтээр даган мөрдөх, санаачлага гаргах явдал хангалтгүй байв.

Түүнээс хойш 5 жилийн дараа Улсын их хурлын гишүүн Мигэддоржийн Батчимэг нарын санаачлагаар 2015 оны 2 сарын 12-ны өдөр Монгол Улсын Их Хурлаас “Монгол хэлний хууль”-ийг батлан гаргасан нь монгол түмний зүрх сэтгэлийг баясгасан хууль болсон билээ. Үндэсний монгол бичгийн тухай заалтууд нь:

7.2.Энэ хуулийн 11.1.2-т заасан үндэсний бичгийн хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлж, зохих бэлтгэл хангасны үндсэн дээр төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэргээ кирил болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулна

7.3.Өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад үндэсний бичгийг зургаадугаар ангиас эхлэн төгстөл тусгайлсан хөтөлбөрөөр заана.

7.4.Их, дээд сургуульд элсэгчдээс авах элсэлтийн ерөнхий шалгалт болон төрийн албанд анх орох иргэнээс авах монгол хэлний шалгалтын агуулгын дөрөвний нэгээс доошгүй хувь нь үндэсний бичгийн мэдлэгийг үнэлэхэд чиглэнэ.

⁸ Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн 2010 оны 7- сарын 06-ны өдрийн “Монгол бичгийн албан хэрэглээг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” 155 тоот зарлиг



THE CULTURAL WAY

7.5.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдаас гадаад улсын адил төвшний албан тушаалтанд илгээх албан бичиг, захидлыг үндэсний бичгээр үйлдэж гадаад хэлээрх орчуулгыг хавсаргана.

11.1.2.монгол хэл, бичиг үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх, хамгаалах, хөгжүүлэх, үндэсний бичгийн хэрэглээнд албан ёсоор шилжих дунд болон урт хугацааны үндэсний хөтөлбөр, дүрэм, журам, үндсэн чиглэл боловсруулж хэрэгжүүлэх;

24.2.Энэ хуулийн 7.2 дахь хэсгийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.⁹

Эдгээр монгол бичгийн тухай гол заалтууд нь үндэсний монгол бичгийн хэрэглээг эрчимжүүлэх, албан ёсоор хэрэглэж эхлэх огноог товлон, ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн зарлигийг давхар хуульчлан баталгаажуулж өгсөн билээ.

Монгол хэлний тухай хууль батлагдсанаар Хэлний бодлогын үндэсний зөвлөлийг Монгол улсад анх удаа байгуулж, эзэнгүй явж ирсэн монгол хэлний бодлого, хяналтыг нэгдмэл зохицуулалтад оруулсан юм. Мөн өөрийн дураар зөв бичих дүрэм зохиох, өөрчлөх явдлыг цэгцэлж, зөв бичих дүрэм, нэр томъёоны орчуулгыг нэг мөр болгох эрхийг ШУА-ийн дэргэдэх судалгааны хүрээлэнд олгохын зэрэгцээ хэвлэл мэдээллийн байгууллагуудад эх хэлээ хадгалж хамгаалах үүрэг хүлээлгэв. Гадаад хэлээр сургалт явуулдаг хувийн сургуулиудад монгол хэлний хичээл заавал орох, үндэсний монгол бичгийн хэрэглээг 2025 оноос эхлэн шат дараатай нэмэгдүүлэхийг мөн хуульчилсан билээ.

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Үндэсний бичиг үсгийн баярыг тохиолдуулан 2018 оны тавдугаар сарын 3-ны өдөр Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай зарлиг гаргалаа. Зарлигийн монгол бичгийн тухай гол заалт нь:

- Монгол бичгийн дунд болон урт хугацааны үндэсний хөтөлбөрийг боловсруулан баталж,

2018 онд багтаан хэрэгжүүлж эхлэх; бүх шатны боловсролын сургалтын байгууллагын суралцагч хичээлийн хөтөлбөрөөр монгол хэл, бичгийн хичээлийг судлахдаа цахим орчинд монгол бичгийг ашиглах, бичвэр боловсруулах бүрэн чадамжтай болж төгсдөг байх; монгол бичгийн хичээлээр улсын төрөлжсөн олимпиадыг зохион байгуулж хэвших; элсэлтийн ерөнхий шалгалт өгөх иргэнээс заавал авах монгол хэл, бичгийн шалгалтад босго оноо тогтоох; монгол хэл, бичгийн хичээлийг үр бүтээлтэй заан сургаж, амжилт гаргаж буй багш нарыг урамшуулж ажиллахыг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад үүрэг болгосугай.

⁹ Монгол хэлний хууль, 2015 оны 2 сарын 12



THE CULTURAL WAY

- Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг,

бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай хэмээжээ.¹⁰

Зарлиг хүлээлгэн өгөх ёслол дээр Ерөнхийлөгч “2025 оноос төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллага албан бичгээ кирил болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулахын үндсэн бэлтгэл нь монгол бичгийн дунд болон урт хугацааны үндэсний хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх гээд хуульд заасан атал хууль мөрдөгдөж эхлээд 3 жил болоход Боловсролын яам уг хөтөлбөрийг боловсруулж батлаагүй байна. Тиймээс 2018 онд багтаан монгол бичгийн дунд болон урт хугацааны үндэсний хөтөлбөрийг боловсруулан баталж, хэрэгжүүлэх хэрэгтэй. Монгол бичгээр уншиж, бичих бол мэдлэгээс хэтрэхгүй. Орчин цагт монгол бичгийн хэрэглээ цахим орчинд суурилна. Тиймээс цахим орчинд монгол бичгийг ашиглах, бичвэр боловсруулах бүрэн чадамжийг бүх шатны боловсролын хөтөлбөрөөр эзэмшдэг байх зайлшгүй шаардлагатай. Иргэд, багш нар, эрдэмтэн судлаачдаас хамгийн ихээр гарч буй санал бол элсэлтийн шалгалтад заавал авч буй монгол хэл, бичгийн шалгалтад босго оноо тогтоох асуудал юм. Босго оноо тавихгүй юм бол шалгалт авч иргэдийн татварын мөнгө, олон багш, ажилтны хүч хөдөлмөрийг үргүй зарахын хэрэг байхгүй. Монгол бичгийн улсын олимпиад нэртэй олимпиадууд байгаа нь үнэндээ нэг сургууль, хэвлэл мэдээллийн болон төрийн бус байгууллагын хэмжээнээс хэтрэхгүй байна. Энэ хэрээр монгол хэл, бичгийн үнэлэмж унаж байна. Иймд элсэлтийн шалгалтад босго оноо тогтоох, төрөөс улсын олимпиад албан ёсоор зохион байгуулах, багш нарыг үнэлж урамшуулах нь эх хэл, үндэсний бичгийн үнэлэмжийг сэргээж, сурагчдад эх оронч хүмүүжил олгохын эхлэл байх учиртай. Яамны эрхзүйн байдлын тухай хуулиар “Ерөнхийлөгчийн зарлиг шийдвэрийн биелэлтийг хангах, сайдын эрхлэх асуудлын хүрээний чиглэлээр Ерөнхийлөгчийн өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж ажиллах”-ыг заасан байдаг тул Боловсролын яаманд эдгээр ажлыг хэрэгжүүлэхийг үүрэг болгож байна.” хэмээн дэлгэрүүлж, онцлон хэлсэн билээ.

Уг зарлиг нь Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлж, Монгол Улсын иргэний үндэсний бичгээ сурч судлах, өвлөх, өвлүүлэх, эзэмших,

¹⁰ Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Үндэсний бичиг үсгийн баярыг тохиолдуулан 2018 оны тавдугаар сарын 3-ны өдөр гаргасан “Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай” зарлиг



THE CULTURAL WAY

хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх хуулиар олгогдсон эрх, боломж, нөхцөлийг хангах төрийн үүргийг биелүүлэх үүднээс; 2025 оноос төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллага албан бичгээ кирил болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулах бэлтгэлийг хангахад чиглэгдэж байгаа юм. Энэ зарлигийн заалт ёсоор БШУЯам 2018 оны хавар комисс байгуулж “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ийг боловсруулсан билээ. Сангийн яам зэрэг газар хөтөлбөр хэрэгжүүлэхэд орох санхүүгийн зардлыг тусгаагүй байна хэмээн цааргалан буцаасан тул комисс дахин нягталж, 250 сая төгрөгийн тодотгол хийж өгсөн билээ.

Зохих шатны байгууллагаар хэлэлцэгдсээр Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 96 дугаар тогтоолоор “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III” батлагдлаа.

Уг хөтөлбөрт “Монгол Улсын Засгийн газраас 1995-2005 онд “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр I”, 2008-2015 онд “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр II”-ийг тус тус хэрэгжүүлсэн. “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр I, II” хэрэгжсэнээр ерөнхий боловсролын сургуулийн VI-IX ангид монгол бичиг хичээлийг судалж, иргэний болон боловсролын баримт бичгийг кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн үйлдэх, ном, сурах бичиг зохиох, хөрвүүлэх, түүх, соёлын бүтээлийг нийтийн хүртээл болгох зэрэг үр дүн бий болсон. Гэвч “Бүх нийтэд монгол бичгийг сургах, нийтийн хэрэглээний бичиг болгох, хэрэглэх орчин бий болгох” зэрэг зорилтууд хангалтгүй хэрэгжиж иржээ.”¹¹ хэмээн онцлон заасан юм. Уг хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг цаг хугацаатай, хэрэгжүүлэх эзэнтэй, биелүүлэх боломжтой байдлаар нэн чамбай боловсруулан гаргасан билээ.

Бидэнд одоо үндэсний монгол бичгээ сэргээн хэрэглэхэд шаардлагтай эрх зүйн бүх бичиг баримт бүрдлээ. Ерөнхийлөгчийн монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх зарлиг гарсанаас хойш 5 жил өнгөрөхөд болон “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III” гарсанаас хойш 3 өнгөрөхөд, Монгол бичгийн төлөө тэмцсэн үндэсний шилдэг сэхээтнүүд, нийт ард түмний дундах улс үндсээ гэх сэтгэлтэй эх оронч хэсгийнхэн нөр их хөдөлмөр зүтгэл гаргаж байсан 1990 оны үеийн шиг тийм эрчимтэй ахиц, зарим нэгэн заалтыг хагас дутуу хэрэгжүүлсэнээс өөр одоогоор харагдахгүй байна. Харин ч сонин хэвлэлээр эсрэг ухуулгын зүйл ч бас гарах боллоо. Тийм учраас энэ мэт суртал ухуулгын хуурамч мэдээллээс монгол хүн бүр түргэн ангижирч, монгол бичгийн Монголын нийгэм, Монгол Улсын оршихуйд гүйцэтгэж ирсэн үүрэг, хойшид ямар ач холбогдолтой болох талаар шинжлэх ухааны үнэн зөв мэдээллийг хүлээн авч, үндэсний монгол бичгээ түргэн сэргээж, Монгол Улсын албан ёсны бичиг болгохын төлөө нийтээр тэмцэх хэрэгтэй

¹¹ Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III



THE CULTURAL WAY

бөгөөд үүний тул Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III-ийг Засгийн газраас тууштай удирдан хэрэгжүүлэх; Төрийн албан хаагчид, төр нийгмийн зүтгэлтэн дарга, сайд нар ард олонд үлгэр жишээ болж, үндэсний монгол бичгээ эхлэн сурах явдлыг эн тэргүүнд чухалчилбал, уул хөтөлбөр хэрэгжиж, улмаар монгол бичгээ төрийн албан ёсны бичиг болгож чадах нь эргэлзээгүй. Учир нь эх оронч үзлийн гол цөм, амин сүнс нь эх хэл, эх хэлний гол цөм амин сүнс нь үндэсний бичиг үсэг байдаг билээ.

Монголчууд бид согдоос авсан үндэсний монгол бичгээ орхиж мартсангүй, харин ч монгол хэлэндээ таацуулан боловсруулж өнөөдрийг хүртэл хэрэглэж ирсэн нь монголын ард түмнээс дэлхийн үсэг бичгийн түүхэнд гүйцэтгэсэн нэгэн чухаг хувь нэмэр даруй мөнийг монгол хүн бүр ухамсарлах ёстой юм.

Олон улсын амьдрал улам бүр дэлхийжиж, орчин үеийн шинжлэх ухаан техникийн ололт түргэн нэвтэрч, мэдээллийн олон улсын стандарт төлөвшиж англи хэл нь латин үсэг хэмээх “Унаатайгаа” хүн төрөлхтний ихээхэн хэсгийг байлдан дагуулж байгаа хийгээд Монгол улс өрнөдийн соёл иргэншлийн нөлөөнд хүчтэй татагдан орж буй бодит байдал нь язгуурын монгол бичгийн хувь заяаг ихээхэн ээдрээтэй болгож, үндэсний бичиг үсгээ дангааршуулахаас өөр аргагүй болгож байна.

Үндэсний бичиг, яруу сайхан монгол хэлтэйгээ байсан цагт бид энэ ертөнцөд мөнхөд орших болно. Үндэстэн байгаа цагт үндэсний бичиг үсэг болон хэл байсаар байх болно. Дэлхийн улс орнууд бичиг үсгээ бидэн шиг яагаад засахгүй байна вэ? Учир нь хэлний нэгдэлээ, үндэстний нэгдэлээ задлахгүй устгахгүйн төлөө шүү дээ. Монгол соёлын амин зүрх бол монгол хэл, монгол бичиг нь юм. Монгол хэл мөхвөл монгол соёл мөхнө. Монгол соёл мөхвөл монгол үндэстэн мөхнө. “Төр улс үндэсний дархлаа болох монгол хэлийг хамгаалж, хөгжүүлж байхгүй бол монгол гарвал нь байсаар байтал, Монгол улс байсаар атал монголоор ярьдаг хүнгүй болох цагт монгол үндэстэн сөнөнө гэдгийг давтан хэлмээр байна.”¹² Тийм болохоор монгол хэл бол монголын ард түмний сэтгэхүй, нийгэм, уламжлал, түүх, соёлтой шууд холбоотой амин чухал зүйл юм. “Манай бүх телевизийн арын бичиг нь англи, францаар байгаагийн зорилго нь тодорхойгүй, туурга тусгаар бие даасан их бага оронд манайх шиг ингэхгүй байгаа нь нэг л сонин”. “Гудамжинд гарахад олон хэлийн хаяг туурга тусгаар улс мөн үү гэсэн бодлыг улам батлаад өгнө”

Ер нь, аливаа бичиг үсэг тухайн ард түмэн улс үндэстний хувьд эрх чөлөө, тусгаар тогтнолынх нь баталгааны гол цөм болсон оюун санааны тусгаар тогтнолыг нөхцөлдүүлэгч гол хүчин зүйл байдаг учраас харийнхан

¹² Б.Магсаржав, “Хэл-Үндэстэн-Газар нутаг-Төр улс”, Хэл бичиг, Утга суудлал, Улаанбаатарын Их Сургуулийн Эрдэм шинжилгээний бичиг № 2 (1), УБ., 2005 он



THE CULTURAL WAY

бусдыг боолчлох, мөхөөн устгах бодлогоо хэрэгжүүлэхийн тулд юуны өмнө түүний хэл сэтгэлгээ рүү довтолдог бөгөөд ингэхдээ тэрхүү хэл сэтгэлгээг хадгалан хамгаалж байдаг ганц хэрэглүүр болсон бичиг үсгийг халах солихыг эн тэргүүний зорилго болгодог байна.

Хятад, Орос хоёр улсад суугаа монголчуудын хэл соёл улам бүр уруудан доройтож, эгзэгтэй байдалд орж байгаа үед Монгол улсын гүйцэтгэх үүрэг улам ихээр дээшлэх ёстой. Монгол улс нь олон зууны түүхтэй Монголын эзэнт улсын өвийг залгамжлан авсан цорын ганц улс орны хувьд бүх монгол туургатаны түүхийг хадгалан тэмдэглэж хойчийн үедээ уламжлуулах хариуцлагатай үүргийг хүлээх ёстой бөгөөд мөн монгол хэлтнүүдийг нэгтгэж байсан монгол бичгийг төрийн бичиг болгох нь бидний үүрэг юм. Ингэх юм бол халхыг төв болгон үзэх нутгархаг үзэл нь арилж бусад улс орны монголчуудын түүхэнд гүйцэтгэсэн үүргийг бодит байдлаар нь үнэлэх боломж бүрэлдэж, хэл, соёл, түүхийн нэгдэл бий болон монгол хэл нийт монголчуудын дундын гүүр хийгээд бахархал болон цэцэглэн хөгжих болно. Бид өнгөрсөн үеэ гар буугаар буудваас ирээдүй үе маань биднийг үхэр буугаар буудах болно.

Изриал мэтийн ухаант улс үндэстэн мартагдаж мөхсөнөө сэргээж маргаашийн ирээдүй рүү түүнийхээ хамт орохоор зүтгэж явахад амьд байгаа бичиг үсгийн соёлоо ад үзэн бусдын үсгээр явна хэмээн зүтгэх нь учир утгагүй хэрэг бөгөөд Монголын аугаа соёл болсон монгол бичгээ хойч үедээ өвлүүлэхийн тулд “Монгол хэлний хууль” болон “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ийн заалтыг чандлан мөрдөж, ажлыг эрчимжүүлэн, 2025 оны 1 сарын 1-ээс шилжин орох шаардлагатай байна.



THE CULTURAL WAY

НОМ ЗҮЙ

1. Г.Аким. Бичиг минь, хүлэг минь. /Утга зохиол/, 1990-2-9, № 7
2. Н.Балжинням, Монгол хэлний гадаад үгийн толь, УБ., 2005
3. БНМАУ-ын Засгийн газрын тогтоол, шийдвэрийн эмхтгэл. БНМАУ-д албан хэргийг монгол бичгээр хөтлөн явуулах бэлтгэлийг хангах тухай. 1991 он, х.320-323
4. Ж.Бямбаа. Үндэсний соёл сэргэнэ. /Утга зохиол/, 1990-3-23, № 13
5. Б.Я.Владмирцов. Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия. 1987
6. Давид Лукаш. Монгол бичгийн эмгэнэлт хувь заяа. /Ил товчоо/, 1993-6-1-10, № 14
7. С. Идшинноров, Г.Цэрэндорж. Үндэсний бичгээ халсан түүхээс гэрчлэх нь. /Үнэн/, 1990-3-3, № 53
8. Б.Магсаржав, “Хэл-Үндэстэн- Газар нутаг-Төр улс”, Хэлбичиг, Утга суудал, Улаанбаатарын Их Сургуулийн Эрдэм шинжилгээний бичиг № 2 (1), УБ., 2005 он
9. Монгол хэлний хууль, 2015 оны 2 сарын 12
10. Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III, 2020 оны 3 сарын 18
11. Г.Мэнд-Ооёо. Сонгодог уламжлалаа үгүүлсээр. /Утга зохиол/, 1990-2-9, № 7
12. Г.Мэнд-Ооёо. Сонгодог уламжлалаа үгүүлсээр. /Утга зохиол/, 1990-2-9, № 7
13. Э.Равдан. Монгол хэл, соёлын асуудалд. /Өнөөдөр сонин/, 1999 оны 3-р сар
14. Ж.Санжаа, Монгол хэлний авиан зүй ба авиалбар зүй, УБ., 2008
15. Б.Сумьяа. Монголын нүүдэлчдийн соёл. Оршихуй, эс оршихуй. УБ., 1998
16. Ж.Төмөрцэрэн, Монгол хэлний үгийн сангийн судлал, Улаанбаатар, 1966 он
17. Л.Чулуунбаатар. Монгол бичгээ яах вэ. /Утга зохиол/, 1990-2-9, № 7
18. Л.Чулуунбаатар, Нүүдэлчин монголчуудын бичиг үсгийн соёл, УБ., 2000
19. Ц.Шагдарсүрэн. Монголчуудын утга соёлын товчоон. УБ., 1991
20. Ц.Шагдарсүрэн. Монгол үсэг зүй. УБ., 1981
21. Ц.Шагдарсүрэн, “Эх хэлээ эвдэхгүй юмсан”, УБ., 2007
22. Б.Элбэгзаяа, Монгол бичиг хорин жилийн товчоон, Улаанбаатар, 2004
23. Ерөнхийлөгчийн 2010 оны 7- сарын 06-ны өдрийн “Монгол бичгийн албан хэрэглээг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” 155 тоот зарлиг
24. 2015 оны 2 сарын 12-ны өдөр Монгол Улсын Их Хурлаас баталсан “Монгол хэлний хууль”
25. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Үндэсний бичиг үсгийн баярыг тохиолдуулан 2018 оны тавдугаар сарын 3-ны өдөр гаргасан “Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай” зарлиг

ХАСБУГИЙН “УЛААН АСРЫН ЗҮҮД”-ИЙН МОНГОЛ ОРЧУУЛГЫН ГАР
БИЧМЭЛ ДЭВТРҮҮД

Саруул*

ХУРААНГУЙ

“Улаан асрын зүүд” бол Хятад улсын эртний уран зохиолын “нэвтэрхий толь” мөн. Энэхүү бүтээлийн монгол орон дахь тархалт, хүлээлт ба судлал нь монголын алдарт зохиолч, онолч Хасбутай нягт холбоотой. Хасбугийн монгол орчуулгийн “улаан асрын зүүд”-ийн адил бус зургаан гар бичмэл дэвтрүүд нь орчуулж хуулсан он жил, илэрхийлсэн үг хэллэгийн онолт, нийтлүүлсэн зорилго чиглэл, дэвтрийн өнгө үзэмжийн хувьд цөм өвөрмөц ялгамжаатай байж, монгол утга зохиол, сурвалж бичиг судлал жич “улаан асрын зүүд”-ийн судалгааны чухал эх хэрэглэхүүн байж, маш өндөр судалгааны үнэ цэнэтэй хэмээн үзэж байна.

Түлхүүр үгс: *“Улаан асрын зүүд”, Монгол орчуулга, Гар бичмэл дэвтэр, Ялгамжаа*

“Улаан асрын зүүд” нь барлагдан хэвлэгдээд удалгүй Хятад улсын өвөр монголын зүүн хэсгийн харчин түмэд орон жич баруун хэсгийн алшаа, ойрад орны монгол бичигтэн сэхээтнүүдийн дунд бага хэвчээтэй тархан дэлгэрч байснаас 19 дүгээр зууны эхэнд, хасбугаар хосгүй их

* Өвөр Монголын Их Сургуулийн Монгол Судлалын Дээд Сургуулийн 2019 оны докторант, sarvv12018@163.com



THE CULTURAL WAY

оюун билиг ба оюунлаг хүч хөдөлмөртөө түшиглэн, түүнийг товчлон орчуулж, “гүн утгатай ба учир дор холбогдсон үгийг боловч, би цөм бинд тавиж, дунд сайныг ануу болбоос дусал орхин, муу хүмүүний гүн үг дор боловч зурвас татаж тэмдэглэв”^[1], “малчин тариачин боловч мөн үзхүйдүр гайгүй”^[2] хэмээх хоёргүй сэтгэлээр нарийлаг сайхан цохолборлосноос эдүүгээ болтлох хоёр зуун жилийн хугацаанд, монголчуудын дунд өргөн тархагдаж, монгол уншигчдын бахархал хүртээлийг олж, адил бус цаг үеийн хүмүүст үсэн бийрээр бичигдэн иржээ. Харамсалтай нь одоохонд Хасбуын “бинд тавиж, дусал орхин, зурвас татаж тэмдэглэсэн” уул гар бичмэл эх нь хараахан олдоогүй байсаар. Харин түүний адил бус гар бичмэл дэвтэр улсын дотоод гадаадад, дөрвөн бүтэн хоёр зэрэмдэг нийт зургаан зүйл олдоод байгаа юм.

1. Монгол улсын төв номын санд хадгалагдаж байгаа Сайшаалт ерөөлтийн хорин дөрөвдүгээр (1819) оны гар бичмэл, 10 дэвтэр 20 бүлэг, шүлэг хавсаргасан будагт зураг ба бүгдийн хуулла нь үгүй. Муутуу цаасанд үсэн бийрээр сийрүүлэгдэж, дэвтрийн гадар хавьсан дээр “Хүн лэү мэн” гэх манж үсгийн номын нэртэй, дэвтэр дэлгэмэгц нэгдүгээр нүүрт “шинэ орчуулсан Хүн лэү мэн бичгийн оршил” гэх манж монгол үсгээр бичигдсэн зохиолын нэр ба оршил бий. “Шинэ орчуулсан Хүн лэү мэн бичгийн оршил”-ийн ар талд “сайшаалтай ерөөлтийн шарагчин туулай жил өвлийн арван сарын шинэтгэл өдөр,

^{[1][2]} Цао Сюэ Чин, Гао Э зохиож, Хасбу цохлон орчуулав: “улаан асрын зүүд” (тэргүүн, дэд, гудгаар, дөдгөөр), үндэстний хэвлэх үйлдвэр хэвлэв, өвөр монголын их сургуулийн монгол хэл бичиг утга зохилын салбараас хичээл хүмүүжил эрдэм шинжилгээний дотоодийн тусламжид, 1975 он.



THE CULTURAL WAY

өглөг байсгалантын өргөө гэрт орчуулан тэмдэглэв”^[3] гэсэн нь Хасбугийн “улаан асрын зүүд”-ийн орчуулан цохолборлосон найдвардай он жил байж мэднэ. бусад гар бичмэлд иймэрхүү тодорхой орчуулан цохолборлосон он жилийн тэмдэглэлгүй. Сайшаалт ерөөлтийн шарагчин туулай жил бол нийтийн он тооллын 1819 он болох нь тодорхой. Энэ нь Хасбу Хятад улсын нэрт “улаан”-ий цохлон шүүмжлэгч Ван ший лиан, Жан шин зи нараас ч эрт “улаан асрын зүүд”-ийг цохлон шүүмжилсэн чухал баримтыг хангажээ. Хорьдугаар бүлгийн цохолборт “монголын хэлээр орчуулан чадсан ануу өглөг байсгалантын гэрүүн эзэн хасбу мөн”^[4] гэж тэмдэглэсэн нь “улаан асрын зүүд”-ийн орчуулан цохолборлосон нь Хасбу мөн болохыг эргэлзээгүй баталжээ. Оршил дахь мэдээ сэлт нь Хасбугхийн намтар түүхийг судлахад чухал сүвэгчийг хангаж болох юм. Тус гар бичмэлын хорин нэгдүгээр бүлгээс дөчдүгээр бүлэг хүртлэх хорин бүлэг арван дэвтэр нь дутуу байна.

2,Өвөр монголын номын санд хадгалагдаж байга Чин улсын Төр гэрэлтийн хорин долдугаар (1847) оны гар бичмэл, хоёр дугтуй 20 дэвтэр 40 бүлэг, шүлэг хавсаргасан 11 будагт зураг ба Боо юуь зүүдэг “нэвт гайхамшиг эрдэн хас”, Боо цайн зүүдэг “алтан оньс”-ын дээрх гор үсэг зэрэг нь цөм бүрэн бий. Дэвтрийн хэмжээ нь 18.2cm×12.5cm, утасны үдмэлтэй байж, цагаан цаасан дээр үсэн бийрийн хичээнгүй тигээр бичигдэж, шарлан хуучирч хорхойд идэгдсэн газар олон байдаг. Дугтуйн нүүрт “Шинэ орчуулсан Хүн лэү мэн бичиг” гэх манж үсгийн

^{[3][4]} Сайшаалт ерөөлтийн хорин дөрөвдгөр оны гар хуулмал дэвтэр, монгол улсын төв номын сан, 1819 он.



THE CULTURAL WAY

номын нэртэй, дэвтэр бүрийн гадар нүүрт “тэргүүн”, “хоёрдугаар” хэмээн дэвтрийн дугаарыг бичжээ. Тус гар бичмэлын нэгдүгээр нүүрээс “Шинэ орчуулсан Хүн лэү мэн бичгийн оршил”^[5] гэж эхлэн, оршлын ард “Төр гэрэлтийн хорин долдугаар оны намрын тэргүүн сарийн шнин өдөр эхлэн бичвэй”^[6] гэж бичиж бий. Тус гар бичмэл нь одоохонд олдоод байгаа бүх гар бичмэлын дотор хамгийн бүрэн бүтэн дэвтэр болно.

Тус гар бичмэл дэвтрийн ирэлт тодорхойгүй, одоохны номын сангийн судлагчийн таамаглахаар бараг алшаа аймгаас олдсон магад гэж бий. Хэрэв үнэхээр алшаа аймгаас олдсон бол харин ихэд сонирхолтой юм. Очир нь хятад хэлний “улаан асрын зүүд”-ий аль олон бар хэвлэлийн дотроос алшаа вангийн ордноос олдсон “монгол вангийн ордны бар хэвлэл” нь нилээд бүрэн бүтэн бар хэвлэл болно. Тэгэхээр хэрэв энэ нь үнэхээр алшаа вангийн ордноос олдсон бол цаашдаа судлууштай зүйл олон бий.

3,Өвөр монголын их сургуулийн номын санд хадгалагдаж байгаа Бадруулт төрийн тавдугаар (1879) оны гар бичмэл, дөрвөн дугуй 20 дэвтэр 40 бүлэг, шүлэг хавсаргасан 11 будагт зураг бий, оршилгүй ба “нэвт гайхамшиг эрдэн хас”, “алтан оньсон”-ий гор үсэг нь ч үгүй, харин зайг нь үлдээжээ. Дэвтрийн хэмжээ нь 24.4cm×22cm, муутүү цаас байж, үсэн бийрийн хичээнгүй тигээр бичигдэж, дэвтрийн нүүрт “Хүн лэү мэн бичиг” хэмээн манж үсгээр бичиж, түүний дагууд нь “тэргүүн”, “дэд” гэж дэвтрийн дугаарыг хадав. Тус гар бичмэлын нэгдүгээр

^{[5][6]} Төр гэрэлтийн хорин долдугаар оны гар хуулмал дэвтэр, өвөр монголын номын сан, 1847 он.



THE CULTURAL WAY

дэвтрийн нэгдүгээр нуур нь “Шинэ орчуулж гаргасан чухал Хүн лэү мэн бичгийн үзэх арга”^[7] гэж эхлэн, хорьдугаар дэвтрийн хамаг сүүлийн нүүрт “Бадруулт төрийн тавдугаар он, зуны тэргүүн сарийн хорин долооноо хуулав”^[8] гэж тушааж бий. Энэ нь тус дэвтрийн хуулсан он бол 1879 он болохыг тодорхой харуулжээ. Гэвч Хасбугийн цохлон бичсэн он жил биш. Тус гар бичмэл дэвтрийг 1956 онд, Тэгшдүрэн багш түмэдийн цолмонд хэлний шинжилгээ хийж явахдаа Ван боо шан гэгч хүнийг дамжин олов. Үүний илэрсэн газар орон нь Хасбугийн намтар түүхийг судлахад мөн тусламж болж болно. Тус гар бичмэл дэвтэр нь бүрэн бүтэн боловч зарим хэсэг бүлгийн үсэг нь балархай болсон байна.

4,Өвөр монголын нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн номын санд хадгалагдаж байгаа гар бичмэл дэвтэр нь одоохонд хоёр бүтэн нэг зэрэмдэг нийт гурван зүйл байна.

№1,Иргэн улсын анхдугаар оны хар хулгана жилийн (1914) гар бичмэл, 20 дэвтэр 40 бүлэг байж, оршил үгүй. Шүлэг хавсаргасан зурагтаахь зураг ба шүлэг нь ч үгүй. Дэвтрийн хэмжээ нь 18.2cm×12.5cm, утасны үдмэл байж, үсэн бийрийн хичээнгүй тигээр бичигдэж, дугтуйн нүүрт “Хүн лэү мэн бичиг” гэж манж үсгээр бичин, дэвтрийн гадарт дугаарыг бичиж, “中共中央蒙绥分局图书馆 Хятад улсын коммунист намын төв хорооний өвөр монголлын сүй юаны хуваарь

[7][8] Бадруулт төрийн тавдугаар оны гар хуулмал дэвтэр, өвөр монголын их сургуулийн номын сан, 1879 он.



THE CULTURAL WAY

товчооны номын сан”^[9] хэмээх жишүүлжин шунхан тамга ба “赠阅”^[10] гэх хятад үсгийн тамгатай.

№2, Чин улсын Төр гэрэлтийн үеийн гар бичмэл, 20 дэвтэр 40 бүлэг, “үзэх арга” ба шүлэг хавсаргасан зурагтаахь зураг нь үгүй, харин шүлэг нь бий. Дэвтрийн хэмжээ нь 21.5cm×15.7cm, утсан үдмэлтэй байж, цагаан цаасан дээр шунхан үзгийн бийрийн хичээнгүй тигээр тэмдэглэгджээ. Тэргүүн дэвтрийн нуурын гадарт “хар хулгана жилийн, намрийн тэргүүн сарийн, сайн өдөр бичив, хөх барс жилийн, зуны дундад сар дур, шинэтгэн засаж үдэв”^[11] гэж үдсэн он сарыг тодорхой тушааж бий. Энэхүү хар хулгана жил, хөх бар жилийг хараахан баттай нотлох баримт олдоодой тул хожимын судалгаанд нягтлах чухалтай.

№3, Чин улсын сүүлч үеийн гар бичмэл, 6 дэвтэр 22 бүлэг, шүлэг хавсаргасан зурагтаахь шүлэг нь бий, зураг нь үгүй. Дэвтрийн хэмжээ нь 22.3cm×14cm, гүн цэнхэр өнгийн дугтуйд хавьсалж, дэвтрийн гадар дотор нь цөм цагаан цаас бөгөөд утсан үдмэлтэй, үсэн бийрийн гүйлгэн тигээр улаан шугамтай цаасан дээр бичсэн байна. Дугтуйн гадарт “Хүн лүү мэн бичиг” хэмээн монголлоор бичиж, олдсон газрын тухай “цахар аймгийн Содномдамбагаар дамжин олов”^[12] гэж гадар хавьсанд тэмдэглэж бий. Тус гар бичмэл нь зэрэмдэг дэвтэр, хэрэглэсэн цаас,

^{[9][10]} Иргэн улсын анхдугаар оны гар хуулмал дэвтэр, өвөр монголын нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн номын сан, 1912 он.

^[11] Чин улсын төр гэрэлтийн үеийн үсэн бийрийн гар хуулмал, өвөр монголын нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн номын сан.

^[12] Чин улсын сүүлч үеийн үсэн бийрийн гар хуулмал, өвөр монголын нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн номын сан



THE CULTURAL WAY

үсгийн тигийг нарийн шинжхэд, нилээд хожуу үеийн гар бичмэл дэвтэр болох нь тодорхой.

Судалгааг үндсэлбэл, судлаачидаас дээрх эл гар бичмэл дэвтрийн агуулгыг харьцуулан харгуулж, тэдгээрийн адил ба адил бус талыг шинжлэхээр дамжин, Хасбугийн монгол орчуулгын “улаан асрын зүүд”-ийн эл гар бичмэл дэвтрийн хоорондох харьцааг нэгэнт заан тодорхойлжээ. Даруй, Хасбугийн уул гар бичмэл эх нь хоёр их бичмэл системээр уламжлагдан тархагдсан байна.^[13] Үүнд, Сайшаалт ерөөлтийн хорин дөрөвдүгээр он (1819)-ий гар бичмэл дэвтэр нь одоохонд олдсон Хасбугийн монгол орчуулгын “улаан асрын зүүд”-ийн (“шинэ орчуулсан Хүн лээ мэн бичиг”-ийн) хамгийн эртний гар бичмэл дэвтэр болно. Мөн ч “одод тултал олдсон дэлхий дээрх ‘Улаан асрын зүүд’-ийн хамаг эртний товч орчуулгын дэвтэр болно”^[14] хэмээн тодорхойлсон байдгийг дурдалтай. Тус гар бичмэл дэвтрийн оршлын ард тэмдэглэсэн Сайшаалт ерөөлтийн шарагчин туулай жил бол нийтийн он тооллын 1819 он болход судлаачид санал нэгтэй. 1819 он нь мөн эрдэмтэдийн Хасбугийн намтар түүхийн тухай магадлал нотлолтой нийцэж бий. Өнгөрсөнд, судлаачидаас өвөр монголын номын санд хадгалагдаж байгаа Чин улсын Төр гэрэлтийн хорин долдугаар он, даруй 1847 оны гар бичмэл дэвтрийг үндэслэн, Хасбу 1847 онд “Улаан асрын зүүд”-ийг цохлон орчуулсан гэж үзэж байжээ. Хожим нь тус гар бичмэл дэвтрийг илрүүлснээс судлаачидын Хасбугийн “Улаан асрын зүүд”-ийг орчуулан дууссан цагийн тухай асуудал нь тодорхой

[13] 陈岗龙：《哈斯宝<新译红楼梦>抄本初探□□简论蒙古国国立图书馆藏本的价值》，《内蒙古民族大学学报》（社会科学汉文版），2018年第4期。

[14] 额尔很巴雅尔：《<红楼梦>蒙译及其对蒙古族文学的影响》，《红楼梦学刊》，2019年。



THE CULTURAL WAY

дүгнэлттэй болжээ. Өөрөөр хэлбэл, 1819 он болон 1847 он нь Хасбугийн орчуулан цохолсон он биш, харин хуулан сийрүүлэгчийн хадсан он болох бөгөөд Хасбугаар үүнээс өмнө нэгэнт “Улаан асрын зүүд”-ийг орчуулан дууссан болох нь лавтай.

Дээрх зургаан зүйлийн гар бичмэл дэвтрээс гадна, 20 дугаар зууны далаад оны эхээр өвөр монголын их сургуулийн Б·Гэрэлт профессороор төлөөлүүлсэн ахмад эрдэмтэдийн Төр гэрэлтийн хорин долдугаар оны гар бичмэлд суурилан, Бадруулт төрийн тавдугаар он ба хөх бар жилийн гар бичмэлтай харьцуулан хянаж, харгуулан тиглэсэн, уран бичлэгтэн Хаванжаб, Чвн чин юн сэйрүүлэн бичсэн 11 дэвтэр “Улаан асрын зүүд” нь одоохны Хасбу судлалд өргөн ашиглагдаж байгаа эрдэм шинжилгээний лавлалтын материал болох 4 дэвтэр бүхий “Улаан асрын зүүд”-ийн (“Шинэ орчуулсан Хүн лүү мэн бичиг ”) үсэн бийрийн гар бичмэл болно. Тус гар бичмэл дэвтрийг 1975 онд, Б·Гэрэлт профессороор өвөр монголын их сургуулийн номын санд хандивлан хүргэжээ. Одоохонд энэ нь өвөр монголын их сургуулийн номын сангийн ховор чухаг сурвалж бичгийн материалын тасагт хадгалагдаж бий. Энэхүү 11 дэвтэр нь хоёр дугтуйд хавьслогдож, дэвтрийн хэмжээ нь 18.6cm×26.7cm, арав тооны нүүрийн дугаартай, хятад үсгийн дэвтрийн дугаартай, ном бүрийн тэргүүн нүүрт өвөр монголын их сургуулийн тамагтай. Тэргүүн дэвтрийн дунд 11 хувь будаггүй зураг, “хэвлэн нийтлэгчийн үг” зэргийг хавьчуулсан онцлогтой.

ДҮГНЭЛТ

Хасбугийн монгол орчуулгын “Улаан асрын зүүд”-ийн эдгээр адил бус гар бичмэл дэвтрууд нь адил бус цаг үеийн монгол утга зохилын



THE CULTURAL WAY

онцлог ба монгол хэлний онцлогийг хадгалж байгаа ховор чухаг сурвалж бичиг тул орчуулж хуулсан он жил, илэрхийлсэн үг хэллэгийн оноолт, нийтлүүлсэн зорилго чиглэл, дэвтрийн өнгө үзэмжийн хувьд өвөрмөц ялгамжаатай байх нь үзэхэд илхэн. Энэхүү адил бус гар бичмэл дэвтрууд нь монгол утга зохиол, сурвалж бичиг судлал жич “Улаан асрын зүүд”-ийн судалгааны чухал эх хэрэглэхүүн байж, маш өндөр судалгааны үнэ цэнэтэй хэмээн үзэж байна.

ABSTRACT

“Ulaan Asar Zuud” is an encyclopedia of ancient Chinese literature. The distribution, anticipation and study of this work in Mongolia is closely related to the famous Mongolian writer and theorist Hasbu. Unlike the Mongolian translation of Hasbu's “Ulaan Asar Zuud”, the six manuscript notebooks have unique differences in terms of the year of translation, the punctuation of the expressed words, the purpose of the publication, and the appearance of the notebooks. It is considered to be an important source material for the research of “Ulaan Asar Zuud” and has a very high research value.

Key words: *Ulaan Asar Zuud, mongolian translation, manuscript notebook, difference*



THE CULTURAL WAY

НОМ ЗҮЙ

1. Цао Сюэ Чин, Гао Э. Улаан асрын зүүд (тэргүүн, дэд, гудгаар, дөдгөөр), ҮнХХ 1975
2. Сайшаалт ерөөлтийн хорин дөрөвдгөр оны гар хуулмал дэвтэр 1819. МУТНС
3. Төр гэрэлтийн хорин долдугаар оны гар хуулмал дэвтэр 1847. ӨМНС
4. Бадруулт төрийн тавдугаар оны гар хуулмал дэвтэр 1879. ӨМИСНС
5. Иргэн улсын анхдугаар оны гар хуулмал дэвтэр 1912. ӨМНШУХНС
6. Чин улсын төр гэрэлтийн үеийн үсэн бийрийн гар хуулмал. ӨМНШУХНС
7. Чин улсын сүүлч үеийн үсэн бийрийн гар хуулмал. ӨМНШУХНС
8. 陈岗龙: 《哈斯宝<新译红楼梦>抄本初探□□简论蒙古国国立图书馆藏本的价值》, 《内蒙古民族大学学报》(社会科学汉文版), 2018年
9. 额尔很巴雅尔: 《<红楼梦>蒙译及其对蒙古族文学的影响》, 《红楼梦学刊》, 2019年。

ИЛ ХААНТ УЛСЫН АРГУН ХААНЫ ГУРВАН ЭЛЧИЙН ҮЙЛ ХЭРГИЙГ ӨРНӨ,
ХЯТАД, ПЕРС СУРВАЛЖААС ХАЙХ НЬ

Соёлбаатар*

ХУРААНГУЙ

Ил хаант улс болон Юань улсын элчин харилцаанд чухал нэг эргэлт бол гагц хуурай замын харилцаанаас хуурай болон далайн хос замын харилцаанд шилжсэн явдал болно. Одоо бидний мэдэж байгаагаар бол Аргун хааны гурван элчин юань улсаас Марко поло болон түүний аав Абагатай нь хамт далайгаар Ил хаант улсдаа харьсан нь анх сурвалжид илэрсэн хоёр улсын далайн замын элчин харилцаа юм. Аргун хааны гурван элчийн тухай тусгай сэдэвт бүтээл үгүй боловч “Зууны маргалдаан” хэмээгдсэн Марко поло юань улсад ирсэн эсэхээр өрнө болон дорнын эрдэмтдэд дамаар судлагдаж байсан юм. Гэхдээ тийм ч гүнзгийрч чадаагүй байв. Тус өгүүлэлд Аргун хааны гурван элч Ултай, Авших, Хуза нарын угсаа гарвал үйл ажиллагаануудыг нягтлахыг зорьсон юм.

Түлхүүр үгс: *Ултай, Авших, Хуза, Марко поло*

Нэг. “Зууны маргалдаан” дахь гурван элч

“Зууны маргалдаан” хэмээх нь арван гуравдугаар зууны Италийн жуулчин Марко поло юань улсад хүрсэн эсэхийн тухай олон эрдэмтэн мэргэд хорьдугаар зуунд дал гаруй жил маргалдаан мэтгэлцээн болсныг хэлж байна.¹ Анх хятдын эрдэмтэн Yang Zhi Jiu (杨志玖) юань улсын албаны найруулсан ном “*经世大典 (jing shi da dian)*” –ийн “Замч (站赤)”-ийн хэсэгт тэмдэглэсэн албан бичиг болон “Марко улын аялал”-ыг үндэслэн Марко поло Аргун хааны гурван элчтэй хамт Хөхчин хатныг

* Өвөр Монголын Их Сургуулийн докторант

¹ 李治安：《杨志久先生与马克·波罗来华的“世纪论战”》，2019年第12期，第62页。（Li Zhi An: “The Famous Historian Yang Zhi Jiu and the ‘century controversy’ of the Authenticity of marco polo in China”. History teaching. No.12,2019, pp62.）



THE CULTURAL WAY

хамгаалан юань улсаас аяарласан цаг бол өрнийн эрдэмтний үздэг 1292 биш, харин 1291 он болно гэжээ.² Энэ судалгаа нь францын нэрт эрдэмтэн Pelliot³, английн эрдэмтэн Boyle⁴, америкийн хар лам Cleaves⁵-ийн дэмжлэгийг олсон юм. Үүний дараа Yang Zhi Jiu хорьдугаар зууны наяд оноос хорин нэгдүгээр зууны эх хүртэл америкийн судлаач Heager⁶ хятадын судлаач WangYuMin (王育民)⁷, английн судлаач Frances Wood⁸-тэй маргалдаан болж Марко пологийн тухай цөхөртлөө өгүүлэл нийтлэлээ эмхэтгэн өгүүллийн түүвэр болгон хэвлэжээ.⁹

Хятдын эрдэмтэн YangZhiJiu, францын эрдэмтэн Pelliot, английн эрдэмтэн Boyle америкийн эрдэмтэн Cleaves яаж дан Марко поло юань улсад хүрч өнгөрсөн гэсэнд итгэсэн нь хятад сурвалж “Jing shi da dian (经世大典)” дахь “Замч (站赤)” хэсгийн албаны бичигт илэрсэн “Wu Lu (兀鲁), A Bi Shi Ha (阿必失呵), Huo Zhe (火者)” зэрэг гурван элч нь “Марко пологийн аялал”-д байгаа “Oulatai, Arousca, Coja” болно гэж үзсэнд байгаа юм. Доор хятад сурвалж “Jing shi da dian (经世大典)”-д байгаа гурван элчийн тухай тэмдэглэлийг үзье¹⁰:

(至元二十七年)十七日,尚书省阿难答,都事别不花等奏:平章沙不定上言“今年三月奉旨,遣兀鲁、阿必失呵、火者取道马八儿,往阿鲁浑大王位下。同行一百六十人,内九十人已支分例。余七十人,闻是诸王所赠遣及买得者,乞不给分例口粮”。奉旨:勿与之!

² 杨志玖:《关于马可波罗离华的一段汉文记载》,《文史杂志》,1941年第一卷第12期;“A New Discovery referring to Marco Polo’s Departure from the chine source”,Jounal of the Royal Asiatic society of Bengal letters,Volume4,1944;“Marco Polo quits china”,Harvard Jounal of Asiatic studies, volume9,No.1.1945.9.

³ Paul Pelliot:Notes on Marco Polo,pairs1959,pp.392—394.

⁴ John Andrew Boyle,“Rashid al—Din and the Franks”,Central Asiatic Journal,NO.14,1970.

⁵ Francis Woodman Cleaves:“A Chinese Sourse Bearing on Marco Polo’s Departure From China and a Persian sourse on His Arrival in Persia”,Harvard Journal of Asiatic Studies, Vol.36,pp.181—203,1976.

⁶ John W .Haeger,“Marco Polo in China Problems with Internal Evidence”,Bulletin of sung and yuan studies,1929,14,pp.23—30.

⁷ 王育民:《关于<马可波罗游记>的真伪问题》,《史林》1988年第2期。

⁸ Frances Wood:“Did Marco Polo go to China”,london,1995.

⁹ 杨志玖:《马可波罗在中国》,天津,南开大学出版社,1999年。

¹⁰ 永乐大典,卷19418(第八册)[M].北京:中华书局书局影印本,1986.7211下。



THE CULTURAL WAY

Cleaves-ийн үзэл¹¹:

On the 17th day[...of the 8th moon...of the 27th year of chih-yÜan (21september 1290)] the shang-shu 尚书,A-nan-ta 阿难答 (Ananda) ,the Tu-shih, pieh pu-hua 别不花 (Be[g]Buqa),and others memorialized(奏): “the P’ing-chang 平章,sha-pu-ding 沙不丁 (Šabuding) ,has sent up a statement(上言) ;

‘In the 3rd moon of this year[7April-6May 1290] there was received an Imperial Directive(奉旨) [to the effect] that Wu-lu-tai 兀鲁歹 (uluda) ,A-pi-shih-ha 阿必失呵 (AbiŠqa) ,and Huo-che 火者 (Qoje) be dispatched to proceed to the domain(位下) of the Ta-wang 大王,A-lu-han 阿鲁浑 (Argun) ,via(取道)Ma-pa-erh 马八儿 (Mabar) .’

“ ‘Co-travellers(同行) ; 160persons.

“ ‘[As for] 90 persons among [them],rations(分例) have already been disbursed. [As for]the remaining 70 persons, it has been heard that they are those who have been donated(遣赠) as well as parchased(买得) by sundry officials (诸官) . It is requested that they not be furnished rations (分例) and provisions (口粮) .’ ”

There was received an Imperial Directive:

“Do not give them.”

Cleaves-ийн англи орчуулга ихэнхдээ зөв. Гэхдээ хоёр газар хараахан тохиромжгүй байна. Cleaves гурван элчтэй хамт аялсан 160 хүмүүсийн 70 хүн нь “эл ноёдын худалдан авч хүргэсэн хүмүүс” гэж орчуулж байна. Анхны уг хятад эх бичгээр тийм утга гарахгүй байна. Харин энэ 70 хүн нь “хөвгүүд (Чингис ханы ургийн ван нар) хүргэсэн болон худалдан авсан хүмүүс” болно. Тус албан бичигт 90 хүмүүст нэгэнт хувилсан амуу олгосон, үлдсэн 70 хүмүүс нь хөвгүүд хүргэсэн болон худалдан авсан хүмүүс учраас улсын сангаас хувилсан амуу

¹¹ Francis Woodman Cleaves: “A Chinese Source Bearing on Marco Polo’s Departure From China and a Persian source on His Arrival in Persia”,Harvard Journal of Asiatic Studies, Vol.36,pp.187.



THE CULTURAL WAY

олгохгүйг санаачилсан байна. Cleaves 《分例口粮(fenlikouliang)》 гэх хятад үгсийг 《хувилсан зүйл болон ам хүнс (rations (分例) and provisions (口粮)) 》 гэж орчуулж байна. Гэхдээ энэ хэдэн үгс нь тусгай (оноосон) нэр үгс юм. Элч нар замаар зорчих дан өртөө бүр элчдэд зориулсан шүүс, дарс, хүнс зүйлийг эрэмбэ зэргээр нь тогтоосон хувь бий.

Хятад эх бичгээс монголчилбол :

(Жы юань-ий хорин долоон оны найман сар)-ийн арван долооны өдөр , шаншү ананд , түш бэхи бух нар айлтгасан нь : пинзан шаавутин бичиг ирүүлж “Энэ жилийн гурван сард зарлигаар ултай, авших, хуза нар мавар улсаар дайрч Аргун да вангийн улсад илгээв. Хамт аялагсад 160 хүмүүн, түүний дотор 90 хүмүүнд хувь олгов. Үлдсэн 70 хүмүүн нь сонсоход хөвгүүдийн бэлэг болгон хүргэсэн болон худалдан авсан хүмүүс байв. (эдгээр хүмүүст) хувь ам эс өгөхийг хүсэж байна. зарлигаар: эс өгтүгэй гэв .

Дээрх албан бичигт Жы юань 27 (1290) оны 8 сар шан шү түшмэл ананд, түш бэхи бух хубилай хаанд айлтгал өргөж шаавутингийн өргөсөн бичиг даахь ултай, авших, хуза нарын элчний бүлгэм Ил хаант улс руу далайгаар аялахад хэрэгсэх ам хүнсэн хангалгыг зөвдөлцсөн байна. Албан бичгийн агуулгаас мэдэх нь хубилайгаас далайгаар аялах шийдвэр гаргасан энэ удааны зөвлөлдөөнөөс уртай 5 сар байв. Элчингийн бүлгэм Дайду-аас мордон хуурайгаар чиован жүүд (Quan zhou 泉州) хүрч дарвуулт онгоцны түлхэх хүч болох умрын салхийг хүлээж байгаа нь илхэн, элчингийн бүлгэмд хөвгүүдийн хүргэсэн хүмүүс болон худалдан авсан хүмүүс байгаа учраас эдгээр хүмүүст хувь ам олгох тухай зөвлөлдсөн нь өмнө нь ийм учир цөөхөн тохиолддог байсантай холбогдолтой. Урьд нь хуурайгаар харьцдагаас 1290-аас эхлээд далайгаар харьцах болсон шинэ шийдвэрийг зөвлөлдөөнөөр гаргасан байна. Юунд далайгаар харьцдаг болсон бэ гэвэл юань улс болон Хайду-аар тэргүүлсэн Өгөдэй, Цагадайн хойчис зүүн туркистаны газраар их дайн болж хоёр улсын элчийн харьцаа хэсэг хугацаанд



THE CULTURAL WAY

тасарсан байсан байв. Доор бид “Маркопологийн аялал” дахь гурван элчийн мэдээг үзье¹² :

Энэ үед зүүн энэтхэгийн Аругун (Аругун/argon) хааны их хатан Булган (болгана/Bolgana) насан эцэслэв. Их хатан бээр насан эцэслэхийнхээ өмнө хаанд гэрээслэлээ үлдээхдээ, их хааны эзэмшлийн катай (катаёо/Cataio) дахь хатны ургийн бус хүнийг минь сэнтийд бүү суулга, хааны хатан байсан ч үл зөвшөөрнө хэмээжээ. Тийн их хатны хэлсэн ёсоор Аругун хаан улатай (Ulatay), Апушика (Arusika), Хуза (Caza) гэх гурван ноёныг бараа бологчдын хамт их хаан руу илгээж Булган хатны ургийн хүнээс хатан сонгохыг хүсжээ. Их хаан тэднийг машид баясан хүлээн авч, хатны гэрээс ёсоор когатин (Cogatin) хэмээгч 17 настай өнгө зүс сайтай охиныг үзүүлэхэд элч нарт ихэд таалагджээ. Аругун хаанд охин хүргэхдээ их ёс төрийг сэтгэн хороо цэрэг, эд агуурсыг ихэд бэлтгэн барьсны хойно, элч нар их хаанаас зөвшөөрөл авч морилон одов. Тэд ирсэн замаараа буцсан бөгөөд найман сарыг элээжээ. Татарын зарим хаад өөр зуураа дахин дайн хийсэн учир зам хаагдаж, цааш явахын аргагүй болов. Чингээд ордны зүг буцан, их хаанд зам зуурын учир явдлыг айлтгажээ. Энэ үед Марко усан онгоцоор Энэтхэгийн далайг гаталж ирсэн бөгөөд их хаанд нутаг орны сонин, аян замын содон мэдээ зангийг айлтгахын сацуу усан онгоцоор далайд ямарч айлтгүй явж буй учрыг уламжилжээ. Тэрхүү мэдээ Аругун хааны элч нарын сонорт хүрч, нутгаасаа гараад гурван жил болсон тэд нутагтаа буцахыг хүсэж байв. Тэдний адилаар эх нутагтаа буцахыг хүссэн никол, маффо, марко нартай уулзахаар явав. Тэд зөвлөлдөн тогтоод элч нар, хатны хамтаар их хаанд бараалахж, Аругун хааны нутаг руу далайгаар орох хугацаанд, зардал сүйтгэл хэмнэн аялна (усан онгоцноор аялсан ноён маркогийн хэлсэнчлэн), их хаан бээр далайгаар аянд гаршсан николо, маффо, марко нараар удирдуулан хүргэхийг зөвшөөрсөн байв.

Дээрх материалд ултай, авших, хуза гурван элчин Хүхөчин хатантай цуг буцах замаар найман сар аялахад дайнаас болж зам хаагдан ийш тийш буцаж, марко, николо, маффио зэрэг гурван итали хүнтэй нийлж Ил хаан улстаа буцахаар болсон байна. Хубилай хаанаас

¹² Марко польн аялал.Г- бат -учрал,Элизабетта Рагагнин,Самүэла Симион Итали хэлээс монголчлов, Улаанбаатар,2019,pp.35.



THE CULTURAL WAY

элчийн бүлгэм их далайгаар аялахад амар мэнд байхыг ихэд санааширч байсан ч марко нар урд нь энэтхэгийн далайд хүрч баялаг туршлага хуримтлуулснаар аяарлахыг нь зөвшөөрсөн юм.

Далайн бэрхшээлт аянд Марко Поло гурван элчийн хамт олон өдөр хоногийг үдсэнээр бат бэх нөхөрлөлийг байгуулсан юм. Pilliot “Марко Пологийн аялал”-ын Абага хаан болон Аргуны хаан орын тэмцэл нь бараг Ултайгаас мэдээ авсан байж мэднэ гэжээ. Тэр Дуссоны бүтээл дэхь Аргуны элч “Ултай хатан ” нь “Ултай” болон “Хатан” хоёр хүн байж таарна гэжээ¹³. Celeavs Yangzhijiu-гийн судалгааны суурин дээр Марко Пологийн Юань улсаас аяарласан ба Ил хаан улсад хүрсэн байдлыг нарийн тоочсон байна. Далайн бартаат аянд ултай, авших хоёр нас нөгчиж зөвхөн хуза үлдсэн байна. Ултай, авших хоёрын зам зуураа нас нөгчсөн нь перс сурвалжид тэдний үйл хэргийг өргөн тэмдэглэх бололцоог багасгасан юм. Гэхдээ энд тэнд тасархай мөрүүд байсаар байгаа ч онцгойлон авшихын угсаа гарлыг нилээд тод тэмдэглэсэн байна .

Хоёр перс сурвалжаас ултай, авших, коз нарын үйл хэрэг, угсаа гарлыг хайх нь: өмнөх хэсэгт Аргун хааны гурван элч ултай, авших, хуза-ийн юань улс дахь үйл явдлуудыг нарийлаг тоочсон юм. Гэхдээ энэ нь “зууны маргалдаан”-ыг танилцуулахын дагууд өмнөх хүмүүсийн судалгааны бүтээлд эргэцүүлэл хийсэн төдий юм. “Зууны маргалдаан”-д Марко Поло юань улсад орсон эсэхээр хоёр тал хуваагдаж эрдэмтэн мэргэдүүд сэцэлсээр иржээ. Гурван элчийн үйл хэрэг хэдийгээр Марко Пологийн сэдвийн завсраар судлагдсан ч эрдэмтдийн анхаарлыг төдийл татаагүй, саглагар хайлаасны сүүдэрт цухуйсан зулзага ногоо мэт байв. Хэрвээ гурван элч Марко нарыг авч яваагүй бол өрнөдөд нөлөөтэй том бүтээл гарахгүй байх болов уу. Юань улсад элчилсэн Аргун хааны гурван элчийг угсаа гарал, үйл хэргийг судлах нь Марко Поло юань улсад хүрсэн тухай “зууны маргалдаан”-ы судалгааг улам цаашид өрнүүлэх мөртөө юань улс болон Ил хаант улсын элчийн харилцаа онцгойлон 12-13 дугаар зууны олон улс үндэстний далайн замын харилцааны судалгаанд чухал үйлдэлтэй юм .

¹³ Paul Pelliot:Notes on Marco Polo,pairs1959,pp798.



THE CULTURAL WAY

(1) Ултай

Ил хаант улсын Аргун хааны элч Ултай ваасафын түүхэнд тэмдэглэгдсэн байна. Ваасафын түүхэнд ултай Аргуны дэмжиж Абага-ын эсрэг тэмцсэн байна. Ваасафын түүхэнд :¹⁴

Дараа нь Болдтөмөр, Зургаадай, Ялхнаар тэрүүлсэн тусгай мянганыг хошуучилж явуулав. Өөрөө одон зурхайчны үзлэгээр исламын 683 оны хоёрдугаар сарын нэгэнд эмэгч, тагай заргчи, тодой, хядлаг бухын хүү хасан, алгуу, улдуй, хадаан ба ааман зэрэг ноёдыг дөрвөн мянган цэргийн хамт мөн замаар оруулав.

Абага хаан Аргуны холбоотон болох хонгирадийг цаазалснаас абага болон Аргуны зөрчил ширүүсэж, эцэстээ дайн хийх хүрсэн юм. Ултай нь Аргуны дайчилсан цэргийн ноён мөртөө Абага-ийн эсрэг дайнд мордсон байна. Ултай нь Аргуны итгэлт нөхөр хувьд нөгөө хоёр элчээсээ илүү байр суурьтай байв. Авших нь Аргуны илгээсэн гурван элчийн дэд байранд байсайд, түүний угсаа гарал үйл хэрэг Түүхсийн чуулганд тэмдэглэгдсэн нь японы эрдэмтэн судлаачдад олж харагдаагүй байна.

(2) Авших

Авших нь хонхотан аймгийн хүн юм. Түүхсийн чуулганд хонхотан аймгийн Мэнлэг эцгийн хүү долон чэрби, сүйхт чэрби, содыг дурдаад, авших нь тэдгээрийн хойчис болно гэж тэмдэглэсэн байдаг. Гэхдээ аль нэгнийх нь хойчис болох нь тодорхойгүй байна. Гэхдээ мэнлэг эцгийн үр удам болох нь гарцаагүй болно. Түүхсийн чуулганд :¹⁵

Тэдгээрийн хойчис энэ орон (ирсэн орныг хэлж байна)-д байгаа нь Жингин хатны хүргэн түнсайд болон авших, энэ авших тэдэн хааны дэргэд үүрэгтэй явуулсан юм .

Дээрх материалаас авших нь үүрэг хүлээж хубилай хаан өөд элчилснийг мэднэ. Энэ үүрэг нь их болоод хатны залгамжлагчийг залах явдал болно.

¹⁴ Tākhrir-i Tārikh-i Vassāf, pp.76.

¹⁵ Rashid al-din/Rawshān,Jami'al Tavārikh, vol.1,pp168.



THE CULTURAL WAY

(3) Хуза

Хуза нь гурав дахь байрт байх элч юм. Исламын шашны алдартай багш буюу тэдгээрийн хойчсийг хуза гэж дууддаг. Хятад, өрнийн, перс сурвалжид энэ хүний нэр хуза гэж тэмдэглэж байна. Гэхдээ хузань энэ хүний жинхэнэ нэр уу эсвэл исламын шашны алдартай багш буюу тэдгээрийн хойчис болох нь тодорхойгүй байна. Түүхсийн чуулганд ¹⁶:

Авганар хотод хуза болон нэг бүлэг элчидтэй учрав. Тэд нь Аргун хааны зарлигаар хааны дэргэд хүрч, их Булган хатны төрлийн хүүхнийг гуйж Булган хатны орыг залгамжлуулах гэв. Тэд Хүхөчин хатан ба хаадын эрхэмлэдэг тансаг эрднэсийг авч ирэв. Хасан тэнд бууж, хүхөчин хатантай хуримлав .

Энэ хуза нь ислам хүн байх бололцоо их байна. Юань улс болон Ил хаант улсын элчийн бүлгэмд ислам хүн зөндөө байж, өндөр тушаалд томилогдож байв. Абага болон Аргуны тэмцэлд хуза ороогдож Аргунд байрвчлагдахад Булган хатан түүнийг авран гаргасан юм. Хуза нь Булган хатантай онцгой харьцаатай байсан нь илхэн байлаа. Гэхдээ Булган хатан нас нөгчисний дараа түүнийг Аргун цаазалсан байна. Юань улсад элчилсэн хуза нэртэй элч нь хуза-тай ямар нэгэн харьцаатай хүн байж Булган хатны ортаг арилжаачин хувиар юань улсад хүрсэн байж магад.

ABSTRACT

An important turning point in the diplomatic relations between the Kingdom of Light and the Yuan was the transition from land-only to land-sea duality. As we now know, the three ambassadors of Argun khan returned to the Il Kingdom by sea from the Yuan State together with Marco Polo and his father Abaga, which is the maritime diplomatic relationship between the two countries that was first revealed in the sources. Although there is no specific work on the three messengers of Arghun khan, it has been studied by Western and Eastern scholars whether or not Marco Polo arrived in the Yuan country, which was considered the "Controversy of the Century". But it didn't go that deep. In the article, the three messengers of Argon khan, Ultai, Avshih, and Huza, tried to analyze their activities.

Key words: *Ultai, Ascend, Huza, Marco Polo*

¹⁶ 《史集》汉译本第三册, 第 267 页。

ХАМГААЛАЛТ БА ӨВ ЗАЛГАМЖЛАЛ: ЗҮҮН МОНГОЛЫН АРДЫН ҮЛГЭРЭЭР
ДАМЖУУЛАН ХАМТАЧ ЭХ ОРОНЧ ҮЗЭЛ ТӨЛӨВШҮҮЛЭХ ТУРШЛАГА

Өнөр*

ХУРААНГУЙ

Зүүн Монголын аман зохиол нь монгол, хан, манж үндэстний эдийн засаг, нийгмийн харилцан хамаарал, соёлын зан заншлын түүхэнд тэмдэглэгдэн үлдсэн түүхийн хувьд хятад үндэстний уламжлалт соёлын чухал хэсэг юм. Эдгээрийн дотроос “Ха Зуо-зүүн монгол ардын үлгэр” нь үндэсний биет бус соёлын анхны өвийн хувьд зүүн монголчууд ардын үлгэрээ хадгалан хамгаалсны үр дүн бөгөөд олон үндэстэн ястны харилцан ойлголцол, хүлээн зөвшөөрөгдсөн амьдралын түүх, тусгалыг агуулсан мөн хятад улсын бүтээн байгуулалтын нэгэн чухал хэсэг юм. Үндэсний хамтач оюун ухаан эх орны чухал агуулга юм. Иймд өвөг дээдсийн сэтгэл санааны болон оюун санааны хэрэгцээг “Ха Зуо-зүүн монгол ардын үлгэр”-ийн хамтын илэрхийлэлд шинжлэн судалснаар биет бус соёлын өвийг дахин боловсруулах практик нь дараа дараагийн амьдралд бэлтгэдэг гэсэн таамаглал дэвшүүлж байна. Энэ нь урт хугацаанд үр дүнтэй арга юм. Бүх үндэстэн ястны хамтач оюун санааны эх оронч үзлийг төлөвшүүлэхэд түлхэц өгөх гол арга зам болно.

Түлхүүр үгс: *Зүүн монгол ардын үлгэр, эх оронч үзэл, биет бус соёлын өвийг хамгаалах, түүхэн замнал*

* Ордос хотын Технологийн Дээд Сургуулийн багш, 1819848889@qq.com
Судалгааны чиглэл: *Угсаатны соёл, аялал жуулчлал*



THE CULTURAL WAY

保护与传承：东蒙民间故事构筑共有精神家园的实践

乌尼尔

（鄂尔多斯应用技术学院 内蒙古 鄂尔多斯 017010）

摘要：东蒙民间故事作为蒙、汉、满多民族经济社会相互依存，文化习俗交互共生的记录史，是中华民族传统文化的重要组成部分。其中，《喀左·东蒙民间故事》作为第一批国家级非物质文化遗产，是东蒙民间故事的保护成果，蕴含其中的生活历史以及多民族彼此认识和认同的反映，更是建设中华民族共有精神家园的重要内容。因此，通过分析《喀左·东蒙民间故事》中先民对于情感和精神需求的集体表达，从保护与传承视角提出非物质文化遗产实现“第二生命”的价值循环实践，是长久、有效推进各民族共有精神家园建设的重要途径。

关键词：东蒙民间故事；共有精神家园；非物质文化遗产保护；路径

2021年5月，文化和旅游部发布《“十四五”非物质文化遗产保护规划》要求“深入实施非物质文化遗产传承发展工程，切实提升非遗保护传承工作水平，不断增强中华优秀传统文化的生命力和影响力，构建各民族共有的精神家园”。¹东蒙民间故事中族际互动与文化交融的重要内容，是非物质文化遗产保护背景下建设多民族共有精神家园，持续推进东蒙各民族文化生存与发展的重要资源。

《喀左·东蒙民间故事》是第一批国家级非物质文化遗产，更是了解东蒙各民族文化精神的重要视角。李瑞芬指出《喀左·东蒙民间故事》的搜集与刊布，为中华民

作者简介：乌尼尔（1998—），女，内蒙古通辽人，鄂尔多斯应用技术学院教师，主要从事民族文化、民族旅游研究。

邮箱：1819848889@qq.com

地址：内蒙古自治区鄂尔多斯市康巴什区东大街1号鄂尔多斯应用技术学院（017010）

电话：15848161727

¹ 《“十四五”非物质文化遗产保护规划》，中华人民共和国文化和旅游部网站：http://www.gov.cn/zhengce/zhengceku/2021-06/09/content_5616511.htm，访问日期：2022年9月1日。



族文化乃至世界民族文化遗产保护作出了贡献。²随着《喀左·东蒙民间故事》的整理与出版，其相关研究主要围绕东蒙民间故事的文化内涵³与审美意象⁴，非物质文化遗产的保护⁵与开发⁶等民族民间文化的继承和发展方面，尚未围绕“精神家园”的文化功能与精神蕴涵进行相关研究。而纵观以往研究，学界围绕“各民族共有精神家园”问题展开了广泛的研究，逐渐突显出民族文化在精神家园建设中的作用。基于此，

《喀左·东蒙民间故事》作为东蒙各民族经济社会相互依存，文化习俗交互共生的重要史证，对《喀左·东蒙民间故事》何以构筑东蒙各民族共有、共享、共建的精神家园进行剖析，从非物质文化遗产保护与传承视角，将如何发挥《喀左·东蒙民间故事》在各民族精神家园建设中的作用进行探讨，是民间故事构筑共有精神家园的重要补充。

一、东蒙民间故事的核心价值

自明末清初始，随着多民族在东蒙地区逐步融合、共同生活，各民族文化相互渗透、融合，共同创造了东蒙民间故事。可以说，东蒙民间故事是东蒙各民族文化的“集合”。因此经过游牧文明与农耕文明互动、碰撞和重组的过程，东蒙各民族在特定的客观自然环境和社会历史条件中，文化习俗相互影响和经济社会相互依存的史实，造就了东蒙民间故事特有的内容和风格，从而在各民族先民的反复讲述中丰富、发展东蒙民间故事的同时，孕育出了东蒙地区强大的文化内聚力和民族凝聚力。

东蒙民间故事中各民族文化存在着一定的内在联系性，并表现出相互影响、相互借鉴的特点，形成了具有鲜明地域性的文化遗产，承载着人们对于族群、民族认同的集体记忆。而《喀左·东蒙民间故事》作为东蒙民间故事重要的保护成果，是东蒙多民族共享的民族文化，更是共同的精神财富。从《喀左·东蒙民间故事》（1-12卷）的整理出版到《喀左·东蒙民间故事》（13-24卷）的补充完善，在趋渐完整的故事

²李瑞芬：《喀左县蒙古族民间文学的搜集与刊布》，《黑龙江民族丛刊》2010年第3期。

³靳宏琴，王墨清：《追寻民族心灵史的文化轨迹——以“东蒙民间故事”为例》，《民间文化论坛》2011年第3期。

⁴隋丽：《喀左东蒙民间故事叙事模式与审美意象研究》，《辽宁大学学报》（哲学社会科学版）2021年第6期。

⁵刘思诚：《从“三套集成”到“非遗保护”的民间故事搜集整理——以喀左东蒙民间故事为例》，《辽宁师范大学学报》（社会科学版）2020年第5期。

⁶刘思诚：《非物质文化遗产与区域文化软实力建设——以国家非遗“喀左东蒙民间故事”为例》，《辽宁师范大学学报》（社会科学版）2019年第1期；刘思诚：《非物质文化遗产：一宗重大的文化旅游资源》，《财经问题研究》2019年第6期。



THE CULTURAL WAY

文本中，以鲜活生动的生活样态描写了东蒙各民族交往交流交融的情感关联，书写出各民族先民对其生存环境和生活文化的认识与认同，使东蒙各民族能够在《喀左·东蒙民间故事》带来的文学创造中凝聚共识，又以其产生认同感和归属感。

《喀左·东蒙民间故事》作为第一批国家级非物质文化遗产，在东蒙各民族漫长的交往交流交融中所展现的移民定居、随旗通婚、榜青苗地等族际间互借、互鉴、互补的社会生活图景，是游牧到农耕的自然融合中形成的生存智慧和经验总结，亦是蒙、汉、满各民族合力创造的精神传统和文化记忆。从这个意义上来讲，《喀左·东蒙民间故事》所具有的“民族共有性”“文化多样性”特点，在漫长的政治、经济和文化的发展进程中，反映了东蒙各民族“共休戚、共存亡、共荣辱、共命运”的民族精神意识，逐渐汇聚成构筑东蒙多民族共有家园的精神力量。正如赫斯科维茨所言：“民间故事本质上比一个民族的书面表达要更丰富，更确切地说，如果他们的人种志被学者们系统化了，那么，即可窥视他们生活方式的途径。”⁷《喀左·东蒙民间故事》中多民族共同生活的“活态”展现，承载着长期积淀下来的生活文化和生存经验，也蕴涵着东蒙各民族的道德标准和价值观念。因此，作为东蒙多民族历史记忆的载体，《喀左·东蒙民间故事》对于培育东蒙多民族文化精神方面同样发挥着重要作用。

二、东蒙民间故事构筑东蒙各民族精神家园的基础条件

民间故事独特的功能和价值，能够满足无数民众的精神和情感需要，正如刘守华先生所言：“民间故事和我们的生活有着很大的关系，就像是一种滋养着人们精神生活的植被”，⁸《喀左·东蒙民间故事》亦是如此。在东蒙各民族生存、生活、文化的文本表达中，所反映的族际共生、交流共享、情感共通等时代所具有的特质，是伴随着东蒙各民族文化的频繁交流、深度融合而体现的共有精神家园。

（一）族际共生的历史条件

清初以来，络绎不绝的移民带来了不同的民族文化，逐渐在东蒙地区形成了以蒙古族文化为基础的东蒙民间故事。就现存的《喀左·东蒙民间故事》来看，其形成是

⁷（美）阿兰·邓迪斯编：《世界民俗学》，陈建宪，彭海斌译，上海：上海文艺出版社，1990年，第398页。

⁸邓立峰：《守护好民间故事这块精神植被——访民间艺术家、民间故事研究专家刘守华》，《中国文艺评论》2022年第12期，第115页。



THE CULTURAL WAY

在东蒙各民族“流动——迁徙——融合”的发展模式中多民族文化交流交融的历史见证。

随着大规模的移民，东蒙地区人口结构不断变化的同时，不同族际群体在文化上的相互影响、渗透以及吸收，对《喀左·东蒙民间故事》的形成均产生了重要影响。一方面，《喀左·东蒙民间故事》受到游牧文化和农耕文化的影响，造就了兼备“游牧——农耕”复合型文化特点。换言之，在游牧文化和农耕文化逐渐聚合、交融的过程中，东蒙多民族实现了从族群自居到共同聚居的同时，塑造了东蒙地区文化共生格局。“东蒙文化，在二百年便完成了游牧文化和农耕文化的转换和转换中的相融，是有着深远的历史之因的”。⁹对此，“俺答汗接纳进入漠南谋生的汉人逃兵、难民，给予他们牛羊、耕具、农地，在土默特地区开发农区鼓励垦殖”，¹⁰这段历史也证实了东蒙多民族历史生活中农牧兼容发展的史实。因此，在《三官庙》《马兰道》¹¹中，开垦农田、定居放牧和分养分放等游牧文化与农耕文化交织交融的民间故事情节，均展现出东蒙各民族在游牧和农耕文化的互动中逐渐凝聚、共同发展的痕迹。

另一方面，《喀左·东蒙民间故事》的形成又受到多民族关系的影响。《新媳妇儿戏瞎子》中提到蒙古扎鲁芒萨的“新媳妇儿是个汉族呼恨”；《谁说不可能》中又提到达古拉的媳妇儿“是汉人……和邻营子杨明、李昌都是好友，这两人也是汉人”等故事细节中不仅强调了蒙汉两族和谐共居的生活图景；而且在《陪嫁牡丹》中，“康熙皇帝玄烨将其爱女爱新觉罗氏郡主，下嫁给功臣万丹伟征札萨克之子额琳臣”为妻，¹²虽为满蒙两族间的政治联姻活动，但通过长期的通婚结缔建立起满蒙友好相处的民族关系，极大地促进了多民族文化的融合与发展。

在三百年来不断的交流融合过程中，各民族面对东蒙这片陌生的地域，无论在农牧并存的经济社会生活，还是在多民族通婚往来的历史细节中，不断拉近不同民族之

⁹ 《喀左·东蒙民间故事》编委会编：《喀左·东蒙民间故事》（综合卷一），沈阳：辽宁民族出版社，2008年，第6页。

¹⁰ 王明珂：《游牧者的抉择：面对汉帝国的北亚游牧部族》，桂林：广西师范大学出版社，2008年，第288页。

¹¹ 《喀左·东蒙民间故事》编委会编：《喀左·东蒙民间故事》（综合卷一），沈阳：辽宁民族出版社，2008年，166-188页。

¹² 《喀左·东蒙民间故事》编委会编：《喀左·东蒙民间故事》（蒙古族故事家索都卷），沈阳：辽宁民族出版社，2008年，第99-132页。



间的心理距离。由此，不论《照明树》¹³中农牧并存的经济发展模式，还是《月中高娃》¹⁴中不同族群的同源共生关系，东蒙民间故事中凝聚着多民族共同发展、友好相处的历史记忆，成为了构筑东蒙各民族精神家园的重要条件。

（二）交流共享的人文条件

马林诺夫斯基提出：“文本是非常重要的。但是，它保留下来的是一种缺乏环境的非生活的东西。……我们还必须记住个体所处的社会环境、娱乐传奇的社会功能和文化作用，所有这些因素是相当明显的。”¹⁵面对险恶的生存环境，东蒙各民族借用人物、动物的特点，以各种讽喻或明显教训意义的人物故事、动物故事，来体现当时的文化信息和生活内容，并传递自己对未来美好生活的憧憬，成为了东蒙民间故事独特的文化魅力。如《巴拉根仓的故事》中，面对恶劣的自然条件和贪婪的统治者，巴拉根仓斗智斗勇的故事情节，蕴含着丰富的生活经验和劳动技能的同时，充分体现出先民对于东蒙生存环境的隐喻表达。

东蒙民间故事的呈现、演绎，也是由多民族共同生活的社会环境造成的。传承人额尔敦朝克图既擅长蒙文、满文，又读懂藏文、汉文的能力，¹⁶以及传承人都达古勒和宝音老夫妇用蒙汉双语讲述东蒙民间故事¹⁷所呈现出的语言多样性特点，既是东蒙多民族文化互鉴互学、互渗互融的重要体现，也是多民族在东蒙这片土地上交流交往、共生共存的历史痕迹。东蒙民间故事本身就是东蒙各民族交往、交流、交融和多民族文化碰撞、交融、整合的三百年历史实践中孕育而成的。在《画上的蜗牛和刀螂》¹⁸《张大胆比武定居》¹⁹《蒙古人敬关公》²⁰《百日还乡》²¹等民间故事的反复讲述中，

¹³ 《喀左·东蒙民间故事》编委会编：《喀左·东蒙民间故事》（蒙古族故事家宝颜巴图卷），沈阳：辽宁民族出版社，2008年，第99-102页。

¹⁴ 《喀左·东蒙民间故事》编委会编：《喀左·东蒙民间故事》（蒙古族故事家额尔敦朝克图卷：上卷），沈阳：辽宁民族出版社，2008年，第3-9页。

¹⁵ （美）阿兰·邓迪斯编：《世界民俗学》，陈建宪，彭海斌译，上海：上海文艺出版社，1990年，第395-396页。

¹⁶ 《喀左·东蒙民间故事》编委会编：《喀左·东蒙民间故事》（蒙古族故事家额尔敦朝克图卷：上卷），沈阳：辽宁民族出版社，2008年，第2-5页。

¹⁷ 《喀左·东蒙民间故事》编委会编：《喀左·东蒙民间故事》（蒙古族故事家都达古勒、宝音卷），沈阳：辽宁民族出版社，2008年，第1-20页。

¹⁸ 《喀左·东蒙民间故事》编委会编：《喀左·东蒙民间故事》（蒙古族故事家金荣卷：下卷），沈阳：辽宁民族出版社，2008年，第62-66页。

¹⁹ 《喀左·东蒙民间故事》编委会编：《喀左·东蒙民间故事》（综合卷一），沈阳：辽宁民族出版社，2008年，第39-45页。



THE CULTURAL WAY

展现了各民族在原有文化基础上的丰富和发展，使世居东蒙的各民族不仅通过学习彼此丰富的生活与生产技能，形成了农牧交错的复合生态环境，而且在深度交流彼此优秀的文化传统的过程中，创造了如今底蕴丰厚的非物质文化遗产。同时，在民族多元文化中所蕴含的“人创造文化，文化培育人”作用，也不断培养、涵育东蒙多民族的传统文化自信，使民族文化从地域差异走向文化共相。

此外，在国家“双语教育”方针下，已出版的《喀左·东蒙民间故事》（1-24卷）蒙汉双语卷中，蒙汉两族文化的共生关系，体现出民族地区推广普及国家通用语言文字的重要决策部署；蒙汉两族文字的相异形态，又体现出尊重和保障少数民族语言文字学习和使用，成为了民族地区推广通用语言文字的范例。这一举措，不仅有助于营造良好的语言环境，增进各民族交往交流交融，更有助于东蒙多民族文化在时代的发展中与时俱进，助力各民族走向现代化。

（三）情感共通的精神条件

钟敬文先生指出：“无论怎样，民间文艺的制作，仍然可说是集团的。”²²可以说，东蒙多民族是《喀左·东蒙民间故事》的创作者，亦是传承者，而《喀左·东蒙民间故事》是东蒙多民族表达情感、寄托愿景的一种方式。

这样的前提下，《喀左·东蒙民间故事》中友好密切的情感关系体现了多民族对于美好精神生活的需求。马林诺夫斯基曾指出：“一物品之成为文化的一部分，只是在人类活动用得着它的地方，只是在它能满足人类需要的地方。……所有的意义都是依它在人类活动的体系中所处的地位，它所关联的思想，及所有的价值而定。”²³正如《王子山》²⁴中提到，“蒙汉同胞常常遭洪灾”时，有一位关里迁来的汉族扎鲁王子不仅“教人们开荒种地，还领人们栽树造林”，而且“带领蒙汉同胞不分日夜地凿

²⁰ 《喀左·东蒙民间故事》编委会编：《喀左·东蒙民间故事》（蒙古族故事家额尔敦朝克图卷：上卷），沈阳：辽宁民族出版社，2008年，第113-119页。

²¹ 《喀左·东蒙民间故事》编委会编：《喀左·东蒙民间故事》（蒙古族故事家宝颜巴图卷），沈阳：辽宁民族出版社，2008年，第107-112页。

²² 钟敬文：《钟敬文民间文学论集》（下），上海：上海文艺出版社，1985年，第17页。

²³ （英）马林诺夫斯基（Bronislaw Malinowski）著：《文化论》，费孝通译，北京：华夏出版社，2002年，第17页。

²⁴ 《喀左·东蒙民间故事》编委会编：《喀左·东蒙民间故事》（综合卷二），沈阳：辽宁民族出版社，2008年，108-109页。



THE CULTURAL WAY

山开渠”的故事情节，既展现了多民族协力农垦的共同生活，也表达了各民族和睦相处的共同期许。

事实上，东蒙民间故事“本身就是不同的民族文化和谐的结晶”，²⁵更是一个精神情感寄托的“家园”。《老呃门其阿布桑》²⁶中提到，老阿布桑爷俩途径爆发瘟疫的汉族营子，“一家一家，一人一人地帮助老道人治病”后，根据老阿布桑山歌中的深意，汉族“营子里的人们采树籽，挖树苗……种树栽树，挖泉找水”的故事描述中，无不体现出蒙汉两族的密切交往中双向性的情感交流。老阿布桑为洪知县夫人治病后，洪知县根据老阿布桑的愿望，在“臭洼沟栽上十颗杏树，十颗油松，拿出些银子买树籽，救灾民”为回报的蒙汉两族互惠互助的故事中，极大满足了先民内心对于精神归属的需要。在《母亲树》²⁷中，有一棵“被人们称为神树”的大柏树因长期惠及民众，“有人叫她干娘，有人叫她干阿嬷，有人叫她‘阿嬷树’，有人叫她母亲书”来表达内心对东蒙地域独特的情感，并赋予其神圣价值，同样是人们在恶劣的生存环境中对美好生活的追寻。概言之，“没有真挚的情感作为动力，一个社会系统或许能够自主运行，但此时置身其中的人，不过是系统的零件”，²⁸而东蒙民间故事中多民族之间互惠互助的行为，正是以情感为基石，建立稳固民族关系、培育共同情感的关键所在。

东蒙民间故事本就是各民族人民“对生活意义、生存价值和生命归宿的一种精神和文化认同”。²⁹因此在多民族文化“交集”的环境中，“民间故事恰恰默默地成为其媒介，凝聚了多民族认同的共同的民族精神”，³⁰才得以创造世代传承的宝贵精神财富。在这点上，东蒙民间故事对于凝聚起各民族“同心”思想起到不可低估的作用，也为构筑东蒙多民族共有精神家园提供了强大的情感支撑。

²⁵ 《喀左·东蒙民间故事》编委会编：《喀左·东蒙民间故事》（综合卷一），沈阳：辽宁民族出版社，2008年，第10页。

²⁶ 《喀左·东蒙民间故事》编委会编：《喀左·东蒙民间故事》（蒙古族故事家索都卷），沈阳：辽宁民族出版社，2008年，第99-101页。

²⁷ 《喀左·东蒙民间故事》编委会编：《喀左·东蒙民间故事》（综合卷一），沈阳：辽宁民族出版社，2008年，第191-197页。

²⁸ 成伯清：《从同情到尊敬——中国政治文化与公共情感的变迁》，《探索与争鸣》2011年第9期，第49页。

²⁹ 赵璇：《构建当代中华民族共有精神家园》，广州：世界图书广东出版公司，2014年，第38页。

³⁰ 何茂莉：《多民族融合与文化一体化——以西南古驿道区域民间故事为中心》，《中国边疆史地研究》2019年第4期，第184页。



三、东蒙民间故事构筑东蒙各民族精神家园的实践路径

《喀左·东蒙民间故事》作为东蒙各民族生活文化的一部分，大量关于族际共生、交流共享、情感共通的故事文本，都是在恶劣的生存环境中东蒙各民族寄托情感的重要渠道，更是东蒙各民族心中精神家园的具体体现。因此，在数字化信息“包围”的这个时代，《喀左·东蒙民间故事》作为口述文学，将《喀左·东蒙民间故事》的保护、传承与“推动中华优秀传统文化创造性转化、创新性发展”的重大文化方针相结合，摆脱其“易消失、难传承”的困境，需要从非物质文化遗产保护与传承视角提出整体性保护、传承性发展以及创造新转化的发展方向，是切实推进各民族精神家园建设的关键所在。

（一）整体性保护：建设文化空间的“非遗”保护实践

近年来，整体性保护作为我国非物质文化遗产保护的基本原则之一，我国一些文化空间创建的成功案例，对非物质文化遗产的保护与传承也起到了重要的推动作用。因此，面对《喀左·东蒙民间故事》的保护与传承举步维艰的困境，以建设非物质文化遗产保护的文化空间，推动文化生态高质量保护成为了延续非物质文化遗产生命力的重要举措。

基于国际社会文化多样性要求和我国非物质文化遗产保护工作的时代要求，建设文化生态保护区是实现人文生态与自然生态平衡发展，体现人与自然和谐共处的重要举措，更是推动《喀左·东蒙民间故事》高效保护的重要路径。2010年，辽宁省喀左县文化馆副馆长李瑞芬³¹提出建设白音爱里非物质文化遗产生态保护区，以文化产业的力量建设区域软实力。这一想法的提出，对白音爱里村重点保护《喀左·东蒙民间故事》的同时，推动文化事业可持续发展，促进生态文明与社会和谐发展至关重要。

然而，乡村振兴战略的实施无疑对《喀左·东蒙民间故事》的保护与挖掘提出了更高的要求。乡村振兴与非物质文化遗产保护工作的目的，在参与主体、成效等维度上具有高度的一致性的特点，将《喀左·东蒙民间故事》的保护与乡村振兴相结合的目标推向了前所未有的高度，从而实现《喀左·东蒙民间故事》的高效保护之际推动乡村跨越式高质量发展，既能繁荣乡村文化、助力乡村振兴，更能延续《喀左·东蒙民间故事》的生命力。因此，随着人们对精神文化生活的重视，基于“真实性”“整



体性”“传承性”原则，将《喀左·东蒙民间故事》的保护重任与民众获得感、幸福感和安全感联系起来，从民众的生活层面提出《喀左·东蒙民间故事》地域特色性的空间场所建设，打造文化内涵丰富的精神生活环境来浸润每个人的心灵与情感，才能真正满足人们对美好生活的向往与期盼。

（二）传承性发展：激活多元主体的“非遗”传承实践

《喀左·东蒙民间故事》作为“一种依赖于人的抽象的精神存在”³²，是与其活态承载和动态表现的传承人紧密联结在一起的。目前，随着“人亡艺绝”的传承险境，《喀左·东蒙民间故事》的传承谱系已难以续写。而传承人作为非物质文化遗产的传承主体和重要载体，《喀左·东蒙民间故事》的传承、延续需要每一位“传承人”在世代相传中强化民族文化认同的同时，扩展其传承主体的范围来不断确保《喀左·东蒙民间故事》的生命力得以继承发扬，从而助力《喀左·东蒙民间故事》时代化、大众化的新发展。

当前“活化民间文学类非物质文化遗产传承，以人为中心成为其基本遵循”，³³《喀左·东蒙民间故事》亦是如此。面对当前“讲述”日益缺失的现象，传承《喀左·东蒙民间故事》的文化内涵，延续其民族精神的重任，已成为每一个“传承人”突破地域、民族、文化的边界，研究外来文化并参照其优点进而反省和发展《喀左·东蒙民间故事》的直接需要。

因此，传承人作为文化传承活动中最重要、最活跃的部分，激发民众的主动参与文化与经济的深度融合，鼓励人人成为“传承人”，为《喀左·东蒙民间故事》的传承性发展提供了重要的“生存场”。2019年，刘思诚³⁴提出围绕展馆、节日、景点、传承人和产品推进东蒙民间故事的文旅融合发展对策。基于此，将“民族文学作为一

³¹ 李瑞芬：《喀左县蒙古族民间文学的搜集与刊布》，《黑龙江民族丛刊》2010年第3期，第171页。

³² 宋俊华：《非遗代表性传承群体认定何以可为》，《文化遗产》2022年第4期，第3页。

³³ 林继富：《民间文学类非物质文化遗产活化传承的基本遵循》，《中南民族大学学报》（人文社会科学版）2020年第4期，第61页。

³⁴ 刘思诚：《非物质文化遗产：一宗重大的文化旅游资源》，《财经问题研究》2019年第6期，第144-145页。



种资源与旅游紧密结合”，³⁵根据当地居民、旅游者和传承人等利益相关者主体对于非物质文化遗产旅游发展所作出的情感响应，鼓励民众亲身参与“农文旅”的深度融合发展，来产业兴旺、增收致富，不仅能够增强民众对《喀左·东蒙民间故事》的自豪感和认同感，更有助于激发各利益相关主体加入传承队伍的自觉性和自主性，使《喀左·东蒙民间故事》在更加广阔的领域得到传承和发展，长久、有效实践东蒙各民族精神家园建设。

另外，根据中共中央办公厅，国务院办公厅印发的《关于进一步加强非物质文化遗产保护工作的意见》，将《喀左·东蒙民间故事》的文化内容融入国民教育体系的同时，将东蒙各民族优秀传统文化融入各学段各学科的教材，充分利用游牧农耕文明互动的历史渊源和文化资源，来拓展非物质文化遗产研修、研习、研学项目以及学科建设，多措并举让民族文化认同扎根于青少年心中，能够以教学模式凸显《喀左·东蒙民间故事》的价值内涵，增强青少年对民族文化认同。例如石林彝族自治县省级非物质文化遗产传承基地——维则青联希望小学开设非物质文化遗产课程，大力宣传彝族撒尼文化的举措，为世代延续民族文化培养出一代又一代的传承力量。

（三）创造性转化：发展数字技术的“非遗”创新实践

目前，由于“民间文学类非遗，无论申报还是保护，文学性文本的呈现成为主体”，³⁶极大缺乏能够捕捉传承人当下的细微神情、举止以及讲述现场氛围的能力是口述文学《喀左·东蒙民间故事》仅存在于书面文本，而无法视觉呈现其“民俗场”的主要困境。

自2008年《喀左·东蒙民间故事》（1-12卷）的整理、出版，《喀左·东蒙民间故事》已然实现了从口述文本向书面文本的转化。但是，面对录音资料逐渐消磁和失真的现象，创造性转化作为口述文学生存与发展的不竭动力，现代技术内嵌于《喀左·东蒙民间故事》不仅是顺应时代的发展，更是《喀左·东蒙民间故事》创新发展的需要。对于《喀左·东蒙民间故事》来讲，通过数字技术储存管理和传播展示的优势，建立数字化科学保护与管理数据库，延伸传统记录工作的同时创新建档技术，确

³⁵ 宋俊华：《中国非物质文化遗产保护发展报告》，北京：社会科学文献出版社，2020年，第40页。

³⁶ 毛巧晖：《记录与保管：民间文学类非物质文化遗产保护探赜》，《中央民族大学学报》（哲学社会科学版）2022年第3期，第85页。



THE CULTURAL WAY

保《喀左·东蒙民间故事》的存续状态，是延续东蒙民间故事生命力的重要手段。因此，针对《喀左·东蒙民间故事》单一的记录、保管，创建一个影音图文结合的数据库，进行全方位、立体化的储存管理，从而实现“保护中传承，传承中创新，创新中发展”是当前非物质文化遗产数字化保护的新趋势新要求。

如今，“新兴的现代技术正在构成古老的口头传统在当代社会运行和发展的有机组成部分”，³⁷从而带给民众鲜活生动、直抵民心的文化体验。究其根源，仿真技术等智能化数字技术不仅能够体现出《喀左·东蒙民间故事》的时代印记与现代创新，而且能够以数字虚拟仿真呈现《喀左·东蒙民间故事》的讲述情景，更加形象化、细节化、视觉化地展示非物质文化遗产的深层文化内涵，满足人们真切重现人物、故事和情节的需要。更为重要的是，在口传文学“往日讲故事的家庭场景和乡村场景已经难觅踪迹”³⁸的现实困境中，以“智能与仿真技术的运用及声音、语言和图像技术的融合”³⁹的创新实践，最大程度上“恢复”甚至“再生”讲述“新”民俗场，能够还原讲述民俗场的沉浸感和现实感，再现《喀左·东蒙民间故事》的时代内涵和精神价值，使非物质文化遗产“远距离存在”成为现实。

可以发现，在人工智能快速发展时代，对于《喀左·东蒙民间故事》的保护、传承和创新，不仅仅是实现东蒙各民族文化及其意义的现实转换，更是以现代化手段实现美好精神生活、构筑共有精神家园的时代需要。

结语

总之，《喀左·东蒙民间故事》作为东蒙多民族对于日常生活的直观反映，是一种社会文化现象，更是东蒙多民族共同创作、享用的精神产品。而“民族精神家园的载体是民族文化”，⁴⁰意味着《喀左·东蒙民间故事》作为东蒙地区蒙、汉、满各民

³⁷ 张建军：《记录口头传统：从书面文本到数字技术》，《民族文学研究》2020年第1期，第116页。

³⁸ 林继富：《民间叙事与非物质文化遗产》，北京：中国社会科学出版社，2012年，第348页。

³⁹ 牛金梁：《非物质文化遗产智能化传播的数字技术赋权逻辑》，《湖南师范大学社会科学学报》2020年第5期，第150页。

⁴⁰ 王健，金炳镐：《“一体两翼”建设中华各民族共有精神家园》，《贵州民族研究》2020年第2期，第3页。



THE CULTURAL WAY

族文化聚合、交融的重要内容，在“精神与文化的关系往往难以分割”⁴¹的重要组成部分中，已然成为了东蒙多民族精神家园的重要载体。正如《喀左·东蒙民间故事》总序中，靳宏琴指出：“文化，特别是非物质文化遗产所承载的文化，是创造人类共有精神家园的奠基者、开路人、设计师、建筑工……则是人类的时代共识。”⁴²

《喀左·东蒙民间故事》在各民族口耳传授与继承中从族际共生、交流共享、情感共通方面记录着民族历史、民间文学的同时，展现着各民族对于美好精神生活的共同追求。因此，根据《喀左·东蒙民间故事》与东蒙各民族精神家园的共生共契、同心同向的内在逻辑，《喀左·东蒙民间故事》的整体性保护、传承性发展和创造性转化的实践路径，不仅能够展现出《喀左·东蒙民间故事》深厚的文化内涵，传承、延续各民族文化，而且能够推进东蒙各民族赖以生存与发展的精神家园建设，从而为东蒙各民族共同进步、共同发展提供助益。

ABSTRACT

“Hazuo·Eastern Mongolian Folk Stories” not only records national history and folk literature from the aspects of inter-ethnic symbiosis, exchange and sharing, and common emotions in the oral transmission and inheritance of various ethnic groups, but also demonstrates the common pursuit of a beautiful spiritual life by all ethnic groups. Therefore, according to the internal logic of symbiosis, coexistence and co-direction between “Hazuo·Eastern Mongolian Folktales” and the spiritual homeland of various ethnic groups in East Mongolia, the overall protection, inheritance development and creativity of “Hazuo·Eastern Mongolian Folktales” The practical path of transformation can not only show the profound cultural connotation of “Hazuo·Eastern Mongolian Folk Stories”, inherit and continue the culture of various ethnic groups, but also promote the construction of spiritual homes for the survival and development of all ethnic groups in Eastern Mongolia, thus providing a good foundation for Eastern Mongolian people. Provide assistance for the common progress and common development of all ethnic groups in Mongolia.

Keywords: *Eastern Mongolian folk tales; shared spiritual home; protection of intangible cultural heritage; path*

⁴¹ 张同基，包哲兴：《精神生活：一个属人的世界——有关精神生活中若干问题的研究札记》，《宁夏社会科学》1996年第6期，第85页。

⁴² 《喀左·东蒙民间故事》编委会编：《喀左·东蒙民间故事》（综合卷一），沈阳：辽宁民族出版社，2008年，第22页。



THE CULTURAL WAY

НОМ ЗҮЙ

1. 李瑞芬：《喀左县蒙古族民间文学的搜集与刊布》，《黑龙江民族丛刊》2010年
2. 靳宏琴，王墨清：《追寻民族心灵史的文化轨迹——以“东蒙民间故事”为例》，《民间文化论坛》2011年
3. 隋丽：《喀左东蒙民间故事叙事模式与审美意象研究》，《辽宁大学学报》（哲学社会科学版）2021年
4. 刘思诚：《从“三套集成”到“非遗保护”的民间故事搜集整理——以喀左东蒙民间故事为例》，《辽宁师范大学学报》（社会科学版）2020年
5. 刘思诚：《非物质文化遗产与区域文化软实力建设——以国家非遗“喀左东蒙民间故事”为例》，《辽宁师范大学学报》（社会科学版）2019年第1期；刘思诚：《非物质文化遗产：一宗重大的文化旅游资源》，《财经问题研究》2019年
6. （美）阿兰·邓迪斯编：《世界民俗学》，陈建宪，彭海斌译，上海：上海文艺出版社，1990年，第398页。
7. 邓立峰：《守护好民间故事这块精神植被——访民间艺术家、民间故事研究专家刘守华》，《中国文艺评论》2022年
8. 《喀左·东蒙民间故事》编委会编：《喀左·东蒙民间故事》（综合卷一），沈阳：辽宁民族出版社，2008年
9. 王明珂：《游牧者的抉择：面对汉帝国的北亚游牧部族》，桂林：广西师范大学出版社，2008年
10. 《喀左·东蒙民间故事》编委会编：《喀左·东蒙民间故事》（蒙古族故事家索都卷），沈阳：辽宁民族出版社，2008年
11. 钟敬文：《钟敬文民间文学论集》（下），上海：上海文艺出版社，1985年
12. （英）马林诺夫斯基（Bronislaw Malinowski）著：《文化论》，费孝通译，北京：华夏出版社，2002年
13. 成伯清：《从同情到尊敬——中国政治文化与公共情感的变迁》，《探索与争鸣》2011年
14. 赵璇：《构建当代中华民族共有精神家园》，广州：世界图书广东出版公司，2014年
15. 何茂莉：《多民族融合与文化一体化——以西南古驿道区域民间故事为中心》，《中国边疆史地研究》2019年
16. 宋俊华：《非遗代表性传承群体认定何以可为》，《文化遗产》2022年第4期，第3页。
17. 林继富：《民间文学类非物质文化遗产活化传承的基本遵循》，《中南民族大学学报》（人文社会科学版）2020年
18. 宋俊华：《中国非物质文化遗产保护发展报告》，北京：社会科学文献出版社，2020年
19. 毛巧晖：《记录与保管：民间文学类非物质文化遗产保护探赜》，《中央民族大学学报》（哲学社会科学版）2022年
20. 张建军：《记录口头传统：从书面文本到数字技术》，《民族文学研究》2020年
21. 牛金梁：《非物质文化遗产智能化传播的数字技术赋权逻辑》，《湖南师范大学社会科学学报》2020年
22. 王健，金炳镐：《“一体两翼”建设中华各民族共有精神家园》，《贵州民族研究》2020年
23. 张同基，包哲兴：《精神生活：一个属人的世界——有关精神生活中若干问题的研究札记》，《宁夏社会科学》1996年

ДАРЬГАНГА УУЛЫН ХОШУУНЫ НИЙГМИЙН ЗАРИМ АСУУДЛЫГ
ТОДРУУЛАХ НЬ

Э.Итгэл*

ХУРААНГУЙ

Дарьганга уулын хошуу хэмээн нэрлэгдсэн түүхэн зурвас цаг үе бол Дарьгангачуудын хуучин нийгмээс шинэ нийгэмд шилжин орсон шилжилтийн үе байсан юм. Энэхүү шилжилтийн үеийн нийгмийн зарим асуудлыг тодруулахад Дарьганга уулын хошууны хүн ам зүйтэй холбогдох баримтууд дахь хүн амын ажил эрхлэлт, бичиг үсэг тайлагдалт, төрөлт, нас баралт, өнчин, ганц бие, бэлэвсэн, өвчин эмгэг, гэмт хэргийн байдал зэргийг тусгайлан анхаарах нь чухал юм. XX зууны эхэн үеийн Монголын нийгэм-эдийн засгийн талаарх судалгаа шинжилгээ, түүний дотор хүн ам зүйн судалгаа эдүгээ хүртэл бүрэн боловсруулагдаагүй байна. Тухайлбал, Ардын хувьсгал ялсны дараахан байгуулагдсан аймаг, хошуудын хүн ам зүйн асуудлыг тал бүрээс нь судалж, түүхийн бүрхэг, зангилаа олон асуудлуудыг нарийвчлан судлах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. 1922 оноос Ардын Засгийн Газраас хувьсгалт нийгмийн зорилтыг хэрэгжүүлж, засаг захиргааны шинэ өөрчлөлтүүдийг хийж эхэлжээ. Энэ хүрээнд 1923-1924 онд хуучны зарим онцлог бүхий орон нутгийн байгууллагууд, шавийн тухай тусгайлсан дүрмүүдийг батлан гаргажээ. Үүний гол зорилго нь эдгээр онцлог бүхий газруудад бусад хошуу нутгийн нэгэн адил ардчилсан засаг захиргааг байгуулахад оршиж байв.

Түлхүүр үгс: *Дарьганга уулын хошуу, түүхэн хүн ам зүй, нийгмийн байдал*

Дарьгангын өөрчлөлт шинэчлэлтийг түргэтгэх зорилгоор Засгийн газраас Дотоод явдлын яаманд нутгийн захиргааны дүрэм боловсруулахыг үүрэг болгосон. Төд удалгүй нутгийн захиргааны дүрэм боловсруулагдаж Засгийн газрын 1924 оны 9 сарын 20-ны өдрийн 38 дугаар хурлаар хэлэлцүүлж дэмжигдсэн байна. Ингээд 1924 оны 10 сарын 27-ны өдөр “*Дарьгангын нутгийн захиргааны дүрэм*”¹-ийг 10 бүлэг, 54 зүйлтэйгээр батлагдсан бөгөөд энэ нь Дарьганга уулын хошуу байгуулагдах үндэс суурь нь болсон юм. 1924 оны нутгийн захиргааны дүрмийн үндсэн заалтуудад зохих өөрчлөлтүүдийг хийж 1925 оны 7 сарын 12, 13-ны өдрүүдэд болсон “*Хошууны*

* Өвөр Монголын Их Сургуулийн докторант

¹ МУУТА. Ф-84. Д-1.ХН-4



THE CULTURAL WAY

анхдугаар хурал”² -ын тогтоолоор Дарьганга сүрэгчин тусгай захиргаа халагдан бусад хошуудын нэгэн адил Дарьганга уулын хошуу байгуулагджээ.

Дарьганга уулын хошуу хэмээн нэрлэгдсэн түүхэн зурвас цаг үе бол Дарьгангачуудын хуучин нийгмээс шинэ нийгэмд шилжин орсон шилжилтийн үе байсан юм. Энэхүү шилжилтийн үеийн нийгмийн зарим асуудлыг тодруулахад Дарьганга уулын хошууны хүн ам зүйтэй холбогдох баримтууд дахь хүн амын ажил эрхлэлт, бичиг үсэг тайлагдалт, төрөлт, нас баралт, өнчин, ганц бие, бэлэвсэн, өвчин эмгэг, гэмт хэргийн байдал зэргийг онцлон судлахыг зорилоо.

Хүн ам зүйн шинжлэх ухаанд хүн амын судалгааны чухал үзүүлэлтүүд болох нийгмийн асуудлуудын талаарх мэдээллийг агуулж буй баримтууд нь Үндэсний Төв Архивын “Орчин үеийн баримтын жагсаалт”-нд хадгалагдан байх Ф-84 буюу Хан хэнтий уулын аймгийн Дарьганга уулын хошууны фондын хадгаламжийн нэгжийн бүртгэл³ юм. Энэхүү фонд нь 2 данстай бөгөөд данс-1 нь 75 хадгаламжийн нэгж, данс-2 нь 29 хадгаламжийн нэгжээс тус тус бүрдэж байна. Тус фондод 1923-1930 он хүртэлх Дарьганга уулын хошуутай холбоотой баримт материалууд агуулагдаж байна. Мөн Ф-1 буюу Сайд нарын зөвлөл⁴-д холбогдох баримтууд, Ф-4 буюу Дотоод явдлын яам⁵-нд холбогдох баримтууд, Ф-11 буюу Улсын Бага Хурлын Тэргүүлэгч⁶-дэд холбогдох баримтуудад Дарьганга уулын хошуутай холбогдол бүхий баримтууд хадгалагдаж байна. Эдгээр нь Дарьганга уулын хошуу хэмээх зохион байгуулалтад орсон байх үеийн мөн тус зохион байгуулалтад орохоос өмнө ба дараа дараагийн хэдэн жилийн үйл явдлуудад холбогдох баримт материалууд агуулснаараа ихээхэн үнэ цэнэтэй юм.

Дээрх баримтууд нь Дарьганга уулын хошууны бүх амын тоог он тус бүрээр нь харах боломжийг бидэнд олгож байна.

Архивын баримтууд дахь хүн амтай холбоотой тэмдэглэлд хар хүмүүс, эмс, жинхэнэ лам нар гэж ялгажээ. Лам нарыг бүртгэхдээ жинхэнэ лам нар хэмээн онцолсон байх бөгөөд тэдний насыг ялган тэмдэглээгүй тойм байдлаар нийт тоог тэмдэглэсэн байна. Эрэгтэй хүмүүсийг бүртгэхдээ хар хүмүүс хэмээн тэмдэглээд, насны байдлаар нь 1-7 нас жоохон хөвгүүд, 8-17 нас хөвгүүд, 18-45 нас идэр эрс, 46-аас дээш нас хөгшин эрс хэмээн тус тус ялган тоог нь гаргажээ. Эмэгтэйчүүдийг насны байдлаар нь 1-7 нас охид, 8-17 нас хүүхэн, 18-аас дээш нас эмс хэмээн тус тус ялган тоог нь тэмдэглэжээ. Мөн хүн амын судалгаанд холбогдох зарим чухал зүйлсийг тодруулахын тулд 1930 оны бүртгэл дансыг ашиглах зайлшгүй шаардлагатай болсон юм. Учир нь 1928, 1929 оны хүн амын нийгмийн асуудалд холбогдох хэрэглэгдэхүүн болох ажил эрхлэлт, өвчин эмгэг, төрөлт зэргийг бүртгэсэн нь яг ижил байсан тул 1930 оны бүртгэл дансыг ашиглах зайлшгүй шаардлагатай болсныг энд онцолмоор байна.

² МУУТА. Ф-1. Д-2. ХН-114

³ МУУТА. Ф-84. Д-1, 2


⁴ МУУТА. Ф-1. Д-1-9

⁵ МУУТА. Ф-4. Д-1, 2

⁶ МУУТА. Ф-11. Д-1, 2



Дарьганга уулын хошууны бүх амын тоо



1925-1926 онд нийт хүн ам 284 ам буюу 2%-аар өссөн, 1926-1927 онд 1086 ам буюу 7.2%-аар өссөн, 1927-1928 онд 518 ам буюу 3.4%-аар буурсан, 1928-1929 онд 951 ам буюу 6.1%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Дарьганга уулын хошуу анх байгуулагдсан 1925 он ба Хан Хэнтий уулын аймагт харьяалагдахаас өмнө буюу 1929 оны тоог харьцуулбал нийт хүн ам 1713 ам буюу 11.1%-аар өссөн үзүүлэлттэй байна.

Дарьганга уулын хошууны нийгмийн зарим асуудлыг тодруулан судлахад архивын баримт материалуудад тэмдэглэгдсэн мэдээ, баримтууд гол эх сурвалж болж байгаа билээ. Хүн амын дэлгэрэнгүй бүртгэл, хошууны элдэв хэрэгтэй холбоотой данснуудад буй мэдээ баримтуудыг ашиглан тухайн үеийн нийгмийн зарим асуудлыг ажиглах боломж бүрдэж байна.

Ажил эрхлэлтийн байдал: Дарьганга уулын хошууны хүн амын ажил эрхлэлтийн байдлыг бид хүн амын бүртгэлтэй холбоотой баримтуудаас түүвэрлэн авлаа. Хүмүүсийн хөдөлмөр эрхлэх байдлыг тэмдэглэхдээ нас, хүйсээр нь ялган тэмдэглэсэн байх бөгөөд эрэгтэйчүүдийн хувьд 8-17, 18-45, 46-аас дээш насны гэж ялган тэмдэглэжээ. Эмэгтэйчүүдийг 8-17, 18-аас дээш насны хэмээн ялган тэмдэглэсэн байна. Лам нарыг ямар нэгэн хөдөлмөр эрхэлдэг гэж тэмдэглээгүй байна.

1929 оны мэдээ 1928 оны мэдээтэй адил байгаа тул давхардуулан оруулсангүй. 1925 оны хүн амын бүртгэлд хүн амын өвчлөлтийн байдлыг бүртгээгүй байна. Үүнээс хойш дурдагдах хүн амын бичиг үсэг тайлагдалтын байдал, өвчин эмгэгийн байдал, төрөлт, нас баралт, ганц бие, бэлэвсний байдлыг энэ жишгээр авч үзсэн болно.



THE CULTURAL WAY

Дарьганга уулын хошууны хүн амын ажил хөдөлмөр эрхлэлтийн байдлыг авч үзэхдээ баримтад тэмдэглэснээр эрэгтэйчүүдийн, эмэгтэйчүүдийн гэж ялган авч үзэх нь чухал юм. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ажлын төрлийг хүн амын тооллогын асуулгын хуудас бидэнд дэлгэрэнгүй өгүүлж байгаа билээ.

Эрэгтэйчүүдийн ажил хөдөлмөр: Мал адгуулах, цэргийн, өртөөний, дархан (алт мөнгөний, модны, төмрийн), бичгийн, оёдлын, тариа тарих, хадлан хадах, жин тээх, бусад ямар нэгэн ажил гэх зэрэг хөдөлмөрийг эрхэлж байжээ.

Эмэгтэйчүүдийн ажил хөдөлмөр: гэрийн ажил, бичгийн ажил, оёдлын ажил зэрэг хөдөлмөрийг тэмдэглэжээ.

Хүснэгт 1. Эрэгтэйчүүдийн ажил эрхлэлтийн байдал

| Эрхлэх ажил | | Нас | 1926 он | 1927 он | 1928 он | 1930 он |
|-------------------------------|-----------------|-----------------|---------|---------|---------|---------|
| Мал адгуулдаг | 8-17 нас | | 244 | 99 | 88 | 1783 |
| | 18-45 нас | | 1181 | 1184 | 1329 | |
| | 46-аас дээш нас | | 879 | 520 | 327 | |
| Бичгийн ажил | 8-17 нас | | | 22 | 12 | 16 |
| | 18-45 нас | | | 87 | 23 | |
| | 46-аас дээш нас | 1 | 31 | | | |
| Дархан | Мөнгө | 8-17 нас | | | | 11 |
| | | 18-45 нас | 3 | 4 | 8 | |
| | | 46-аас дээш нас | 4 | 5 | 7 | |
| | Мод | 8-17 нас | | | | 2 |
| | | 18-45 нас | 3 | | 1 | |
| | | 46-аас дээш нас | 3 | 3 | 2 | |
| | Төмөр | 8-17 нас | | | | |
| | | 18-45 нас | | | | |
| | | 46-аас дээш нас | | | 2 | |
| Оёдлын | 8-17 нас | | | | | |
| | 18-45 нас | | | | | |
| | 46-аас дээш нас | | 1 | 1 | | |
| Агнуур | | | | | | 53 |
| Ямар нэгэн ажилд биеэ хөлслөх | | | | | | 1 |
| Бусад ямар нэгэн ажил | | | | | | 5 |
| Нийт | | | 2318 | 1956 | 1800 | 1871 |

1926 онд Дарьганга уулын хошууны бүх хар хүний тоо 5257 байсны 2318 (44%) нь ямар нэгэн хөдөлмөр эрхэлж байсан байна. 1927 онд 5048 хүнээс 1926 (38.1), 1928 онд 5138 хүнээс 1800 (35%), 1930 онд 5347 хүнээс



THE CULTURAL WAY

1871 (35%) нь ажил хөдөлмөр эрхэлж байсан гэдгээр бүртгэгджээ. 1925 оны хөдөлмөр эрхлэлтийн мэдээ бидэнд хараахан олдсонгүй. 1929 оны хөдөлмөр эрхлэлтийн мэдээ 1928 оныхтой яг адил байгаа учир энд оруулсангүй. 1926-1930 он болоход эрэгтэйчүүдийн ажил эрхлэлт 9%-аар буурсан үзүүлэлттэй байна.

Эрэгтэйчүүдийн олон тоотой эрхэлж буй ажил нь мэдээж мал аж ахуйтай холбоотой мал адгуулах ажил орж байна. Үүний дараагаар бичгийн ажил орж байгааг дээрх хүснэгт илтгэж байна.

Дархны ажил нь дотроо алт мөнгөний, модны, төмрийн гэж ялгагдан тэмдэглэгдэж уг ажлыг цөөн хүн эрхэлж байсан. Мөн дархны ажил хийж байгаа хүмүүсийн насны байдлыг ажиглавал он оны бүртгэлд бүгд ахмад настан буюу 46-аас дээш насны хүмүүс байсан харагдаж байна. Агнуурын ажил нь 1930 оноос өмнөх бүртгэлд бүртгэгдээгүй байна. Эндээс эрчүүд огт ан агнадаггүй байжээ гэж ойлгож болохгүй. Ан агнуурыг тусгай ажилд тооцдоггүй байсан байж болох юм. 1929 оноос агнуурын ажил эрхлэгч бий болсон байх магадлалтай. Учир нь 1929 оны нэгэн бүртгэлд “алсан чонын тоо-309”⁷ гэж тэмдэглэсэн байдаг. Иймээс 1930 оны бүртгэлд хошууны хүмүүсийн ажил хөдөлмөрийн байдалд агнуурын ажил эрхлэгчийг тусгайлан бүртгэсэн байна.

1930 оны тоо бүртгэлд агнуураас гадна нэмж бас нэгэн ажил тэмдэглэгдсэн нь хөлсний хөдөлмөр эрхлэгчдийг бүртгэсэн байна. Энэ нь тухайн үед тус хошуунд олон байгаагүй хошууны хэмжээнд ердөө 1 гэж бүртгэгдсэн байна. Тухайн үед хүн ам олонтой газруудад (Хүрээ, Хиагт) хөлсөөр хөдөлмөрлөх явдал түгээмэл байсан ч Дарьганга уулын хошууны нутагт төдий л дэлгэрээгүй байжээ.

1927, 1928 он тус бүрт 1 хүн оёдлын ажил эрхэлдэг гэж бүртгэгдсэн байна. Мөн хөдөлмөр эрхлэлтийн хамгийн идэвхтэй нас аль ч онд 18-45 нас буюу идэр насныхан эзэлж байна.

Хүснэгт 2. Эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийн байдал

| Эрхлэх ажил | Нас | 1926 он | 1927 он | 1928 он | 1930 он |
|-----------------------|-----------------|---------|---------|---------|---------|
| Гэр малын ажил | 8-17 нас | 498 | 158 | 396 | 2723 |
| | 18 наснаас дээш | 4011 | 2990 | 2480 | |
| Бичгийн ажил | 8-17 нас | | 2 | | 7 |
| | 18 наснаас дээш | | | | |
| Оёдол | | | | | 196 |
| Бусад ямар нэгэн ажил | | | | | 5 |
| Нийт | | 4509 | 3150 | 2876 | 2931 |

⁷ МУУТА. Ф-84. Д-1. ХН-48



THE CULTURAL WAY

1926 оны бүртгэлд 6939 эмэгтэй хүн бүртгэгдсэний 4509 буюу 65% нь гэр малын ажил эрхэлдэг гэж тэмдэглэгдсэн байна. 1927 онд 6924 эмэгтэйн 3148 (45.4%) нь гэр малын ажил, 2 хүн бичгийн ажил, 1928 онд 7046 эмэгтэйн 2876 (40.8%) нь гэр малын ажил, 1930 онд 7582 эмэгтэйн 2723 (36%) нь гэр малын ажил, 7 (0.009%) нь бичгийн ажил, 196 (2.5%) нь оёдлын ажил, 5 (0.06%) нь бусад ямар нэгэн ажил эрхэлдэг гэж тус тус тэмдэглэгдсэн байна. Эмэгтэйчүүдийн ажил эрхлэлт 1926-1928 онд буурсан үзүүлэлттэй байна. Албан ёсны бүртгэлд ямар үзүүлэлтийг харж бүртгэсэн нь сонирхолтой байгаа юм. 1930 оны бүртгэлд оёдлын ажил эрхэлдэг хүмүүсийг тусгайлан бүртгэсэн байна. Эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийн байдал 1926-1930 онд 26.4%-аар буурсан үзүүлэлттэй байна.

Дарьганга уулын хошууны хүн амын хөдөлмөр эрхлэлтэд уламжлалт мал аж ахуйгаа дагасан мал адгуулах, гэр малын ажил зонхилж байжээ. Уг ажлыг нийт эрэгтэйчүүдийн 18-45, эмэгтэйчүүдийн 18-аас дээш насныхан голлон эрхэлж байгаа нь судалгааны явцаас ажиглагдаж байна.

Хадлан хадах, тариа тарих зэрэг ажлууд асуулгын хуудсан дээр байх авч Дарьганга уулын хошуунд эдгээр ажлыг хийдэг нэг ч хүн бүртгэгдээгүй байна. Хадлан хадах бол малтай айл бүрийн хийх ёстой ажил мөн. Өвлийг өнтэй давахын хамгийн гол хүчин зүйл билээ. Тухайн үед тусгайлан хадлангийн ажил эрхэлдэг хүмүүс байгаагүй байна.

Энэ талаар нэгэн баримтад “Хадлан хаддаг өрх байхгүй, тариа тарьдаг өрх байхгүй”⁸ гэж тэмдэглэсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийн нас эрэгтэй, эмэгтэй ялгаагүй 8 наснаас эхэлж байна. 8-17 насны хүүхдүүдийн хувьд ажил эрхлэлт харьцангуй бага байсан байна. Гэсэн хэдий ч Монгол хүүхдүүдийн онцлог бол аж ахуйгаа дагаад бага наснаасаа гэр малын ажилд туслаж, тэндээс амьдралын ухаанд суралцаж байдаг. Энэ бол Монгол малчдын үе удам тасралтгүй үргэлжилсээр байгаагийн илрэл юм.

Бичиг үсэгт тайлагдсан байдал: Тус хошууны хүн амын бичиг үсэг тайлагдалтын байдлыг авч үзэхдээ 1926 он⁹, 1927 он¹⁰, 1928 он¹¹, 1930 он¹²-ы хүн амын бүртгэл дэх тоо баримтуудыг ашиглалаа.

⁸ МУУТА. Ф-84. Д-1. ХН-48

⁹ МУУТА. Ф-84. Д-2. ХН-3

¹⁰ МУУТА. Ф-84. Д-1. ХН-72

¹¹ МУУТА. Ф-84. Д-2. ХН-9

¹² МУУТА. Ф-84. Д-1. ХН-40



THE CULTURAL WAY

Хүснэгт 3. Дарьганга уулын хошууны хүн амын бичиг үсэг мэдэх хүний тоо

| | Нас | Ямар бичиг | 1926 он | 1927 он | 1928 он | 1930 он |
|--------------------------------------|-----------------|------------|---------|---------|---------|---------|
| Хөвгүүд ба хар хүмүүсийн бичиг эрдэм | 8-17 нас | Монгол | 4 | 22 | 39 | 22 |
| | | Төвд | 326 | 488 | 486 | 523 |
| | | Хятад | | | | |
| | 18-45 нас | Монгол | 85 | 92 | 100 | 89 |
| | | Төвд | 308 | | 399 | 11 |
| | | Хятад | | | | |
| | 46-аас дээш нас | Монгол | 34 | 36 | | 29 |
| | | Төвд | 95 | 2 | | 2 |
| | | Хятад | | | | 1 |
| Эмс охидын бичиг эрдэм | 8-17 нас | Монгол | | 2 | 1 | |
| | | Төвд | | | | |
| | | Хятад | | | | |
| | 18-аас дээш нас | Монгол | | | | |
| | | Төвд | | | | |
| | | Хятад | | | | |

Дээрхээс ажиглавал 1926 онд бичиг үсэг мэдэх хүний тоо 852 бөгөөд бүгд эрэгтэй хүн байна. Энэ нь тухайн оны нийт хүн амын 6.1%-ийг эзэлж байна. 1927 онд 640 (4.2%) эр, 2 эм бичиг үсэг мэднэ гэж бүртгэгдсэн нь өмнөх оноосоо 1.9%-аар буурсан байна. 1928 онд 1024 (7.1%) эр, 1 эм бүртгэгдсэн нь өмнөх оноосоо 3%-аар өссөн байна. 1930 онд 677 (4.3%) эр хүн бичиг үсэг мэднэ гэж бүртгэгдсэн байна.

Бичиг үсэг мэдэх хүний тоо нийт хүн амын тооноос хамааралтайгаар өсөж буурч байсан байна. Бичиг үсэг мэдэх хүмүүсийг бүртгэхдээ Монгол, Төвд, Орос, Англи, Хятад, Япон эдгээрээс алийг нь мэдэх эсэхийг сонгох маягаар асуултыг гаргасан байна.

Дарьганга уулын хошууны хүн амын бичиг үсэг тайлагдалтын хувьд 1926 -1928 онд Төвд бичиг мэдэх хүний тоо илт давамгайл байгаа нь дээрх хүснэгтээс харагдаж байна. Насны хувьд авч үзвэл 8-17, 18-45 насны эрэгтэйчүүд бичиг үсэг тайлагдсан байдлаараа дийлэнх хувийг эзэлж байна. Тэр дундаа Төвд бичиг мэдэх хүмүүс зонхилж байна. Судалгааны материалд (1926-1928, 1930 он) тэмдэглэгдсэнээр эмэгтэйчүүд ганц нэг бичиг мэднэ гэж бүртгэгдсэн хэдий ч зарим онд огт бүртгэгдээгүй байна.

Судалгааны явцад ажиглагдсан нэг зүйл нь хүн амын бүртгэл дэх эмэгтэйчүүдтэй холбоотой бүртгэл баримтад төдий л ач холбогдол өгдөггүй байсан нь ажиглагдаж байна. Энэ нь нийгэмд эмэгтэйчүүдийн оролцоо бага байсантай холбоотой юм. 1927 онд “эмэгтэйчүүдийн эрх чөлөөг хөгжүүлэн эрдэм боловсролд дэвшүүлэхийг огтхон ч гүйцэтгэж чадаагүй ба бас эмэгтэйчүүдийг хуучны байдлаар богтлон мал адгуус мэт худалдах явдал үргэлжилсээр болохыг эрхбиш устгаж, эрх чөлөөг бүрэн бүтнээр эдлүүлэн,



THE CULTURAL WAY

эрдэм боловсролтой болгохыг гүйцэтгэ”¹³ хэмээн тамгын газраас бүх сумдын дарга нарт зааварлаж байжээ. Мөн 1929 оны бүртгэлд сонгууль ба тушаалын алба хааж буй эмэгтэйчүүдийн тоо 10 гэж тэмдэглэгдсэн байна. Энэ бол тухайн үеийн эмэгтэйчүүдийн тоотой харьцуулбал бага тоо буюу 0.06%-ийг эзэлж байна.

Дарьганга уулын хошууны хүн амын бүртгэлд Монгол, Төвд, Хятад бичиг үсгийн алийг мэдэхийг асуусан байдаг боловч 1930 онд 1 хүн Хятад бичиг мэднэ гэж бүртгэгдсэн байна. Өмнөх онуудад нэг ч хүн хятад бичиг мэднэ гэж бүртгэгдээгүй байна. Монгол бичиг үсэг мэдэх хүний тоо 1926-1928 онд тогтмол нэмэгдсэн байна. 18-аас дээш насны эрэгтэйчүүд дийлэнх хувийг эзэлж байжээ. Үүнд жинхэнэ лам нарын тоон үзүүлэлт нөлөөлж байсныг үгүйсгэх аргагүй юм.

Төвд бичиг үсэг мэдэх хүний тоо аль ч онд давамгайл байна. Энэ нь тухайн үед Монголд шарын шашны нөлөө хүчтэй байсны нэгэн илрэл юм.

Өвчин эмгэгийн байдал: Хүн амын өвчин эмгэгийн байдлыг бүртгэхдээ эрэгтэй, эмэгтэй, лам нар гэж тус тус ялган тэмдэглэсэн байхаас гадна насны байдлаар нь ангилан бүртгэсэн байна. Өвчин эмгэгийг дотор нь заар, хэлгүй дүлий, сохор гэж тус тусад нь тэмдэглэсэн байна. Бид судалгаандаа заар, хэлгүй дүлий, сохор гэж тэмдэглэгдсэн тоог нэгтгээд өвчин эмгэг гэсэн нийт тоог нь ашиглалаа. Хазгар, дутуу тахир гэж хүн амын бүртгэлд тусгайлан бүртгэснийг тэр хэвээр нь авч үзлээ.

Хүснэгт 4. Эрэгтэйчүүдийн өвчин эмгэгийн байдал

| Өвчний нэр | Нас | 1926 он | 1927 он | 1928 он | 1930 он |
|---|-----------------|---------|---------|---------|---------|
| Өвчин эмгэг (заар, хэлгүй дүлий, сохор) | 1-17 нас | 17 | 9 | 8 | 67 |
| | 18-45 нас | 70 | 53 | 33 | |
| | 46 наснаас дээш | 30 | 19 | 18 | |
| Хазгар, тахир дутуу | 1-17 нас | 7 | 8 | 13 | 49 |
| | 18-45 нас | 35 | 39 | 40 | |
| | 46 наснаас дээш | 14 | 11 | 24 | |

¹³ Э.Лувсанбалдан. Дарьгангын түүх. УБ., 2013. т 203



THE CULTURAL WAY

Хүснэгт 5. Эмэгтэйчүүдийн өвчин эмгэгийн байдал

| Өвчний нэр | Нас | 1926 он | 1927 он | 1928 он | 1930 он |
|---|-----------------|---------|---------|---------|---------|
| Өвчин эмгэг (заар, хэлгүй дүлий, сохор) | 1-17 нас | 7 | 8 | 5 | 45 |
| | 18 наснаас дээш | 46 | 32 | 15 | |
| Хазгар, тахир дутуу | 1-17 нас | 3 | 4 | 5 | 16 |
| | 18 наснаас дээш | 16 | 29 | 26 | |

Хүснэгт 6. Жинхэнэ лам нарын өвчин эмгэгийн байдал

| Өвчин | 1926 он | 1927 он | 1928 он |
|---|---------|---------|---------|
| Өвчин эмгэг (заар, хэлгүй дүлий, сохор) | 14 | 20 | 10 |
| Хазгар, тахир дутуу | 3 | 20 | 14 |

Дээрх хүснэгтүүдээс ажиглавал хүн амын өвчин эмгэгийн байдал жилээс жилд буурах хандлагатай байна. Эрэгтэйчүүдийн (хар, лам) өвчилсөн байдал нь эмэгтэйчүүдээс илүү байна. 1926 оныг 1930 онтой харьцуулбал 1926 онд өвчин эмгэгтэй нийт 262 (Энэ нь тухайн оны нийт хүн амын 1.8%-ийг эзэлж байна) хүн бүртгэгдсэн бол 1930 онд 177 (1.1%) гэж бүртгэгджээ. Эндээс үзвэл хүмүүсийн эрүүл мэндийн байдал мэдэгдэхүйц сайжирсан байна. Өвчлөлт өндөр байгаа нас нь 18-аас дээш насныхан байна. Тэр дундаа эрэгтэйчүүдийн хувьд 18-45 насныхан дийлэнх хувийг эзэлж байгаа нь ажиглагдаж байна.

Төрөлт, нас баралт: Төрөлт, нас баралтын тухай хүн амын бүртгэл дансанд нарийн бүртгэсэн байна. Эр, эм хүний тоо гаргасны дор нэмсэний тоо, хорсоны тоо гэж тэмдэглэсэн нь төрөлт болоод нас баралтыг тодруулахад маш чухал баримт болж байна. Нэмсэн хорсоны тоог гаргахдаа тухайн тооллого явагдахаас 1-3 сарын өмнөх байдлаар тоог нь гаргаж байжээ. Жишээлбэл, 1926 оны 9 сарын 8-ний бүртгэлд нэмсэн хорсоны тоог бүртгэхдээ 16-р он 8 сарын 1 хүртэл байдлаар гэж тэмдэглэсэн байна. 1928 оны 10 сарын 1-ний бүртгэлд 18-р он 6 сар хүртэл гэж тус тус тэмдэглэсэн байна.



THE CULTURAL WAY

Хүснэгт 7. Дарьганга уулын хошууны хүн амын төрөлт, нас баралтын байдал

| | | 1926 он | 1927 он | 1928 он |
|---------|--------|---------|---------|---------|
| Эрэгтэй | Нэмсэн | 85 | 84 | 86 |
| | Хорсон | 199 | 87 | 84 |
| Эмэгтэй | Нэмсэн | 69 | 91 | 64 |
| | Хорсон | 93 | 74 | 71 |

1925 оны бүртгэлд төрөлт, нас баралтын тухай тэмдэглээгүй байна. Дээрх хүснэгтээс ажиглавал төрөлт огцом өөрчлөлтгүйгээр өсөж байсан нь харагдаж байна. Харин нас баралт буурч байгаа нь ажиглагдаж байна. Эдгээр нь хүн амын өсөлтөд нөлөөлөх чухал хүчин зүйлс юм. Нэмсэн, хорсоны тоог төрөлт болоод нас баралтын тоо гэж авч үзсэн нь архивын баримтад хэрхэн тэмдэглэгдсэнийг үндэслэсэн билээ. Тодруулбал, Дарьганга уулын хошууны хүн амын дэлгэрэнгүй бүртгэл данс¹⁴ (1927 он)-ийг ажиглаваас хүн амыг бүртгэхдээ эрэгтэй эмэгтэй тус бүрийн насны ангиллын доор нь нэмсэн, хорсон гэсэн хэсэгт холбогдох сар өдрийг тэмдэглэсэн байдаг. Жишээ нь: нэр, нас, хорсон (он, сар, өдөр), нэмсэн (он, сар, өдөр) гэж тэмдэглэсэн байх бөгөөд шилжсэн, ирсэн, явсан гэсэн тэмдэглэгээ байхгүй байсан тул нэмсэнийг төрсөн, хорсоныг нас баралтын тоо гэж үзсэн юм.

Дээрх хүснэгтэд байх тоо нь тухайн үеийн нийт хүн амын өсөлт, бууралтыг тодорхойлоход боломжгүй мэт харагдаж байгаа ч ерөнхий зүй тогтлыг ажиглаваас 1926-1927 онд нэмсэний тоо огцом өсөж, хорсоны тоо огцом буурсан нь 26-27 онд хошууны нийт хүн 1086 ам буюу 7.2%-аар өссөн үзүүлэлттэй давхцаж байна. 1927-1928 онд нэмсэний тоо буурч, хорсоны тоо өссөн нь 1927-1928 онд хошууны нийт хүн ам 518 ам буюу 3.4%-аар буурсан үзүүлэлттэй тус тус давхцаж байна.

Өнчин, ганц бие, бэлэвсний байдал: Өнчин, ганц бие, бэлэвсний бүртгэлийг 1926 оны 9 сарын 8¹⁵-ны хүн амын дэлгэрэнгүй бүртгэл дансанд буй тоог ашиглав. Энэ нь Дарьганга уулын хошууны хүн амд эзлэх өнчин, ганц бие, бэлэвсэн хүмүүсийн тоо (1925-1929 онд) хичнээн байсныг харуулах чухал үзүүлэлт тул зайлшгүй авсан болно.

Хүснэгт 8. Дарьганга уулын хошууны хүн амын өнчин, ганц бие, бэлэвсний байдал

| | | 1926 он | 1927 он | 1928 он |
|-------------|----------|---------|---------|---------|
| Эрэгтэй | Өнчин | 14 | 21 | 2 |
| | Ганц бие | 23 | | |
| Эмэгтэй | Өнчин | 5 | 6 | 8 |
| | Ганц бие | 17 | | |
| | Бэлэвсэн | 1 | 2 | 2 |
| Жинхэнэ лам | Өнчин | 17 | 18 | 4 |

¹⁴ МУУТА. Ф-84. Д-2. ХН-2

¹⁵ МУУТА. Ф-84. Д-2. ХН-2



THE CULTURAL WAY

1926 онд нийт өнчин хүний тоо 36 ам байсан нь тухайн оны нийт хүн амын 0.2%-ийг эзэлж байна. 1927 онд 45 ам буюу нийт хүн амын 0.3% энэ нь өмнөх оноосоо 0.1%-аар өссөн байна. 1928 онд 14 ам буюу нийт хүн амын 0.09%-ийг эзэлж байна. Ганц бие хүний тоо 1926 онд 40 ам буюу нийт хүн амын 0.2%-ийг эзэлж байна. Бэлэвсэн хүний тоо 1926 онд 0.007%, 1927, 1928 он тус бүрт 0.01%-ийг эзэлж байна. Үүнээс үзэхэд өнчин, ганц бие, бэлэвсэн хүмүүс, тус хошууны нийт хүн амын маш хувийг эзэлж байсан нь харагдаж байна.

Гэмт хэргийн бүртгэл: Дарьганга уулын хошууны гэмт хэргийн гаралт, бүртгэл нь тухайн үеийн нийгмийн байдалд холбогдох зайлшгүй чухал хүчин зүйлсийн нэг юм. Тус хошууны гэмт хэргийн гаралттай холбогдох баримт нь 1927 оны нэгдүгээр сараас Дарьгангын тамгын газрын Зарга шүүх хэлтэс татан буугдаж хошууны Шүүн таслах газрыг мөн оны тавдугаар сарын 12 нээх хүртэлх үед холбогдож байна. Тухайн үед 3 төрлийн гэмт хэрэг бүртгэгдсэнээс “27 этгээдийг хорьж байсны 2 нь хүн амины, 18 нь хулгайн хэрэгт, 7 нь хурдан буу дарагдуулсан”¹⁶ зэрэг хэрэг үйлдсэн хүмүүс байжээ. Энэ нь тухайн оны нийт хүн амын 0.1%-ийг эзэлж байна. Мөн 1929¹⁷, 1930¹⁸ оны гэмт хэргийн бүртгэл, ял эдэлж буй хүмүүсийн тоотой холбоотой баримтыг ажиглавал.

1929 оны бүртгэлд нийт 4 хэрэг бүртгэгдсэн байна. Үүнд: 1. Хүний мал юмыг хулгайлах булаах (дээрэм), 2. Хүний амийг хороосон, 3. Хахуул авсан, 4. Бусдын юмыг ашиглан шингүүлсэн (залилан) гэдгээр бүртгэгджээ. Эдгээр хэргээс хамгийн олон хүн шийтгүүлсэн нь хүний мал, юмыг хулгайлах булаах гэдгээр шийтгүүлсэн 15 хүн, бусад гуравт тус бүр 1 хүн, нийт 18 хүн бүртгэгдсэн байна. Хоригдогсдын дотор намын гишүүн х (үгүй, байхгүй), эвлэлийн гишүүн х хууль ёсоор урьдчилан хорьсон хэрэгтэн х, тогтоолоор ял олж хоригдсон хэрэгтэн 18, өвчнийг эмчлүүлэн буй нь х, цаазаар аваачсан х, бие барсан х, гянднаас оргосон х, ялын нэг дундуурыг эдлэж өнгөрүүлэн урьдчилан гаргасан х, уул ялыг бүрнээ эдлэж гарсан 1, бага хурлын тэргүүлэгчдээс өршөөхийг үзүүлж хэлтрүүлэн тавьсан х хэмээн тэмдэглэсэн байна. 1929 оны 6 сарын 1-ний байдлаар 18 хүн гянданд хоригдож байсан байна. Энэ нь тухайн үеийн хүн амын 0.1%-ийг эзэлж байна.

1930 оны бүртгэлийг үзвээс мөн 4 хэрэг бүртгэгдсэн байна. Үүнд: 1. Бусдын юмыг хулгайлсан зэргийн, 2. Бусдын юмыг ашигласан зэргийн, 3. Хахуул авсан, 4. Мэхлэх зэргээр эр эм болсон гэх хэргүүд бүртгэгдсэн байна. Эдгээрээс хамгийн олон хүн шийтгэгдсэн нь урьд онтой адил бусдын юмыг хулгайлсан, бусад 3 нь тус бүр 1 хүн шийтгэгдсэн байна. 1930 оны 3 сарын 1-ний байдлаар хоригдогсдын дотор намын гишүүн х (х-байхгүй), эвлэлийн гишүүн х, хууль ёсоор урьдчилан хоригдсон х, тогтоолоор ял олж хоригдсон 5, өвчний учир эмчлүүлэн буй нь х, цаазаар аваачсан х, бие барсан х, гянднаас оргосон х, ялын нэг дундуурыг эдэлж өнгөрүүлэн урьдчилан гарсан 3, уг ялыг

¹⁶ МУУТА. Ф-84. Д-1. ХН-30

¹⁷ МУУТА. Ф-84. Д-1. ХН-35

¹⁸ МУУТА. Ф-84. Д-1. ХН-70



THE CULTURAL WAY

бүрнээ эдэлж гарсан 4, улсын бага хурлын тэргүүлэгчдээс өршөөхийг үзүүлэн хэлтрүүлэн тавьсан х болмой гэж бүртгэлийг төгсгөлд тэмдэглэжээ. 1929 онд ялтны тоо, 1930 он болоход 3 дахин буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь тухайн үед гэмт хэрэгт оногдуулж байсан ялын хэмжээ (хугацаа) хөнгөн байжээ хэмээн дүгнэж болохоор байна. Эцэст нь өгүүлбээс Дарьганга уулын хошуунд гэмт хэргийн бүртгэгдсэн тохиолдол бага байна.

ДҮГНЭЛТ

Дарьганга уулын хошууны хүн амын хөдөлмөр эрхлэлтэд уламжлалт мал аж ахуйгаа дагасан мал адгуулах, гэр малын ажил зонхилж байжээ. Уг ажлыг нийт эрэгтэйчүүдийн 18-45, эмэгтэйчүүдийн 18-аас дээш насныхан голлон эрхэлж байсан байна.

Хүн амын бичиг үсэг тайлагдалтын байдал нь 18-аас дээш насны эрэгтэйчүүд дийлэнх хувийг эзэлж байна. Төвд бичиг үсэг мэдэх хүний тоо аль ч онд давамгайл байна. Энэ нь лам нарын тооноос шууд хамааралтай бөгөөд тухайд үед шарын шашны нөлөө Монголд хүчтэй байсны илрэл юм.

Эмэгтэйчүүдийн хувьд бичиг үсэг мэдэх байдал маш бага зарим онд огт тэмдэглэгдээгүй байна. 1929 оны бүртгэлд сонгууль ба тушаалын алба хааж буй эмэгтэйчүүд, нийт эмэгтэйчүүдийн дотор 0.06%-ийг эзэлж байсан. Энэ нь нийгэмд эмэгтэйчүүдийн оролцоо бага байсныг харуулж байна.

Хүн амын өвчин эмгэгийн байдал жилээс жилд буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь хүмүүсийн эрүүл мэндийн байдал мэдэгдэхүйц сайжирсаар байсныг харуулж байна.

Нэмсэний тоо огцом өсөж, хорсоны тоо огцом буурсан нь 1926-1927 онд хошууны нийт хүн 1086 ам буюу 7.2%-аар өссөн үзүүлттэй давхцаж байхаас гадна 1927-1928 онд нэмсэний тоо буурч, хорсоны тоо өссөн нь 1927-1928 онд хошууны нийт хүн ам 518 ам буюу 3.4%-аар буурсан үзүүлэлттэй мөн давхцаж байна. Дарьганга уулын хошуу (1925-1929)-нд улс төр, эдийн засаг, нийгмийн өөрчлөлт, шинэчлэлт явагдсаны үр дүнд дотоод болон гадаад байдал харьцангуй тогтвортой байсан байна.

ABSTRACT

The so-called Dariganga Mountain Range was a time of transition from the old Dariganga society to a new one. In order to clarify some social issues of this transition period, the aim of the study is to study employment, literacy, births, deaths, orphans, singles, widows, diseases, and crime in the population data of Dariganga Mountain Range.

Keywords: *Darganga Mountain Cape, historical demography and social status*



THE CULTURAL WAY

НОМ ЗҮЙ

1. МУУТА. Ф-84. Д -1.ХН-4
2. МУУТА. Ф-1. Д-2. ХН-114
3. МУУТА. Ф-84. Д-1, 2
4. МУУТА. Ф-1. Д-1-9
5. МУУТА. Ф-4. Д-1, 2
6. МУУТА. Ф-11. Д-1, 2
7. МУУТА. Ф-84. Д-1. ХН-48
8. МУУТА. Ф-84. Д-2. ХН-3
9. МУУТА. Ф-84. Д-1. ХН-72
10. МУУТА. Ф-84. Д-2. ХН-9
11. МУУТА. Ф-84. Д-1. ХН-40
12. МУУТА. Ф-84. Д-2. ХН-2
13. МУУТА. Ф-84. Д-1. ХН-30
14. МУУТА. Ф-84. Д-1. ХН-35
15. МУУТА. Ф-84. Д-1. ХН-70

16. Э.Лувсанбалдан. Дарьгангын түүх. УБ., 2013. т 203

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

NEWS



THE CULTURAL WAY
CENTER FOR CULTURAL STUDIES

“СОЁЛЫН ЖИМЭЭР” Соёл Судлалын Төвийн тухай

Анх 2015 онд монгол судлаач залуу эрдэмтдийн судалгааны ажлыг дэмжих, харилцан туршлага солилцох зорилготойгоор “Содон Соёд” эрдэм шинжилгээний нэгдэл байгуулагдаж байв.

2020 оноос “Соёлын Жимээр” соёл судлалын төв болгон өргөтгөв. Тус төвийн үйл ажиллагааны цар хүрээ улам өргөжин, судалгаа шинжилгээний ажлыг сурталчлахын сацуу орчуулга, хөрвүүлгийн ажлыг гүйцэтгэх боллоо.

Эрдэм шинжилгээний өгүүллийг хөрвүүлж найруулан, монгол улсад хэвлэгдэх стандартад нийцүүлэх, тухайн ажлыг сэтгүүлд хэвлүүлэх ажлыг гүйцэтгэсээр ирэв. Мөн тусгай төслийн хүрээнд бичигдсэн судалгааны ажлыг хөрвүүлж, орчуулан монгол улсад хэвлүүлэх ажлыг зохион байгуулсаар байна. Үүнээс гадна бидний бас нэг онцлох үйл ажиллагаа бол монгол судлаач эрдэмтдийн судалгааны ажлыг дэмжих зорилгоор эрдэм шинжилгээний сэтгүүлийг монгол улсад эрхлэн хэвлүүлэх ажлыг өрнүүлсээр байна.

2022 оны 1 дүгээр улирлаас манай сэтгүүл **ISSN** буюу олон улсын эрдэм шинжилгээний номын санд албан ёсоор бүртгэгдэн цаашид улирал тутам хэвлэхээр төсөвлөн ажиллаж байна.

РЕДАКЦ

© Тус сэтгүүлийг хэвлэх эрх хуулиар хамгаалагдсан болно.
Зөвшөөрөлгүй бүх төрлөөр хуулбарлахыг хориглоно !



THE CULTURAL WAY
CENTER FOR CULTURAL STUDIES

„...אנחנו מיישנים את המחקר הזה בצורה מקצועית“

לדבריו, המחקר הזה יתפרסם במהדורה חדשה של כתב העת „הדרך“ ויש לו ISSN 2022. „...אנחנו מיישנים את המחקר הזה בצורה מקצועית“

...אנחנו מיישנים את המחקר הזה בצורה מקצועית. „...אנחנו מיישנים את המחקר הזה בצורה מקצועית“

...אנחנו מיישנים את המחקר הזה בצורה מקצועית. „...אנחנו מיישנים את המחקר הזה בצורה מקצועית“

„...אנחנו מיישנים את המחקר הזה בצורה מקצועית“

“СОЁЛЫН ЖИМЭЭР” Соёл Судлалын Төвөөс
кирилл үсэгт хөрвүүлсэн судалгааны бүтээлээс

1400 ЖИЛИЙН ӨМНӨХ ӨВӨГ
МОНГОЛ ХЭЛ

1400 жилийн өмнөх өвөг
МОНГОЛ ХЭЛ

Солонгод Д.Хурцбат




Elias Verlag IMoFiF e.V.
Cologne Germany 2020

1400 жилийн өмнөх өвөг монгол хэл

Солонгод Д.Хурцбат 1. Өмнөх өвөг монгол хэл ④

Солонгодол Хуриватарын Хадагаламж Суудлын Цуврал



© 2021 by Elias Verlag IMoFiF e.V. - Cologne, Germany

© 2021 by Elias Verlag IMoFiF e.V. - Cologne, Germany

Өвөг монгол хэл - Монгол брахми бичиг

1450 онд бичигдсэн
Монгол брахми бичиг —
Монгол хэлний үндэс

© 2021 by Elias Verlag IMoFiF e.V.



Elias Verlag IMoFiF e.V.
Cologne Germany 2021




КИРИЛЛ ҮСЭГТ ХӨРВҮҮЛЖ, ЭРХЛЭН ХЭВЛҮҮЛСЭН СУДАЛГААНЫ БҮТЭЭЛ

2021 онд анх удаа хийгдсэн "Кирилл үсэгт хөрвүүлж, эрхлэн хэвлүүлсэн судалгааны бүтээл"

Кирилл үсэгт хөрвүүлж, эрхлэн хэвлүүлсэн судалгааны бүтээл

Кирилл үсэгт хөрвүүлж, эрхлэн хэвлүүлсэн судалгааны бүтээл


Кирилл үсэгт хөрвүүлж, эрхлэн хэвлүүлсэн судалгааны бүтээл



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠶᠢᠷᠠᠭᠤ ᠨᠠᠶᠢᠷᠭᠢᠢᠨ ᠲᠤᠮᠤᠨᠤᠯᠤᠯᠤᠰᠤᠨ ᠲᠤᠮᠤᠨᠤᠯᠤᠯᠤᠰᠤᠨ ᠲᠤᠮᠤᠨᠤᠯᠤᠯᠤᠰᠤᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠶᠢᠷᠠᠭᠤ ᠨᠠᠶᠢᠷᠭᠢᠢᠨ ᠲᠤᠮᠤᠨᠤᠯᠤᠯᠤᠰᠤᠨ
 ᠲᠤᠮᠤᠨᠤᠯᠤᠯᠤᠰᠤᠨ ᠲᠤᠮᠤᠨᠤᠯᠤᠯᠤᠰᠤᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠶᠢᠷᠠᠭᠤ ᠨᠠᠶᠢᠷᠭᠢᠢᠨ ᠲᠤᠮᠤᠨᠤᠯᠤᠯᠤᠰᠤᠨ ᠲᠤᠮᠤᠨᠤᠯᠤᠯᠤᠰᠤᠨ



| МОНГОЛ ЯРУУ НАЙРГИЙН | |
|---|-----|
| Солонгод Д.Хасбаатар | |
| ТАРЧИГ | |
| ОМНОХ УГ | 6 |
| УДИРГААЛ | 8 |
| 1. РЧОЙНОМ ба Д.Чулуунбаатарын яруу найргийн | 8 |
| 2. Сүлдэгдэлтэй байдал | 15 |
| 3. Судалгааны зорилго, судалгааны материал | 23 |
| 4. Судалгааны арга | 24 |
| БЭНДЭГЭР БУС ГЭВЭЭ НАМГАР БА УРАН БУТГАА | 25 |
| Илгээгч хэсэг, Яруу найрагч Ринчиноом Чойномын намтар | 40 |
| Хөгжигч хэсэг, Ринчиноом Чойномын уран бүтээлүүд | 45 |
| Граммурын хэсэг, Ринчиноом Чойномын намтар | 45 |
| 1. Энэ өрнө, утгайга, тусгайр тогтохын утга | 49 |
| 2. Ардчилал, эрх чөлөөт буюу эрх чөлөөт | 51 |
| 3. Могой могойдуудтай тус зам ба чөлөөт | 57 |
| 4. Илгээгч хэсэг бүтэц байгуулалт | 60 |
| 5. Шүүж найргийн тусай | 62 |
| 6. Шүүж илгээгч хэсэг байдал ба хайр дурлалын тусай | 63 |
| 7. Ардчилал тусай | 66 |
| Дэргэдүүр хэсэг, Р.Чойномын яруу найргийн | 66 |
| уран чадварын онцлог | 67 |
| 1. Р.Чойномын хөгжлийн онцлог | 71 |
| 2. Р.Чойномын яруу найргийн онцлог | 82 |
| 3. Р.Чойномын яруу найргийн уран чадвар | 89 |
| 4. Р.Чойномын яруу найргийн онцлог | 106 |
| 5. Утга могойдуудтай тус зам ба чөлөөт | 122 |
| Төгсгөл хэсэг, Д.Чулуунбаатарын намтар | 122 |
| 1. Д.Чулуунбаатарын намтар | 124 |
| 2. Яруу найрагч Д.Чулуунбаатар их амьтат дурсгал | 147 |
| Урлагчид хэсэг, Д.Чулуунбаатарын намтар | 147 |
| 1. Яруу найрагч Д.Чулуунбаатарын уран чадвар | 150 |
| 2. Д.Чулуунбаатарын яруу найргийн тусай | 161 |



“СОЁЛЫН ЖИМЭЭР” эрдэм шинжилгээний сэтгүүлд

ӨГҮҮЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ

Ерөнхий шаардлага:

- Урьд өмнө хэвлэгдээгүй байх
- Монгол судлал ба түүх, соёлын чиглэлийн асуудлыг хөндсөн байх
- Шинжлэх ухааны үндэслэлтэй, шинэлэг үзэл санаа дэвшүүлсэн байх
- Судалгааны логик уялдаа, дэс дараалал тодорхой байх

Техник шаардлага:

- Кирил үсгээр бичигдсэн байх (үүний хамт гарчиг, товч агуулга, түлхүүр үг зэргийг англи хэл дээр бичих)
- Хэл зүй хийгээд найруулга зүйн ямар нэг алдаагүй байх
- Үг үсгийн алдаагүй байх
- Цаасны хэмжээ В5
- Үсгийн өндөр 12
- Эшлэл зүүлтийг тухайн хуудсанд хийх эсвэл АРА форматаар бичсэн байх (үсгийн өндөр 10)
- Нүүрийн тоо – 8-15

Судалгааны ажлын бүтэц:

Гарчиг

- Гарчиг англи хэл дээр (content)
- Судлаачийн овог нэр, эрдмийн цол зэрэг, эрхэлж буй ажил, и-мэйл хаяг, утасны дугаарыг бичих
- Товч агуулга
- Товч агуулга англи хэл дээр (abstract)
- Түлхүүр үг
- Түлхүүр үг англи хэл дээр (key word)
- Судалгааны үндсэн хэсэг
- Дүгнэлт
- Ном зүй
- Дагалдуулал (хэрвээ шаардлагатай бол үйлдэх)

Өгүүлэл хэвлэгдэх явц:

- Өгүүлэл хүлээн авна.
- Өгүүллийг редакцийн гишүүд шүүн хэлэлцэнэ.
- Хэвлэх ба үл хэвлэхийг шийднэ.
- Хэвлэгдэх боломжтой засварлах, өөрчлөх зүйлс буйг мэдэгдэнэ (тодорхой хугацаа өгнө).
- Өгүүлэл хэвлэгдэнэ.

-> **לשון המהירות** ..

-> **לשון המהירות** היא מונחיה של **התקשורת** , **התקשורת** היא **התקשורת** (התקשורת) ..

-> **התקשורת** היא **התקשורת** ..

-> **התקשורת** היא **התקשורת** ..

-> **התקשורת** היא **התקשורת** ..

לשון המהירות :

-> **לשון המהירות** (התקשורת) היא **התקשורת**

-> **התקשורת**

-> **התקשורת**

-> **התקשורת** היא **התקשורת**

-> **התקשורת** היא **התקשורת** (key word)

-> **התקשורת**

-> **התקשורת** היא **התקשורת** (abstract)

-> **התקשורת**

-> **התקשורת**

-> **התקשורת** היא **התקשורת** , **התקשורת** היא **התקשורת** , **E-mail** היא **התקשורת** , **התקשורת** היא **התקשורת**

-> **התקשורת** היא **התקשורת** (content)

-> **התקשורת**

לשון המהירות :



THE CULTURAL WAY

СОЁЛЫН ЖИМЭЭР

Соёл Судлалын Төв

THE CULTURAL WAY СОЁЛЫН ЖИМЭЭР ISSN: 2791-1446

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ СЭТГҮҮЛИЙН

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Улаанбаатар 2023



THE CULTURAL WAY

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

ДҮГЭРЖАВ БАДАМДОРЖ / Доктор (Sc.D) /

1950 онд Завхан аймгийн Эрдэнэхайрхан суманд төрсөн, эрэгтэй. Монгол хэл, уран зохиолын багш. Хэлбичгийн шинжлэх ухааны доктор, МУИС-ийн профессор. Судалгааны чиглэл: Монгол хэл шинжлэлийн утга судлал

| д/д | Ажлын газрын нэр | Хугацаа | Эрхэлсэн ажил |
|-----|---|--|---|
| 1 | Завхан, тэлмэн сум, Бага сургууль | 1968-1970 он | Бага ангийн багш |
| 2 | Завхан, Төвийн 10 жилийн сургууль | 1970-1973 он | Пионерийн ахлах удирдагч |
| 3 | ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн | 1979-1983 | Эрдэм шинжилгээний ажилтан |
| 4 | Ховд, УБДС | 1983-1986 | Монгол хэлний багш |
| 5 | Япон, Токио, Гадаад хэлний их сургууль | 1986-1989 | Зочин профессор |
| 6 | МУИС Унгар, Шинжлэх ухааны их сургууль МУИС | 1990 оноос 2009-2015 он 2016 оноос | Монгол хэлний багш Зочин профессор Зөвлөх профессор |



THE CULTURAL WAY

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Л.ЧУЛУУНБААТАР / Доктор (Ph.D) /

1952 онд Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр суманд төрсөн, эрэгтэй. Монгол хэл, англи хэлний багш мэргэжилтэй. Хэл шинжлэлийн ухааны доктор, профессор. Судалгааны чиглэл: Харьцуулсан хэл шинжлэл

Хэлний чадвар: Орос, Англи, бичгийн Төвд хэлтэй, Япон хэлний анхан шатны мэдлэгтэй

Боловсрол:

1960-1964 Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын бага сургууль,

1964-1968 Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын 8 жилийн дунд сургууль,
1968-1970 Мөрөн хотын 1-р 10 жилийн дунд сургууль

1976-1981 МУИС-ийн ХБФ-ийн Монгол хэлний анги

1982-1983 МУИС-ийн Багш нарын сурганы курс

1984-1986 МУИС-ийн Англи хэлний 2 жилийн оройн курс

1999-2000 ОХУ-ын Улаан-Үүд хотын Монгол,Төвд, Буддын судлалын хүрээлэнгийн докторантур

2005 оны 4-р сараас 2005 оны 12-р сар Токиогийн Гадаад Судлалын Их сургуулийн япон хэлний 9 сарын курс

Ажилласан байдал:

1970-1971 Хөвсгөл аймгийн Мөрөн хотын Гурилын үйлдвэрт ажилчин

1971-1974 Ардын армийн 013-р ангид байлдагч, бага түрүүч

1974-1976 Хөвсгөл аймгийн Мөрөн хотын Гурилын үйлдвэрт ажилчин

1981-1989 МУИС-ийн ХБФ-ийн Монгол хэлний тэнхимд багш

1989-1991 Англи улсын Лондонгийн Их Сургуульд мэргэжилтэн багш

1991-1992 МУИС-ийн ХБФ-ийн Монгол хэлний тэнхимд багш

1992-1994 МУИС-ийн Аспирантур хариуцсан мэргэжилтэн



THE CULTURAL WAY

1994-1998 МУИС-ийн Гадаад харилцааны хэлтсийн дарга

1998-2003 МУИС-ийн МХСС-ийн Гадаад хэлний тэнхмийн эрхлэгч

2003-2005 МУИС-ийн МХСС-ийн захирал

2005-2008 Токиогийн Гадаад Судлалын Их сургуулийн зочин профессор

2008 оны 4 сараас МУИС-ийн МХСС-ийн Гадаад хэлний тэнхмийн профессор
багш

2009 оны 9 сараас 2013 МУИС-ийн МХСС-ийн Гадаад хэлний тэнхмийн
эрхлэгч

2013-2014 МУИС-ийн МХСС-ийн Гадаад хэлний тэнхмийн зөвлөх профессор

2014-2016 БНХАУ-ын ӨМӨЗО-ны ӨМИС-д зочин профессор

2016-2017 МУИС, ШУС, ХУС, ИБАС-ийн тэнхмийн зөвлөх профессор

2017 оны 9 сараас МУИС-ийн ОУХС-ийн Англи хэлний хөтөлбөрийн багт
зөвлөх профессор



Солонгод ЛООСАЛ ХУРЦААТАР / Доктор (Ph.D) /

1959 онд Хятад улсын Өвөр Монголын Ордос хотын Отог хошуунд төрсөн, эрэгтэй. 1971-1974 онд тухайн үеийн Отог хошууны Булаг сумын Хархадан сүмийн бага сургуульд суралцан төгсөв. 1974 оноос хоёр жил нутагтаа малчин байв. 1976-1978 онд Өвөр монголын Монгол хэл бичгийн тусгай мэргэжлийн сургуульд монгол хэл бичиг ба орчуулгын мэргэжлээр суралцан төгсөв. 1980 онд Өвөр монголын Их сургуулийн номын сангийн ухаан ба гүн ухааныг суралцан төгсөв. Тэр тус жилээс эхлэн Өвөр монголын Засаг захиргааны дээд сургуульд номын санч ба үндэстний асуудлын тухай сэтгүүлчээр 1989 он болтол ажиллав. 1989 онд Вольтер Хейссиг гуайн урилгаар Германы Бонн их сургуульд зочин судлаачаар ажиллаж, “Монгол бөө мөргөлийн тайлга тахилгын соёл” хэмээх бүтээлээ туурвин хэвлүүлэв. 1996 онд Германы Кёльн Их сургуульд оюутан, магистр сурлагаа угсаатан зүйн салбар ба өрнө дахины судлалаар нэгдүгээр дэд мэргэжил, Бонн их сургуулийн Төв Азийн судлалаар хоёрдугаар дэд мэргэжлээр суралцан төгсөв. 1999 онд Германы Түбинген их сургуулийн соёл гүн ухааны хүрээлэнд харьцуулал шашин судлал ба соёл угсаатан зүйн мэргэжлээр докторын сурлагаа амжилттай суралцан төгсөж гүн ухааны цол хамгаалав. 1999 оны 4-8 дугаар сард Японы Осака хот дахь Улсын угсаатан зүйн музейд зочин судлаачаар уригдаж, энэ хугацаандаа “Чингис хаан тайлга” (докторын өгүүлэл) хэмээх тав дахь номоо герман хэлээр хэвлүүлэв. 2000-2017 онд тэр Герман улсад Ордос арилжаа бизнес хийгээд аялал жуулчлалын компаний захирлаар аж ахуйлал эзэгнэв. 2017 оноос бизнесээ бүрэн орхиж, аавынхаа гэрээсээр, В.Хейссиг багшийнхаа “Хурцбаатар дор, сайн ном бичих болтугай” гэсэн бичээсээр монгол соёл сурвалжаа үргэлжлүүлэн судлав.

Л.Хурцбаатарын хэвлүүлсэн гол болох эрдэм судалгааны номууд:

1. “Хатагин арван гурван атаа тэнгэрийн тайлга”, 1987 он, Өвөр монгол, Хайлаар.
2. “Хишигбатын гүн ухаан жич нийгмийн үзэл санааны тухай материал”, 1988 он, Өвөр монгол, Хөх хот.



THE CULTURAL WAY

3. “Монголын бөө мөргөлийн тайлга тахилгын соёл”, (Ч.Үзмээгийн хамт), 1991 он, Өвөр монгол, Хайлаар.
4. “Хишигбатын <Эрт ба эдүгээх эрдэнийн товч>”(бусадтай хамтарсан), 1997 он, Өвөр монгол, Хайлаар.
5. “Чингис хааны тайлга”(докторын өгүүлэл, герман хэл), Sengi Ethnological Reports 11, 1999 он, Япон, Осака.
6. “Чингис хааны алтан бичиг” (Огонос Цогтын хамт), 2001 он, Өвөр монгол, Хайлаар.
7. “Ордосын мянгад овогтон Хишигдүүрэнгийн монголын соёл түүхийн тухай гар бичмэлүүд” (бусадтай хамтарсан), QMD Nr.II. 2011 он, Токуо.
8. “Хишигбат” (бусадтай хамтарсан, 6 боть), 2012 он, Өвөр монгол, Хөх хот.
9. “Монголын бөө мөргөлийн тайлга тахилгын судлал” (бусадтай хамтарсан, 4 боть), 2012 он, Герман, Кёльн.
10. “Л.Чулуунбаатарын бүрэн зохиол” (Солонгод Л.Хастбаатарын хамт, 4 боть), 2014 он, Герман, Кёльн.
11. “Монголчуудын уугал бичгийн соёлын үүсэл буюу Хөх Түрэг бичиг” (судлалын цуврал ②, Д.Баатарын хамт), 2018 он, Герман, Кёльн.
12. “1400 жилийн өмнөх Өвөг монгол хэл – Хүйс толгойн бичээсний судлал” (судлалын цуврал ①, монголоор), 2019 он, Герман, Кёльн.
13. “Эртний түрэг бичээсний хэлний үгийн бүтцийн толь” (бусадтай хамтарсан, судлалын цуврал ③, кириллээр), 2020 он, Герман, Кёльн.
14. “1400 жилийн өмнөх Өвөг монгол хэл – Хүйс толгойн бичээсний судлал” (судлалын цуврал ④, кириллээр), 2020 он, Герман, Кёльн.
15. “Эртний түрэг бичээсний хэлний үгийн бүтцийн толь” (бусадтай хамтарсан, судлалын цуврал ⑤, монголоор), 2020 он, Герман, Кёльн.



THE CULTURAL WAY

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

ЦОЛМОН / Доктор (Ph.D) /

1987 онд БНХАУ-ын ӨМӨЗО-ы Шилийн гол аймгийн Хөвөөт шар хошуунд төрсөн, эмэгтэй.

Нэг. Боловсрол

1. 2006-2010 он: Их Сургууль (Bachelor)

- Хуа Жүн-ий Багшийн Их Сургууль – БНХАУ-ын гол зургаан багшийн их сургуулийн нэг.
- Мэргэжил: Түүхийн ухаан
- Эрдмийн зэрэг хамгаалсан өгүүлэл: Чин улсын шинэ засгийн үе дэх Өвөр Монголын атар хагалбарлалт

2. 2010-2013 он: Магистр

- Өвөр Монголын Их Сургуулийн Монгол Түүхийн ухааны салбар
- Мэргэжил: Өвөр Монголын ойрх үеийн түүх
- Эрдмийн зэрэг хамгаалсан өгүүлэл: 1925-1931 оны Дотоод Монголын ардын хувьсгалт намын түүх

3. 2013-2017 он: Доктор

- Өвөр Монголын Их Сургууль
- Судалгааны чиглэл: Өвөр Монголын ойрх үеийн түүх
- Эрдмийн зэрэг хамгаалсан өгүүллийн гарчиг: Өөртөө засах ба хувьсгал-Дотоод Монголын ардын хувьсгалт намын түүх (1917-1947)

Хоёр. Гадаад дахь боловсрол ба Олон улсын хурал

1. Гадаад дахь боловсрол

- 2011.11-2012.06: МУИС-ийн Нийгмийн Шинжлэх Ухааны тэнхимд солилцооны оюутан.
- 2014.08-2015.09: АНУ-ын Индиана Их Сургуулийн (USA Indiana University) Төв Ази Судлалын тэнхимд Кристофер Этвүүд (Christopher P. Atwood) багшийн чиглүүлэг дор зочин судлаач.
- 2015.03-2015.05: Харвард Их Сургуулийн (Harvard University) зочин судлаач.
- 2016.07-2016.08: ОХУ-ын Бүгд Найрамдах Халимаг Улсад зуны сургуулийн судлаач.

2. Олон улсын эрдэм шинжилгээний хурал



THE CULTURAL WAY

- 2013.11: Австралийн Үндэсний Их Сургуульд (Australian National University) болсон XX зууны Монголын Судлалын нээлттэй хурал: “Дагур Мерсе-ийн захидал ба 1928 оны Баргын хөдөлгөөн”.
- 2014.10: Жонс Хопкинсийн Их Сургуульд (Johns Hopkins University) болсон XX зууны түүхэн дэх Дундад улсын зах хязгаар орны асуудал: Өвөр Монголын хошууд өөртөө засах орны эрэлд
- 2015.04: Харвард Их Сургуульд (Harvard University) болсон Төв ба Дотоод Азийн шинэ судалгааны чиглэл: “1928 оны Баргын хөдөлгөөн ба олон улсын харилцааны ээдрээт чанар”.

Гурав. Нийтлэгдсэн өгүүлүүд (төлөөлөх чанартай хэдийг сонгон тавьсан болно)

1. Дагурын сэхээтэн Мерсе-ийн амьдрал ба түүний үзэл санаа (1894-1925)
2. 1925-1931 оны хоорондох Цахар орон ба Дотоод Монголын ардын хувьсгалт намын харилцаа холбоо – *монгол хэлээр ӨМӨЗО-д нийтлэгдэв.*
3. Монгол орны цэцэг өвчин ба лам нарын хийдэг тарилга буюу вакцины тухай – *хятад хэлээр Япон улсад нийтлэгдэв.*
4. Буриад эрдэмтэн Цэвээний тухай (1) – *монгол хэлээр ӨМӨЗО-д нийтлэгдэв.*
5. Буриад эрдэмтэн Цэвээний Цахараар аялсан тэмдэглэл – *монгол хэлээр ӨМӨЗО-д нийтлэгдэв.*
6. Чингисийн онгон буюу Эзэн хороонд Цэвээний явуулсан эрдэм шинжилгээний үйл ажиллагаа ба орчин үеийн Ордос – *англи хэлээр Япон улсад нийтлэгдэв.*

Эрдэм шинжилгээний үүрэг тушаал:

- БНХАУ-ын Монгол Түүхийн нийгэмлэгийн гишүүн.
- Америкийн Монгол Судлалын нийгэмлэгийн гишүүн.
- БНХАУ-ын Цахар Судлалын нийгэмлэгийн дээд зөвлөлийн гишүүн (director)

Хэлний боловсрол

- Монгол хэл (*Уйгуржин монгол бичиг бичих унших ярихын өндөр зэргийн түвшин, кирилл бичгээр унших өндөр зэргийн түвшин*)
- Хятад хэл (*Унших, бичих, ярих өндөр зэргийн түвшин*)
- Англи хэл (*Унших, бичих, ярих өндөр зэргийн түвшин*)
- Орос, Япон хэл (*Унших, ярих анхан шатны түвшин*)



THE CULTURAL WAY

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Боржгин УРГААЦЭЦЭГ / Доктор (Ph.D) /

1985 онд БНХАУ-ын ӨМӨЗО-ы Жарууд хошуунд төрсөн, эмэгтэй.

- 2004 оны 9 сараас 2008 оны 7 сард Өвөр Монголын Их Сургуульд Англи хэлний мэргэжлээр бакалавр хамгаалсан.
- 2009 оны 9 сараас 2012 оны 7 сард Өвөр Монголын Их Сургуулийн Монгол Түүхийн салбарт суралцаж магистр цол хамгаалжээ.
- 2018 оны 9 сараас 2022 оны 12 сард Өвөр Монголын Их Сургуулийн Монгол Түүхийн салбарт “Дундад улсын түүхийн мэргэжил”-ээр доктор (Ph.D) цол хамгаалав. Одоо БНХАУ-ын Бортохойн Их Сургуульд Түүхийн хичээлийн багшаар ажиллаж байна. БНХАУ-ын Цахар эрдэм шинжилгээний бүлгэмийн гишүүн.

Зүүнгар хошууны засаг яамны дансыг эмхэтгэн хэвлүүлэх бүлгэмийн гишүүн. Судалгааны чиглэл: Монгол газар оронд явагдаж байсан цайны арилжаа, түүний хэрэглээ, цайны нийгэм түүхэнд үзүүлсэн нөлөө зэргийг судалдаг.

Өгүүллийн бүтээл

- ❖ Цайг монголчууд хэрэглэх болсны эхлэл гэх өгүүллээ “Дундад улсын монгол судлал” гэх сэтгүүлд нийтлэв.
- ❖ Юань улсын үеийн Өвөр Монголын баруун хэсгийн цайны арилжаан хөгжил ба Ордос монголчуудын цайны хэрэглээ гэх өгүүллээ “Өвөр Монголын Их Сургуулийн эрдэм шинжилгээ”-ний сэтгүүлд нийтлүүлэв.
- ❖ Цайны монголчуудын нийгэм амьдрал дахь үйлдэл хэмээх өгүүллийг “Цахар соёл судлал” сэтгүүлд нийтлүүлэв.
- ❖ Цайны зам ба монголчуудын цайны соёл гэх өгүүллээ “Монгол улсын ШУТИС-ийн эрдэм шинжилгээ”-ний сэтгүүлд нийтлүүлэв.
- ❖ XIII-XVII зууны монголчуудын цайны хэрэглээ гэх өгүүллээ “Монгол улсын Улаанбаатар Их Сургуулийн эрдэм шинжилгээ”-ний сэтгүүлд нийтлүүлэв.



Н.МЯГМАР / Доктор (Ph.D) /

ШУА-ийн Түүх, Угсаатны зүйн хүрээлэнгийн Нийгэм соёлын хүн судлалын салбарын эрдэм шинжилгээний ажилтан, эмэгтэй.

Нэг. Диссертаци зохиол

1. Төв аймгийн нутаг дахь эртний түүхийн үл хөдлөх дурсгалууд /магистрын ажил/
2. Өвөр Монголын малчдын аж амьдралын стратеги (Хөвөөт шар хошууны жишээн дээр) /докторын ажил/

Хоёр. Эрдэм шинжилгээний өгүүлэл

1. “Цахар Монголчуудын мөргүүлсэн эцэг эх сонгох ёсон” АММСТөв ЭШ-ний сэтгүүл XVII; ISSN 2072-8085, 2018 он
2. “Өвөр Монголын хот айл, түүний тогтолцоо”. УБИС-ийн Түүх, угсаатан зүйн ЭШ-ний сэтгүүл-XIV, ISSN 2310-256X, 2019 он.
3. “Өвөр Монголын нутаг бэлчээр, түүний үйл явцыг шинжлэх нь”. АММСТөв ЭШ-ний сэтгүүл XVIII; ISSN 2072-8085, 2019 он.
4. “Өвөр Монголын малчдын нутаг бэлчээр, аж байдлын тухай”. ШУА-ийн Түүх археологийн хүрээлэнгийн “Угсаатан судлал” ЭШ-ний сэтгүүл XXVI, ISBN 9789919-5550-4-5 2019 он.
5. “Малжих орны нийгмийн шилжилт, малчдын одоох байдал” БНХАУ-ын ӨМӨЗО-ын ӨМИС-ийн “Гүн ухаан, нийгмийн шинжлэх ухаан” ЭШ-ний сэтгүүл №6, ISSN1006-5547. 2020 он. (гадаад)



THE CULTURAL WAY

Гурав. Эрдэм шинжилгээний илтгэл

1. Цахар хуримын ёсон дахь нэгэн онцлог, түүнийг шинжлэх нь - “Цахар соёл” ЭШХ /БНХАУ, Улаанцав/ 2017.11 сар (гадаад)
2. Малчдын аж ахуйн стратеги - БНХАУ, ӨМИС-ийн Нийгэм зүй, угсаатны зүйн сургуулийн ЭШХ/ 2018 он (гадаад)
3. Эрүүлийг хамгаалах салбарт Монгол улсаас Лаос улсад үзүүлсэн буцалтгүй тусламж ба Найрамдал эмнэлэг - БНМАУ-ын бүтээн байгуулалт: Ололт, амжилт, сургамж ЭШХ /Түүх угсаатны зүйн хүрээлэн/ 2020.09 сар
4. Монгол-Хятад үндэстний харилцаан дахь “Хүүхэд шургуулах” домын тухай шинжлэх нь - “Монголын угсаатан судлал-2020” ЭШХ /Түүх угсаатны зүйн хүрээлэн/ 2020.10 сар
5. Нийгмийн ухамсарын түвшин дэх шашин шүтлэгийн илрэл, түүний эсрэг тэмцсэн нь – “БНМАУ: Буддын шашин, сүм хийдийн асуудал /1944-1990/” ЭШХ /Түүх угсаатны зүйн хүрээлэн/ 2020.11 сар



THE CULTURAL WAY

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Солонгод ЛООСАЛ ХАСБААТАР / Доктор (Ph.D) /

1965 онд БНХАУ-ын Ордос Отогийн өмнөд хошууны Манхат гацааны Алаг толгойд төрсөн, эрэгтэй. 1972-1983 онд Отогийн өмнөд хошууны Булаг сум, хошууны дунд сургуулийг төгссөн. 1985-1989 онд Тунляо дахь Өвөрмонголын Үндэстний Дээд Сургуулийн Монгол хэл утга зохиолын мэргэжил эзэмшив. 1989-1993 он болтол Ордосын Эзэн хороо хошууны Монгол дунд сургуульд багш, Отогийн өмнөд хошууны намын хороонд ажиллаж байв. 1994-1997 онд Монгол улсын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнд “Яруу найрагч Ренчиний Чойномын амьдрал уран бүтээл” сэвдээр докторын зэрэг хамгаалсан. 1999 оноос Монгол улсын Улаанбаатар Их Сургуулийн гадаад хэлний тэнхимд эрхлэгчээр ажиллав. “Монгол ээжийн хүү” (хамтын бүтээл) яруу найргийн ном, “Солгой хөгжим шиг цагийг сөрж явсан найрагч”, “Яруу найргийн урлахуй эрдэм”, “Чойномын амьдрал уран бүтээл”, “Солонгод овогтны гэрийн цагиг”, “Эрт эдүгээгийн Нангиад орон”, “Цагийн жаварт бөхөөгүй зул” зэрэг эрдэм ном, сургалт судалгааны бүтээлүүдээ бичиж хэвлүүлэв. “Монгол бөө мөргөлийн тайлга тахилгын судлал” хэмээх номын 1 дүгээр боть (“Хаадын гэрийн арван гурван атаа тэнгэрийн тайлга хийгээд Хатгинчууд”-ыг Солонгод Л.Хурцбаатар ахын хамт бичив), “Хишигбат” 4 дүгээр боть (Солонгод Л.Хурцбаатарын хамт)-ийг хамтран бичив. “Л.Чулуунбаатарын бүрэн зохиол”-ыг Л.Хурцбаатартай хамтран эмхэтгэн нийтлэв. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй”-г Д.Дамдинсүрэнтэй хамтран найруулж 5 дугаар ботид судалгааны бүтээл “Цагийн жаварт бөхөөгүй зул” нь бүрэн эхээрээ сонгогдон оров. Одоо Өвөрмонголын Их Сургуулийн Монгол Судлалын Дээд Сургуульд Дэлхийн уран зохиол ба харьцуулсан уран зохиолын судалгааны чиглэлээр судлаачдыг удирдаж, шинээр үүсгэн байгуулсан кирилл үсгийн мэргэжлийн ангийн сургалтын ажлыг голлон хариуцаж байна.



THE CULTURAL WAY

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

БАТ-ОЧИРЫН БОЛД / Доктор (Ph.D) /

1963 онд БНХАУ-ын ӨМӨЗО-ы Шилийн гол аймгийн Сөнөд баруун хошууны Сайхан-Өлзий сумын Сайханшил гацаанд төрсөн, эрэгтэй. Соёл судлаач, орчуулагч, яруу найрагч. Одоо япон улсын Эрүүл мэнд спортын их сургуульд хүн зүй судлал, сэтгүүл зүйн мэргэжлээр доктор, професор багш.

2002 онд японы Чива их сургуулийн судлах хүрээлэнгээс “Монгол бөхийн соёл уламжлал болон түүний шинэчлэлтийн тухай соёл хүн зүйн судалгаа” гэх сэдвээр эрдэм шинжилгээний докторын цол хамгаалжээ. “Чоно болон бөх – монгол бөхийн барилдаан дахь амилгын ёсны тухай” (2005) зэрэг 50 гаруй эрдэм шинжилгээний өгүүлэл, “Тулалдааны соёл – тулалдааны тухай хэвлэл мэдээллийн нийгэм зүй” (2010) зэрэг хамтран бичсэн 10-аад ном бүтээлтэй. “Монгол бөхийн бэлгэдэл зүй” өгүүлэл нь Спорт хүн зүйн үндсэн онол” (2004) гэх японых сургуулийн сурах бичигт сонгогдон оров. Үүнээс гадна уран зохиолын талаар “Хамар” (2009), “Аймшигт шөнө” (2012) зэрэг японы өгүүллэгүүд, “Элс манхны театр” зэрэг цуврал орчуулгын бүтээл, “Б.Болдын бөхийн яруу найраг” (2016), “Хайрын үзэл” (2017), “Дэлхийн монгол цуврал” (хамтран зохиосон 2019), зэрэг яруу найргийн түүвэр болон “Хорвоо доголдох үнэн тууль” (Б.Билигийн зураг хавсаргав) гэх найраглалын номоо хэвлүүлжээ. 2020 оноос түүний орчуулсан японы хүүхдийн уран зохиолын бүтээлүүдийг Өвөрмонголын радио телевизийн “Гурван цаг” нэвтрүүлгээр олонтоо нэвтрүүлжээ. 2016 онд “Дэлхийн монгол цувралын нийгэмлэг”-ийг үүсгэн байгуулж, монгол цуврал сонирхогчдын бүтээлийг японы сэтгүүл дээр олон хэлээр нийтэлж байгаа бөгөөд 2021 оноос “Дэлхийн монгол цуврал” цахим сэтгүүлийн найруулагчаар ажиллаж байна.



THE CULTURAL WAY

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Тэлэнгүд ЗАЛГААБАЯР / Доктор (Ph.D) /

1987 онд БНХАУ-ын ӨМӨЗО-ы Шилийн гол аймгийн Сөнөд зүүн хошуунд төрсөн, эрэгтэй. ӨМИС-ийн Монгол Судлалын Дээд Сургуулийн ЭШС-ийн туслах найруулагч.

2009 онд ӨМӨЗО-ы Тариалангийн Их Сургуулийн Аж ахуйн дээд сургуулийг төгсөв. 2014 онд Өвөрмонголын Багшийн Их Сургуулийн Монгол Судлалын Дээд Сургууль төгсөж, Хятадын эртний сурвалж бичгийн магистр цол хамгаалжээ. 2021 онд Өвөрмонголын Их Сургуулийн Монгол түүхийн салбарыг төгсөж, түүхийн ухааны доктор цол хамгаалав. Эдүгээ Өвөрмонголын Их Сургуулийн Эрдэм шинжилгээний сэтгүүл найруулах тасагт ажиллаж байна.

